АРИУН ЭЦЭГ ФРАНЦИС
ПАП ЛАМЫН АЙЛДСАН

# “БИД БҮГД АХАН ДҮҮС МӨН (*FRATELLI TUTTI*)”

ХЭМЭЭХ

АХАН ДҮҮСИЙН ЁСОН БОЛОН
НИЙГМИЙН НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ

Улаанбаатар хот
2023 он

© Libreria Editrice Vaticana
Библи судрын эшлэл: Ариун Библи
© 2004, 2011, 2013 оны Ариун Бичээс Нийгэмлэг

"Мөнхийн Үсэг" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

## ТҮГМЭЛ ЗАХИДАЛ

1. Фрателли Тутти ("Бид бүгд ахан дүүс мөн")[1]. Ассисийн Гэгээн Францис ах, эгч, дүү нартаа хандан энэхүү үгийг айлдаж, тэдэнд Есүс Христийн айлдсан Сайн мэдээний охь нь болсон амьдралын зам мөрөөр замнахыг санал болгосон байдаг. Тийм учир түүний айлдсан сургаалуудаас би энэ нэгийг нь сонгосон юм. Энэ бол газрын хол, ойрын орон зайн хязгаарыг давсан хайрын тухай айлдсан сургаал юм. Францис айлдахдаа "хол сууж байгаа биш харин дэргэд нь байгаа юм шигээр" [2] ах дүүгээ хайрлаж чаддаг тэр хүмүүнийг "адис хүртсэн" гэж үзэж болно гэжээ. Гэгээн Францис ийнхүү шууд айлдсан энгийн үгээрээ биеэрээ ойр, хол байгаагаас болон хаана төрсөн, эсхүл хаана оршин суудгаас нь үл шалтгаалан хүн бүрийг хүлээн зөвшөөрөх, үнэлэх, хайрлах боломж бололцоог бий болгож байгаа ах дүүгийн хоорондын харилцаа холбооны нээлттэй сэтгэлийн мөн чанарыг илэрхийлсэн байна.

2. Нэг нэгнийгээ ах дүүгийн сэтгэлээр хайрлах, энгийн төлөв даруу байх, ямагт баяр баясгалан цацраахын илэрхийлэл болсон Гэгээн Францис надад нөлөөлсний ачаар би *Laudato Si* буюу "Таныг магтан дуулья!" хэмээх Түгмэл захидлаа бүтээсэн билээ. Энэ удаа мөн адил Тэрээр намайг зоригжуулж, би ахан дүүгийн нарийн нандин харилцаа холбоо, нийгмийн найз нөхөрлөлийн харилцааны тухай энэхүү шинэ Түгмэл захидлыг бүтээж түмэн олонд хүргэж байна. Гэгээн Францис өөрийгөө нар, далай, салхитай ахан дүүгийн харилцаа холбоотой гэдгээ мэдэрч байсан. Гэхдээ өөртэй нь адилхан мах, яснаас

бүрдсэн хүмүүстэй тэрнээс илүү ойр дотно холбоотой гэдгээ сайн мэддэг байсан. Тэрээр очсон, хүрсэн газар бүртээ энх амгалангийн үрийг тарьж, ядуу зүдүү амьдралтай, орхигдсон, амь нь тасрах шахсан, гологдсон, хамгийн дорд үзэгдсэн хүмүүсийг хамгийн ойр дотно ах дүүгээ мөн хэмээн үзэж, тэд нартай холилдон хутгалддаг нэгэн байжээ.

## ХИЛ ХЯЗГААРГҮЙ БАЙХЫН ТУХАЙ

3. Гэгээн Францисын зүрх сэтгэл ямагт нээлттэй байсан, ингэснээр тэрээр ямар нэгэн хүлээсэнд баригддаггүй байсан, хэнийг ч гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварладаггүй байсныг гэрчилсэн нэгэн чухал үйл явдал түүний амьдралд тохиолдсон байдаг. Энэ бол тэр үед Египетэд сууж байсан Малик-эль-Камил Султантай уулзахын тулд хийсэн түүний аялал билээ. Францис өөрөө ядуу, түүнд олдсон хөрөнгө мөнгө бага, очих газар хол, аялах зам урт, хэл, соёл, шашны ялгаа их зэргээс шалтгаалаад ихээхэн хүнд аялал хийсэн байдаг. Загалмайтны дайны хүнд хэцүү үед хийсэн аялал нь хүн бүрийг халуун дотноор тэврэхийг зорьсон түүний хайр сэтгэл үнэхээр агуу байсныг нотолсон юм. Францисын Тэнгэрбурханд үнэнч байсан сэтгэл түүний ах дүү нараа хайрлаж байсан хайрын сэтгэлтэй адилхан байсан юм. Аливаа саад бэрхшээл, аюул заналаас үл айж, үл шантардаг байсан Францис Султантай уулзахаар алс холын замд гарахдаа “хэрэв та нар сарацинууд болон тэд нартай адилхан Тэнгэрбурханд үл итгэгчдийн дунд” орвол өөрсдийнхөө дүр төрхийг хадгалахын зэрэгцээ “аливаа хэрүүл маргаанд оролцолгүйгээр Тэнгэрбурханыхаа

төлөө хэн ч байсан түүнд захирагдах хэрэгтэй" [3] хэмээн шавь нартаа хандан айлдаж байсан сургаалаа өөрөө хатуу чанд баримталж явсан юм. Тэр цаг үеийг харгалзан бодвол түүний энэхүү сургаал үнэхээр ер бусын номлол байжээ. Одоогоос тэртээ найман зуун жилийн өмнө Гэгээн Францис аливаа дайсагнах, зөрчилдөхийн бүхий л хэлбэрийг тэвчиж, хүн өөрийнх нь итгэлийг хуваалцдаггүй өөр хүнд ах дүүгийн ёсоор, номхон байхын үлгэрийг үзүүлэн "захирагдах" нь зөв хэмээн сургадаг байсан байна.

4. Францис өөрийн номлолыг тулган хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор үгийн дайныг өдөөдөггүй байсан. Харин Тэрээр зүгээр л Тэнгэрбурханы хайрыг тараан түгээдэг байжээ. Тэрээр Тэнгэрбурхан бол их хайр сэтгэл, их хайр сэтгэлд оршиж байгаа хүн Тэнгэрбурханы ивээлд оршиж байна гэсэн үг" хэмээн ойлгодог байжээ *(1 Иохан 4:16)*. Ийм учир Тэрээр бүгдэд эцэг лүгээ адил хандаж, ах дүүгийн харилцаа холбоо бүхий нийгмийн дүр зургийг бүгдийнх нь санаа сэтгэлд тод томруун дүрслэгдэхээр төрүүлж чадсан байна. Нээрээн "бусдыг өөрийн амьдралын эргүүлэгт татан оруулахын тулд биш харин өөрсдийгөө нээн олж улам бүр бүрэн бүтэн болоход нь туслахын тулд хүмүүстэй ойр дотно харилцаа холбоо тогтоодог нэгнийг эцэг хэмээн нэрлэж болно" [4]. Тэр цаг үеийн ертөнцөд бараг алхам бүрт шовойх харуулын цамхаг, сүндэрлэх хамгаалалтын хана хэрмүүдийн дунд орших хот суурин газрууд эрх мэдэл булаацалдсан баян гэр бүлүүдийн хооронд эцэс төгсгөлгүй өрнөх зэрлэг балмад дайнуудын талбар болж, харин ядуурал, үгээгүй хоосон амьдрал хөдөөг бүхэлд нь нөмөрсөн байжээ. Францис болохоор зүрх сэтгэлээ нээн жинхэнэ амар амгаланг урьж, санаа

бодлоосоо бусдыг хүчирхийлэн дарахын хүслийг зайлуулж чадсан байна. Тэрээр өөрөө ядуучуудын нэг нь болж, бүгдтэй эв найртай амьдрахыг хүсдэг болсон байна. Францисын үлгэрлэлийн дагуу би иймхүү эдгээр хуудсыг бичиж байна.

5. Миний хувьд хүмүүсийн хоорондын ах дүүгийн харилцаа холбоо, нийгмийн найз нөхөрлөлийн харилцаа байнга санаа бодлыг минь өдөөж байдаг юм. Сүүлийн жилүүдэд би энэ тухай янз янзын газар байнга ярьж байгаа билээ. Энэхүү Түгмэл захидалдаа тэдгээр хэлсэн үгийг нэгтгэж, энэ чухал сэдвийн тухай арай өргөн хүрээнд эрэгцүүлэхийг зорьсон болно. Би "*Laudato Sí*" буюу "Таныг магтан дуулъя!" Түгмэл захидлыг бэлдэхдээ Тэнгэрбурханы хүчээр бий болсон хүмүүний амийг хайрлан хамгаалах шаардлагын тухай хүчтэй номлосон Ортодокс шашинтаны Тэргүүн Хамба Бартоломео ахаас онгодоо авсан бол энэ удаад миний бие Абу Дабид уулзсан Их Имам Ахмад Аль-Тайебын айлдсан үгэнд онцгой их урамшин зоригжсон юм. Тэрээр: "Тэнгэрбурхан бүх хүмүүсийг эрх, үүрэг, нэр хүндийн хувьд ижил тэгш бүтээсэн бөгөөд бүгдээрээ ах дүү лүгээ адил эв найртай амьдрахыг уриалсан юм" [5] гэсэн билээ. Энэ бол жирийн нэгэн дипломат ёсны дагуу хэлсэн үг биш, харин санаа бодлоо хуваалцсан, хамтын үүргээ ухамсарласнаас үүдэлтэйгээр үүссэн гүн гүнзгий эргэцүүллийн илэрхийлэл юм. Энэхүү Түгмэл захидалдаа бид хоёрын гарын үсэг зурсан Бичиг баримтад туссан томоохон сэдвүүдийн заримыг нь сонгон авч, хөгжүүлсэн болно. Түүнчлэн өөрийн санаа бодлыг тусгахаас гадна дэлхийн өнцөг булан бүрийн хувь хүн, хамт олноос хүлээн авсан олон олон захидал, бичиг баримт, санаа бодолтой танилцан тэдгээрээс шилж сонгон оруулсан билээ.

6. Дараах хуудаснуудад ах дүүгийн хайрын тухай бүрэн бүтэн сургаал багтсан хэмээн үзэх хэрэггүй, харин энэхүү хайр бүх дэлхийг багтаасан цар хүрээтэй бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүн бүрт нээлттэй гэдгийг харуулсан гэж хэлж болно. Би энэхүү нийгмийн чиг баримжаатай Түгмэл захидлаа та бүхэнд толилуулахдаа энэ сэдвээр тасралтгүй үргэлжилж буй эргэцүүлэлд даруухан хувь нэмрээ оруулахыг хичээсэн юм. Ингэснээр өнөөдөр хүмүүс бусдыгаа устгах, нэг нэгнийгээ үл тоох байдлаар хандаж байгаа цаг үед бид ах дүүгийн харилцаа холбоо, нийгмийн харилцааны тухай шинэ ухаарлыг бий болгож, тулгамдсан асуудлуудад улиг болсон үгийн явцуу хүрээнээс давсан бодитой хариу барьж чадна гэдгийг нотлох гэсэн юм. Хэдийгээр би энэхүү Түгмэл захидлыг миний зөн билгийн онгодыг өдөөж, итгэлийг бэхжүүлж байдаг Христийн шашны номлолын үүднээс бичсэн нь үнэн ч сайн санаат бүх хүмүүс хоорондоо харилцан санаа бодлоо хуваалцахыг урьсан эргэцүүлэл болгохыг хичээсэн болно.

7. Би энэхүү захидлыг бичиж байх яг тэр үед гэнэт Ковид-19 цар тахал дэгдэж, бидний аюулгүй байдал юутай хэврэг вэ? гэдгийг илчлэн харуулсан юм. Улс орон бүр өөр өөрийн аргаар хямралт байдалд хандсан нь ойлгомжтой ч хамгийн гол нь тэд ийм үед хоорондоо хамтран ажиллаж чаддаггүй нь бүхнээс тод харагдсан билээ. Бид хоорондоо гүн гүнзгий, нягт харилцаа холбоо тогтоосон байдаг ч биднийг бүгдийг нь хамарсан асуудлуудыг шийдвэрлэх гэж оролдохдоо дэндүү хуваагдмал байдаг нь нотлогдлоо. Хэрэв бид энэ бүхнээс тогтсон хэв маягийн дагуу хийж ирсэн ажлаа сайжруулах нь хангалттай юм байна, одоо байгаа тогтолцоо, зохицуулалтуудаа боловсронгуй

болговол болох юм байна гэсэн сургамжийг авлаа гэж үзэх юм бол үнэн хэрэгтээ өөрийгөө хуурч, бодит байдалд дүгнэлт хийж чадаагүйн илэрхийлэл болно.

8. Бидний амьдарч байгаа энэ цаг үед миний хүсэл хүмүүн бүр эрхэм чанартайг хүлээн зөвшөөрснөөр бүгд хоорондоо ахан дүүгийн харилцаа холбоо тогтоох эрмэлзлийг сэргээхэд оршино. Бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд ахан дүүс, эгч дүүсийн харилцаа холбоо тогтооно гэсэн үг. Бидэнд яаж мөрөөдөх вэ, яаж амьдралаа гайхамшигт адал явдал болгох вэ? гэдгийг заах нэгэн агуу нууц бий. Хэн ч байсан бусдаас тусгаар ганцаараа амьдарч чадахгүй... Та бидэнд биднийг дэмждэг, бидэнд тусалдаг хамт олон хэрэгтэй. Бид тэр хамт олонтойгоо хамт байж байхдаа нэг нэгэндээ урагшаа харахад нь тусалж чадна. Хамт мөрөөдөх нь үнэхээр чухал билээ... Бид бусдаас тусгаар ганцаараа байхдаа зэрэглээ харахаас цаашгүй, байхгүй хий юм хараад байдаг. Харин мөрөөдөл бол та бидний хамтдаа бүтээж байгаа бодит байдал мөн билээ" [6]. Тийм учир бүгдээрээ нэгэн гэр бүл мөн хэмээн бодож хамтдаа мөрөөдье, хоол ундаа хувааж аян замдаа хамт явж байгаа хүмүүс мөн хэмээн бодъё, та бидний хамтын гэр орон болох газар дэлхий дээрээ хамтдаа амьдарч байгаа хүүхдүүд мөн гэж бодъё, хүн бүр өөрийн итгэл үнэмшил, сүжиг бишрэлийн утга агуулгын баян тансагийг нэг нэгэнтэйгээ хуваалцъя, хүн бүр дуу хоолойгоо нийлүүлэн өргөе, бид бүгд нэг нэгэндээ ах дүүс, эгч дүүс мөн гэдгээ ойлгоцгооё.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

# ХААЛТТАЙ ЕРТӨНЦ ДЭЭР ХУРСАН ХАР ҮҮЛС

9. Би та бидний өдөр тутмын амьдралын тал бүрийг нарийн судалж, эцсийн хариу өгөхүйц дүгнэлт хийх гэж зүтгэхийн оронд манай өнөөдрийн ертөнцөд байгаа, бүхнийг хамарсан ахан дүүгийн харилцаа холбоог тогтоон хөгжүүлэхэд саад учруулж буй зарим чиг хандлагын талаар санаа бодлоо хуваалцъя гэж бодлоо.

## БҮТЭЛГҮЙТСЭН МӨРӨӨДӨЛ

10. Дэлхий ертөнц олон олон дайн дажин, сүйрэл гамшгаас томоохон сургамж авч хоорондоо янз янзын хэлбэрийн нарийн харилцаа холбоо тогтоох чиглэл рүү аажим аажмаар урагшилж байна хэмээн олон арван жилийн турш бодож байжээ. Тухайлбал, Нэгдсэн Европын тухай сайхан мөрөөдөл байна. Ийм Европ нийтлэг үндэс язгуураа хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ өөрсдийн нэг нэгнээсээ ялгарах баялаг онцлогоороо бахархан баясна. Бид “Европын Холбооны үндэслэгчид хагарал, хуваагдлыг арилгах, энэхүү тивийн бүх үндэстний хооронд энх тайвныг тогтоох, анд нөхдийн харилцааг бэхжүүлэхийн тулд хамтран ажиллах чадварт тулгуурласан ирээдүй байна хэмээн олж харсан юм” [7] хэмээн бодох ёстой.

Түүнчлэн саяхан хүртэл Латин Америкийг ойртуулан нягтруулах хүсэл эрмэлзэл улам бүр өсөн нэмэгдэх чиг хандлага байсан билээ. Энэ чиглэлд зарим алхам хийгдсэнийг тэмдэглэх нь зүйтэй. Зарим улс орон, зарим бүс нутгийн хувьд эвлэрэн найрамдах, эе эвийг тогтоох оролдлого сайн үр дүн авчирч, ихээхэн итгэл найдварыг төрүүлсэн билээ.

11. Гэвч та бидний амьдарч буй энэ цаг үед зарим талын ухралт гарч байгаа шинж тэмдэг харагдаж байна. Аль хэдийн мартагдсан гэж бодогдож байсан бүр эртний зөрчлүүд шинээр сэргэж, харалган, хэт туйлширсан, хонзогногч, түрэмгий, хэт үндсэрхэх үзэл энд тэнд толгойгоо өндийлгөж байгаагийн жишээ олон болж байна. Зарим улс оронд янз янзын үзэл суртлын нөлөөн дор буй болсон олон түмнийг хамарсан үндэсний нэгдлийн тухай ойлголтын улмаас амиа бодох үзлийн шинэ хэлбэрүүд үүсэж, үндэсний эрх ашгаа хамгаалж байгаа нэрийн дор нийгмийн эрүүл саруул ухаан алдагдаж байна. "Шинэ үе бүр өнгөрсөн үеүдийн хийсэн тэмцэл, хүрсэн амжилтыг үргэлжлүүлэн өөрсдийн хүрэх зорилго, алсын хараагаа илүү том болгох ёстой. Энэ бол тухайн үеийнхний туулах ёстой амьдралын зам мөр мөн. Сайн сайхан үйл хэрэг, хайрын сэтгэл, шударга ёс, эв нэгдэл бол бүгдээрээ нэг дор нэгэн зэрэг хүрчихдэг зорилго биш билээ. Харин тэдгээрт хүрэхийн тулд өдөр бүр хичээн зүтгэх ёстой. Өнгөрсөн үед хүрсэн амжилтдаа сэтгэл ханан өнөөдөр гараа хумхин жаргаж суух боломжгүй бөгөөд та бид ах дүү, эгч дүү нар маань бидний анхаарлыг өөрийн эрхгүй татах тийм хүнд хэцүү нөхцөлд амьдарч байгааг анзаарахгүй байх эрхгүй

билээ” [8] хэмээх мэргэн үгийг дахин эргэн санах нь зөв юм.

12. “Өөрийгөө дэлхийд нээх” гэсэн хэллэгийг гол нь эдийн засаг, санхүүгийн салбарынхан өргөн хэрэглэдэг бөгөөд өнөөдөр энэхүү хэллэгийн утга санаа явцуурч ихэнхдээ гадаадын ашиг сонирхлыг оруулж ирэхэд нээлттэй байх, эдийн засгийн хүчирхэг улс орон, аж ахуйн байгууллагууд дэлхийн бүх орнуудад ямар нэгэн саад бэрхшээл, хүндрэлгүйгээр хөрөнгө оруулах эрх чөлөөтэй байхын тухай ойлголтыг илэрхийлдэг болсон байна. Даяаршлагдсан эдийн засаг орон нутгийн шинжтэй зөрчлүүд, нийтийн сайн сайхан байдлыг үл хүндэтгэх чиг хандлагыг өөрийн эрх ашигт нийцүүлэн бүгдэд нэг загварын соёлыг тулгаж байна. Энэ соёл дэлхийг нэтгэж байгаа хэдий ч “нийгэм улам бүр даяаршлагдаж байгаа ч бидний хооронд ахан дүүгийн харилцаа холбоо тогтохгүй байгаа бөгөөд хөршүүд болохоос цаашгүй” гэсэн мэргэн үгийн дагуу хүмүүсийг болон үндэстнүүдийг нэг нэгнээс нь хөндийрүүлэн салгаж байна. Тооны олныг эрхэмлэдэг өнөөгийн дэлхий ертөнцөд хувь хүний ашиг сонирхол түлхүү дэмжигдэж, хүн ба хамт олны хоорондын нандин холбоо суларч буй учир бид улам бүр нэг нэгнээсээ холдож, хөндийрөн зожгирч ганц ганцаараа болж байна. Нээрээн зах зээлд хүмүүс улам бүр зөвхөн хэрэглэгчид, эсхүл хөндлөнгийн этгээдүүд болон хувирч байна. Ийм төрлийн даяаршил өөрсдийгөө хамгаалах чадвартай эрх дархтангуудын дүр төрхийг улам бүр тод томруун болгож, сул дорой, ядуу бүс нутгийн дүр төрхийг бүдгэрүүлж, улмаар тэднийг улам бүр эмзэг, бусдаас ихээхэн хараат, тэднээс бүр их шалтгаалдаг болгож байна. Ийм байдал цаашид үргэлжилбэл “хагалж хуваа, тэгээд эзэлж захир”

гэсэн зарчмын дагуу үйл ажиллагаа явуулдаг үндэстэн дамнасан эдийн засгийн хүчирхэг этгээдүүдийн өмнө улс төр улам бүр сулран дордож хэврэг шинж чанартай болж байна.

*Түүхэн ухамсрын төгсгөл*

13. Энэ бүхний эцэст түүхийн үйл явцын утга агуулга улам бүр алдагдаж, улмаар нурах, эвдрэх үйл явц эрч хүчээ авч байна. Нэг ёсны "задлан нураах" үйл явц өрнөж, өнөөгийн тогтсон соёлд хүний эрх чөлөө бүхнийг тэгээс эхлэн бүтээж чадна гэсэн бардамнал улам бүр газар авч байна. Энэхүү байдал эцсийн эцэст нэг л юм руу чиглэгдэж байгаа бөгөөд тэр нь хэмжээ хязгааргүй хэрэглээ, хов хоосон хувиа бодох үзэл юм. Би энэ бүхний талаар санаа сэтгэл зовж байгаа тул залуучуудад зөвлөгөө өгөх нь зөв гэж бодлоо. "Хэрэв хэн нэгэн хүн залуучуудад хандан түүхээ үл тоох, ахмад үеийн туршлагыг үгүйсгэх, өнгөрснийг дорд үзэх, зөвхөн өөрийнх нь дүрсэлж буй ирээдүй рүү тэмүүлэхийг зөвлөж байгаа бол тэр хүн ингэснээрээ залуучуудыг эрхшээлдээ оруулах, тэд нараар өөрийнх нь хэлсэн бүхнийг хийлгэх зорилго тавьжээ хэмээн ойлгож болно. Тэр хүн залуучууд дотроо хоосон хөндий байх, үндэс суурьгүй байх, үл итгэх үзэлд автсан байхыг хүсэх бөгөөд ийм нөхцөлд тэд гагцхүү өөрийнх нь амласанд үг дуугүй итгэн дагах, өөрийнх нь хий гэснийг хийх болно гэдгийг мэдэж байгаа биш үү. Яг ингэж бүх үзэл суртал ажилладаг гэж хэлж болно. Эхлээд тэд бүх ялгааг задлан арилгана, ингэснээр эцэст нь тэд аливаа эсэргүүцэлгүйгээр ноёрхоно. Гэхдээ ингэхийн тулд тэдэнд залуучууд хэрэгтэй, түүхийг сонирхдоггүй, өнгөрсөн үе үеийн үлдээсэн оюун ухааны болон хүмүүний баялгийг үгүйсгэн татгалздаг, өөрсдөөс нь өмнө болсон

юу ч байсан огт мэддэггүй залуучууд хэрэгтэй” [10].

14. Соёлын колончлолын шинэ шинэ хэлбэр бий болжээ. “Бусдыг дууриах хүсэлд автаж солиорсон, эсхүл хүчирхийлэл хийхийн тулд ухаанаа алдсан, эсхүл уучилшгүй хэнэггүй зантай болсон, туйлын идэвхгүй байдалд бүрэн автсан ард түмэн уламжлалаа гээдэг бөгөөд эцсийн эцэст тийм ард түмэн зүрх сэтгэлийн өвөрмөц дүр төрхөө алдаад зогсохгүй ёс суртахууны цул байдлаа гээж, ингэснээр оюун ухаан, эдийн засаг, улс төрийн тусгаар тогтнолоо бүрэн алддаг” [11] гэдгийг мартаж болохгүй. Түүхэн ухамсар, шүүмжлэлт сэтгэлгээ, шударга ёсыг тогтоохын төлөөх тэмцэл болон нэг нэгэндээ ойртон нягтрах үйл явцыг сулруулах хамгийн шилдэг арга бол агуу үгсийг ямар ч утга учиргүй болгох, эсхүл тэр үгсийг хүмүүсийн тархи толгойг эргүүлэхийн тулд ашиглахад оршино. Өнөөдөр ардчилал, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл гэх зэрэг үг яг ямар утга санааг илэрхийлж байгаа вэ? Эдгээр үгийн утга санааг мушгин гуйвуулж захиран дарангуйлахын зэвсэг болгон ашиглахад тохируулан өөрчилсөн байна. Тодруулбал ямар ч үйлдлийг зөвтгөхөд тохирсон утга санаагүй үгс болгосон байна.

## БҮХ ХҮНД ЗОРИУЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА

15. Хүмүүсийг захирах, тэднийг хяналтдаа байлгах хамгийн шилдэг арга бол зарим үнэт зүйлийг хамгаалж байгаа нэрийдлээр тэднийг цөхрөнгөө барсан байдалд оруулах, тэдний зүрх зоригийг мохоох явдал мөн билээ. Өнөөдөр олон улс оронд аливааг хэтрүүлэн ярих, туйлшрах, хэт түрэмгий байх зэрэг нь улс төрийн зорилгод хүрэх зэр

зэвсэг болсон байна. Бүхнийг дооглон доромжлох, хардан сэрдэх, үндэслэлгүй шүүмжлэх зэрэг стратегийг баримтлан ашиглаж, янз янзын арга хэрэглэж бусад хүний амьд явах, эсхүл өөрийн санаа бодолтой байх эрхийг үгүйсгэж байна. Бусад хүн үнэний нэг хэсэг мөн, тэд өөрийн үнэт зүйлстэй гэдгийг үгүйсгэж, ингэснээр нийгмийн амьдрал бүхэлдээ ядууран хоосорч, эрхтэн дархтангуудын эрхшээлд орно. Улс төрийн үйл ажиллагаа нийтийн сайн сайханд хүрэх, хүмүүсийн амьдралыг сайжруулахын тулд хэрэгжүүлэх урт хугацааны төлөвлөгөөний талаар эрүүл саруул мэтгэлцээн орнүүлэх тухай байхаа больж, харин бүхнийг зарж борлуулахад чиглэгдсэн бохир аргыг ашиглан бусдыг гутаан доромжлох зорилготой болсон байна. Ийнхүү нэг нэгнийгээ ээлжлэн буруутгах арчаагүй хулчгар дайралтууд мэтгэлцээнийг нэг нэгэнтэйгээ хэзээ ч санал үл нийлэх байнгын зөрчил мөргөлдөөн болон хувиргасан байна.

16. Өрсөлдөгчөө бүрмөсөн устгах нь ялахын нэр мөн хэмээн ойлгосон хоорондоо зөрчилтэй ашиг сонирхлуудын хэврэг торон сүлжээнд баригдсан нөхцөлд бидэнд хөршүүдээ олж харах, хүлээн зөвшөөрөх, амьдралын замын нугачаанд бүдрэн унасан нэгэндээ туслах сэтгэл төрүүлэх хараа байхгүй болсон байна. Өнөөдөр бүх хүн төрөлхтний том гэр бүлийг бүхэлд нь хөгжүүлэхийн тулд дэвшүүлэх агуу зорилгууд бүхий төлөвлөгөөний тухай ярьвал солиорсон юм шиг хүлээн авч байна. Бид нэг нэгнээсээ улам бүр алслагдан холдсоор байна, илүү шударга, илүү ойр дотно холбоотой ертөнц рүү удаан ч гэсэн зайлшгүй хөл нийлүүлэн алхах хүсэл эрмэлзэл дахин дахин харамсалтайгаар нуран унаж байна.

17. Та бид хамтдаа амьдарч байгаа энэхүү дэлхийн тухай санаа зовно гэдэг бол өөрсдийнхөө төлөө санаа зовно гэсэн үг юм. Тийм ээ, та бид өөрсдийнхөө тухай нэг гэрт хамтдаа амьдарч байгаа нэг гэр бүл мөн хэмээн улам бүр хүчтэй бодох шаардлагатай болжээ. Богино хугацаанд ашиг олохын төлөө улайрч байгаа эдийн засгийн хүчирхэг этгээдүүдэд ийнхүү бусдын төлөө санаа зовох сонирхол байхгүй байгаа нь ойлгомжтой. Байгал орчныг хайрлан хамгаалах тухай өргөсөн дуу хоолойг нэг бол юу ч сонсоогүй юм шиг чимээгүй болгоно, эсхүл дооглон шоглох маягаар гутаана. Ингэхдээ өнгөцхөн харахад үндэслэлтэй тайлбар хэлнэ, харин ухаад үзвэл тэр тайлбар тусгай ашиг сонирхлыг халхавчилж байгаа нь тодорхой болно. Та бидний бий болгосон дотроо хоосон хөндий, хаpалган, хамтын алсын хараа байхгүй соёлд “зарим түүхий эд шавхагдан дууссаны дараа сайн сайхан зорилгыг тунхаглах нэрийдлээр үнэн хэрэгтээ дахин шинэ дайн өдөөн эхлүүлэх талбар бэлтгэгдэнэ гэдгийг урьдчилан таамаглаж хэлэхэд хэцүү биш” [12] билээ.

*“Хаягдсан” ертөнц*

18. Манай хүн төрөлхтний гэр бүлийн нэг хэсэг нь бусад хэсгийн ашиг сонирхлын золиос болон орхигдож байгаа, тэднийг харж хандалгүй зөнд нь орхих нь зөв гэж үзэж буй дүр зураг улам бүр тод томруун харагдаж байна. Ингэснээр эцсийн эцэст “хүмүүс бол дээд зэргийн үнэ цэнтэй, тэднийг, ялангуяа ядуусыг болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг халамжлах, хүндэтгэх ёстой хэмээн үзэх үзэл мөхөж байгаа бололтой, хүмүүсийг үзэхдээ хараахан төрөөгүйчүүдийг “ашиг болох болоогүй”, эсхүл хөгшчүүлийг “ашиг болохоосоо өнгөрсөн” гэж тооцдогтой

адил үзэх болсон байна". Та бид аливаа үрэлгэн байдлыг анхаарахаа больсон байна, ялангуяа хоол хүнсний үрэлгэн байдлыг тоохоо больсон нь үнэхээр харамсалтай [13].

19. Төрөлтийн тоо буурч байгаа, хүн амын хөгшрөлт нэмэгдэж буй, ахмадуудаа гунигтай, ганцаардмал байдалд орхиж байгаа зэргээс харахад бүх юмны учир та бидэнд өөрсдөд нь байна гэж дүгнэхээс өөр аргагүй болж байна, энэ бүхэн бид зөвхөн хар амиа бодож амьдардаг болсныг нотолж байна. Ингэснээр "хоол хүнс болон бусад эд зүйлийг хаяад зогсохгүй бүр амьд хүмүүсийг хүртэл хог лугаа адил хаядаг болсон" [14] байна. Та бид коронавирусын улмаас манай гараг дэлхийн зарим газар ахмадуудтай юу тохиолдсоныг харсан билээ. Тэд нар маань тийм эмгэнэлтэй байдлаар энэ хорвоог орхин одох ёсгүй байсан юм. Өмнө нь мөн адил хэт халуун болоход, бусад хүнд хэцүү нөхцөлд үүнтэй адилхан юм болж байсан билээ: ахмадуудаа хамгийн хайнга байдлаар мартан орхиж байсан. Та бид ахмадуудаа өөрсдөөсөө холдуулж, гэр бүлийн гишүүдийнх нь дэргэд тэдний хайр асрамжид байлгахын оронд өөр газар тусгаарлаж, өөрсдөд нь хамаагүй хүмүүсийн асрамжид шилжүүлснээр гэр бүл хэмээх нэгжийг эвдэн бусниулсныгаа ухаараагүй байна. Та бид залуучуудыг өөрсдийнх нь үндэс язгуур болсон удам судраас нь, өөрсдөө бие даан зүтгээд хүрч чадахгүй тэр мэргэн ухаанаас хөндийрүүлэн салгаж байна.

20. Ийнхүү бусдыг хог мэт хаях үйл явц янз янзын хэлбэрээр өрнөж байна. Тухайлбал, хөдөлмөрийн хөлсийг бууруулах гэж улайран зүтгэхдээ ингэснээр ажилгүйдлийг нэмэгдүүлнэ, ядуурлыг өргөжүүлнэ гэсэн муу үр дагавар гарахыг огт тооцохгүй байна [15]. Цаашилбал бусдыг хог

мэт үзэн хаяхад бэлэн байгаа хандлага нь та бидний хувьд аль хэдийн алга болсон хэмээн үзэж байсан үзэл сэргэснээр илэрч байна. Энэ бол арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл бөгөөд алга болсон хэмээн бодож байсан энэхүү буруу үзэл дахин амилан сэргэж байна. Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл та бидний жигшил зэвүүцлийг төрүүлэх ёстой. Энэ буруу үзэл нийгмийн хөгжил дэвшил та бидний бодож байсанчлан тийм бодитой, бас тодорхой болж чадаагүйг нотлон харуулж байна.

21. Зарим эдийн засгийн хууль тодорхой өсөлтийг бий болгосон нь үнэн ч хүмүүний цогц хөгжлийг бий болгож чадаагүй [16]. Баялаг нэмэгдсэн нь үнэн, гэхдээ тэгш бус байдал нэмэгдсэн нь бас үнэн. Үр дүнд нь “ядуурлын шинэ шинэ хэлбэр бий болсон” [17] байна. Орчин үеийн дэлхий ертөнцөд ядуурал буурсан хэмээх дүгнэлт өнөөдрийн бодит байдалд таарч тохирохгүй хуучин, хоцрогдсон шалгууруудад тулгуурласан байна. Тухайлбал, өөр цаг үед эрчим хүчний эх үүсвэрт холбогдоогүй байсныг ядуурлын шинж тэмдэг, хүнд хэцүү амьдралын учир шалтгаан мөн хэмээн тооцдоггүй байсан байна. Ядуурлыг бодитойгоор ойлгох, хэмжихийн тулд тухайн түүхэн цаг үед олгогдох ёстой боломж бололцооны хэмжээ хүрээгээр тооцох ёстой юм.

*Бүрэн түгээмэл болоогүй хүний эрх*

22. Хүний эрх бүгдэд ижил тэгш хангагдахгүй байгаа нь олон жишээн дээр харагдаж байна. Уг нь эдгээр эрхийг хүндэтгэх нь “тухайн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн урьдчилгаа нөхцөл мөн билээ. Хүний эрхэм чанарыг хүндэтгэж байгаа, эрэгтэй, эмэгтэй хүний аль

алиных нь эрхийг ижил тэгш хүлээн зөвшөөрч, баталгаатай хангаж байгаа нөхцөлд хүмүүсийн хоорондын харилцаа холбоо хөгжиж, бүтээлч чанар ундарч, хүмүүний авьяас чадвар нээгдэн дэлгэрч бүтээлч үйлдэл болж нийтийн сайн сайхныг нэмэгдүүлнэ” [18]. Гэтэл “та бидний амьдарч байгаа орчин үеийн нийгмүүдийг ойрхноос сайтар ажиглавал олон олон зөрчил харагдах бөгөөд та бид өөрийн эрхгүй одоогоос далаад жилийн өмнө ёслол төгөлдөр зарлан тунхагласан бүх хүмүүсийн ижил тэгш эрхэм чанарыг бүхий л нөхцөлд үнэхээр хүлээн зөвшөөрч, хүндэтгэж, баталгаатай хангаж, дэмжиж байна уу, үгүй юу? хэмээн дуу алдахад хүрч байна. Өнөөдрийн ертөнцөд шударга бус явдлын олон олон хэлбэр байгаа бөгөөд тэд хэт хялбаршуулан гуйвуулсан антропологийн үзэл болон хүнийг заран мөлжих, хог мэт үзэн хаях, тэр байтугай алахаас буцдаггүй зөвхөн ашиг хонжоо хөөцөлдсөн эдийн засгийн загвараас тэтгэгдэн тэжээгдэж амь бөх оршиж байна” [19]. Энэ бүхэн хүний заяагдмал эрхэм чанарт үндэслэн тулгуурласан ижил тэгш эрхийн талаар та бидэнд юу өгүүлж байна вэ?

23. Үүний нэгэн адил даян дэлхийн янз янзын нийгмүүдийн зохион байгуулалтыг харвал тэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил ижил тэгш эрхэм чанартай гэдгийг эргэцүүлж эхлээ ч үгүй байгаа нь ойлгогдож байна. Та бид ярихдаа нэг юм хэлнэ, харин бидний гаргасан шийдвэр, бодит байдал ярьж хэлснээс огт өөр байгаа билээ. Нээрээн “бүхнээс хасагдсан, буруу хандлага болон зэрлэг балмад ааш араншингийн золиос болсон эмэгтэйчүүд өөрсдийнхөө эрхийг хамгаалах боломж бололцоогоор бусдаас дутуу байдаг учир тэд илүү ядуу зүдүү амьдарч байна” [20] гэж хэлэх хэрэгтэй.

24. Та бид "хэдийгээр олон улсын хамтын нийгэмлэг бүх хэлбэрийн боолчлолыг устгахад чиглэгдсэн олон гэрээ, хэлэлцээр байгуулж, энэхүү үзэгдэлтэй тэмцэхийн тулд янз бүрийн стратегийн бичиг баримтыг гаргасан боловч өнөөдөр хүүхдүүд, янз бүрийн насны эмэгтэй, эрэгтэй хүмүүс буюу сая сая хүмүүс эрх чөлөөгөө эдэлж чадахгүй, аргагүй байдлын улмаас боолын нөхцөлд амьдарч байна гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй... Өнгөрсөнтэй нэгэн адил өнөөдөр ч эмэгтэй, эрэгтэй байхаас үл шалтгаалан хувь хүнийг объект хэмээн ойлгодгоос болоод боолчлол оршсон хэвээр байна... Дүр төрхөөсөө авахуулаад бүхий л байдлаараа Тэнгэрбурхан лугаа адил бүтээгдсэн хүмүүнийг хүчээр тулган аргагүй байдалд оруулах замаар, хууран мэхэлж, эсхүл бие бялдарт нь халдах, сэтгэл санаанд нь нөлөөлөх зэрэг хүчирхийллийн аргаар эрх чөлөөгөө эдлэх боломжгүй болгож, түүнийг бусдын өмч хөрөнгө мэт үзэн худалдаж, үнэ цэнийг нь бууруулж байна. Хүмүүсийг зөвхөн зорилгодоо хүрэхийн тулд ашигладаг хэрэгсэл болгож байна... [Гэмт бүлэглэлтэй холбоотой сүлжээнүүд] орчин үеийн харилцаа холбооны хэрэгслийг чадамгай ашиглан ертөнцийн янз бүрийн өнцөг буланд амьдарч байгаа залуучууд болон эмэгтэйчүүдийг өөрсөддөө татан урвуулж байна" [21]. Аливаа хэвийн хэм хэмжээг эвдэж давсан арга хэлбэрээр эмэгтэй хүнийг эрхэндээ оруулан элдвээр эдэлснийхээ дараа түүнийг хүчээр тулган аборт хийлгүүлж байна. Хүмүүсийг хулгайлж, эцэст нь тэдний эрхтнийг зарж байгаа нь үнэхээр дээд зэргийн жигшил зэвүүцэл төрүүлэхээс өөр аргагүй. Хүмүүсийг хулгайлан зарах болон тэднийг орчин үеийн боол болгож байгаа аливаа арга хэлбэр нь өнөөдрийн ертөнцийг тэр чигээр нь хамарсан том асуудал мөн бөгөөд хүн төрөлхтөн бүхэлдээ

энэхүү асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. "Гэмт бүлэглэлийн байгууллагууд өөрсдийн зорилгод хүрэхийн тулд бүх дэлхийг хамарсан сүлжээг ашиглаж байгаа учир энэхүү муухай үзэгдлийг устган арилгахын тулд нийгмийн бүхий л салбаруудын хамтын ажиллагаа, хамтын зүтгэл яахын аргагүй шаардагдаж байна" [22].

*Мөргөлдөөн ба айдас*

25. Дайн дажин, террорист халдлагууд, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл болон шашны туйлширсан үзлээс үүдэлтэй алан хядах ажиллагаа зэрэг хүний эрхэм чанарын эсрэг чиглэгдсэн дайралтуудыг өөр өөрөөр шүүж байгаа нь тэдэнд зарим ашиг сонирхол, ялангуяа эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс хандаж байгаатай шууд холбоотой. Эрх дархтай хүнд таатламжтай байгаа цагт үнэн үнэнээрээ байна, харин түүнд таатламжтай биш болмогц үнэн гэнэт үнэн биш болно. Харамсалтай нь ийм харгис түрэмгий байдлыг "хэвийн юм шиг хүлээн авдаг болсон бөгөөд энэ нь олон хэсэгт хуваагдсан "дэлхийн гуравдугаар дайн" [23] өрнөсөн лүгээ адил нөхцөлийг бүрдүүлсэн байна.

26. Гэхдээ энэ байдалд гайхаш алдах хэрэггүй. Харин та бид биднийг хооронд нь холбож байдаг хамтын зорилгогүй болсныгоо ухаарах хэрэгтэй байна. Нээрээн "хүмүүний гэр бүлийг бат бэх холбож байдаг ах дүүгийн харилцааны холбоо" дайн болгоны хамгийн эхний золиос болдог билээ. Ингэснээр "аливаа аюул занал учрахад үл итгэх байдал өргөжин гүнзгийрч, хүмүүс аюулгүй байдлаа бодож өөрсдийгөө бусдаас тусгаарлана" [24]. Та бидний

амьдарч байгаа ертөнц “айдас болон үл итгэх байдлаас тэжээгдэж буй хуурамч аюулгүй байдлаар дамжин тогтвортой байдал, энх тайван”-ыг [25] тогтоож болно гэсэн хоорондоо зөрчилтэй ойлголтын хайчинд орсон байна.

27. Хачирхалтай нь та бид өвөг дээдсээсээ өвлөж авсан хэдэн айдастай явдаг бөгөөд технологийн дэвшил хүртэл тэдгээрийг арилгаж чадаагүй байна Нээрээн тэдгээр айдас шинэ технологийн ард нуугдсан хэвээр хадгалагдан үлдэж, тэр ч байтугай улам өргөжин тэлж газар авч байна. Өнөөдөр ч гэсэн мөн адил эртний хотын хана хэрмийн гадна талд эмх замбараагүй байдал ноёрхсон хэвээр байна, тэнд үл мэдэх газар нутаг байна, тэнд зэрлэг онгон нутаг байна. Тэндээс ирж буй юу ч байсан бидний таньж мэдээгүй, ижил дасал болоогүй, бидний суурин газрын нэг хэсэг биш юм болохоор түүнд хэрхэвч итгэж болохгүй. Тэр газар нутаг бол “зэрлэгүүд”-ийн нутаг, та бид тэднээс ямар ч үнэ цэнээр хамаагүй өөрсдийгөө тусгаарлан хамгаалах ёстой. Ингэж бодсоны үр дүнд өөрсдийгөө хамгаалахын тулд шинэ хана хэрэм босгоно, бидний хувьд хана хэрмийн цаадах дэлхий ертөнц алга болно, эцэст нь зөвхөн “та бидний” хэмээх жижиг ертөнц үлдэнэ. Ингэсээр тэр ертөнцөд та бидэнтэй адил төрөлхийн эрхэм чанартай хүмүүс амьдардаг гэсэн ойлголт устан алга болж, тэнд “тэд нар” байна гэсэн бодол бат бэх тогтоно. Ингээд та бид урьд өмнөхтэйгээ адил дахин “хана хэрэм барьж босгох соёлдоо хөтлөгдөнө, явсаар энэ соёл та бидний хүсэл тэмүүлэл болж, та бид зүрх сэтгэлдээ хана хэрэм босгоно, газар дээрээ хана хэрэм босгоно, өөр соёл, өөр хүмүүсээс өөрсдийгөө хана хэрмээр тусгаарлана. Хана хэрэм босгож байгаа хүмүүс өөрсдийнхөө барьж босгосон

хана хэрмэндээ хоригдсон боолууд болж хувирна. Тэд бусадтай харилцан нэг нэгнийгээ баяжуулан хөгжүүлэх үйл явцаас татгалзан өөрсдийн явцуу ертөнцөд зожигрон суух учир тэдэнд алсын хараа байхгүй болно" [26].

28. Төр засгийн тогтолцооны гадна хаягдсан хүмүүсийн ганцаардал, айдас, ямар ч баталгаагүй аюулгүй байдал нь зүсэн бүрийн "мафи" бий болох шимт хөрс болж байна. Эдгээр "мафи" өөрсдийгөө мартагдсануудын хамгаалагчид хэмээн зарлаж, хэдийгээр өөрсдийн гэмт ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхийн төлөө зүтгэж байгаа ч тэдгээр мартагдсануудад янз янзын хэлбэрээр тусалж байгаа учир өргөжин цэцэглэж байна. Түүнчлэн жинхэнэ "мафи"-ийн мэх хэрэглэж хүмүүсийг тэд хоорондоо харилцаа холбоотой болсон нь цаанаа учиртай хэмээн хуурч, ингэснээр сүүлд нь "мафи"-ас салах боломжгүй болгодог хамаарлын хүлээсээр хүлж бүрэн эрхшээлдээ оруулдаг байна.

## ХАМТ ЗАМНАХ ТӨЛӨВЛӨГӨӨГҮЙ ДАЯАРШИЛ БА ДЭВШИЛ

29. Их Имам Ахмад Аль-Тайеб бид нар шинжлэх ухаан, технологи, аж үйлдвэр, нийгмийн халамж зэрэг салбарт, ялангуяа хөгжилтэй орнуудад эерэг дэвшил гарсныг үгүйсгээгүй юм. Гэхдээ "бид үнэхээр агуу, үнэ цэнэтэй хэмээн тооцогддог энэхүү түүхэн дэвшлийн зэрэгцээ олон улсын үйл ажиллагаанд нөлөөлсөн, оюун ухааны үнэ цэнийг болон хариуцлагыг сулруулсан ёс суртахууны доройтол оршсон хэвээр байна. Энэхүү байдал олон хүн сэтгэл санаагаар унах, өөрийгөө бусдаас тусгаарлан зожигрох, цөхрөлд автахад нь ихээхэн нөлөөлж байна

гэдгийг онцлон тэмдэглэж байгаа юм". Та бид "ойлгомжгүй байдал, сэтгэлээр унах, ирээдүйгээс айх явдал газар авсан, явцуу эдийн засгийн ашиг сонирхолд хөтлөгдсөн өнөөгийн ерөнхий нөхцөлд олон улсын байдал хурцдах, зэвсэглэлээр хөөцөлдөх явдал идэвхжих"-ийг харж байна. Түүнчлэн бид "улс төрийн томоохон хямрал дэгдэж, шударга бус явдал тохиолдож, байгалийн баялгийг тэгш бус хуваарилж байгааг тэмдэглэх ёстой... Ядуурал, өлсгөлөнгийн улмаас ядарч зутарсан сая сая хүүхдүүдийг үхэлд хүргэсэн ийм хямрал болж байхад олон улсын түвшинд дув дуугүй байж байгаатай эвлэрч болохгүйг хэлэх хэрэгтэй" [27]. Хэдийгээр явцуухан харвал үгүйсгэж болохгүй хөгжил дэвшил байгаа ч том зургаар нь харвал ийм нөхцөл байдал та биднийг хүмүүнлэг ирээдүй угтан хүлээж байгаа гэдгийг хэрхэвч нотолж чадахгүй ээ.

30. Өнөөгийн ертөнцөд бүгдээрээ хүн төрөлхтний нэгэн том гэр бүлд хамаатай гэсэн мэдрэмж суларч, шударга ёс болон энх тайвны төлөө хамтдаа зүтгэх тухай тэмүүлэл хий хоосон, хоцрогдсон мөрөөдөл юм шиг санагддаг болсон байна. Харин түүний оронд би хүчтэй хэмээн өөрийгөө хуурсан, гэхдээ бид бүгдээрээ нэг усан онгоцонд хамт суусан байгаагаа ойлгоогүй хуурамч үзлийн цаана нуугдсан, юунд ч итгэхээ больсон сэтгэлийн хямралаас үүдэлтэй хүйтэн цэвдэг, зөвхөн өөрийн тав тухыг бодсон, даяаршлагдсан хайхрамжгүй, хэнэггүй байдал газар авсан байна. Ийм хуурамч үзэл ахан дүүгийн харилцаа холбооны агуу үнэ цэнийг ухаардаггүй бөгөөд харин ч "юунд ч үл итгэх сэтгэлийг бий болгодог. Сэтгэл санаагаар унах, аливаад итгэхээ болих замаар замнавал эцэстээ ийм үр дүнд хүрнэ... Өөрийгөө бусдаас тусгаарлан зожигрох, зөвхөн өөрийн явцуу эрх ашгийн хойноос хөөцөлдөх

замаар замнавал итгэл сэргэхгүй, өөрийгөө шинэчилж чадахгүй. Харин энэ бүх сөрөг юмны эсрэг байр суурийг баримтлах нь зөв юм. Хөндийрөх биш ойртох, дайжих биш учрах хэрэгтэй. Зожигроход "үгүй" гэж хэлье. Ойртон дотносоход "за" гэж хэлье. Мөргөлдөх, зөрчилдөхийг номлосон соёлд "үгүй" гэж хэлье, уулзах, учрахыг эрхэмлэсэн соёлд "за" гэж хэлье" [28].

31. Та бид нэг нэгэнтэйгээ уралдан урагшаа тэмүүлэн зүтгэх боловч хамтдаа явах замын зураггүй өнөөгийн ертөнцөд "гагцхүү өөрийн сайн сайханд санаа зовсон аминч үзэл болон хүн төрөлхтний том гэр бүлийн хөгжил дэвшлийн төлөө санаа тавих үзэл хоёрын хоорондох зай завсар өргөжин гүнзгийрсээр амиа бодсон хувь хүмүүс ба нийт хүн төрөлхтний том гэр бүлийн хоорондох хөлгүй ангал болон хувирч байна... Аргагүй байдалд орж хамт амьдрах бол нэг хэрэг, харин хамтын амьдралын баялаг бөгөөд сайхан үрийн үнэ цэнийг мэдрэх гэдэг бол огт өөр зүйрлэшгүй сайхан мэдрэмж мөн билээ. Чухамхүү ийм үрийг олох гэж хөөцөлдөх, ийм үрийг тарьж ургуулахын төлөө зүтгэх нь нэн чухал юм" [29]. Технологи байнга шинэчлэгдэн хөгжиж байна. Гэхдээ "шинжлэх ухаан, технологийн дэвшил илүү ижил тэгш байдал бий болгох, нийгмийн оролцоог илүү нэмэгдүүлэх сайн үр дүн авчирвал ямар гайхамшигтай бэ. Алс хол анивчих од гаригийг нээхийн сацуу та биднийг тойрон амьдарч байгаа ах дүүгийнхээ хэрэгцээ шаардлагыг шинээр нээвэл ямар гайхамшигтай сайхан бэ" [30].

32. Нээрээн Ковид-19 цар тахал хэмээх аймшигт гай гамшиг та бид нэг дэлхийн нэг хамт олон мөн, бид бүгд нэг усанд онгоцонд суусан байгаа, өнөөдөр нэг хүний тулгамдсан асуудал бид бүгдийн тулгамдсан асуудал мөн гэсэн ухаарлыг богино цаг хугацаанд өгсөн. Бид ганцаараа амь мултарна гэж байхгүй, аврагдвал бүгд хамт аврагдана гэдгийг дахин ухаарсан. Би тэр аймшигт өдрүүдэд: "Энэ салхи шуурга бидний туйлын эмзэг байдлыг нээн харууллаа, бид зарим буруу юмыг мэдээжийн юм хэмээн ойлгон итгэж, тэдгээрт тулгуурлан өөрсдийн өдөр тутмын амьдрал, төсөл, зорилго, дадал дасал болсон зүйлс, ач холбогдолтой хэмээн эрэмбэлсэн юмсаа зохион төлөвлөдгийгөө ухаарсан... Та бид бусдад харагдахгүйн тулд өөрсдийн "би" гэсэн бардамналаа ард нь нууж байдаг тэр нүүрэн хэсэг болсон буруу ойлголтууд энэхүү шуурганд тэсэлгүй нуран унаж, бид нэг нэгэнтэйгээ амьд холбоотой, бид нэг нэгнийхээ ах, эгч, дүүс мөн хэмээн дахин ухаарах боломж олгож, энэхүү ухаарал нэг талаас зайлшгүй байсан, нөгөө талаас Тэнгэрбурхны адислал байсан юм" [31] гэж хэлсэн.

33. Энэ дэлхий технологийн дэвшлийн ачаар "хүний хүчин зүйлийн сул тал"-ыг багасгаж чадах эдийн засагтай болох гэж тууштай зүтгэсэн. Түүнчлэн чөлөөт зах зээл бүх юмыг аюулгүй байлгах нөхцөлийг өөрөө бүрэн хангаж чадна гэдэгт итгэдэг хүмүүс байсан. Гэвч хянаж зогсоох ямар ч боломжгүй түрэмгий цар тахлын харгис, урьдчилан таамаглах аргагүй хүнд цохилтууд та бид цөөн тооны хүний сайн сайхны төлөө биш харин хүн бүрийн, нийт хүмүүсийн төлөө сэтгэл санаагаа тавих ёстой гэсэн

ухаарлыг яахын аргагүй сэргээсэн. Өнөөдөр та бид нэг зүйлийг хүлээн зөвшөөрөх ёстой. Тодруулбал “бид элбэг дэлбэг, баян тансаг байхын төлөөх хүсэл мөрөөдлөөр сэтгэлээ зогоон цатгаж, эцэстээ юм юм руу үсчих, өөрсдөө бусдаас тусгаарлан зожигрох, ганцаардахын өлсгөлөнд нэрвэгдэж байна. Бид нийтийн сүлжээнд холбогдох гэж зүтгэж зүтгээд эцэстээ ахан дүүгийн харилцаа холбооны амтыг мартсан байна. Бид хурдан, баталгаатай үр дүнд хүрэх гэж тэмүүлээд эцэстээ байнга яарсан, санаа сэтгэл зовсон хүмүүс болж хувирсан байна. Бид виртуал байдлын хоригдлууд болж жинхэнэ бодит байдлын амт, үнэрийг мартсан байна” [32] гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой болжээ.

34. Хэрэв бүх юм хоорондоо холбоотой нь үнэн юм бол дэлхийг хамарсан энэхүү гай гамшиг бидний бодит байдалд хандаж байгаа байдалтай, бидний өөрсдийн болон бүх юмны амьдралын эзэн мөн гэсэн бардамналтай огт холбоогүй хэмээн үзэх ямар ч боломжгүй. Би Тэнгэрбурханы гэсгээл ирнэ гэж хэлэхийг хүсэхгүй байна, бид байгал орчноо бохирдуулсныхаа төлөө эргээд гэсгээгдэнэ гэж хэлэх нь хангалттай биш. Дэлхий ертөнц өөрөө энэ бүх байдлыг эсэргүүцэн уйлж байна. Бид яруу найрагч Виргилийн “эд юмсын нулимс” буюу амьдрал, түүхийн золгүй явдлуудын тухай өгүүлсэн алдарт шүлгийн мөрийг [33] эргэн санахаас өөр аргагүй байдалд байна.

35. Та бид “амьдралын багш” [34] болсон түүхийн сургамжийг хэтэрхий хурдан мартаж байна. Энэхүү эрүүл мэндтэй холбоотой хямрал дуусмагц бид нөгөө эд барааны хойноос улайран хөөцөлдөж, амиа бодсон, өөрийгөө хамгаалж зөвтгөсөн нүхэндээ буцаж орвол

хамгийн том алдаа болно. Тэнгэрбурханы тусын дагуу энэ бүхэн өнгөрсний дараа бид дахин “тэднийг”, “тэд нар” хэмээн бодохоо больж харин гагцхүү “бид” гэж боддог болох хэрэгтэй. Энэ гай гамшиг та бидний хувьд хүмүүсийн ямар ч сургамж аваагүй түүхийн дахин нэгэн эмгэнэлт явдал биш байгаасай. Бид жилийн жилд эрүүл мэндийн тогтолцоог сулруулан нураасны уршгаар бий болсон амьсгал дэмжих тоног төхөөрөмжийн дутагдлаас болоод нас барсан ахмадуудыг яагаад ч мартаж болохгүй. Энэхүү их уй гашуу ямар ч сургамжгүй бүү өнгөрөөсэй, харин бидэнд амьдралын шинэ хэв маяг руу нэг алхам хийх ёстойг ухааруулаасай. Бидэнд бид бүгдээрээ нэг нэгэндээ хэрэгтэй гэдгийг дахин мэдрүүлээсэй, гагцхүү ийм замаар замнавал нэгэн том гэр бүл болсон хүн төрөлхтөн өөрсдийн босгосон хана хэрмийг нурааж, олон нүүр царай, олон дуу хоолой, олон хэлбэртэйгээр дахин шинээр мэндэлж чадна.

36. Та биднийг төөрөгдүүлэн буруу зүг рүү залан чиглүүлж байсан даяаршлын үзэл арилан алга болж, олон олон хүнийг хоосон хөндий орон зай, санаа сэтгэлийн байнгын түгшүүртэй байдалд оруулах тул та бид бидний цаг үе, эрч хүч, нөөц бололцоонд үгүйлэгдэн шаардагдаж байгаа нэг нэгэнтэйгээ ойр дотно байх, нэг нэгэнтэйгээ эв санааны нэгдэлтэй байх хамт олныг бүрдүүлэн бүтээх хамтын хүсэл тэмүүллийг сэргээж чадах ёстой юм. “Цөөн тооны хүний бэл бэнчин нь хүрэх хэрэглээг шүтсэн, тийм хэрэглээнд хөтлөгдсөн амьдралын хэв маягт зүрх сэтгэлээ өгч, тархи толгойгоо мэдүүлбэл энэ нь эцэстээ харгис хатуу үйлдэл, харилцан нэг нэгнийгээ устгах үйл ажиллагаа руу хөтлөн аваачна” [35] гэдгийг улайм цайм үгүйсгээд зогсож байх хэмжээний гэнэн нэгэн байж болохгүй. “Хүн

бүр гагцхүү өөрийнхөө төлөө" гэсэн ойлголт тун удалгүй эмх замбараагүй байдалд хүргэх бөгөөд ингэснээр цар тахлаас илүү хор хөнөөл учруулна.

## ХҮНИЙ ЭРХЭМ ЧАНАР ХИЛ ДЭЭР АЛГА БОЛЖ БАЙНА

37. Зарим улс төрийн популист дэглэм, түүнчлэн зарим эдийн засгийн либерал хандлагын аль аль нь ямар ч үнэ цэнээр хамаагүй дүрвэгсэд нэвтрэн орж ирэхийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ёстой хэмээн үздэг. Мөн ядуу буурай орнуудад үзүүлж байгаа тусламжийн хэмжээг бууруулвал зохино, ингэснээр тэд ёроолдоо хүртэл унаж хүссэн хүсээгүй хэмнэлтийн горим руу шилжихээс өөр аргагүй байдалд орох ёстой хэмээн тайлбарлах гэсэн оролдлого байдаг. Зарим хүн иймэрхүү утга санаа бүхий хийсвэр, дэмжихэд хэцүү мэдэгдлийн цаана олон олон хүний амьдрал, амь нас байгаа гэдгийг ойлгохыг хүсэхгүй байна. Олон олон дүрвэгсэд дайн дажин, харгислал, байгалийн гамшгаас дайжин зугтаж байгаа билээ. Зарим дүрвэгсэд "өөрсөддөө болон гэр бүлийнхэндээ боломж бололцоо хайн дүрвэн ирж байгаа нь ч үнэн. Тэд сайн сайхан ирээдүйг мөрөөдөж, мөрөөдөлдөө хүрэхэд нь туслах нөхцөлийг бий болгохыг зорьж байгаа" [36].

38. Харамсалтай нь зарим дүрвэгсэд "Барууны соёлд татагдаж, зарим үед бодит байдлаас илүү хэт өндөр хүлээлттэйгээр дүрвэж ирчихээд удалгүй сэтгэл санаагаар унаж гүн гүнзгий гутралд автдаг. Ихэнхдээ хар тамхи, зэвсэг наймаалагчдын сүлжээтэй холбоотой ёс суртахуунгүй хүн наймаалагчид дүрвэж явах замдаа байсхийгээд зэрлэг балмад харьцааны золиос болдог, сэтгэл санаа болон бие бялдрын халдлагад өртдөг дүрвэгдэгсдийн сул дорой

байдлыг овжин ашигладаг билээ” [37]. Дүрвэгсэд “төрж өссөн нутгаа орхидог, соёл, шашны үндэс сууриасаа тасардаг. Ард нь үлдэж байгаа хамт олон нь дундаасаа хамгийн идэвх санаачилгатай хүмүүсээ алдаж байгаа учир хэдэн хэсэгт хуваагдаж бүрэн бүтэн байдлаа алддаг, эцэг эхийн аль нэг нь, эсхүл хоёулаа хүүхдүүдээ нутагтаа орхин дүрвэж байгаа учир ийм гэр бүл мөн адил бүрэн бүтэн байдлаа алддаг” [38]. Ийм учир “дүрвэхгүй байх эрх буюу төрсөн, өссөн нутагтаа амьдрах эрхийг дахин баталгаажуулах хэрэгтэй” [39].

39. Түүнчлэн “дүрвэгсдийг хүлээн авч буй зарим улс оронд айдас, түгшүүр буй болж, тэдгээрийг улс төрийн зорилгоор өдөөн хатгаж улам их хүч оруулдаг. Ингэснээр бусад улс орны хүмүүсийг илэрхий нүд үзүүрлэх явдал газар авч, иргэд өөрсдийгөө бусдаас хөндийрүүлэн зожигрох чиг хандлагатай болно. Энэ байдлыг заавал өөрчлөх хэрэгтэй” [40]. Дүрвэгсэд бусад хүмүүсийн нэгэн адил тухайн нийгмийн амьдралд оролцох эрхтэй гэдгийг ойлгохоо больж, тэд бусад хүмүүсийн нэгэн адил эрхэм чанартай гэдгийг мартжээ. Уг нь тэднийг “өөрсдийн авралыг хамтран бүтээгчид” гэж үзвэл зохино [41]. Хэн ч дүрвэгсэд бусадтай адил хүмүүс гэдгийг ил тод үгүйсгэхгүй боловч үнэн хэрэгтээ амьдрал дээр бидний гаргаж байгаа шийдвэр, бид тэдэнд хандаж байгаа хандлага зэргээс харахад тэд бусдыг бодвол үнэ цэн багатай, ач холбогдол доогуур, хүнээс доогуур этгээдүүд болж хувирсан байна. Христийн шашинтнуудын хувьд ингэж бодох нь туйлын буруу бөгөөд ийм бодолд автвал түр зуурын улс төрийн зорилгын улмаас аливаа хүн гарал үүсэл, арьсны өнгө, шашин шүтлэгээс үл шалтгаалан эрхэм мөн чанартай бөгөөд ах дүүгийн харилцаа холбооны ариун сэтгэлийн

дээд хууль үйлчилдэг хэмээх үнэнийг үгүйсгэсэнтэй адил болно.

40. “Дүрвэгсдийн асуудал дэлхийн ирээдүйг тодорхойлоход өмнөхөөс илүү чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэг нь ойлгомжтой болж байна” [42]. Харин өнөөдөр “аливаа иргэний нийгмийн суурь болдог зарчим буюу ах, эгч, дүү нарынхаа төлөө хариуцлага хүлээх ёстой гэсэн ойлголт алга болж байгаа нь” [43] дүрвэгсдийн асуудалд шууд сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал Европ энэ замаар замнаж байгаа нь ихээхэн эрсдэл дагуулж байна. Гэвч “[Европ] агуу соёл, шашны өв уламжлалтай учир Хүмүүн аливаа бүхний төвд байх ёстой гэсэн зарчмыг хамгаалах, иргэдийнхээ эрхийг хангах, дүрвэгсдийг хүлээн авч тэдэнд туслалцаа үзүүлэх гэсэн хоёр давхар ёс суртахууны хариуцлагыг хэрэгжүүлэх зөв тэнцвэрийг олж чадах хангалттай арга хэрэгсэлтэй билээ” [44].

41. Би зарим хүн дэрвэгсдээс айж эмээдэг, тэдний асуудалд хандахдаа эргэлзэж тээнэгэлздэгийг ойлгож байна. Энэ бол бидний өөрийгөө хамгаалах гэсэн төрөлхийн зантай шууд холбоотой гэж бодож байна. Гэхдээ хувь хүн болон ард түмэн бусдад нээлттэй хандаж баймааж сая бүтээлч байна, үр дүнтэй амьдарч чадна гэдэг нь үнэн билээ. “Эргэлзээ тээнэгэлзээ болон айдас болгоомжлол бидний бодох, биеэ авч явахыг тодорхойлдог болох нь биднийг тэвчээргүй, бусдад хаалттай, тэр байтугай өөрсдөө тэр бүр ухаардаггүй ч арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэлтэй болгодог юм. Ингэснээр айдас биднийг бусадтай уулзан учрах хүсэл эрмэлзэлгүй болгож байна” [45]. Иймд учир би хүн бүрт хандаж зарим үед иймэрхүү төрөлхийн зангийн хүлээснээс салж чаддаг байх ёстой гэж хэлж байна.

42. Хачирхалтай нь өөрийгөө бусдаас тусгаарласан, бусдад үл тэвчих байдлаар түрэмгий ханддаг хандлага өсөж байгаа ч хүмүүс хоорондын орон зай агшин багасч, ингэснээр хувь хүний нууцлагдах ёстой хувийн амьдрал хэмээх ойлголт алга болж байна. Бүх юм жүжиг лүгээ адил болж, түүнийг бүгдээрээ үздэг, бүгдээрээ хөндлөнгөөс сонирхон оролцож шалгадаг болсон байна. Хүмүүсийн хувийн амьдрал бусдын байнгын хараа хяналтад бүрэн оржээ. Цахим харилцааны хэрэгслүүд бүхнийг ил тод болгож байна, ингэснээр хүмүүсийн амьдралыг самнан харж, нүцгэлж, хов живийн бай болгож байна. Энэ бүхнийг өөрийн нэр, хаягаа нуух байдлаар хийж байна. Бусдыг хүндэтгэх хандлага алга болж, хэдийгээр бид хэн нэгнийг үгүйсгэх, үл тоох, зайнд барих боловч хувь хүний амьдрал руу ичихгүйгээр өнгийн харж, нарийн ширийн бүх юмыг нь уудлан онгичиж байна.

43. Үзэн ядалтаар дүүрэн, устган сөнөөх зорилготой цахим дайралтууд бол зарим хүний бодож байгаагаар нэг нэгнийгээ дэмжиж байгаа эерэг хэлбэрийн үйл ажиллагаа биш. Харин энэ бол нийтлэг дайсныхаа эсрэг нэгдсэн хувь хүмүүсийн ажиллагаа юм. “Цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол хүмүүсийг донтуулах, зожигруулах, тэд аажмаар бодит байдалтайгаа холбоо тасрах эрсдэлийг дагуулж байдаг бөгөөд ингэснээр хүмүүсийн хоорондын жинхэнэ сэтгэлийн харилцааг хааж боогдуулдаг юм” [46]. Ийм харилцаанд хүмүүсийн биеийн хөдөлгөөн, нүүрний хувирал, ярихын хажуугаар дуугүй байхын утга учир, тэр байтугай үнэр, гар хурууны чичиргээн, нүүр царай улайх, хөлс гарах зэрэг амьд хөдөлгөөн дутагдах

бөгөөд тэгвэл энэ бүхэн баймааж сая хүмүүсийн хооронд бодитой харилцаа үүсэх, тэд нэг нэгнийгээ ойлгох боломжтой болно. Цахим харилцаа бол өнгөц харахад нийгмийн харилцаа мэт санагдах боловч үнэн хэрэгтээ түүнийг тогтооход найз нөхрийн харилцаа бий болон хөгжүүлэхэд шаардагддаг цаг хугацаа хэрэггүй байдаг, энэ бол тогтвортой харилцаа биш, цаг хугацаа өнгөрөх тусам санал нэгдэх үйл явц өрнөн гүнзгийрдгээс огт өөр харилцаа билээ. Цахим харилцаа бол хамт олныг буй болгодог харилцаа биш, энэ харилцаа “би” хэмээх үзлийг нуухын зэрэгцээ түүнийг улам бүр дэлгэрүүлнэ. “Би” хэмээх үзэл бусдад дээрэнгүй хандах хандлагаар, ядарсан зүдэрснийг дорд үзэх үйлдлээр илэрнэ. Цахим харилцаа хүмүүсийн хооронд гүүр болж, хүн төрөлхтнийг нэгтгэж чадахгүй.

*Ичгүүр сонжуургүй түрэмгийлэл*

44. Хувь хүмүүс өөрсдөд нь тав тухтай санагдах хэрэглээ шүтсэн орчиндоо бусдаас тусгаарлагдан оршиж байхдаа ч ихээхэн дайсагнах сэтгэл, доромжлол, хүч чадлаа урвуулан ашиглах үйлдэл, гүтгэлэг, бусдыг нураан унагаахад чиглэгдсэн үгээр илэрхийлэгдсэн адал балмад зан авир зэргийг өдөөн зоригжуулж байгаа байнгын бөгөөд эрүүл биш сонирхол татсан харилцаа холбоог сонгож болдог билээ. Нийгмийн түрэмгийлэл компьютер болон бусад хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөр дамжуулан юутай ч адилтган зүйрлэхийн аргагүй боломж бололцоотой болсон байна.

45. Ийм байдал аливаа үзэл сурталд хязгааргүй эрх чөлөө олгожээ. Хэдхэн жилийн өмнө бүгдийн хүндэтгэлийг алдах эрсдэлийг дагуулж байсан үг, үйлдлийг өнөөдөр ямар ч шийтгэлгүйгээр хамгийн бүдүүлэг үгээр илэрхийлж болдог болсон байна. Зарим улс төрчид хүртэл ингэж хэлж ярьдаг болжээ. Та бид "асар их эдийн засгийн эрх ашиг цахим ертөнцөд үйл ажиллагаа явуулж, хамгийн зөөлөн боловч хамгийн гүн гүнзгий нэвтрэх чадвартай аргаар бусдыг эрхэндээ оруулан хянаж байгаа бөгөөд ингэх нь хүмүүсийн ухамсар, ардчилсан үйл явцаар тоглож буйг мартаж болохгүй. Өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа олон платформ эцсийн дүндээ адилхан сэтгэдэг хүмүүс хоорондоо харилцах, холбоо тогтоохыг дэмжих байдлаар ажиллаж байгаа бөгөөд ингэснээр тэднийг мэтгэлцэж маргалдах боломжоос хаан тусгаарлаж байна. Иймэрхүү хаалттай тойрог, явцуу хүрээнд худал мэдээлэл түгэн дэлгэрч, хүмүүс нэг нэгэндээ анхнаасаа үл итгэх байдлаар хандах, тэр ч байтугай нэг нэгнийгээ үзэн ядах явдал улам хүчтэй болж байна" [47].

46. Та бид үе үе аливаад туйлшран итгэхийн хөнөөлт хэлбэр шашинд итгэгчдийн дунд, тэр тусмаа Христэд итгэгчдийн дунд тааралддагийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэд ч мөн адил "интернэт болон цахим харилцаа холбооны янз янзын хэлбэрийг ашиглан үгийн түрэмгийллийн сүлжээнд татагдан орсон байдаг билээ. Католик хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүртэл аливаа байх ёстой хэм хэмжээг эвдэж, бусдыг доромжлох, тэднийг гүтгэх ажлыг хэвийн зүйл мэт үзэж явуулдаг тохиолдол байдаг. Ингэснээр ёс суртахууны аливаа тогтсон жишгийг эвдэх, хүмүүсийн нэр хүндийг хүндэтгэх ёстой гэсэн ойлголтыг үгүйсгэж байна" [48]. Тэгвэл энэхүү зохисгүй байдал та

бидний Эцэг тэнгэр бид хоорондоо ах дүүгийн харилцаа холбоотой байх ёстой гэж сургасан сургаалыг түгээн дэлгэрүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулж чадах уу?

*Мэргэн ухааныг агуулаагүй мэдээлэл*

47. Жинхэнэ мэргэн ухаан бодит байдалтай нүүр тулан учрахыг хүсдэг. Харин өнөөдөр бүх юмыг санаагаараа зохион бүтээдэг, хүссэнээрээ нуудаг, дур зоргоороо өөрчилдөг цаг үе болсон байна. Ийм учир өөрийнх нь бодож төсөөлснөөс огт өөр бодит байдлын өчүүхэн нэг хэсэгтэй учрах нь ихээхэн хүнд үйл явдал болж байна. Улмаар өөрт сайхан санагдаж байгаа болон өөрт муухай санагдаж байгаа сэтгэгдэлд тулгуурлан “лайк”, эсхүл “дислайк”-ийг дарж зөвхөн сонирхолтойгоо сонгодог арга механизмыг өргөн дэлгэр ашигладаг болсон байна. Яг ийм аргаар хүн зөвхөн өөрийнх нь ертөнцийг хуваалцахыг хүссэн явцуу хүрээний хүмүүсийг өөрөө сонгоно. Өнөөдрийн виртуал сүлжээнд бид муухай санагдсан, санал бодол нийлээгүй нөхцөл байдал, эсхүл хүнийг шууд “дилийт” хийн устгаж байна. Ингэснээр виртуал хүрээ үүсэж, энэхүү хүрээ та биднийг бодит ертөнцөөс салган тусгаарлаж байна.

48. Хүмүүсийн хоорондын амьд харилцаанд байдаг хамт суугаад нэг нэгнийгээ сонсдог арга нь өөрийнхөө ач холбогдлыг хэт дөвийлгөхийн хүслээс салж чадсан, бусдын төлөө санаа сэтгэл тавих, тэднийг өөрийн амьдралд найрсгаар урин оруулах замаар бусдыг хүлээн зөвшөөрөх чадвартай болсон хүмүүсийн эерэг хандлагыг тодорхойлдог билээ. Харин “өнөөдрийн ертөнц ерөнхийдөө дүлий дүмбэ ертөнц болсон байна... Зарим үед орчин үеийн дэлхий ертөнцийн юманд хөөгдөж

туугдсан юм шиг тал тал тийш үсчсэн байдал өөр хүн чухам юу хэлээд байгааг анхааралтай сонсох боломжгүй болгож байна. Гэхдээ та бид бусдыг сонсох чадвараа хэрхэвч алдах ёсгүй". Гэгээн Францис "Тэнгэрбурханы дуу хоолой, ядуучуудын дуу хоолой, сул дорой, эргэлзэж тээнэгэлзсэн хүмүүсийн дуу хоолой, газар дэлхий, байгалийн дуу хоолойны аль алийг нь сонссон. Тэдгээр дуу хоолойг сонсож амьдралын зам мөрөө өөрөө зурж сонгосон. Миний чин сэтгэлийн хүсэл Гэгээн Францисын суулгасан үр аль болохоор олон хүний зүрх сэтгэлд соёолон ургаасай гэдэгт оршино" [49].

49. Чимээ аниргүй байхын гайхамшиг алга болж, бусдыг анхааралтай сонсох боломж байхгүй болж, тэдгээрийн орон зайг сэтгэл хөдлөлд автсан хүмүүсийн нэг нэгэндээ илгээсэн богино бичвэрүүд эзэлж байгаа энэ цаг үед хүмүүсийн хоорондын нандин харилцааны суурь бүтэц эвдрэн нурах эрсдэлд орж байна. Ингэснээр амьдралын цоо шинэ хэв маяг буй болж, бид зөвхөн хүссэнээ хийдэг, харин хянаж чадахгүй, эсхүл богино хугацаанд өнгөцхөн мэдэж чадахгүй юмнаасаа зайлан зугтдаг болж байна. Ийм үйл явц өөрийн дотоод хуулиараа өрнөсөөр хамтын мэргэн ухаанд хүрэх боломж олгодог тунгалаг бодрол бясалгалын урсгалыг таслан зогсоодог.

50. Та бид чухамхүү тайван ярих, эсхүл ширүүн маргалдах зэргээр ямар ч байсан нэг нэгэнтэйгээ ярилцах замаар үнэнийг олохын тулд хамтдаа эрж хайх хэрэгтэй. Ингэхийн тулд та биднээс тууштай байх чанар шаардагдана. Ингэх нь дуугүй байж сурахыг шаардана, зүрх сэтгэлийн шаналлыг дагуулна, гэхдээ хувь хүмүүс болон олон түмний хуримтлуулсан өргөн дэлгэр туршлагыг багтаана.

Та бидний хурууны үзүүрт хуран цугларсан мэдээллийн үер биднийг илүү ухаантай болгож байна гэж бодож болохгүй. Мэргэн ухаан бол түргэн зуур интернэт ухаад олчихдог юм биш, баталгаагүй мэдээллийн цуглуулга ч биш. Ийм аргаар үнэнтэй учрахад шаардагдах хэрсүү ухаан суух боломж байхгүй. Хүмүүсийн хоорондын яриа хамгийн сүүлчийн мэдээллийг тойрон эргэлддэг. Мэдээ бүр нэг л хэвтээ түвшинд нэг нэгнээсээ ялгарахгүй цуврах бөгөөд эцэстээ учир нь олдохгүй овоолго болно. Харин та бид анхаарлаа төвлөрүүлэх, аливаа юм үзэгдлийн гүн рүү нэвтрэн орох, бидний амьдралыг утга учиртай болгох тэр чухал юмыг танин мэдэх чадваргүй болно. Улмаар эрх чөлөө хэн нэгний бидэнд мэхлэн зарсан хий үзэгдэл болно. Интернет ухахыг эрх чөлөө эдэлж байгаа мэтээр бодож өөрсдийгөө хуурч төөрнө. Гагцхүү үнэхээр эрх чөлөөтэй, амьд уулзалтууд хийхээсээ айж эмээдэггүй хүмүүс нутаг орондоо, эсхүл даян дэлхийд ахан дүүгийн харилцаа холбоо тогтоох үйл явцыг өрнүүлэн үр дүнд хүргэж чадна.

### БУСДЫН ЭРХШЭЭЛД ОРОХ БОЛОН ӨӨРИЙГӨӨ ДОРД ҮЗЭХ ХЭЛБЭРҮҮД

51. Эдийн засгийн хувьд хөгжсөн зарим улс орныг хөгжиж байгаа орнуудад үлгэр жишээ болгодог. Уг нь хөгжиж байгаа улс орон бүрийг өөрт нь таарч тохирох замаар хөгжихөд нь туслалцаа дэмжлэг үзүүлэх нь илүү оновчтой бөгөөд тухайн орны соёлын үнэт зүйлсийг хүндэтгэхийн зэрэгцээ шинэ хөгжил дэвшил гарах чадварыг нь дээшлүүлвэл зохино. Бусдыг үг дуугүй даган дуурайх гэсэн наанаа сүржиндүү, цаанаа хоосон хүсэл мөрөөдөл бүтээхийн оронд хуулбарлах болон хэрэглэхийг дэмжих

бөгөөд улмаар тухайн үндэстний хувьд өөрийгөө бусдаас доогуур үнэлэх байдалд оруулна. Ядуу буурай улс орны баячуудын хүрээнд, түүнчлэн дөнгөж сая ядуучуудын эгнээнээс гарсан хүмүүсийн дунд үндэсний өвөрмөц сэтгэлгээ, ажил хийх аргаасаа татгалзах хүсэл эрмэлзэл бий болдог билээ. Тэд өөрсдийн соёлын өвөрмөц дүр төрхийг дорд үзэж бүх муу муухай юмны үүр уурхай мэт боддог.

52. Бусдыг эрхэндээ оруулах хамгийн амархан арга зам бол тэд өөрсдийгөө хүндэтгэхээ болих байдаг. Бидний амьдарч байгаа ертөнцөд шинэ журам тогтоож байгаа энэхүү чиг хандлагын цаана өөрийгөө үл хүндэтгэх үзлийг ашиглан улам бүр хүчээ авч байгаа ашиг сонирхол цэцэглэн хөгжиж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан дээдчүүдэд зориулсан шинэ соёлыг бий болгохыг оролдож байна. Ийм нөхцөл байдал санхүүгийн зах зээл дээр тоглогчид болон эдийн засгийн түрэмгийлэгчдэд боломж бололцоо олгодог бөгөөд ядуучууд ямагт хохирогчид болдог билээ. Ард түмний соёлыг үл тоомсорлосон байдал явсаар байгаад улс төрийн удирдагчдыг хүмүүсийн сайн дураар хүлээн зөвшөөрсөн, урт удаан цаг хугацаанд үйлчлэх чадвартай үр ашигтай хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх чадваргүй болгодог.

53. Бид "үндэс язгуургүй болох, хэнд ч хаана ч харьяалагдахгүй болохоос илүү аймшигтайгаар нэг нэгнээсээ холдон хөндийрөх гэж байхгүй. Хүмүүс хоорондоо нэг нэгэндээ хамаатай, харьяалалтай гэсэн мэдрэмж хүчтэй байх тусам, үе үеийнхэн болон янз бүрийн хамт олны хооронд нэг нэгэнтэйгээ нарийн нандин харилцаа холбоотой болох

тусам, бусдад хайнга хандах, ингэснээр хоорондоо улам холдон хөндийрөх аливаа үйлдлийг хийхийг тэвчих тусам тухайн улс орон цэцэглэн хөгжиж, хүмүүс хөгжлийн үр шимийг хүртэж, сайн сайхан ирээдүйг бий болгоно" [50].

ИТГЭЛ НАЙДВАР

54. Би анхаарахгүй, тоомсорлохгүй байж болохгүй эдгээр хар үүл та бидний амьдрал дээр хурсан байгаа ч энэхүү Түгмэл захидлын дараагийн хуудсуудад шинэ шинэ итгэл үнэмшлийн зам мөрийн талаар хэлэлцэх, тэднийг сонгох тухай ярих болно. Тэнгэрбурхан та бидний хүмүүний амьдралд сайн сайхны үрийг харамгүй ихээр тарьж суулгасан байгаа билээ. Саяхан бид бүгдийг дайрсан цар тахал та бидэнд эргэн тойронд байгаа хүмүүсийг нээн таних, хүндэтгэх боломж боломж бололцоо олгосон. Тэд бүгд айдаст автсан цаг үед өөрсдийн амь насыг эрсдэлд оруулахаас буцахгүйгээр хүнд хэцүүг давах гэж зүтгэсэн билээ. Та бид эмч нар, сувилагчид, эмийн сангийнхан, дэлгүүр мухлагийн эзэд болон ажилтнууд, цэвэрлэгээний ажилтан, ажилчид, асрагчид, тээврийн салбарынхан, сайн дурын ажилтнууд, лам хуврагууд, сүжиг бишрэлтэй хүмүүс... зэрэг хамгийн наад захын үйлчилгээ үзүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, эмх замбараа хангах ажлыг хариуцсан эрэгтэй, эмэгтэй жирийн хүмүүс та бидний хамтын түүхийн шийдвэрлэх ач холбогдолтой үйл явдлуудыг өөрсдийн эр зоригоор тодорхойлж байна, та бидний амьдрал, хувь заяа тэд нартай яахын аргагүй сүлжилдэн холбогдож, тэд нараар тэтгэгдэн тогтож байна гэдгийг ухаарч эхэлж байгаа нь сайн хэрэг мөн. Тэд хэн ч ганцаараа амь гарахгүй гэдгийг сайн ойлгосон билээ. [51]

55. Одоо би хүн бүрийг итгэл найдвараа сэргээхийг уриалж байна. Учир нь итгэл найдвар бол “буй болсон нөхцөл байдал, түүхийн шаардлагаас үл шалтгаалан хүн бүрийн зүрх сэтгэлд гүн гүнзгий үндэслэсэн нэгэн чухал сэтгэлийн тухай өгүүлдэг билээ. Итгэл найдвар та бидэнд хандан хүсэл, тэмүүлэл, үр дүнтэй амьдралаар амьдрахсан гэсэн мөрөөдөл, агуу үйл хэрэг бүтээхсэн гэсэн чин сэтгэлийн хүслийн тухай өгүүлнэ. Агуу үйл хэрэг та бидний сэтгэл зүрхийг бүрэн дүүрэн болгож, та бидний эр зоригийг сэрээн мандуулж, үнэн, сайн сайхан, гоо үзэсгэлэн... зэрэг өндөрт орших бодит амьдралтай уулзуулан учруулна”. Итгэл найдвар бол эр зоригийн илэрхийлэл мөн, итгэл найдвар бидний харах хүрээг хязгаарлаж байгаа өөрийн тав тух, ямар ч найдваргүй аюулгүй байдал, нөхөн олговор зэргийг давж илүү алс хол руу харж чадна. Итгэл найдвар биднийг нээн зоригжуулж амьдралыг улам илүү гоо үзэсгэлэнтэй, илүү үнэ цэнтэй болгодог агуу зорилго руу чиглүүлнэ” [52]. Тийм учир бүгдээрээ итгэл найдварын зам мөрөөр үргэлжлүүлэн замнацгаая хэмээн уриалж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

# ЗАМ ДЭЭР ТААРСАН ҮЛ ТАНИХ ХҮН

56. Өмнөх бүлгийг өнөөгийн тулгамдсан асуудлуудын тухай хуурай тэмдэглэл, тодорхойлолт хэмээн бодож унших хэрэггүй. “Та бидний энэ цаг үеийн хүмүүс, ялангуяа ядуу зүдүү, өвдөж зовсон хүмүүсийн баяр баясгалан, итгэл найдвар, гуниглал, түгшүүр бол Христийг дагагчдын баяр баясгалан, итгэл найдвар, гуниглал, түгшүүр мөн билээ. Нээрээн хүмүүний гэсэн тодотголтой аливаа юм тэдний зүрх сэтгэлд цуурайтна” [53]. Бидний туулан өнгөрч байгаа манан будан дунд гэрэл гэгээ олох гэж оролдохдоо үйл хэрэгт уриалан зоригжуулсан хэдэн мөр бичихийнхээ өмнө би энэхүү бүлгийг Есүс Христийн хоёр мянган жилийн өмнө айлдсан нэгэн сургаалт зүйрлэлд зориулъя гэж бодлоо. Хэдийгээр энэхүү Түгмэл захидлыг шашнаар нь ялгалгүйгээр сайн сайхан сэтгэлтэй хүн бүрт зориулсан нь үнэн боловч уг сургаалт зүйрлэл та бидэнд бүгдэд нь хамаатай бөгөөд түүнийг уншсан, сонссон хүн бүр уг сургаалт зүйрлэлийн тухай эргэцүүлэн бодох, утга санааг нь ухаарахын тулд тархи толгойгоо гашилгах хэрэгтэй.

*"Ингээд нэгэн хуульч босож, Есүсийг сорин: -Багш аа, мөнх амийг өвлөн авахын тулд би яах ёстой вэ? гэж асуухад Тэрээр түүнд: Хуульд юу гэж бичигдсэн байдаг билээ? Чи хэрхэн уншсан бэ? гэхэд тэр хүн: Чи Тэнгэрбурхан Эзнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч, бүх оюун ухаанаараа хайрла. Мөн хөршөө өөрийн адил хайрла гэсэн байдаг хэмээв. Тэгэхэд нь* Есүс: *Чи зөв хариуллаа. Үүнийгээ үйлд, тэгвэл чи амьтай болно гэв. Харин тэр өөрийгөө зөвтгөх гэж* Есүст хандан: *Миний хөрш гэдэг чинь хэн бэ? гэжээ.* Есүс *хариуд нь: Нэгэн хүн Иерусалимаас Иерихо орохоор явж байжээ. Тэр дээрэмчдийн дунд орчихож. Тэд түүнийг нүцгэлэн зодоод амьтай төдий орхиод оджээ. Тохиолдлоор нэгэн тахилч тэр замаар явж байгаад, түүнийг харуутаа дэргэдүүр нь өнгөрөөд явчихав. Түүнчлэн нэгэн леви хүн мөн тэнд хүрч ирээд, түүнийг харуутаа дэргэдүүр нь өнгөрөөд явчихжээ. Харин түүгээр явж байсан нэгэн самари хүн түүнтэй таарчээ. Тэр түүнийг харуутаа өрөвдөн, түүн дээр ирж, шарханд нь тос, дарс асгаж боогоод, унаан дээрээ тэгнэн дэн буудалд хүргэж ирэв. Тэгээд түүнийг асарчээ. Маргааш нь тэр хоёр денар авч буудлын эзэнд өгөөд, "Түүнийг сайн асарч байгаарай. Та илүүг зарвал би буцахдаа танд дахин төлье" гэжээ. Энэ гурвын хэн нь дээрэмчдийн гарт орсон, тэр хүний хөрш болсон гэж чи бодож байна? гэхэд тэр хүн: Түүнд энэрлийг үйлдсэн нь гэв. Есүс түүнд: Явж, үүний адил үйлдэгтүн гэжээ" (Лук 10:25-37).*

*Далд утга санаа нь*

57. Энэхүү сургаалт зүйрлэл нэгэн эртний асуудалтай холбоотой юм. Библи судар дэлхий ертөнц болон хүнийг бүтээсэн тухай түүхийг толилуулсны дараа хүмүүс хоорондын харилцааны асуудлыг хөнддөг. Каин өөрийн

дүү Абелын амийг хөнөөдөг. Тэгтэл Тэнгэрбурхан түүнээс "Чиний дүү Абел хаана байна?" гэж асуудаг (*Эхлэл* 4:9). Түүний өгсөн хэгжүүн хариу бол уг нь хүн бүрийн өгдөг жирийн хариулт биш байсан билээ. Тэрээр: "Би дүүгийнхээ харгалзагч юм уу?" гэж хариулсан байдаг (Эхлэл 4:9). Тэнгэрбурхан тавьсан асуултаараа хувь заяа бол нэгэнт зурагдсан зураг мөн гэсэн ойлголт та бидний бусдад хайнга ханддагийг зөвтгөх ёсгүйг ойлгуулж байна. Харин ч эсрэгээрээ буюу Тэнгэрбурхан та бид хоорондын зөрчлөө шийдвэрлэж чадах, нэг нэгнийхээ төлөө санаа сэтгэл тавьдаг өөр соёлыг бүтээхийг уриалан зоригжуулж байна.

58. Иовын ном Бүтээгч Бурхан хэмээх цорын ганц Тэнгэрбурхан бид бүгдийг бүтээсэн хэмээх номлол зарим нийтлэг эрхийн үндэс суурь болдогийг харуулна. "Намайг эхийн хэвлийд бүтээсэн тэр Тэнгэрбурхан бусдыг мөн адил бүтээсэн биш үү? Эхийн хэвлийд биднийг яг нэг хэвээр бүтээсэн биш үү?" (Иов 31:15). Олон зууны дараа Гэгээн Иреней яг ийм утга санааг илэрхийлэхийн тулд хөгжмийн аялгуугаар жишээ татсан байдаг. Тэрээр: "Үнэнийг олохын тулд зүтгэж байгаа хүн хөгжмийн нотуудыг тус тусад нь салангид бүтээсэн мэт бодож, тэдний хоорондын ялгаанд анхаарлаа хандуулах хэрэггүй. Харин тэдгээр нотуудын нийлэн илэрхийлж байгаа бүтэн аялгууг нэг хүн зохиож бүтээсэн гэдгийг ухаарах хэрэгтэй" [54].

**Жич:** *Ромын Пап Францисын энэхүү Зарлигийн уг хэсгийн төгсгөлд англи эхэд нь байхгүй, харин орос эхэд байгаа дараах бичвэрийг эл хэсгийн утга санааг илүү тодорхой болгоход ач холбогдолтой болов уу хэмээн бодож, орос хэлнээс орчуулсан монгол орчуулгыг залгуулан нэмж*

*оруулсныг болгооно уу.*

“Учир иймд үнэнд дуртай хүн нэгэн аялгууны өнгө бүр хоорондоо зайтай байдагт хууртаж болохгүй, нэг өнгийг нэг хүн бүтээсэн, өөр өнгийг өөр хүн бүтээсэн, дээгүүр өнгийг нэг хүн, доогуур өнгийг өөр хүн, дунд өнгийг гурав дахь хүн тус тус бүтээсэн хэмээн төсөөлөн төөрөлдөж болохгүй, харин эдгээр өнгийг бүгдийг нь нэг л туурвигч бүтээсэн гэдгийг хүлээн зөвшөөрч, ингэсэн нь нэгэн хөгжмийн бүтээлийн ур ухаан, шударга зарчим, эерэл, гоо сайхны баталгаа болдог билээ. Энэхүү аялгууг сонсож байгаа хүн Бүтээн туурвигчийг сайшаан магтах хэрэгтэй, зарим дуу авианы чанга өнгөтэйг сонсон гайхаш алдах, зарим дуу авиа зөөлөн өнгөтэйг анхааралтай сонсох, зарим дуу авианы өнгө энэ хоёр өнгөний дундуур байгааг ялган сонсох, бусад дуу авианы өнгийг таньж сонсох, өнгө бүр хаашаа тэмүүлж байгааг ухаарах, ийнхүү өнгө бүр өөр өөрийн онцлогтой байгаагийн утга учрыг олох, гэхдээ энэ бүх өнгө, дуу авиа, аялгуу бүхэлд нь бүтээгч бүтээхдээ баримталсан дүрмээс хазайхгүй байх, бүхнийг бүтээсэн нэг Тэнгэрбурханд итгэх итгэлээс урвахгүй байх, Бүтээгч Тэнгэрбурханыг хараахгүй байх ёстой”.

59. Эртний еврейчүүдийн уламжлалд нэг нэгнийгээ хайрлах, нэг нэгнийгээ асрах тухай харилцаа гагцхүү нэг үндэстний хүмүүсийн хооронд байж болно хэмээн үздэг байсан бололтой. “Өөрийгөө хайрлаж байгаа мэт хөршийгөө хайрлаж бай” (Леви 19:18) хэмээх эртний зарлигийг нэг улсын иргэдийн хоорондын харилцаанд хамаатай хэмээн ойлгодог байжээ. Гэвч яваандаа энэхүү зарлигийн хамрах хүрээ улам өргөжин тэлсэн байдаг, ялангуяа Иудаизм Израил Улсын газар нутгийн хилийн чанадад хөгжихөд

түүнийг илүү өргөн утгаар ойлгох хэрэгтэй болсон байна. Ингээд та бид өөр нэгэн зарлигийг дагах ёстой болсон. Энэ бол "бусад хүн таны эсрэг битгий хийгээсэй хэмээн бодож байгаагаа өөрөө бусдын эсрэг битгий хий" гэсэн зарлиг (харьцуул. Тобит 4:15) юм. Есүс Христ мэндлэхээс нэг зууны өмнө Хиллель рабби ингэж айлдсан байдаг: "Энэхүү зарлиг бол Тора хэмээх ариун сургаалын гол утга санаа мөн. Бусад ном сургаал бол энэ зарлигийн тайлбар юм" [55]. Тэнгэрбурханы үйл хэргийг дагах гэсэн хүсэл эрмэлзэл явсаар байгаад яг бидний дэргэд байгаа хүмүүсийн тухай бодох бодол болон явцуурсан билээ. "Хүний нигүүлсэнгүй сэтгэл хөршид хүрдэг бол Тэнгэрбурханы нигүүлсэнгүй сэтгэл бүх амьд амьтныг хамардаг" (Сирах 18:13).

60. "Шинэ Гэрээ" сударт Хиллелийн айлдсан: "Та нар хүмүүсийг өөрсөддөө хэрхэн хандаасай гэж хүснэ, өөрсдөө ч тэдэнд бүхий л зүйл дээр тийнхүү ханд. Үүнд л хууль ба эш үзүүлэгчид буй" (Матай 7:12) гэсэн ерөнхий зарчим эерэг утгаар илэрхийлэгдсэн байна. Энэхүү хуульчлагдсан зарлиг бүгдэд хамаатай бөгөөд Эцэг тэнгэр "нарыг мандуулахдаа сайн, муу хэнд ч адил тусаж байхаар зохицуулсан байдаг" (Матай 5:45) учир энэхүү хууль мөн адил та бид нийт хүн төрөлхтөнд хамааралтай хэмээх үндэс сууринд тулгуурлах ёстой байдаг шиг хүн бүрийг хамрана. Тийм учир "Эцэг тэнгэр нигүүлсэнгүй байдагтай адил нигүүлсэнгүй бай" (Лук 6:36) гэсэн зарлиг байдаг билээ.

61. Библи судрын эртний хувиудад бичсэнийг үзвэл гадны хүнийг найрсгаар угтахын тулд зүрх сэтгэлээ яагаад нээн дэлгэх ёстой тухай өгүүлсэн байдаг. Энэхүү ойлголт

еврейчүүд урьд өмнө өөрсдөө Египетэд гадны хүмүүс хэмээн тооцогдон амьдарч байсан ой санамжтай нь холбоотой юм.

*“Ирмэл хүнийг бүү гадуурх, бүү дарангуйл. Учир нь та нар Египетийн нутагт ирмэл хүмүүс байсан” (Гэтлэл 22:21).*

*“Чи ирмэл хүнийг бүү дарангуйл. Та нар ч Египет газарт ирмэл хүмүүс байсан учраас ирмэлд хүний сэтгэлийг мэднэ” (Гэтлэл 23:9).*

*“Нутагт чинь ирмэл хүн та нартай хамт суурьших аваас түүнийг бүү дарла. Та нартай хамт суурьших ирмэл хүн та нарт, дунд чинь буй уугуул хүн мэт байж, чи түүнийг өөрийн адил хайрла. Учир нь та нар Египет нутагт ирмэл хүмүүс байсан билээ”(Леви 19:33-34).*

*“Чи усан үзмийн цэцэрлэгээс усан үзмээ хураагаад, үлдсэнийг нь дахин бүү түү. Тэр нь ирмэл хүмүүс, өнчин, бэлэвсэнд үлдэнэ. Чи Египет нутагт боол байснаа сана” (Дэд Хууль 24:21-22).*

Шинэ Гэрээ тэр аяараа ахан дүүгийн найрсаг харилцаа холбоотой байхын чухлыг эрхэмлэхийг уриалсан байдаг.

*“Учир нь хууль бүхэлдээ нэг үгэнд л багтдаг юм. Энэ нь “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэн нь мөн” (Галат 5:14).*

*“Ах дүүгээ хайрладаг нь гэрлийн дотор байгаа бөгөөд түүнд бүдрүүлэх шалтгаан байхгүй. Харин ах дүүгээ үзэн ядагч нь харанхуй дотор байгаа бөгөөд харанхуй дотор алхаж, нүдийг нь харанхуй сохолсон тул хаашаа яваагаа ч үл мэднэ” (1 Иохан 2:10-11).*

*“Бид ах дүүгээ хайрладаг учраас үхлээс аминд шилжсэнээ мэднэ. Үл хайрлагч нь үхэл дотор байна” (1 Иохан 3:14).*

*"Учир нь харсаар атлаа ах дүүгээ хайрладаггүй нь, хараагүй Тэнгэрбурханыг хайрлаж чадахгүй шүү дээ" (1 Иохан 4:20).*

62. Энэхүү хайрын сэтгэлээр хандахыг уриалсныг явцууруулан ойлгочих гээд байдаг. Гэгээн Паул Христийн шашны анхны нэгдлүүд хаалттай, бусдаас тусгаарлагдсан байдалтай байгуулагдаж байсныг мэдэж байсан учир шавь нартаа хандан: "нэг нэгэндээ болон бүх хүнд" (*1 Тесалоник* 3:12) хайрын сэтгэлээр хандах ёстойг ухуулж байсан байна. Иоханы шавь нарын нэгдлийнхэн хэдийгээр өмнө нь танихгүй мэдэхгүй хүмүүс байсан ч ижилхэн Христийн шашинтай нөхдүүдээ халуун дотноор угтан авдаг байсан байна (*3 Иохан* 5). Та бид энэ өнцгөөс нь харвал хайрын сэтгэл ах дүү, эгч дүү, хол, ойр болон хаанаас ирсэн нь хамаагүй тэдэнд туслах ёстой хэмээн сургадаг Сайн Самари хүний тухай сургаалт зүйрлэлийн утга учрыг илүү сайн ойлгож чадна. "Хайрын сэтгэл та биднийг бусдаас тусгаарлан зожигруулж байгаа гав гинжийг тас цохино, хайрын сэтгэл гав гинжийн оронд гүүр босгоно. Хайрын сэтгэл та бид бүгд гэр орондоо байгаа юм шиг тийм мэдрэмж төрүүлэхүйц нэгэн агуу том гэр бүлийг бүтээхэд тусална... Хайрын сэтгэл нийгүүлсэнгүй сэтгэл, эрхэм чанарыг түгээн цацраана" [56].

*Замын хажууд орхигдсон*

63. Есүс хулгайч нарт дээрэмдүүлсэн, шархадсан хүн замын хажууд хэвтэж байсан тухай түүхийг айлддаг. Олон хүн түүний дэргэдүүр явж өнгөрсөн ч нэг нь ч саатан зогссонгүй ээ. Энэ хүмүүс бүгд том том албан тушаал, нийгэмд эзэлсэн

байр суурьтай байсан ч нийтийн сайн сайхны төлөө санаа зовох сэтгэлгүй байжээ. Энэ хүмүүс шархадсан хүнийг асрахад шаардагдах цаг, цагаа больё гэхэд бусдад хандаж түүнд туслахыг хэлэхэд хэрэгтэй хэдхэн хормыг хүртэл зарцуулахаасаа харамлажээ. Гэтэл нэг хүн дэргэдүүр нь явж өнгөрөлгүй зогсож, шархадсан хүн рүү дөхөн очиж, түүнд чин сэтгэлээсээ туслахыг бодож, хэрэгцээнд нь зориулан өөрийн мөнгийг хүртэл зарцуулжээ. Тийнхүү шархадсан хүний дэргэд саатан зогссон хүн та бидний ямагт яарч байдаг энэхүү ертөнцөд хүн бүрийн харамладаг нэгэн эрхэм юмаа хүртэл өгсөн байна. Энэ бол өөрийн цаг хэмээх хамгийн үнэ цэнтэй юмаа өөр хүнд зарцуулсан байна. Уг нь тэр хүн энэ өдөр төлөвлөсөн ажилтай, өөрийн гэсэн хэрэгцээ шаардлагатай, бусдад хэлсэн амалсан юмтай, хүсэл зорилготой байсан нь ойлгомжтой. Гэвч тэр хүн ядарч зовсон хүнтэй учирмагцаа өөрийн ажлыг хойш нь тавьсан байна. Хэдийгээр замын хажууд хэвтэж байсан хүнийг таньдаггүй, мэддэггүй байсан ч түүнд цаг заваа, анхаарал сэтгэлээ зориулжээ.

64. Та өөрийгөө эдгээр хүмүүсийн алинтай нь адилхан гэж үзэж байна вэ? Энэ асуулт бүдүүлэгдүү мэт санагдаж болох боловч үнэн хэрэгтээ шулуухан тавьсан асуулт юм. Дээрх хүмүүсийн алиных нь ааш араншинтай таны ааш араншин ижилхэн юм шиг санагдаж байна вэ? Та бид ямагт бусдыг, ялангуяа сул дорой хүмүүсийг үл тоодгийгоо хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хэдийгээр хүн төрөлхтөн ихээхэн хөгжил дэвшилд хүрсэн ч та бидний хөгжилтэй хэмээгдэх нийгмийн хамгийн сул дорой, эмзэг хэсгийнхэнд хань болох, тэднийг асрах, дэмжих хэрэгцээ гарахад бид бүгд энэ талаар ёстой “а” ч үгүй байдгаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Та бид бидэнд шууд нөлөө үзүүлэхгүй бол

ядарсан зүдэрсэн хүмүүсээс нүүрээ буруулах, дэргэдүүр нь анзаарахгүй өнгөрөх, тэд хүнд хэцүү нөхцөл байдалд орсныг нь үл тоомсорлох зэрэг ааш араншин гаргадгаа хэвийн үйлдэл мэтээр хүлээж авдаг билээ.

65. Манай гудамжинд хэн нэгэн рүү дайрч довтоллоо гэхэд олон хүн дэргэдүүр нь анзаараагүй юм шиг яаран өнгөрдөг. Зарим хүн машинаараа хүн дайрчхаад газар дээрээсээ зугтдаг. Тэд бүгд аливаа асуудалд орохоосоо үхтлээ айна. Тэд өөрсдийнх нь гаргасан алдаанаас болж өөр хүн амь насаа алдаж болно гэдгийн тухай огт боддоггүй. Энэ бол янз бүрийн хэлбэрээр зугуухан орон зай эзэлж байгаа амьдралд хандах чиг хандлагын илэрхийллүүд мөн билээ. Цаашилбал өөрсдийн хэрэгцээнд барьцаалагдсан та бид зовж байгаа хүнийг хармагцаа айн сандардаг. Та бид өөр хүний асуудлыг шийдвэрлэх цаг завгүй байдаг учир ихээхэн тав тух алддаг. Энэ бол яахын аргагүй эрүүл биш нийгмийн шинж тэмдэг мөн. Баян чинээлэг амьдралыг бүтээхийг зорьж байгаа хэрнээ зовж зүдэрсэн нэгнээсээ нүүрээ буруулдаг нийгэм болсон байна.

66. Та бид ингэж доошоо унан живж огтхон ч болохгүй! Одоо бүгдээрээ сайн Самари хүний жишээг хамтдаа харъя. Есүс Христийн сургаалт зүйрлэл та бидний амьдралын дуудлага бол өөр өөрсдийн үндэстний болон бүх дэлхийн сайн иргэд байх, шинэ нийгмийн харилцаа холбоог бүтээгчид байхыгаа дахин нээн олж мэдэхийг уриалж байна. Энэхүү уриалга шинэ тутам мэт санагдах боловч та бид оршин байгаагийн хамгийн суурь хуулинд үндэслэсэн байгаа юм. Энэхүү хуулийн утга учир та бид нийгмийг нийтийн сайн сайхны төлөө чиглүүлэхийг ухаарахад оршино. Нэгэнт ийм зорилготой гэдгээ ухаарсан бол тухайн нийгмийн улс

төрийн болон нийгмийн дэг журмыг тогтоох, нийгмийн харилцааны эд эсийг бэхжүүлэх, түүний хүмүүнлэг зорилгыг бататган бэхжүүлэх шаардлагатай. Сайн Самари хүн үйл ажиллагаагаараа "хүн бүрийн орших нь бусдын оршихтой гүн гүнзгий холбогдсон байдаг, улмаар амьдрал бол зүгээр урсан өнгөрч байгаа цаг хугацаа биш, харин хүмүүс хоорондын харилцаа мөн" [57] гэдгийг тод томруун харуулж байгаа юм.

67. Энэхүү сургаалт зүйрлэл манай шархадсан дэлхийг шинээр бүтээн босгохын тулд та бидний гаргах ёстой үндсэн шийдвэрийн тухай тод томруун өгүүлсэн байна. Өнөөдөр та бид ихээхэн зовлон зүдүүртэй нүүр тулан учирч байгаа тул ийм нөхцөлд сайн Самари хүний үлгэр жишээгээр амьдрах хэрэгтэй. Харин энэнээс өөр шийдвэр гаргавал та бид нэг бол олон дээрэмчдийн нэг нь болж хувирна, эсхүл замын хажууд хэвтэж байгаа хүний зовж байгааг харсаар байж түүнд өрөвчхөн сэтгэлээр хандалгүй дэргэдүүр нь явж өнгөрч байгаа хүнтэй адил болно. Энэхүү сургаалт зүйрлэл та бидэнд бусдын эмзэг байдлыг ойлгодог, бусдыг хасах, тусгаарлах зарчимд захирагддаг нийгмийг бүтээн байгуулахаас татгалздаг, сайн хөрш лүгээ адил байж чаддаг, уруудаж доройтсоныгоо өөд нь татахдаа нийтийн сайн сайхны төлөө үйл хэрэг бүтээж байна гэж боддог, тэдгээрийн санаа сэтгэлийг сэргээдэг эрэгтэй, эмэгтэй хүмүүс эвтэй хамт олныг сэргээн байгуулж чадна гэдгийг харуулж байна. Үүний зэрэгцээ энэхүү сургамжит түүх хар амиа боддог, амьдралд байдаг зайлшгүй үүрэх ёстой хариуцлагаас зайлсхийн зугтдаг хүмүүсийн сэтгэлийн чиг хандлагын талаар анхааруулан сэрэмжлүүлж байна.

68. Энэхүү сургаалт зүйрлэл хийсвэр ёс суртахууны асуудлыг хөндөөгүй бөгөөд өөрөө зөвхөн нийгмийн болон ёс суртахууны мессэжийн хэмжээнд тооцогдох ёсгүй. Уг түүх нэгэн том хүн төрөлхтний оршихуйн чухал хэрнээ мартагдсан талын тухай өгүүлж байна. Энэ бол бид гагцхүү хайрын сэтгэлд байдаг нэгэн зорилгод хүрэхийн тулд буй болсон гэсэн ойлголт юм. Та бид хүний зовлонд юу ч болоогүй юм шиг хэнэггүй хандаж болохгүй. Та бид хэн нэгэн хүн амьдралынхаа бүхий л замыг нийгмийн хог шаар мэт байдалтайгаар туулж болно гэдэгтэй эвлэрч болохгүй. Харин хүний зовлонтой учирвал зүрх сэтгэл шимшрэх ёстой, бусдаас тусгаарлагдсан тав тухтай байдлаасаа гарах шаардлагатай, тэр байтугай бүр өөрчлөгдвөл зохино. Чухам үүнд хүний эрхэм чанарын тухай утга санаа оршино.

*Дахин дахин яригддаг нэгэн түүх*

69. Энэхүү сургаалт зүйрлэлийн утга санаа тодорхой бөгөөд шулуухан. Гэхдээ энэ түүх та бид ах, эгч, дүү нартайгаа харилцаж өөрсдийгөө аажим аажмаар танин мэдэх явцдаа дотроо ихээхэн тэмцэлддэгийг мөн адил сануулж байна. Эрт орой хэзээ нэгэн цагт та бид хэн нэгэн зовж байгаа хүнтэй учрах нь гарцаагүй. Тэгвэл өнөөдөр тийнхүү зовж байгаа хүмүүсийн тоо олон болжээ. Замын хажууд хэвтэж байгаа шархадсан хүнийг татаад авах уу, эсхүл түлхээд хаях уу? хэмээн гаргах тэр шийдвэр аливаа эдийн засаг, улс төр, нийгэм, шашны төслийг дүгнэх шалгуур болно. Та бид өдөр бүр сайн Самари хүн шиг байх уу, эсхүл юунд ч хөдлөхөө больж хөрсөн сэтгэлтэй хөндлөнгийн ажиглагч байх уу? гэдгийн аль нэгийг сонгох ёстой байдаг. Хэрэв та бид өөрсдийн амьдрал, эсхүл бүр хүн төрөлхтний

амьдралын түүхийг эргэн харвал энэхүү сургамжит түүхэд гарч байгаа хүн бүрийг санагдуулахаар биеэ авч явж байгаа нь ойлгогдоно. Та бид бүгд нэг бол шархадсан хүн, дээрэмчин, дэргэдүүр нь өнгөрч байгаа хэнэггүй хүн, эсхүл сайн Самари хүнийг санагдуулахаар амьдарч байна.

70. Энэхүү сургамжит түүхэд гарч байгаа хүн бүр замын хажууд байгаа зовж зүдэрсэн хүнтэй учирмагцаа хэрхэн өөрчлөгдөж байгааг нь харахад үнэхээр сонин. Ингээд бодоход Иудей хүн үү, эсхүл Самари хүн үү, тахилч хүн үү, эсхүл худалдаачин хүн үү гэдэг нь ач холбогдолтой биш болно. Эцсийн дүндээ хүмүүс хоёрхон төрөлд хуваагдана: нэг хэсэг нь зовж байгаа хүний төлөө санаа сэтгэлээ тавьдаг хүмүүс, нөгөө хэсэг нь дэргэдүүр нь хэнэггүй царайлаад өнгөрч байдаг хүмүүс; тусын гараа сунган тонгойж байдаг хүмүүс, харцаа буруулаад зугтаж байдаг хүмүүс. Яг ийм мөчид та биднийг бусдаас ялгадаг онцлог, бидэнд өгсөн нэр хоч, бидний зүүсэн баг бүгд алга болж, бидний жинхэнэ мөн чанар илрэн гарч ирдэг: энэ бол үнэн тодрох агшин мөн. Та бид шархадсан хүнд тусын гараа сунгахын тулд тонгойх уу? Та бид шархадсан хүнийг өөд нь татаж босгохын тулд өөрсдөө доошоо тонгойх уу? Энэ бол өнөөдрийн тулгамдсан асуудал мөн, та бид энэ асуудалтай нүүр тулан учрахаасаа айж эмээх ёсгүй. Хямрал тулж ирсэн байхад шийдвэрийг цаг алдалгүй гаргах шаардлагатай байдаг. Яг өнөөдрийн энэ цаг мөчид, яг өнөөдрийн энэ газар шороон дээр хэн нэгэн хүн дээрэмчин биш, эсхүл хэнэггүй царайлсан хүн биш бол тэр бол шархадсан хүн, эсхүл зовж зүдэрснийг мөрөн дээрээ үүрээд тусалж байгаа хүн мөн гэдгийг бид батлан хэлж болно.

71. Сайн Самари хүний түүхийг өнөөдөр ч дахин дахин давтан ярьж байна. Та бид нийгэм, улс төрийн идэвхгүй байдал манай дэлхийн олон хэсгийг эвдэрч хаягдсан зам лугаа адил болгосныг харж байна. Дотоод, гадаадын хэрүүл маргаан, боломж бололцоог хайр найргүй гээн алдаж байгаа хариуцлагагүй байдал олон олон хүнийг замын дэргэд орхиж, нийгмийн харилцаанаас түлхэн гаргаж байна. Энэхүү сургаалт зүйрлэлд Есүс Христ та бидэнд ямар нэгэн сонголт хийхийг тулгаагүй. Тэрээр шархадсан хүн, эсхүл түүнд тусалсан хүн уур бухимдалд автвал, эсхүл өшөө хонзон авах хүсэл тачаалд олзлогдвол юу болох байсан бол? хэмээн та биднээс асуугаагүй ээ. Есүс Христ хүний сэтгэлийн хамгийн сайн шинж чанарт итгэсэн байна. Энэхүү сургаалт зүйрлэлд Тэрээр та биднийг зоригжуулж бусдыг хайрлах сэтгэлдээ тууштай байхыг, зовж зүдэрсэн хүний эрхэм чанарыг сэргээхийг, өөрийнх нь нэр алдартай дүйцэхүйц тийм сайхан нийгмийг бүтээн байгуулахыг уриалж байна.

*Сургамжит түүхийн гол баатрууд*

72. Уг сургаалт зүйрлэлд эхлээд дээрэмчид гардаг. Есүс Христ дээрэм тонуул болсны дараа аяллаа эхэлдэг хэмээн өгүүлсэн байдаг. Ингэснээр та бид анхаарлаа дээрэм тонуул дээр, эсхүл дээрэмчид дээр төвлөрүүлэх шаардлагагүй болж байна. Гэхдээ та бид дээрэмчид байсныг сайн мэднэ. Та бид энэ дэлхийн газар шороо, хөрсөн дээр буугаад эрх дарх, ашиг хонжоо, хагарал хуваагдлын явцуу ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх гэсэн оролдлогууд нэгнийгээ түрэмгийлэн хүчирхийлэх, хаяж орхихын том том сүүдрийг бий болгосныг олж харна. Одоо дараах асуултад хариулах шаардлагатай: шархадсан хүнийг орхиод өөрсдийн амийг

бодоод нуугдах газар руу гүйх үү, эсхүл хулгайчдын араас нэхэн хөөж тэднийг барьж авах уу? Шархадсан хүн та бидний эвлэршгүй хагарал хуваагдал, та бидний хэнэггүй хайхрамжгүй байхын харгис зан араншин, та бидний үзэн ядалт, зөрчлийн золиос болоод хохирох уу?

73. Сургаалт зүйрлэл зовж байгаа хүний дэргэдүүр нь хэнэггүй царайлаад өнгөрч байгаа хүмүүсийг анхааралтай ажиглах хэрэгтэйг сануулдаг. Тэд замын нөгөө талд гарах гэж гүйхдээ санаатайгаар, эсхүл санамсаргүйгээр, сандарсан болохоороо, эсхүл жигшсэн учир хэнэггүй царайлсан хэрнээ биеэ барьсан байдалтай байгаа нь тахилч, леви хүн хоёр бол та бид болон биднийг тойрч байгаа дэлхийн хооронд улам бүр томорч байгаа ангалын гунигтай тусгал юм гэдгийг харуулж байна. Зай бариад хажуугаар нь гарах олон арга байдаг билээ: та бид өөрийн дотоод ертөнц рүү дүрвэж болно, бусдад хайхрамжгүй хандаж болно, зовж зүдэрч байгаа хүмүүсийн эмгэнэлтэй хувь заяанд хөндий хүйтэн хандаж болно. Эсхүл өөр тийш харж болно. Зарим улс оронд, эсхүл тухайн улс орны зарим өнцөг буланд ядуус болон тэдний соёлыг жигшин сэжиглэдэг, тэнд гаднаас хуулбарласан хөгжлийн төлөвлөгөө ядуусыг ядуурлаас амархан гаргачихсан юм шиг бусдын зовлон зүдүүрээс харцаа буруулдаг билээ. Зарим хүн бусдын зовлон зүдүүрийн тухай асуудал зүрх сэтгэлийг нь хөндүүрлүүлж магадгүй хэмээн бодож, энэ асуудалд анхааралтай ханддаггүйгээ тайлбарлахдаа ядуу хүмүүс гэж байхгүй хэмээн хэлдэг. Тодруулбал ядуус тэдний анхаарлын гадна үлддэг байна.

74. Зовж байгаа хүнийг хараагүй юм шиг хажуугаар нь өнгөрч байгаа хүмүүсийн тухай анзаарахаас өөр аргагүй нэгэн

зүйл бий: тэр хоёр хоёулаа шүтлэгтэй, Тэнгэрбурханд итгэдэг, нэг нь тахилч, нөгөө нь леви хүн байжээ. Энэхүү жижиг ч гэсэн чухал онцлогийг анзаарахгүй байж болохгүй. Энэ байдал Тэнгэрбурханд итгэх, Тэнгэрбурханд мөргөж залбирах нь та бид Тэнгэрбурханы таалалд нийцэн амьдарч байгаа гэдэг нөхцөлийг хангаж чадахгүйг харуулж байна. Тэнгэрбурханд итгэгч түүний итгэл өөрөөс нь шаардаж байгаа байдлаар аливаа юманд хандахгүй байгаа ч өөрийгөө Тэнгэрбурханд их ойрхон учир бусдаас хавьгүй дээр хэмээн боддог. Үнэн хэрэгтээ Тэнгэрбурханд чин сэтгэлээсээ зүрх сэтгэлээ нээн хандана гэдэг нь та бид ах дүү, эгч дүү нартаа зүрх сэтгэлээ нээн хандахад тус болохуйцаар итгэл бишрэлээ дагахыг хэлнэ. Гэгээн Иохан Хризостом Христэд итгэгчидтэй учрахдаа энэ тухай ихээхэн тодорхой айлдсан байдаг. Тэрээр: “Чи Аврагч Есүс Христийн биед хайр хүндэтгэлээ илэрхийлэхийг чин сэтгэлээсээ хүсэж байна уу? Түүнийг нүцгэн байхад нь бүү дорд үз. Гадаа даарсан, бээрсэн байхыг нь харсан мөртлөө сүм дотор торгоор өөрийн биеийг ороон гоёж Түүнд бүү мөргөж залбир” [58]. Хачирхалтай нь өөрсдийгөө Тэнгэрбурхан шүтдэггүй хэмээн хэлдэг хүмүүс зарим тохиолдолд Тэнгэрбурханы зарлигийг Тэнгэрбурханд итгэгчдээс илүү сайн дагаж мөрддөг.

75. Ихэнх тохиолдолд “Дээрэмчид” “хажуугаар нь ажиггүй өнгөрч байгаа, өөр тийш харж харцаа буруулж байгаа” хүмүүс дундаас өөрсдийн нууц холбоотныг олсон байдаг. Нийгмийг хууран мэхэлж, нийгмээр тоглодог хүмүүс болон өөрсдийгөө биеэ даасан, хөндлөнгийн шүүмжлэгчид хэмээн сурталчилдаг ч тухайн тогтолцооноос хоолоо олж иддэг, түүнээс ашиг хонжоо олдог хүмүүсийн хооронд нарийн холбоо байдаг нь ажиглагддаг. Аливаа гэмт хэрэг,

хариуцлагаас мултрах, төр засгийн байгууллагуудыг хувийн болон тухайн аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхэд ашиглах, одоогоор арилган устгах боломжгүй муу муухай явдал зэрэгтэй эвлэрэх мөртлөө бүхнийг шүүмжлэх, хүмүүсийн хооронд үл итгэх байдлыг болон эргэлзээ тээнэгэлзээг байнга төрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах нь үнэн хэрэгтээ эмгэнэлтэй "жүжиглэл" мөн. "Бүх юм нэг л болохоо байчихсан байна шүү дээ" гэсэн шүүмжлэлд "Энэ бүхнийг засах боломж байхгүй", "Би тэгээд яалтай ч билээ" гэсэн хариу өгсөн болж ам таглана. Ингэснээр өөрийгөө болон бусдын сэтгэл санааг гонсойлгож, тэднийг цөхрөнгөө барсан байдалд оруулна, бусадтайгаа эв санааны нэгдэл илэрхийлэх, өгөөмөр сэтгэлээр хандах хүслийг нь мохооно. Хүмүүсийг цөхрөнгөө барсан байдалд оруулах нь тэднийг чөтгөрийн тойрогт оруулж байгаатай яг адил юм: байгалийн баялгийг бүрэн эзэмших, бодох, санаа бодлоо илэрхийлэх боломжийг хаан боогдуулах замаар ноёрхлоо тогтоож буй нуугдмал эрх ашиг бүхий зорилгодоо хүрэхэд нь тусална.

76. Ингээд одоо бүгдээрээ шархадсан хүнд анхаарлаа хандуулъя. Заримдаа та бидний хэн нь ч өөрөө түүнтэй адил ихээхэн зовж зүдэрсэн, замын хажууд орхигдсон байгаа мэт санагдах үе байдаг. Та бид төр засаг болон нийгмийн байгууллагууд ямар ч нөлөөгүй, чадамжгүй болсон учир ямар ч найдваргүй байдалд орсон юм шиг санагдана. Эсхүл тэдгээр байгуулага гадна, дотны зөвхөн цөөн тооны хүмүүсийн эрх ашигт барьцаалагдан тэдэнд үйлчилдэг болсон байх нь байдлыг улам найдваргүй болгоно. Нээрээн "Даяаршлагдсан ертөнц харц хараагаа өөрчилдөг зальжин аргатай. Улс төрийн хувьд соёлтой байх нэрийдлээр, үзэл суртлын хувьд сонирхон шохоорхмоор

байдлыг үг дуугүй дагах замаар та бид зовж зүдэрч байгаа хүмүүсийг зориуд алс холоос харна. Бид тэдний тухай холоос телевизийн шууд нэвтрүүлэг хийж дамжуулна, соёлтой үг хэллэг хэрэглэн тэдний тухай хоосон хөндий ярина, гаднаас нь харахад тэдэнд хүлээцтэй хандаж байгаа байдалтайгаар биеэ авч явна” [59].

*Цоо шинээр эхлэх*

77. Өдөр бүр та бидэнд шинэ боломж нээгдэж, шинэ бололцоо гарч ирдэг. Та бид удирдагчдаас бүх юмыг хүсэн хүлээх хэрэггүй, ингэх нь бага балчир хүүхдийг санагдуулна. Та бид шинэ үйл явцыг эхлүүлэх, шинэ өөрчлөлтийг өрнүүлэхэд хамтын хариуцлага хүлээх орон зайтай билээ. Бүгдээрээ тулгамдсан асуудалд баригдаж гацаанд орсон байгаа нийгмээ шинэчлэх, дэмжих үйл хэрэгт идэвхтэй оролцох хэрэгтэй. Өнөөдөр та бид бидний дотор байдаг ахан дүүгийн харилцаа холбооны мэдрэмжээ илэрхийлэх, улам их үзэн ядах болон жигшин зэвүүцэх хүслийг өдөөн дэвэргэхийн оронд бусад хүмүүсийн зовлон зүдүүрийн эмзэглэлийг өөртөө авдаг сайн Самари хүн шиг байх сайхан боломж бололцоо байгаа билээ. Сургаалт зүйрлэлд гардаг жирийн хүн лүгээ адил та бидэнд жирийн хүн байх гэсэн цэвэр ариун, энгийн хүсэл эрмэлзэл байх ёстой, та бид унаж шархадсан хүнийг орхилгүй татаж авах, дундаа оруулах, өөд нь татаж босгохын төлөө байнга, ядарч цуцахыг үл мэдэн зүтгэх чадвартай хамт олон болох ёстой. Та бид сав л хийвэл харгис хэрцгий, эргэн тойрноо харахгүй сохор их зантай болчихоод байдаг, үл итгэх байдал, худал хуурмагийг түгээн тараагч нарын эрхэнд орчихоод байдаг билээ. Олон хүн улс төр болон эдийн засгийг өөрсдийн эрх мэдлийн төлөөх тэмцлийн талбар

мөн хэмээн хардаг. Харин та бидний хувьд сайн сайхныг дэмжигчид болох, сайн сайхны үйл хэрэгт зүтгэх зардас болох нь илүү чухал хэмээн үзэж ийм болцгоохын төлөө хичээн зүтгэхийг уриалж байна.

78. Та бид их үйл хэргийг хамгийн доод шатнаас нь эхлэн хэрэгжүүлж болно. Асуудал бүрийг нэгбүрчлэн ажил хэрэг болгоно, хамгийн тодорхой арга хэлбэрээр орон нутгийн доод түвшинд ажиллана, улмаар ийм жишгээр улс орны болон дэлхийн хамгийн алсын цэгүүдэд хүрнэ, чингэхдээ сайн Самари хүн шархадсан хүний шарх бүрийг асран эдгээсэн лүгээ адил жишээг дагаж бусдын төлөө гэсэн сайхан сэтгэл, зүрхэндээ хөтлөгдөн зүтгэнэ. Бүгдээрээ бусдын төлөө зүтгэцгээе, Тэнгэрбурхан хүмүүний зүрх сэтгэлд сайн сайхны үрийг суулгасан учир өвдөхөөс үл айн, өөрийгөө бусдаас дутуу гэж бодолгүйгээр дэлхий ертөнцийг тэр аяар нь тэвэрцгээе. Эхлээд харахад давшгүй, дийлдэшгүй мэт санагдах хүнд хэцүү саад бэрхшээл бол үнэн хэрэгтээ өсөж өндийхийн боломж бололцоо мөн билээ. Хүнд хэцүүгээр шалтаглан хойш суух нь бууж өгсөнтэй адилхан. Гэхдээ сайн үйл хэргийг ганцаараа хийх хэрэггүй. Сайн Самари хүн шархадсан хүнийг асрах дэн буудлын эзнийг олдогтой адил бүгдээрээ нэг нэгэнтэйгээ холбоогүй хүмүүсийн нийлбэрээс илүү хүчтэй нэгэн гэр бүл болж хүчээ нэгтгэцгээе. Учир нь “бүтэн нь бүтний хэсгээс илүү том байдаг, бүтэн нь бүтний хэсгүүдийн нийлбэрээс илүү том байдаг” [60] билээ. Байнгын тэмцэл, зөрчил мөргөлдөөн та бидний амьдралын утга учрыг аар саархан ач холбогдолтой, үргэлжийн уур уцаар бухимдалд эзлэгдэж баригдсан байдалтай болгоно. Ийм байдлаас нэн даруй салах хэрэгтэй. Өөрсдийгөө зөвтгөн

өрөвдөхөө больцгооё, өөрсдийнхөө гэм зэмийг хүлээн зөвшөөрцгөөе, өөрсдийнхөө идэвхгүй, арчаагүй байдлыг өөрчлөцгөөе, худал хуурмаг үг хэлэхээ больцгооё. Энэ бүх муу муухай байдлаа засвал, хоорондоо эвлэрвэл та бидний амьдрал цоо шинээр эхлэнэ, та бидэнд айх эмээх юм байхгүй болно.

79. Шархадсан хүний дэргэд зогсож саатсан сайн Самари хүн тэр хүнд тусалсныхаа дараа явахдаа өөрийгөө магтуулах, бусдын талархлын үгийг сонсохыг огт бодоогүй. Түүний өөр хүнд туслах гэсэн хүчин чармайлт өөрт нь сэтгэл хангалуун байх боломж олгож, Тэнгэрбурханы таалалд нийцсэн учир өөрийнх нь хувьд үүргээ биелүүлсэн хэрэг болсон юм. Та бид бүгд шархадсан хүний өмнө үүрэг хүлээх ёстой, ард түмнийхээ өмнө, нийт хүн төрөлхтний өмнө үүрэг хүлээх ёстой билээ. Бүгдээрээ сайн Самари хүн лүгээ адил бусдад ойр дотно байж, тэдэнд туслах гэсэн сайхан эрмэлзлийг тэтгэгч ахан дүүгийн харилцаа холбооны сайхан сэтгэлд хөтлөгдөн эрэгтэй, эмэгтэй хүн бүр, залуу, хөгшин хүн бүрийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн төлөө хичээл зүтгэл гаргацгаая.

*Хил хязгаарт баригддаггүй хөршүүд*

80. Есүс Христ “Миний хөрш хэн бэ?” гэсэн асуултад хариулахдаа сайн Самари хүний тухай сургаалт зүйрлэлийг айлдсан юм. Есүсийн амьдарч байсан үеийн нийгэмд “хөрш” хэмээн тухайн хүнд хамгийн ойр амьдарч байсан дотно хүнийг хэлдэг байжээ. Тэр үед хүмүүс гагцхүү өөрийн үндэстний хамгийн ойр дотны хүмүүстээ тусалдаг байсан аж. Тэр үед зарим еврейчүүд Самари хүмүүсийг дорд үздэг, тэднийг бохирдсон хүмүүс хэмээн

сэжиглэдэг байсан байна. Тэдэнд туслах хэрэгтэй гэж боддоггүй байжээ. Есүс өөрөө еврей хүн байсан ч энэ хандлагыг үндсээр нь өөрчилсөн байна. Тэрээр биднээс хэн нь "хөрш" хэмээн хэлэгдэхээр ойр дотно билээ гэж бодохоо орхиж, харин яаж бид өөрсдөө бусдын хувьд "хөрш" нь болтлоо ойр дотно болох вэ? гэдгийг бодохыг хүссэн байна.

81. Есүс та биднээс тухайн хүмүүс та бидний нийгмийн бүлэгт хамрагддаг эсэхээс үл шалтгаалан тусламж шаардагдсан хүмүүсийн дэргэд нь байхыг хүссэн байна. Энэхүү сургамжит түүхэд Самари хүн Жүүдийн омгийн гаралтай шархадсан хүний хувьд хөрш нь болсон байна. Тэрээр шархадсан хүн дээр очиж, дэргэд нь саатсанаар түүх, соёлын бүх хил хязгаарыг эвджээ. Есүс энэхүү сургаалт зүйрлэлийг ярьж дуусаад : "Явж, үүний адил үйлдэгтүн" хэмээн айлдсан (Лук 10:37) байна. Өөрөөр хэлвэл Тэрээр биднийг сорьж бусдын зовж зүдэрч байгааг хараад хоорондынхоо ялгаа, зөрчлийг хойш нь тавьж, бусдаас элдвийн асуулт асуулгүйгээр тэдэнд ойр дотно болж чадах ёстой хэмээн айлджээ. Би туслах ёстой хөршүүдтэй бил үү, үгүй бол уу? хэмээн бодохын оронд би бусдын хувьд өөрөө хөрш нь болно гэж бодох нь зөв болно.

82. Уг сургаалт зүйрлэл дотроо олон асуудлыг агуулж байна. Тухайлбал Есүс Христ айлдахдаа шархадсан хүн бол Иудей хүн, харин дэргэд нь саатан зогсч түүнд тусалсан хүн бол Самари хүн байжээ. Энэхүү жижиг мэт санагдаж болох тодотгол үнэн хэрэгтээ та бид бүгдийг багтаан хамарч чаддаг хайрын сэтгэлийн тухай эргэцүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Самари хүмүүс бөөгийн зан үйл үйлддэг тэр газар нутагт оршин суудаг байжээ.

Иим учир Еврейчүүд тэднийг бохир, сэжиг хүрмээр, бүр аюултай хүмүүс хэмээн үздэг байсан байна. Тэр битгий хэл үзэн ядах сэтгэл төрүүлдэг үндэстний тухай өгүүлдэг нэгэн эртний Еврейчүүдийн судрт Самари хүмүүсийн тухай "тэд нэгэн ард түмэн арай биш юм аа" (Сирах 50:25) болон "Шеченд суудаг тэнэгүүд" (50:26) хэмээн бичсэн байдаг билээ.

83. Тэр үед иим ойлголт байсан учир Есүс Христ: уух юм байна уу? хэмээн өөрт нь хандахад яагаад Самари эмэгтэй хариуд нь: "Чи еврей байж Самари нутгийн эмэгтэйгээс уух ус гуйж байна гэж үү?" хэмээн шулуухан хэлснийг тайлбарлаж болно (Иохан 4:9). Тэр үед Есүс Христийг хамгийн аймшигтайгаар дайрч буруутгая гэвэл түүнийг Самари хүн, "чөтгөр шүглэсэн хүн" (Иохан 8:48) гэж хэлэх байв. Тийм учир Самари хүн болон Еврей хүн хоёрын хооронд нэг нь нөгөөдөхдөө сайхан сэтгэлээр хандсан тухай өгүүлэх нь өөрөө өдөөн хатгаж байгаа шинж чанартай байсан юм. Харин ийнхүү өгүүлсэн нь аливаа үзэл суртлаар хүний тархи толгойг эргүүлэх боломжгүй болгож, та биднээс санаа бодлын хил хязгаараа тэлэхийг шаардаж байна. Энэ сургаалт зүйрлэл та бидний хайрын сэтгэлтэй байх талаар уриалж байгаа уриалгын цар хүрээг бүх хүн төрөлхтнийг хамрах хэмжээтэй болгон өргөжүүлэн тэлж, ингэснээр энэхүү уриалга аливаа нэг нэгнийгээ сургаар буруу ойлгосон ойлголт, аливаа түүхийн болон соёлын саад бэрхшээл, явцуу ашиг сонирхлыг гэтлэн давж байгаа юм.

*Харь хүний гуйлт*

84. Эцэст нь хэлэхэд Шинэ гэрээний өөр нэг хэсэгт Есүс Христ:

“Харь хүн байхад минь та нар намайг урьж оруулсан” (Матай 25:35) гэж өгүүлснийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Есүс Христийн зүрх сэтгэл ямагт нээлттэй байдаг, түүний сэтгэл бусдын хүнд хэцүүг ямагт эмзэглэн хүлээж авдаг байсан тул иймхүү хэлжээ. Гэгээн Паул та бидэнд хандан “баярлаж байгаа хүмүүстэй баярыг нь хуваалц, уйлж байгаа хүмүүстэй зовлонг нь хуваалц” (*Ром* 12:15) хэмээн сургадаг нь учиртай. Та бидний зүрх сэтгэл бусдад ийм байдлаар хандана гэдэг бол бусад хүмүүс хаана төрсөн, тэд хаанаас ирсэн бол гэсэн элдвийн бодолд авталгүйгээр өөрсдийгөө тэдэнтэй хамт байна хэмээн бодож байна гэсэн үг билээ. Ингэснээр та бид бусдад “бидний мах цус мөн” (Исаиа 58:7) хэмээн хандаж сурна.

85. Христийн шашинтай хүмүүсийн хувьд Есүс Христийн айлдсан үг илүү гүн гүнзгий утга санааг агуулна. Энэ үг та биднийг бусдад хаягдаж орхигдсон, гологдсон ах, эгч, дүү нарын дотор Есүс Христ өөрөө оршдог юм (харьцуул. Матай 25:40.45) хэмээн ойлгох ёстойг илэрхийлсэн байна. Тэнгэрбурханд итгэх итгэл бидний сэтгэлийн онгодыг сэрээж, бусдад хүндэтгэлтэй хандах ёстой гэсэн сэтгэлийг бэхжүүлнэ. Христэд итгэгчид Тэнгэрбурхан эрэгтэй, эмэгтэй хүн бүрийг эцэс төгсгөлгүй их хайрын сэтгэлээр хайрладаг бөгөөд “тийм учир эцэс төгсгөлгүй их эрхэм чанарыг” нийт хүн төрөлхтөнд “хайрласан” [61] байна гэдгийг мэдэж авдаг. Та бид Есүс Христ хүн бүрийн сайн сайхны төлөө өөрийн цусыг урсгасан бөгөөд түүний агуу их хайрын сэтгэл хүн бүрт хүртээлтэй гэдэгт эргэлзэлгүй итгэдэг билээ. Энэхүү их хайрын сэтгэл нь гурамсан Тэнгэрбурханы амин зүрх мөн бөгөөд хэрэв та бид энэхүү их хайрын сэтгэлийн эх сурвалж нь юу вэ? хэмээн сонирхвол гурван тэнгэрлэг Бодгалийн

хамт бүрдүүлж байгаа нэгэн цогцод нийгмийн бүхий л амьдралын эх сурвалж болон төгс төгөлдөр чанарыг бүрдүүлсэн загвартай учирч болно. Теологийн шинжлэх ухаан энэхүү агуу үнэний талаар эргэцүүлэх тусам улам баяжин гүнзгийрнэ.

86. Би заримдаа энэ бүхнийг эргэцүүлэн бодоход манай Шашин боолчлолыг болон харгислалын олон хэлбэрийг үг дуугүй шууд буруушаалгүй яагаад ингэж их цаг алдсан юм бол? хэмээн гайхдаг юм. Өнөөдөр теологийн шинжлэх ухаан хөгжиж, оюун ухаан тэлсэн байгаа нөхцөлд ингэснийг зөвтгөн тайлбарлах боломжгүй. Гэтэл өнөөдөр харсаар байтал зарим хүн явцуу, харгис хэт үндсэрхэх үзэлд автах, бусдад дээрэнгүй хандах, бусдыг жигших, тэр байтугай ямар нэгэн юмаараа бид нараас өөр хүмүүсийг илэрхий гадуурхаж байгаагаа өөрийн итгэлээр шалтаглан зоригжиж, эсхүл итгэл нь тэгэхийг зөвшөөрсөн юм шиг байдалтайгаар биеэ авч явж байна. Жинхэнэ итгэл, түүний өдөөн сэрээдэг хүмүүнлэг үзэл ийм байдалд шүүмжлэлтэй хандах ёстой бөгөөд эдгээр буруу үзэл толгойгоо өндийлгөмөгц шууд хариу өгч байх ёстой. Ийм учраас сургаал айлдах, номлохдоо оршихуйн нийгмийн утга учир, оюун ухааны ахан дүүгийн харилцаа холбооны хэмжүүр, хүн бүр заяагдмал эрхэм чанартай гэсэн бидний итгэл үнэмшил, бид бүх ах, эгч, дүү нараа хайрлах, хүлээн зөвшөөрөх сэтгэлтэй байх ёстойн үндэслэл зэргийн тухай шуудхан, илүү тодорхой хэлж ярьж байх ёстой.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

# НЭЭЛТТЭЙ ЕРТӨНЦИЙГ ТӨСӨӨЛӨХ БОЛОН БҮТЭЭХИЙН ТУХАЙ

87. Хүмүүн хэмээх бодьгал "өөрсдийгөө бусдад чин сэтгэлээсээ өргөн барих"-аас өөр аргаар амьдрах, хөгжих, амьдралын зорилгодоо хүрэх боломжгүй байхаар бүтсэн байдаг юм. Түүнчлэн тэд бусад хүнтэй уулзаж баймааж сая өөрсдийгөө танин мэддэг билээ. "Би бусад хүмүүстэй харилцаж баймааж сая өөртэйгээ үр дүнтэй харилцаж чадна" [63]. Хэн ч бусадтай харилцалгүйгээр, хайрын сэтгэлээр хандах бодит хүмүүстэй учралгүйгээр амьдралын гоо сайхныг мэдэрч чадахгүй. Энэ бол хүмүүний бодитойгоор оршихын нууцын нэгэн хэсэг мөн билээ. "Хаана хүмүүсийн хооронд харилцаа холбоо байна, хамт олон байна, ахан дүүсийн ёс байна тэнд амьдрал байна. Бодитой харилцаа холбоо үүсч, чин сэтгэлийн нарийн нандин уяа холбоос зангидагдсан байхад амьдрал үхлээс илүү хүчтэй болдог. Харин та бид зөвхөн өөрсдийгөө болгоогоод хоорондоо холбоогүй арал мэт тус тусдаа байгаад байвал ингэх нь амьдрахын нэр биш, ийм чиг хандлага байгаа цагт үхэл ноёлно" [64].

88. Аливаа хүний зүрх сэтгэлийн гүнд байдаг хайрын сэтгэл хүмүүсийг өөрсдийнх нь хүлээснээс салгаж, бусад руу тэмүүлэх хүсэлтэй болгодог учир хүмүүсийн хооронд нарийн нандин хэлхээ холбоос бий болно, ийнхүү хүний оршихуй өргөжин тэлнэ. Та биднийг хайрын сэтгэлтэй байхаар бүтээсэн учир бидний хувьд хүн бүрийн дотор “өөрсдийн оршихуйг даван гарах хууль” оршиж байдаг билээ. Хайрын сэтгэлтэй болсон хүн өөрийн хүлээснээс салж өөр хүнтэй хамт болсноор илүү бүрэн бүтэн амьдралыг олно [66]. Ийм учир “өөрсдийн оршихуйг даван гарах гэсэн сорилттой байнга тулгардаг билээ” [67].

89. Гэхдээ би хэдхэн хүнтэй, тухайлбал зөвхөн гэр бүлийн гишүүдийн хүрээнд харилцах байдлаар амьдралын хамрах хүрээг явцууруулж болохгүй, би олон олон харилцаа холбоо бүхий ихээхэн өргөн хүрээнд харилцаж баймааж сая өөрийгөө танин мэднэ, энэ өргөн хүрээнд миний өвөг дээдэс ба тэдэнтэй харилцаа холбоотой байсан хүмүүс буюу өнөөдрийн миний амьдралыг тодорхойлсон хүмүүс орно. Би өөрийн хүндэтгэдэг хүмүүстэй харилцаа холбоотой байна гэдэг бол тэд зөвхөн миний төлөө амьдарна, эсхүл би зөвхөн тэдний төлөө амьдарна гэдгийн аль нь ч биш. Бидний хоорондын харилцаа холбоо эрүүл саруул шинжтэй, чин сэтгэлийнх мөн юм бол биднийг бусдад нээж илүү өргөн уудам харилцаатай болгоно, биднийг улам баян дэлгэр харилцаатай болгоно. Өнөөдөр та бидний хамгийн нарийн нандин хэмээн боддог харилцаа гаднаас нь харахад гүн гүнзгий харилцаа байгаа мэт сэтгэгдэл төрүүлсэн, үнэн хэрэгтээ зөвхөн өөрсдийгөө тойрсон сэдвийг хөндсөн, түүнийг

тойрч эргэлдсэн хов жив болон хувирч байна. Гэтэл чин сэтгэлийн шинж чанартай, ухамсартай хайрын сэтгэл, жинхэнэ найз нөхдийн харилцаа бусадтай тогтоосон харилцаа холбоогоор дамжин улам өсөн хөгжих боломж бололцоонд нээлттэй байх чадвартай зүрх сэтгэлд үндэслэн соёолно. Хайрын сэтгэлээр холбогдсон хосууд болон анд нөхдүүд өөрсдийн явцуу сонирхлыг даван гарч, бусдыг найрсгаар тэвэрвэл зүрх сэтгэл нь нээгдэн тэлэх болно. Бусдыг эгнээндээ оруулдаггүй хаалттай хамт олон, явцуу ашиг сонирхолдоо хөтлөгдсөн хосууд бусдыг сөрснөөрөө өөрсдийгөө тодорхойлдог бөгөөд тэд хувиа хичээх үзэл, өөрсдийгөө борцлон хатаахын илэрхийлэл болно.

90. Говь цөл газар амьдардаг цөөн тооны хүмүүстэй шашны бүлгүүд Тэнгэрбурханы ариун дурсгалт газруудад очиж мөргөл үйлдэхээр яваа мөргөлчдийг найрсгаар угтан авдаг гайхамшигтай зан заншлын цогцыг бүрдүүлсэн нь бусдад зочломтгой хандах ёстой гэж тогтоосон ариун үүргийг хэрэгжүүлж байгаагийн баталгаа мөн. Дундад зууны сүм хийдийн санваартнууд мөргөлчдийг яг ингэж халуун дотноор угтан хүлээж авдаг байсныг Гэгээн Бенедиктын тогтоосон журамтай танилцвал олж мэдэх болно. Хэдийгээр сүм хийдийн санваартнууд сахилаа сахиж сахилга баттай байх, дуу чимээ гаргахгүй байхаар тогтоосон журамтай байсан ч тэд Гэгээн Бенедикт: “ядуу зүдүү хүмүүс болон мөргөлчдөд дээд зэргийн анхаарал халамж тавьж байх ёстой” [68] хэмээн сургасныг дагадаг байжээ. Зочдоо хүндэтгэн хүлээж авна гэдэг бол өвөрмөц аргаар амьдралын сорилыг давж байна гэсэн үг, өөрийн эргэлддэг явцуу хүрээнээс халин гарч бусадтай учирснаар үнэ цэн бүхий бэлэг авч байна гэсэн үг мөн билээ. Сүм

хийдийн санваартнууд өөрсдийн баримтлах ёстой үнэт зүйлс бол өөрсдийн явцуу хүрээнээс гарч, өөрсдийгөө бусдад нээх чадварыг агуулж байх ёстойг гүн гүнзгий ухаарсан байдаг.

*Хайрын сэтгэлийн хосгүй үнэ цэн*

91. Хүмүүс ёс суртахууны үнэт зүйл мөн хэмээн тооцогддог тэсвэр тэвчээр, эрүүл саруул ухаан, хөдөлмөрч зан чанар гэх зэрэг сайн шинж чанаруудыг хөгжүүлж, тэдгээрийг баримталснаар өөрсдийн дадал заншил болгож болно. Хэрэв ёс суртахууны үнэт зүйлсийн үзүүлэх нөлөөллийг зөв чиглүүлбэл тэдгээр нь бусдад нээлттэй байх, бусадтай харилцаа холбоо тогтооход чиглэгдсэн байхыг бодож тооцсон байх хэрэгтэй. Ийнхүү зорьсныгоо Тэнгэрбурханаас соёрхсон энэрэл хайраар гүйцэлдүүлж болно. Хэрэв та бидэнд энэрэл хайр байхгүй бол өнгөн дээрээ сайн сайхан шинж чанарыг илэрхийлж байгаа мэт боловч үнэн хэрэгтээ хэн нэгэнтэй хамтран тогтвортой амьдрахад баттай суурь болж чадахгүй хэврэг үнэт зүйлтэй байх болно. Акуйно нутгийн Томас Гэгээнтэн Гэгээн Августины айлдсаныг иш татан хэлэхдээ: шуналтай хүн наанаа даруухан нүүр царайтай байх боловч ийм учир түүний тухай бат бэх үнэт зүйл баримталдаг нэгэн хэмээн хэлж болохгүй гэжээ [69]. Гэгээн Бонавентур энэ тухай айлдахдаа бусад үнэт зүйлс нь энэрэл хайрын үнэт зүйлийг үл баримтлах аваас тэнгэрлэг тушаалуудыг "Тэнгэрбурханы таалал ёсоор" биелүүлж чадахгүй юм хэмээн тайлбарлажээ [70].

92. Аливаа хүний амьдралын оюун сэтгэлийн хэмжүүр нь хайрын сэтгэл байдаг бөгөөд энэ нь эцэстээ "хүмүүний

амьдрал үнэ цэнтэй байсан эсэхийг хамгийн үнэн зөв тодорхойлох хэмжүүр байдаг” [71] аж. Гэтэл зарим итгэгчид хүний амьдралын утга учир өөрийн үзэл суртлыг бусад хүнд хүчээр тулган хүлээн зөвшөөрүүлэх, эсхүл өөрийн үнэнийг хүч хэрэглэн хамгаалах, эсхүл хүч чадлаараа гайхуулахад оршино гэж үздэг. Та бид бүгд нэг зүйлийг сайтар ойлгох хэрэгтэй. Энэ бол Хайрын сэтгэлийг хэзээ ч эрсдэлд оруулж болохгүй, хайрлах сэтгэлгүй байх нь хамгийн дээд аюул занал мөн (харьцуул. *1 Коринт* 13:1-13) гэдгийг ойлгох шаардлагатай.

93. Акуйно нутгийн Томас Гэгээнтэн Тэнгэрбурханы ивээл дор буй болох боломжтой хайрын сэтгэлийг тодорхойлохдоо энэ нь хүмүүний сэтгэлийн дотроос гадагшаа чиглэн хөдөлснөөр илэрнэ гэжээ, тийм учир та бид “хайрлаж байгаа хүнийгээ ямар нэгэн байдлаар бидэнтэй нийлж нэгдсэн хүн” [72] хэмээн үздэг. Та бид бусдад хайртай болно гэдэг бол тэр хүний төлөө сайн сайхныг бүтээхийг хүснэ гэсэн үг юм. Энэ хүсэл дээд зэргийн хүндэтгэлээс үүснэ, өөр хүний үнэ цэнийг үнэлснээс урган гарна. Эцсийн эцэст “энэрэл хайр” хэмээх үгийн цаана байгаа санаа бол та бидний хайртай хүмүүс та бидэнд ойр дотно байна гэсэн үг мөн бөгөөд “тэд асар их үнэ цэнтэй бодгалиуд мөн” [73] билээ. “Хайрын сэтгэл бол нэг хүн нөгөө хүний хувьд ихээхэн сэтгэлд нь тааламжтай байх (*grata*) болсноор илрэх бөгөөд тийм учир сэтгэл нь тааламжтай болсон хүн нөгөө хүнд талархсанаа илэрхийлэхдээ хариу төлбөр (*gratis*) нэхдэггүй [74] билээ.

94. Хайрын сэтгэл бол сайхан сэтгэлээс үүдэлтэй хэдэн үйлдлийн нийлбэр биш. Эдгээр үйлдлийн эх сурвалж бол бусад руу улам бүр татагддаг нарийн нандин холбоо юм.

Ингэснээр бусдыг гаднах дүр төрх, эсхүл ёс суртахууны хувьд гоё сайхан харагдахаас илүү гоё сайхан, санаа сэтгэлд илүү тааламжтай санагдах, таашаалд нийцэх үнэт зүйлсийн илрэл мөн хэмээн үзнэ. Та бид бусдыг байгаагаар нь хайрладаг бөгөөд ингэснээр та бид хайрласан хүмүүстээ сайн сайхан зүйлийг хүсэн тусалдаг билээ. Нэг нэгэндээ чухамхүү ингэж хандах сэтгэлийг бий болгон бөөцийлснөөр та бид нийгмийн ахан дүүсийн нөхөрлөлийг байгуулж, ийм харилцаа хэнийг ч үл гадуурхах бөгөөд бусдад нээлттэй ахан дүүгийн харилцаа холбоо болж төлөвшинө.

### УЛАМ БҮР НЭЭЛТТЭЙ ХАЙРЫН СЭТГЭЛ

95. Хайрын сэтгэл та биднийг нэг нэгэнтэйгээ харилцаж, ахан дүүсийн түгээмэл нэгдлийг бүрдүүлэхийг шаарддаг. Хэн ч өөрийгөө бусдаас тусгаарласнаар хэрсүүжих, амьдралын зорилгодоо хүрэх боломжгүй. Хайрын сэтгэл өөрийн мөн чанараараа улам нээлттэй болох, бусдыг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг билээ. Ингэснээр ихээхэн сонирхолтой амьдралын адал явдалтай аялал эхэлдэг бөгөөд энэхүү аяллын улмаас өмнө нь зах хязгаарт тооцогдож байсан хэсэг нэг нэгэндээ хамаатай, нэг нэгнээсээ хамааралтай хэмээн ухаарах агуу сэтгэлийг буй болгоно. Есүс Христ та бидэнд хандан ингэж айлдсан байдаг: “Та бүгд нэг нэгэндээ ахан дүүс мөн” (Матай 23:8).

96. Өөрсдийн хил хязгаарыг давж гарах шаардлага зөвхөн хүнд байгаад зогсохгүй бус нутгууд, улс орнуудад байдаг билээ. Нээрээн “өнөөдрийн дэлхий ертөнцөд хоорондоо холбоотой болох, харилцаа холбоо хөгжүүлэх явдал өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа бөгөөд энэ үйл явц улс

үндэстнүүд эв нэгдэлтэй байх ёстойг анхааруулж, тэдний хувь заяа нэг гэдгийг сануулж байна. Түүхийн өрнөл дунд, үндэстэн ястан, нийгмүүд болон янз янзын соёлын өнгө, дүр төрх өөр өөр байгаа нөхцөлд та бид нэг нэгнийгээ хүлээн зөвшөөрч чаддаг, нэг нэгнийхээ төлөө санаа тавьдаг ах дүү, эгч дүү нарын нэгдлийг бүрдүүлэхийг шаардсан амьдралын дуудлагын үрийг тарьж байгааг харж байна” [75].

*Хүн бүрийг хооронд нь ойртуулан холбож байгаа нээлттэй нийгмүүд*

97. Хэдийгээр та бид хотын төвд гэр бүлийнхэнтэйгээ хамт байдаг ч зарим зах хязгаар та бидний хувьд ойрхон байдаг. Хайрын сэтгэлийн бүгдэд нээлттэй байх үндсэн шаардлага газар зүйн хувьд хол, ойр байхаас шалтгаалахаасаа илүү аливаа хүний оршихуйн утга учиртай холбоотой. Хайрын сэтгэл найз нөхдийнхөө хүрээг тэлэх, хэдийгээр та бидэнд ойрхон ч би өөрөө тэднийг миний сонирхлын хүрээнд байдаггүй хэмээн боддог хүмүүст хүрэхийн тулд өдөр бүр хүчин зүтгэл гаргах ёстой гэдгийг ухааруулна. Миний дотор нь амьдарч байгаа тэр нийгэмд хаягдсан, гологдсон ах, эгч, дүү хэн ч байсан зовлон зүдүүртэй учирсан бол түүнийг та бидэнтэй нэг улс оронд төрсөн боловч оршихуйн хувьд, амьдралын баталгааны хувьд гадны хүн болсон байна гэж хэлж болно. Тэд нар та бидэнтэй адил эрхтэй иргэд мөн ч төрсөн улс оронд нь тэдэнтэй гадаадын хүнтэй харьцаж байгаа юм шиг харьцаж байна. Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл бол ихээхэн хурдтайгаар мутацид орж өөрчлөгддөг бөгөөд ингэхдээ бүрмөсөн алга бололгүйгээр харин цаг нь болохоор тодрон гарч ирэхээр түр хугацаанд нуугддаг билээ.

98. Одоо би нийгэмд гадны хүн мэтээр тооцогдон ад үзэгдэж байдаг тэрхүү "нуугдмал цоорхойнууд"-ын талаар хэдэн үг хэлье [76]. Хөгжлийн бэрхшээлтэй олон хүн "хэнд ч хамаагүй, ямар ч оролцоогүйгээр амьдарч байгаа хүмүүс лүгээ адил байдаг". Тэд жинхэнэ эрх чөлөөтэй болоход олон юм саад болсон хэвээр байна. Та бид тэднийг зөвхөн асрах тухай санаа сэтгэл тавих нь хангалтгүй. Харин тэд "нийгмийн болон шашны байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох боломжоор хангагдсан байх ёстой. Энэ бол ихээхэн хүчин чармайлт шаардсан, тэвчээргүй хүн амархан залхаж магадгүй үйл явц мөн. Гэхдээ чухамхүү ингэснээр хүн бүр цорын ганц төрсөн, дахин давтагдашгүй бодьгал мөн хэмээн хүлээн зөвшөөрөх оюун ухаан, ухамсар аажим аажмаар бүрэлдэн тогтож бэхжихэд тус нэмэр болох юм". Би энд бас "ахмадуудын тухай бодож байна. Тэд чадвараа алдсан байдаг учир тэднийг нэрмээс хэмээн үздэг". Гэтэл ахмад настан бүр "амьдралын гайхамшигтай түүх, туршлагаа нэмэрлэснээр хамтын сайн сайхан үйл хэрэгт онцгой хувь нэмрээ оруулах" боломжтой байдаг билээ. Би дахин давтаж хэлье: та бид "өөрсдийн чадамжгүй байдлаас болоод ад шоо үзэгдэж байгаа тэр хүмүүст дуу хоолойгоо өргөх боломж олгох эр зоригтой байх ёстой. Өнөөдөр ч гэсэн зарим улс оронд тэдгээр хүмүүсийг бусадтай ижил эрхэм чанартай хүмүүс мөн хэмээн үздэггүй нь туйлын харамсалтай" [77].

### *Бүхнийг хамарсан хайрын сэтгэлийг буруугаар ойлгохын тухайд*

99. Хил хязгаарыг давж чаддаг хайрын сэтгэл бол аливаа хот, улс оронд "нийгмийн нөхөрлөл" хэмээн тодорхойлдог харилцааны суурь юм. Аливаа нийгмийн дотор үүсэж

байгаа жинхэнэ нийгмийн нөхөрлөл бүхнийг хамарсан, нэг нэгэндээ нээлттэй байх орчныг буй болгоно. Энэ нь өөрийнхөө ард түмнийг тэвчиж чаддаггүй, эсхүл хайрлаж чаддаггүй учир улс орондоо тогтдоггүй, ямагт гадаадад явж байдаг хүмүүсийн бүхнийг хайрлаж байгаа мэт харагдахыг хүссэн хуурамч сэтгэлээс огт өөр юм. Өөрийн ард түмнийг дорд үзэж тэдэн рүү доошоо хардаг хүмүүс нийгэм дотор хүмүүсийг нэгдүгээр, хоёрдугаар зэргийн хэмээн хуваaж, ангийн ялгаа бий болгож, хүмүүсийг илүү чухал, чухал биш хэмээн дугаарлаж, илүү эрхтэй хүмүүс, дутуу эрхтэй хүмүүс хэмээн ялгаварлан гадуурхдаг. Тэд ийм хандлага гаргаснаар нийгэмд хүн бүрт өөрийн гэсэн байр суурь байна гэдгийг үгүйсгэдэг.

100. Энд би хүчээр тулган хүлээлгэсэн, хийсвэр шинж чанартай, цөөн тооны хүмүүсийн зохиож төлөвлөсөн, бусдыг тэгшитгэсэн, бусдыг дарангуйлах зорилготой, бусдаас булаан дээрэмдсэн мөн чанартай бүхнийг хамарсан сэтгэлийн тухай хэлээгүй нь мэдээжийн хэрэг билээ. Даяаршлын нэг загвар нь үнэн хэрэгтээ "бүхнийг нэг хэмжүүртэй болгож, нэг хэвэнд цутгасан юм шиг болгодог бөгөөд энэхүү загвар хиймэл нэгдмэл байдлыг бий болгох зорилгодоо хүрэхийн тулд аливаа ялгааг арилгах, өөр өөр уламжлалыг устгахыг оролдоно... Хэрэв даяаршлын нэгэн хэлбэр хүн бүрийг нэг хэвэнд цутгах, бүгдийг тэгшитгэхийг зорьж байгаа бол ийм даяаршил хүн бүрийн болон үндэстэн бүрийн баялаг авьяас чадвар, хосгүй шинж чанарыг устгана гэсэн үг билээ" [78]. Ийм бүхнийг хамарсан шинжтэй хуурамч даяаршил дэлхий ертөнцийг нүд баясгасан янз янзын өнгөгүй болгоно, гоо үзэсгэлэнгүй, улмаар эцсийн дүндээ хүмүүнлэг шинж чанаргүй болгоно. Уг нь "ирээдүй нэг л өнгөтэй биш байна,

та бид эр зоригтой байх юм бол ирээдүйгээ хүн бүрийн төлөөлөн илэрхийлж болох бүхий л олон янз, олон өнгө, хэлбэрээр нь төсөөлж болно. Та бид бүгд нэг хэвэнд цутгачихсан юм шиг биш байх, нэг нэгэнтэйгээ эе эвтэй, зохиролтой амьдарч сурахын тулд хүмүүн төрөлхтөн хэмээх нэгэн том гэр бүлийн гишүүд юутай ихийг сурч мэдэх хэрэгтэй байна вэ!" [79].

### "ХЭРЭГТЭЙ ТАНИЛ ТАЛ"-ЫН ЕРТӨНЦИЙН ЦААНА

101. Одоо дахин сайн Самари хүний тухай сургаалт зүйрлэлийн тухай ярья. Энэ сургамжит түүх бол та бидэнд хэлэх юм ихтэй түүх мөн. Шархадсан хүн замын хажууд хэвтэж байжээ. Түүний дэргэдүүр явж өнгөрч байгаа хүмүүс өөрсдийнх нь дотоод сэтгэл сайн хөрш лүгээ адил байгаач хэмээн уриалан дуудахыг анхаарахгүй байв. Тэд өөрсдийнхөө өдөр тутмын ажлаа хөөцөлдөнө, нийгэмд эзэлж байгаа байр сууриа бодно, нийгэмд ажил үүргийн хувьд юу хийж буйгаа бодно. Тэд өөрсдийгөө тухайн нийгэмдээ чухал хүмүүс мөн хэмээн үзэж, өөрт оногдсон үүргээ биелүүлэх нь бүхнээс илүү чухал хэмээн үзнэ. Замын хажууд хэвтэж байсан шархадсан, орхигдсон хүн тэдний хувьд анхаарлыг нь сарниулсан, үүрэг зорилгоос нь сатааруулсан, ямар ч байсан нэг их чухал биш этгээд байжээ. Тэдний хувьд шархадсан хүн "хэн ч биш" байв, сонирхол татахаар биш, ирээдүйд хийхээр төлөвлөсөн ажилд нь огт хамаагүй этгээд байжээ. Харин сайн Самари хүн энэхүү явцуу ялгаануудыг давж харж чаддаг нэгэн байсан байна. Тэрээр өөрөө аль ч ангилалд таарч тохирохгүй хүн байжээ. Товчхон хэлбэл тэрээр тухайн нийгэмд ямар нэгэн байр суурь эзлээгүй харийн хүн

байсан байна. Тэрээр ямар нэгэн хаяггүй, ямар нэгэн эрхэлсэн ажил, эзэлсэн байр суурьгүй байсан хүний дэргэд очмогцоо алхаагаа саарууулж, төлөвлөгөөгөө өөрчилж, өөрийнх нь тусламж тэр шархадсан хүнд хэрэгтэй болсныг мэдэж түүнд туслахаар гэнэт шийджээ.

102. Өнөөдөр дэлхий ертөнцөд өөрсдийг нь бусдаас салган тусгаарласан дүр төрхтэйгээ үхэн хатан зууралдаж байгаа нийгмийн бүлэглэлүүд буй болж, улам бүр олширч байгаа үед энэхүү сургаалт зүйрлэл хүмүүст ямар сэтгэгдэл төрүүлэх вэ? Энэхүү сургамжит түүх өөрсдийнх нь дүр төрх, тэдний хаалттай, зөвхөн өөрсдөд нь үйлчилдэг бүтцэд ямар нэгэн аюул занал учруулж магадгүй хэмээн болгоомжилж, аливаа гадны төлөөлөл бий болохоос урьдчилан сэргийлж, өөрсдийгөө зохион байгуултад оруулсан хүмүүст яаж тусах вэ? Ийм нөхцөлд хөрш байх боломжгүй билээ. Ийм нөхцөлд зөвхөн өөрсдийнх нь ашиг сонирхолд нийцэн үйлчилж байгаа хүмүүсийг хөрш мөн хэмээн тооцно. “Хөрш” хэмээх үг утга учиргүй болж, харин хөршийн оронд “танилууд” бий болно, тодорхой ашиг сонирхолд хөтлөгдсөн хамсаатнууд буй болно [80].

*Эрх чөлөө, тэгш эрх, ахан дүүгийн ёс*

103. Ахан дүүгийн харилцаа холбоо зөвхөн хувь хүний эрх чөлөөг хүндэтгэн үзэх үзлийн уур амьсгал тогтсоны улмаас, эсхүл засаг захиргааны байгууллагын тогтоосон тэгш байдлаас үүсдэг гэж хэлвэл өрөөсгөл болно. Ахан дүүгийн харилцаа холбоо илүү их ач холбогдолтой харилцаа тогтоохыг шаарддаг, ингэснээр эрх чөлөө, тэгш байдлыг бататган бэхжүүлдэг юм. Ахан дүүгийн харилцаа холбоог ухамсартайгаар төлөвшүүлэхгүй бол юу болох вэ,

ахан дүүгийн харилцаа холбоог боловсролоор дамжуулан дэмжих болон нэг нэгэнтэйгээ харилцах замаар, харилцан нэг нэгэндээ туслах, нэг нэгнийгээ баяжуулахын үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх аргаар дэмжих улс төрийн эр зориг дутвал юу болох вэ? Эрх чөлөө бол та бид өөрсдөө хүссэнээрээ амьдрахын нэр биш, хэнд, эсхүл юунд хамаатай байхыгаа сонгох чөлөөтэй боломжтой байхын нэр биш, хэн нэгнийг, эсхүл ямар нэгэн юмыг өмчлөх, эсхүл түүнийг зөвхөн өөртөө ашигтайгаар ажиллуулахын нэр биш. Эрх чөлөөг ингэж явцуу ойлгох нь түүний баялаг мөн чанарыг үгүйсгэсэнтэй адил болох бөгөөд эрх чөлөө нь юуны түрүүн хайрын сэтгэлд зориулагдсан, түүнд чиглэгдсэн байдаг билээ.

104. Тэгш байдал “эрэгтэй, эмэгтэй бүх хүн тэгш эрхтэй” гэсэн хийсвэр тунхаглалыг зарласнаар бий болохгүй. Харин ахан дүүгийн харилцаа холбоог ухамсартайгаар, тууштайгаар бөөцийлөн бойжуулсаны үр дүнд эрх чөлөө тогтоно. Зөвхөн “ашигтай танилууд”-ын холбоог тогтоосноор хаалттай ертөнцийг бий болгоно. Ийм явцуу холбооны хүрээнд танилуудын хүрээний гадна үлдсэн хүмүүст, нэн ялангуяа өөрсдийгөө болон өөрсдийн гэр бүлийн гишүүдийг сайн сайхан амьдралтай болгохыг зорьдог хүмүүст ямар байр суурь, орон зай олдох вэ?

105. Хувиа бодох үзэл та биднийг илүү эрх чөлөөтэй, илүү тэгш эрхтэй, илүү ойр дотно ахан дүүгийн харилцаа холбоотой болгохгүй. Хувиа бодсон ашиг сонирхлуудын энгийн нийлбэр бүхэл бүтэн хүн төрөлхтний том гэр бүлд илүү тааламжтай дэлхий ертөнцийг бүтээж өгч чадахгүй. Түүнчлэн өнөөдөр даяаршил улам бүр бүхнийг хамрах шинжтэй болж байгаа олон олон “өвчин зовлон”-гоос та

биднийг авран хамгаалж чадахгүй. Гэхдээ хувиа бодох түрэмгий үзэл бол тэнэг биш үзэл мөн учир түүнийг устгахын төлөө зүтгэхийг туйлын хэцүү вирустэй хийх тэмцэлтэй зүйрлэн адилтгаж болно. Энэхүү үзэл та бид бүх юмны учир өөр өөрийн хувийн ашиг сонирхлыг ямар ч хяналтгүйгээр бүхний эхэнд тавихад оршино хэмээн итгүүлж, улам том зорилго тавьж араас нь хөөцөлдөх болон аюулгүйн торыг бүтээх юм бол нийтийн сайн сайхны үйл хэрэгт зүтгэсэн болно хэмээн тооцогдоно гэж хуурч төөрөгдүүлнэ.

## ХУВЬ ХҮМҮҮСИЙГ ДЭМЖСЭН БҮГДИЙГ БАГТААСАН ХАЙРЫН СЭТГЭЛ

106. Нийгмийг хамарсан анд нөхдийн холбоо, бүгдийг хамарсан ахан дүүгийн харилцаа холбоо хэзээ ямагт болон газар бүр хүн болгон үнэ цэнтэйг хүлээн зөвшөөрөхийг шаардана. Хэрэв хүн бүр ийнхүү үнэ цэнтэй юм бол “зарим хүн баялаг ховор, хөгжил сул дорой газар хүн болж төрсөн нь түүний эрхэм чанаргүй, үнэ цэнгүй амьдарч байгааг зөвтгөх үндэслэл болох ёсгүй” [81] гэдгийг туйлын тодорхой бөгөөд чанга хэлэх ёстой юм. Энэ бол нийгмийн амьдралын суурь зарчим мөн бөгөөд харамсалтай нь энэхүү зарчим өөрсдийнх нь ертөнцийг үзэх үзэлтэй нийцэхгүй байна, эсхүл өөрсдийнх нь зорилготой таарахгүй байна хэмээн үздэг хүмүүс уг зарчмыг янз бүрийн аргаар үл тоомсорлох байдлаар баримталдаггүй билээ.

107. Хүмүүн бүр эрхэм чанартай орших, цогц хөгжих эрхтэй төрдөг билээ. Энэхүү суурь эрхийг ямар ч улс орон үгүйсгэх ёсгүй. Зарим хүн үр ашигтай амьдарч чадахгүй байгаа ч, зарим хүн хөгжлийн бэрхшээлтэй төрсөн, эсхүл

хөгжлийн бэрхшээлтэй болсон аль ч тохиолдолд энэхүү эрхийг бүрэн эдэлнэ. Тэд ийм байдалтай байгаа ч хүн учир хэн ч тэдний эрхэм чанарыг үгүйсгэх ёсгүй. Хүний эрхэм чанар байх, байхгүй нь тухайн нөхцөл байдлаас үл шалтгаалах бөгөөд энэхүү чанар гагцхүү түүний хүн болж төрсний заяагдмал эрхийн үнэ цэн дээр тогтоно. Хэрэв энэхүү суурь зарчмыг хатуу баримтлахгүй аваас ахан дүүгийн харилцаа холбоо, улмаар хүн төрөлхтний сайн сайханд ямар ч ирээдүй байхгүй гэж хэлж болно.

108. Зарим нийгэмд энэхүү зарчмыг бүтнээр нь биш хэсэгчлэн баримталдаг. Тэдгээр нийгэм хүн бүрт боломж бололцоог ижил тэнцүү олгох ёстой гэдэгтэй санал нийлдэг. Гэхдээ бүх юм гагцхүү хувь хүнээс өөрөөс нь шалтгаална хэмээн хэлдэг. Ийм байдлаар суурь зарчмыг завхруулбал “сэтгэхдээ удаан, хөдлөхдөө эв хавгүй, бие сул дорой, эсхүл авьяас багатай хүмүүст боломж бололцоотой болоход нь туслахын тулд хөрөнгө оруулалтыг дэмжих оролдлого хийх” [82] нь утгагүй ажил болно. Эмзэг хэсгийнхэнд туслахын тулд хийсэн хөрөнгө оруулалт ашиггүй байж болно, эсхүл аливаа үйл ажиллагааг үр ашиггүй болгож болно. Гэхдээ үгүй ээ, зөвхөн үр ашиг хөөцөлдөж болохгүй. Харин та бидэнд юу хэрэгтэй вэ? гэвэл цаг ямагт бэлэн байдаг, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг төр засаг, иргэний нийгмийн байгууллагууд хэрэгтэй. Эдийн засаг, улс төр, үзэл суртлын системийн чөлөөтэй гэх, үр ашигтай үйл ажиллагаа хэмээхийн адь алийг нь давж харж чаддаг байгууллагууд шаардлагатай. Ийм байгууллагууд хувь хүний эрх ашгийг нийтийн сайн сайхантай хамт цогцоор нь зохицуулахыг хичээдэг юм.

109. Зарим хүн эдийн засгийн хувьд тогтвортой гэр бүлд төрсөн байдаг. Тэд сайн боловсрол эзэмшинэ, тэд таатай орчинд хайр халамжин дунд өсч торнино, заримд нь байгалиас их авьяас заяасан байна. Мэдээжийн хэрэг ийм хүмүүс төр засгийн идэвхтэй үйл ажиллагааг шаардахгүй, тэд зөвхөн эрх чөлөөгөө эрхэмлэнэ. Гэвч яг ийм журам үйлчлэх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангалттай биш. Ийм журам тогтсон байх нь ядуу айлд төрсөн хүүхдэд тохирохгүй, сайн боловсрол эзэмших боломжгүй, эсхүл эрүүл мэндийн сайн эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах боломжгүй хүмүүст тохирохгүй билээ. Хэрэв нийгмийн харилцааг зах зээлийн чөлөөт эдийн засаг, гагцхүү цэвэр үр ашгийн хойноос хөөцөлдсөн эдийн засгийн үйл ажиллагаа голчлон зохицуулна гэж үзэх юм бол ийм нийгэмд дээрх хүмүүс амьдрах орон зайгүй байна гэсэн үг, улмаар ахан дүүгийн харилцаа холбоо бол сулхан, хийсвэр туйлын зорилго байх болно.

110. “Бодит байдал олон хүнд эдийн засгийн эрх чөлөө эдлэх боломж бололцоо олгохгүй байхад, ажлын байртай болох боломж бололцоо улам бүр хумигдаж байхад эдийн засгийн эрх чөлөөг зарлан тунхаглах нь хоёр нүүр гаргах, эсхүл санаатайгаар бусдыг хуурах гэсэн оролдлого мөн” [83] гэж үзэх хэрэгтэй. “Та бид эдийн засаг, нийгмийн тогтолцоо нэг ч хүнийг золиослохгүйгээр ажилладаг болсон цагт, нэг ч хүнийг гээж орхихоо больсон тэр цагт бүгдийг хамарсан ахан дүүгийн харилцаа холбоо тогтсоны баяр наадмыг өргөн дэлгэр тэмдэглэж болно” [84], харин тэр цаг иртэл эрх чөлөө, ардчилал, ахан дүүгийн харилцаа холбоо гэсэн үгнүүд утга агуулгагүй мэт байсаар байх болно. Жинхэнэ хүмүүнлэг, ахан дүүгийн харилцаа холбоо тогтсон нийгэм үр ашигтай бөгөөд тогтвортой арга

замаар энэхүү нийгмийн гишүүн бүр амьдралынхаа үе шат бүрт гав ганцаараа биш харин хамт олонтой байхыг баталгаатай хангаж чаддаг байх ёстой. Гэхдээ хүн бүрийн наад захын хэрэгцээг хангаад зогсохгүй хэдийгээр тэдгээр хүмүүсийн ажил хэргийн гүйцэтгэл дээд зэргийн чанар чансаатай байж чадахгүй ч, тэдний үйл ажиллагааны хурд удаан, үр ашиг муутай ч тэдэнд бусдын сайн сайхны төлөө өөрсдийн чаддаг бүхнээ хийх, зориулах боломж бололцоог олгох хэрэгтэй.

111. Аливаа хүмүүн салшгүй заяагдмал эрхтэй байдаг бөгөөд бусадтай нээлттэй харилцах авьяастай төрсөн байдаг. Та бидний дотор бусадтай харилцах замаар өөрсдийн оршихуйн явцуу хүрээг даван гарах сэтгэлийн дуудлага оршиж байдаг билээ. Учир иймд "хүний эрхийн тухай буруу ойлголтоос болон хүний эрхийг буруу ашигласнаас болж алдаа дутагдал гаргахгүй байхын тулд хичээх ёстой байдаг. Өнөөдөр хувь хүний тухай илүү өргөнөөр ойлгох ёстой тухай чиг хандлага улам бүр тодорч байна. Би үүнийг хувиа бодсон үзлийн тухай гэж хэлэх гэснээ хэлээ хазаж байна. Энэхүү ойлголтын үндэс суурь нь хувь хүн аливаа нийгмийн болон антропологийн харилцаа холбоо, тайлбар сэлтээс ангид байх ёстой гэсэн номлол юм. Хэрэв ингэж ойлговол хувь хүн бусадтай ямар ч холбоогүй "бичил ертөнц" юм шиг төсөөлөгдөнө... Хувь хүн бүрийн эрх илүү том сайн сайхныг бүтээхийн тулд эе эвтэйгээр зохион байгуулалтад орохгүй бол эдгээр эрх хязгааргүй хэмээн тооцогдож, улмаар зөрчил мөргөлдөөн, харгислалын эх сурвалж болж хувирна" [85].

112. Нөгөө талаар та бид бусдын сайн сайхны төлөө, нийт хүн төрөлхтний сайн сайхны төлөө хэмээн зүтгэх гэдэг нь хувь хүн болон тухайн нийгэм хүний цогц хөгжлийг дэмждэг ёс суртахууны үнэт зүйлсийн талаар гүн гүнзгий ухаарахад нь туслахыг багтааж байгаа шүү гэдгийг заавал дурдаж байх шаардлагатай. Шинэ гэрээ Ариун Сүнсийн (харьцуул. *Галат 5:22*) нэгэн үр жимс болох *агатосины* тухай өгүүлдэг билээ. Энэ бол сайн сайханд уягдсан байх, сайн сайхан руу тэмүүлэх гэсэн утга санаа бүхий Грек үг юм. Цаашилбал энэ үг аливаад хамгийн сайн болох, ялангуяа бусдад хамгийн сайн сайхныг бүтээж өгөх, бусад хүн өсөн торниж хэрсүүжих, эрүүл саруул байх, тэд материаллаг баян тансаг байдлын хойноос хөөцөлдөлгүйгээр хэзээ ч үнэ цэнээ алдахгүй үнэт зүйлсийг бөөцийлөн бойжуулахын тухай утга санааг илэрхийлнэ. Үүнтэй адил утга санаа бүхий үг Латин хэлэнд байдаг, энэ бол "*bene-volentia*" буюу шууд утга санаа нь сайн сайхан *(bene)*-ыг хүсэхүй *(volentia)* гэсэн үг юм. Энэ үг бусдад "сайн сайхныг бүтээх эр зориг" гэсэн утга санааг илэрхийлнэ. Түүнчлэн сайн сайхныг санаж хүсэх, аливаа хамгийн үзэсгэлэнтэй, хамгийн дээд зэргийн юм руу тэмүүлэх, бусдын амьдралыг гоо үзэсгэлэнтэй, ариун тансаг, сургамжтай болгоноор дүүргэн чимэхийг хүсэх гэсэн санааг илэрхийлнэ.

113. Харамсалтай нь энд би нэгэн зүйлтийг дахин давтан хэлэх шаардлагатай болж байна. "Та бид ёс суртахуунгүй байдлыг хангалттай харлаа, ёс зүй, сайн сайхан сэтгэл, итгэл үнэмшил, үнэн шударга сэтгэлийг доромжлохыг бас хангалттай харлаа. Аливааг хөнгөмсөг, өнгөцхөн байдлаар харах нь сайн сайхан юм авчрахгүйг зориуд

тэмдэглэн хэлэх хэрэгтэй. Нийгмийн амьдралын суурь зэврэн хэврэгшсэн байхад ашиг сонирхлуудын хоорондын зөрчилдөөн, тэмцэл ноёлно” [86]. Одоо сайн сайхныг дэмжихийн тухай яриандаа эргэж оръё. Өөрсдийнхөө болон нийт хүн төрөлхтний төлөө сайн сайхныг дэмжсэнээр бодитой бөгөөд цогц хөгжил рүү хамтдаа урагшлан дэвшинэ. Аливаа нийгэм үнэт зүйлс нэг үеэс дараагийн үе рүү уламжлагдаж байхыг хүсдэг билээ. Эс тэгвээс дараагийн үе амиа бодох үзэл, харгис түрэмгий зан авир, хээл хахууль зэргийг янз янзын хэлбэрээр үргэлжүүлэх, нэг нэгэндээ туйлын хайнга хандах болно. Ингэснээр нийгмийн амьдрал хувийн ашиг сонирхолын хойноос хөөцөлдөхийн явцуу хүрээнээс гарч чадахгүй гацна, хувь хүмүүсийн хоорондоо зөрчилтэй ашиг сонирхлын торонд орооцолдоно.

*Эв санааны нэгдлийн үнэ цэн*

114. Би эв санааны нэгдлийн тухай бүр онцолж хэлмээр байна. “Эв санааны нэгдэл бол хувь хүний өөрчлөлтийн үр дүнд бий болсон ёс суртахууны нэр төр, нийгмийн хандлага мөн бөгөөд боловсрол, хүн төлөвшлийн асуудлыг хариуцдаг хүмүүст хандан үүрэг хариуцлага үүрэхийг уриалж байгаа билээ. Энд би юуны түрүүн боловсрол олгохын хувьд хамгийн эхний бөгөөд хамгийн чухал үүргийг хүлээж байгаа гэр бүлийн тухай бодож байна. Гэр бүл бол хайрын сэтгэл, ахан дүүгийн харилцаа холбоо, хамт байхын утга учир, нэг нэгэнтэйгээ хуваалцахын сайхан болон бусдын төлөө санаа тавих, тэднийг асран халамжлахын тухай эрдмийг бодит амьдрал дээр сурч нэг нэгэндээ өвлүүлдэг хамгийн анхны газар мөн билээ. Түүнчлэн гэр бүл бол ээжүүд хүүхдүүддээ сэтгэлээ зориулахыг анх үлгэрлэн

үзүүлдэгээс эхлээд гүн гүнзгий итгэл үнэмшлийг өвлүүлэн дамжуулдаг газар мөн. Бяцхан хүүхдүүдэд болон залуучуудад эрдэм заах амаргүй үүргийг нуруундаа үүрдэг багш нар өөрсдийнх нь хариуцлага зөвхөн хичээл заахаас давж бас амьдралын ёс суртахуун, оюун сэтгэл болон нийгмийн хүрээг хамрах ёстойг ойлгох шаардлагатай. Эрх чөлөө, харилцан хүндэтгэл, эв санааны нэгдлийн үнэт зүйлс хүүхдэд бага балчир наснаас нь эхлээд өвлөгдөх ёстой байдаг... Хэвлэл мэдээллийнхэн, ялангуяа өнөөдрийнх шиг мэдээлэл, харилцааны арга хэрэгсэл ихээхэн өргөн дэлгэр болсон энэ цаг үед боловсрол олгох, хүнийг төлөвшүүлэхэд мөн адил хариуцлага үүрэх ёстой"[87].

115. Аливаа бүхэн салан задарч, цул чанараа алдаж байгаа мэт санагдаж байгаа энэ цаг үед та бид эмзэг байдалтай байгаа бусдууддаа туслах хариуцлага үүрснийгээ гүн гүнзгий ухамсарласны учраас буй болсон "нугаршгүй чанга хатуу байдал"-аа [88] дайчилцгаая хэмээн уриалж байна, ингэснээр та бид ирээдүйгээ хамтдаа цогцлоон бүтээж чадна. Эв санааны нэгдэл бусдад үйлчилснээр тод томруун илэрдэг билээ. Ийнхүү үйлчлэх нь бусдын төлөө санаа сэтгэл тавих олон олон арга хэлбэрээр хэрэгжинэ. Ийнхүү үйлчлэх хэмээхийн гол утга санаа "эмзэг хэсгийнхнийг халамжлах, тэдэнд анхаарал тавих, тодруулбал та бидний гэр бүл, манай нийгэм, ард түмний эмзэг гишүүдийг халамжлахад оршино". Хувь хүн бусдын төлөө санаа тавьснаар "хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийн томоор харсан нүдний харцны өмнө өөрийн эрхгүй өөрийн хүсэл, сонирхлоо хажуу тийш тавих, эрх мэдлийн хойноос хорхойсохоо болихын агуу эрдэм"-ийг сурна. "Бусдын төлөө өөрийгөө зориулна гэдэг бол тэдний нүд

рүү харна, биед нь хүрнэ, тэдэнтэй ойр дотно болсныгоо мэдрэнэ, тэр байтугай зарим тохиолдолд тийнхүү ойр дотно болсныхоо төлөө “шаналнa”, тэдэнд туслахыг үнэн сэтгэлээсээ хүснэ. Бусдад өөрийгөө зориулахад үзэл суртал шаардагдахгүй, учир нь та бид үзэл санаанд биш харин хүнд үйлчилдэг билээ” [89].

116. Тусламцаа шаардагдаж байгаа хүмүүс хоорондоо “зөвхөн ядуу зүдүү, зовж зутарсан хүмүүсийн дунд байдаг онцгой эв санааны нэгдлийн холбоог үүсгэдэг. Харамсалтай нь та бидний амьдарч буй өнөөгийн соёл иргэншил тэрхүү эв санааны нэгдлийг нэг бол мартсан, эсхүл мартахыг хүсэж байна. Одоо цагт эв санааны нэгдэл хэмээх үгийг тэр болгон сайхнаар хүлээж авахаа больсон байна. Зарим тохиолдолд энэ үгийг муухай үг гэх болж, хэлээхээсээ хүртэл айж эмээдэг болсон байна. Уг нь эв санааны нэгдэл бол гэнэт нөмрөн ирдэг, тэгснээ замхран алга болдог бусдад өгөөмөөр зан гаргах хүслийн нэр бишээ. Энэ үг бусад хүмүүсийн тухай бодох, тэдний төлөө үйл ажиллагаа явуулах утга санааг илэрхийлнэ. Энэ үг хүмүүсийн амьдрал бол цөөн тооны хэдэн хүн эд хөрөнгөтэй болохоос илүү чухал юм гэсэн утга санааг илэрхийлж байгаа юм. Энэ үг ядуурал, тэгш бус байдал, ажилгүйдэл, газаргүй, гэр оронгүй байхын бүтцийн учир шалтгаан болон нийгмийн, хөдөлмөрийн эрхийг үгүйсгэхийн эсрэг тууштай тэмцэх утга санааг илэрхийлж байгаа юм. Энэ үг ганцхан мөнгө ноёрхдог эзэнт гүрний нураан сүйтгэх мөн чанарын эсрэг тэмцэх утга санааг илэрхийлж байна... Эв санааны нэгдэл хэмээх үгийн язгуур утга санаа нь түүх бүтэх арга зам хэмээх утгыг илэрхийлж байгаа бөгөөд чухам энэхүү түүхийг ард түмний хөдөлгөөнүүд бүтээж байдаг билээ” [90].

117. Та бид өөрсдийн дундын гэр орон болсон гараг дэлхийгээ хайрлан халамжлах ёстой хэмээн хэлэхдээ нийт хүмүүсийн зүрх сэтгэлд байдаг хамтын ухаан, харилцан нэг нэгнийхээ төлөө санаа тавьдаг сэтгэлийн очийг асаахыг хүсдэг билээ. Усны хангамж илүүдэлтэй байдаг ч түүнийг ариг гамтай хэрэглэж нийт хүн төрөлхтний том гэр бүлийн хэрэгцээнд нөөцлөн хадгалж байдаг хүмүүс өөрсдийн хувийн болон өөрсдөө дунд нь байдаг цөөн тооны хүмүүсийн явцуу эрх ашгийг даван харах чадвартай ёс суртахууны өндөрлөгт хүрсэн байна гэж хэлж болно. Энийг л чухам яасан гайхамшигтай хүмүүнлэг сэтгэл вэ! хэмээн дуу алдан магтан сайшаах хэрэгтэй. Та бид бүх хүмүүс, тэр байтугай та бидний амьдарч байгаа улс орны хил хязгаарын чанадад оршин сууж байгаа хүмүүсийн эрхийг бүрэн хүлээн зөвшөөрөхөд яг ийм сэтгэлийн хандлага шаардагдана.

## ӨМЧИЙН НИЙГМИЙН ҮҮРГИЙГ ДАХИН ЭРГЭЦҮҮЛЭХҮЙ

118. Манай газар дэлхий хүн бүрийн төлөө оршиж байгаа. Учир нь та бид хорвоод мэндлэхдээ бүгд адилхан эрхэм чанартай төрсөн байдаг. Арьсны өнгө, шашин шүтлэг, авьяас чадвар, төрсөн өссөн нутаг, одоо оршин сууж байгаа газар зэрэг өөр олон олон ялгаа хэрхэвч зарим хүн бусдаасаа илүү эрхтэй мэтээр үзэх үзлийн зөвтгөл болж болохгүй. Та бид нэгэн том хамт олны хувьд хүн бүр эрхэм чанартай орших ёстой, хүн бүр цогц хөгжих боломж бололцоогоор хангагдсан байх ёстой хэмээн үзэж, энэхүү зарчим баталгаатай хэрэгжихэд туслах үүрэгтэй билээ.

119. Христийн шашин дөнгөж дэлгэрч байсан эхний үед хэд хэдэн сэтгэгчид бүтээсэн эд баялгийн нийтийн

зориулалтын тухай эргэцүүлснийхээ үр дүнд нийтийг хамарсан нэгэн үзэлтэй болсон байна [91]. Ингэснээр тэд хэрэв нэг хүн эрхэм чанартай амьдрахад нь ямар нэгэн юм дутагдаж байгаа бол өөр хүн тэрийг нь авчихаад өгөхгүй байгаа юм байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Гэгээн Иохан Хризостом энэ бүхнийг дараах байлаар нэгтгэн айлдсан байна: "Өөрийн баялгийг ядуу зүдүү хүмүүстэй хуваалцахгүй байна гэдэг бол тэднийг дээрэмдэж, амьжиргааны эх үүсвэргүй болгож байна гэсэн үг. Бидний баялаг бол зөвхөн бидниймх биш тэднийх мөн адил мөн билээ" [92]. Гэгээн Агуу Грегори ингэж айлдсан байна: "Бид ядуу зүдүү хүмүүст наад захын хэрэгцээг нь хангахуйц юм өгнө гэдэг бол бидний биш харин тэдний өөрсдийнх нь юмыг буцааж өгч байгаа юм" [93].

120. Энд би Гэгээн II Иохан Паулын айлдсан, одоо болтол бүрэн үнэлэгдээгүй байгаа: "Тэнгэрбурхан газар дэлхийг хэн нэгнийг ялгаварлан илүү, эсхүл дутуу үзэлгүйгээр бүх хүн өлсөж цангахыг мэдэхгүй тогтвортой амьдрахад зориулж нийт хүн төрөлхтөнд дунд нь өгсөн билээ" [94] гэсэн хүчирхэг үгийг дахин сануулж байна. Миний хувьд: "Христийн шашны уламжлалд хувийн өмчийн эрхийг үнэмлэхүй шинж чанартай, ямагт халдашгүй дархан хэмээн хэзээ ч үзэж байгаагүй билээ. Бүхий л хэлбэрийн хувийн өмч нийгмийн зориулалттайй байх ёстой хэмээн үздэг билээ" [95] гэсэн байр суурийг баримталдаг. Бүтээсэн эд баялаг нийт хүн төрөлхтөнд зориулагдсан байх ёстой гэсэн зарчим бол "бүхэл бүтэн ёс суртахууны болон нийгмийн ёс журмын хамгийн эхний зарчим мөн билээ" [96]. Энэ бол байгалиас заяагдсан эрх мөн бөгөөд нийт эрхийн тэргүүн эрх мөн [97]. Хувь хүний цогц төлөвшил хөгжилд шаардлагатай бараа бүтээгдэхүүн,

сайн сайхантай холбоотой бусад бүх эрх, хувийн өмчтэй, бусад өмчтэй байх эрх, Гэгээн VI Паулын айлдсанаар “энэхүү хамгийн чухал эрхийг ямар нэгэн байдлаар үл хэрэгсэж болохгүй бөгөөд харин ч хэрэгжих нөхцлийг нь хангахын тулд идэвхтэй ажиллах хэрэгтэй” [98] юм. Бүтээсэн баялгийг нийт хүн төрөлхтөнд зориулагдана гэсэн зарчмыг ягштал баримталбал хувийн өмчтэй байх эрх хоёрдогч шинж чанартай нь тодорхой болно. Аливаа нийгмийн үйл ажиллагаанд энэхүү зарчим туссан байх ёстой бөгөөд ингэснээр тодорхой үр дүн гарна. Харамсалтай нь олон тохиолдолд хоёрдогч шинж чанартай эрхүүд анхдагч шинж чанартай гол эрхийн байр суурийг эзэлдэг бөгөөд ингэснээр гол эрх шаардлагагүй юм шиг болдог.

*Хил хязгаарт баригддаггүй эрхүүд*

121. Тийм учир хэн нэгнийг хаана төрснөөс нь шалтгаалан хүний тооноос хасч болохгүй. Түүнчлэн илүү боломж бололцоотой газар нутагт төрсөн учраас бусдаас давамгай байдалтай байгаа тэр хүмүүсээс дутуу эрх эдлэхийг хүлээн зөвшөөрч болохгүй. Улс орнуудын хил хязгаар хүний эрх ижил тэгш хэрэгжихийн замд хаалт садаа болж зогсохыг зөвшөөрч үл болно. Үүний нэгэн адил зарим хүн эмэгтэй хүн болж төрснийхөө төлөө бусдаас цөөхөн эрхтэй байж болохгүй, түүнчлэн төрсөн нутаг, амьдарч байгаа газраасаа болоод хөгжил дэвшлийн ололтоос хоцрох ёсгүй, нэр төртэй амьдрах боломж бололцоогоор дутуу хангагдсан байх ёсгүй билээ.

122. Аливаа хөгжил дэвшил цөөн тооны хүмүүс бүх баялгийг хураан цуглуулах зорилготой байх ёсгүй, харин “хувь

хүний болон нийгмийн, эдийн засгийн, улс төрийн эрх, түүнчлэн улс үндэстнүүд, ард түмнүүдийн эрхийг баталгаатай хангахад чиглэгдсэн байх ёстой” [99]. Зарим хүний эдийн засгийн хувьд чөлөөтэй үйл ажиллагаа явуулах эрх, зах зээлийн эдийн засгийн эрх чөлөө ард түмнүүдийн эрх, ядуу зүдүү амьдралтай хүмүүсийн эрхэм чанарыг үгүйсгэх ёсгүй юм. Тодруулбал байгал орчныг хайрлан хүндэтгэхийг бас үгүйсгэж үл болно. “Хэрэв та бид ямар нэгэн юмыг өөрийн хувийн болговол түүнийг гагцхүү бусдын сайн сайхны төлөө удирдан зохицуулах үүрэгтэй юм” [100].

123. Бизнесийн үйл ажиллагаа бол уг мөн чанартаа “баялаг бүтээх, манай ертөнцийг улам сайжруулахад чиглэгдсэн эрхэм хувь заяа мөн” [101] билээ. Тэнгэрбурхан биднийг Түүний бидэнд хайрласан авьяас чадварыг хөгжүүлэх хэрэгтэй хэмээн зоригжуулдаг бөгөөд Тэрээр бидний амьдарч байгаа дэлхий ертөнцийг хэмжээлшгүй их нөөц бололцоотойгоор бүтээсэн байдаг юм. Тэнгэрбурханы төлөвлөгөөгөөр бол хувь хүн бүр өөрийн нөөц бололцоог дайчлан өөрийгөө дээд зэргээр хөгжүүлэх ёстой байдаг [102]. Энэ нь эд барааг улам олон болгох, баялагийг нэмэгдүүлэхийн тулд эдийн засаг, технологийн хамгийн шилдэг шийдлийг олох гэсэн үг юм. Бизнесийн чадвар бол Тэнгэрбурханы заяасан авьяас чадвар мөн бөгөөд энэ нь гагцхүү янз янзын ажлын боломж бололцоог бий болгосноор бусдыг хөгжүүлэх, ядуурлыг арилгахад чиглэгдсэн байх ёстой. Дэлхий ертөнцийн аливаа баялаг эцсийн эцэст бүгдэд зориулагдсан байх ёстой гэсэн хамгийн чухал, хамгийн гол зарчим хувийн өмчтэй байх эрхийг салшгүй дагалдаж байдаг бөгөөд ингэснээр бүгд энэхүү баялгийг ашиглах эрхтэй байна гэсэн үг [103] юм.

124. Өнөөдөр дэлхий ертөнцийн эд баялаг нийтийн хэрэгцээнд зориулагдах ёстой гэсэн хатуу итгэл үнэмшил, энэхүү зарчим улс үндэстэн, тэдний газар нутаг, түүний баялагт мөн адил хамаарах ёстой юм. Хувийн өмчийн болон иргэдийн эрхийн эрх зүйн чадамжийн өнцгөөр зогсохгүй аливаа эд баялаг нийтийн хэрэгцээнд зориулагдана гэсэн хамгийн эхний баримтлах ёстой зарчмын өнцгөөс харвал аливаа улс орон гадаадын хэмээх хүнд бас хамаатай гэж хэлж болно. Энэ нь тухайн улс орны нутаг дэвсгэрт бий болсон эд баялаг, бараа бүтээгдэхүүнийг өөр газраас ирсэн ядуу зүдүү хүнд өгөхөөс татгалзах ёсгүй гэсэн үг юм. АНУ-ын Тэргүүн хамба нарын сургасны дагуу "аливаа нийгэм байгуулагдахаас бүр өмнө суурь эрхүүд байсан бөгөөд тэд Тэнгэрбурхан хүн бүрийг бүтээхдээ хайрласан эрхэм чанараас үүдэлтэй" [104] ажээ.

125. Ингэснээр улс орнуудын хоорондын харилцаа, солилцоог ойлгох өөр өнцөг гарч ирж байна. Хэрэв хүн бүр салшгүй эрхэм чанартай гэдэг нь үнэн юм бол, нээрээн бүх хүмүүс нэг нэгэндээ ах, эгч, дүү болно гэдэг нь зөв юм бол, хүн бүр бусдын нэгэн адил газар дэлхийн эзэн гэдэг нь үнэн юм бол манай хөрш надтай нэгэн адил нэг улс оронд, эсхүл өөр улс оронд төрсөн гэдэг нь чухал биш болно. Манай улс орон түүний хөгжил дэвшлийн төлөө мөн адил хариуцлага хүлээх ёстой бөгөөд энэхүү хариуцлагаа янз янзын аргаар хэрэгжүүлж болно. Ихээхэн хэрэгцээ шаардлагатай хүнд өгөөмөр сэтгэлээр хандаж болно, эсхүл тухайн хүний төрсөн улс орон дахь амьдралын нөхцөлийг сайжруулахын тулд тэр орныг дарангуйлан мөлжих, байгалийн баялгийг нь ховх сорох, тэнд тогтсон

хээл хахуулийн системийг дэмжихээ болих буюу энэ орны ард түмний бодитой хөгжилд саад учруулж байгаа аливаа юм, үзэгдэл, үйлдлийг дэмжихээ больж болно. Ийнхүү улс орнууд болон ард түмнүүдийн нэгэн адил ийм байдлаар улс орон бүрийн доторх үлэмж их тэгш бус байдал ноёлсон янз янзын бүсүүдэд хандаж болно. Зарим үед бүгд ижил тэгш хүний эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрч чадахгүй байгаа байдал зарим улс орны илүү хөгжилтэй бус нутаг тухайн орны ядуу бүсүүдийг "хэрэггүй ачаа" хэмээн үзэж, тэднээс салснаар өөрсдийн хэрэглээг нэмэгдүүлнэ хэмээн андууран бодоход хүргэдэг билээ.

126. Энд та бид үнэхээр олон улсын харилцааны шинэ сүлжээний тухай ярьж байна. Учир нь та бид зөвхөн хувь хүмүүс, эсхүл жижиг орнууд нэг нэгэндээ харилцан туслах хэмжээнд бодсоор байх юм бол дэлхий ертөнцийн томоохон тулгамдсан асуудлуудыг хэзээ ч яагаад ч шийдвэрлэж чадахгүй билээ. Түүнчлэн та бид бас нэгэн юмыг мартаж болохгүй. Энэ бол "Тэгш бус байдал зөвхөн хувь хүнээр зогсохгүй бүхэл бүтэн улс орнуудыг хөнддөг. Тэгш бус байдал та бид олон улсын харилцааны ёс зүйн тухай эргэцүүлэн бодохоос өөр аргагүй байдалд хүргэж байна" [105]. Нээрээн шударга ёс зөвхөн хувь хүний эрхээр зогсохгүй нийгмийн эрх, ард түмний эрхийг хүндэтгэн хүлээн зөвшөөрөхийг шаардаж байна [106]. Энэ нь "ард түмэн наад захын хэрэгцээгээ хангуулах болон хөгжих эрхтэй хэмээх суурь эрхийг хангах" [107] арга замыг олохыг хэлж байгаа юм. Харин энэхүү эрхийг бүрэн эдлэхэд гадаад өрийн дарамт ихээхэн саад бэрхшээл учруулдаг билээ. Олон тохиолдолд гадаад өрийн төлбөр хөгжлийг дэмжихэд саад болоод зогсохгүй хөгжлийг боймлож, хөгжих нөхцөлийг улам хүндрүүлдэг

юм. Хуулийн дагуу авсан зээлээ буцааж төлөх ёстой гэсэн зарчмыг хүндэтгэн баримтлах ёстой нь үнэн боловч ядуу буурай олон улс орон энэхүү үүргээ биелүүлэхдээ ер нь оршин тогтносон хэвээр байх эсэх, хөгжих эсэх асуудалтай шууд тулгарч байгаа нь буруу юм.

127. Энэ бүх байдал өөрөөр бодож сэтгэхийг шаардаж байгаа нь тодорхой. Ингэж шинээр, өөрөөр сэтгэж эхлэхгүй бол миний энд хэлж номлож байгаа нь бодитой бус мэт санагдана. Та бид нэг талаас хүний салшгүй эрхэм чанараас үүдэлтэй эрх бий гэсэн агуу зарчмыг хүлээн зөвшөөрч баримталбал шинэ хүн төрөлхтний дүр төрхийг урьдчилан төсөөлөн харах тэр шаардлагын хэмжээнд очихоор өндийн босож чадна. Ингэснээр та бид бүгдийг газар, орон сууц, ажилтай болгох тийм ертөнцийг бүтээхийн төлөө тэмүүлж болно. Энэ бол жинхэнэ энх тайвны зам мөр мөн билээ. Та бид гадаад аюул заналтай тулгарахад айж эмээх, үл итгэх байдлын үрийг суулгадаг утга учир муутай, харалган стратегиас татгалзах шаардлагатай. Бодитой бөгөөд бат бэх энх тайван гагцхүү “хүн төрөлхтний нэгэн том гэр бүлд багтан нэг нэгнээсээ харилцан хамаарал бүхий, үүрэг хариуцлагаа ижил тэгш хуваасан ирээдүйг цогцлоон бүтээхийг зорьсон эв санааны нэгдэл, хамтын ажиллагааны бүхнийг хамарсан ёс зүйн үндэс суурин дээр” тогтох боломжтой [108] юм.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

# БҮХ ДЭЛХИЙД НЭЭЛТТЭЙ ЗҮРХ СЭТГЭЛ

128. Хэрэв бүх хүмүүс хоорондоо ах, эгч, дүүгийн харилцаа холбоотой гэдэг нь хийсвэр ойлголт биш харин тодорхой биеллээ олох ёстой итгэл үнэмшил мөн гэж үзвэл үүнтэй холбоотой олон асуудлууд ар араасаа цувран урган гарч ирэх бөгөөд та бид тэдгээрийн нөлөөн дор аливаа юмыг шинэ өнцгөөс олж харах, шинэ хариултуудыг олох шаардлагатай тулгарна.

## ХИЛ БА ТҮҮНИЙ ТОГТООСОН ХЯЗГААР

129. Та бидний хөрш гаднаас дүрвэж ирсэн хүн байх юм бол бөөн асуудал босч ирэх нь ойлгомжтой [109]. Уг нь болдогсон бол дүрвэгсэд ирдэггүй байвал сайн. Ийм байхын тулд тэдний ардаа үлдээн орхиж байгаа улс оронд хүн шиг амьдрах, цогц хөгжихөд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлж өгөх хэрэгтэй юм. Гэхдээ ийм таатай нөхцөл бүрдтэл та бид аливаа хүн, хүмүүс өөрсдийнх нь болон тэдний гэр бүлийн гишүүдийн наад захын хэрэгцээг хангаж байгаа, өөрсдөө өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд боломжтой газрыг сонгон амьдрах эрхтэй гэдгийг нь хүндэтгэн хүлээн зөвшөөрөх ёстой. Та бид гаднаас дүрвэн ирж байгаа хүмүүст хандах ёстой хандлагыг дөрөвхөн үгээр илэрхийлж болно. Энэ бол: тосож авна, хамгаална,

дэмжинэ, шинэ нийгэмд дасган зохицуулна гэсэн дөрвөн үг юм. Учир нь "энэ бол дээрээс доош чиглэгдсэн халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай асуудал биш харин дүрвэгсэдтэй хамт амаргүй замыг туулах, чингэхдээ энэ дөрвөн үгийн илэрхийлсэн утга санааг ухамсартай үйлдэл болгох, ингэснээр өөрсдийн соёл, шашны өвөрмөц дүр төрхийг хадгалан хамгаалахын зэрэгцээ аливаа өөр юманд нээлттэй байх, хүмүүний ахан дүүгийн ёсын дагуу тэдгээр ялгааг яаж дэмжин хөгжүүлэхийг мэддэг байхын тухай юм" [110].

130. Ингэхийн тулд зарим зайлшгүй арга хэмжээ авах ёстой байдаг. Ялангуяа хүмүүнлэгийн гүн гүнзгий хямралаас зугтаж дүрвэсэн хүмүүст туслахын тулд ингэхээс өөр аргагүй. Тухайлбал, дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж болно: виз олгох, олгохдоо хялбаршуулсан журмаар олгох, хувь хүн, эсхүл нэг хэсэг хүмүүс дүрвэгсдэд тусалж тэднийг спонсорлохыг дэмжсэн хөтөлбөр батлан хэрэгжүүлэх, хамгийн эмзэг дүрвэгсдэд зориулж хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэхийн тулд тэдэнд тусгайлан зориулж ямар нэгэн хүндрэлгүйгээр буюу ногоон гэрлээр орж ирэх журмыг тогтоох, дүрвэгсдийг таарч тохирсон тав тухтай орон сууцаар хангах, хувийн аюулгүй байдлыг нь баттай хамгаалах, тэдэнд наад захын шаардагдах үйлчилгээ үзүүлэх, дүрвэгсдийг консулын шуурхай үйлчилгээгээр хангах, хувийн бичиг баримт бүрдүүлэх эрхийг нь хангах, хууль, шүүхийн байгууллагаар бусдын нэгэн адил үйлчлүүлэх, банкны данс нээх боломж олгох, амьжиргааны наад захын хэрэгцээг нь хангасан санхүүгийн эх үүсвэр олгох, дуртай газар руугаа явах, ажлын байраар хангагдах боломж бололцоо олгох, үндэсний цөөнхийг хамгаалах, тэднийг боловсрол эзэмших боломжоор

байнга хангах, шинэ газар идээшин дасах хүртэл нь түр хугацаагаар заавар зөвөлгөө өгөх байдлаар халамжлах, эсхүл түр хугацаагаар толгой хорогдох байртай байлгах хөтөлбөр батлан санхүүжүүлэх, шашин шүтэх эрхийг нь баталгаатай хангах, шинэ нийгэмд дасан зохицохыг нь дэмжих, гэр бүлүүдийн гишүүд нэг нэгнийгээ олж нэгдэн нийлэх үйл явцыг дэмжих, орон нутгийн оршин суугч иргэд дүрвэгсдийг хүлээн авах, тэднийг өөрсдийн дунд оруулан хүлээн авах бэлтгэлийг хангах [111] зэргийг тоочиж болно.

131. Нүүж ирээд суурьшсан, тухайн нийгмийн эд эс нь болж чадсан хүмүүсийг "иргэншил" хэмээх ойлголтод хамруулах нь чухал ач холбогдолтой юм. Ингэснээр тэд эрх, үүргийн хувьд бусадтай ижил тэгш байх бөгөөд улмаар бүгд шударга ёсын үр шимийг хүртэх боломж бололцоотой болно. Ийм учир манай нийгэмд бүрэн иргэншил хэмээх ойлголтыг нэвтрүүлэн тогтоох нь чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн цөөнх гэсэн ялгаварлан гадуурхсан ойлголтыг хэрэглэхээсээ татгалзах шаардлагатай. Энэхүү ялгаварлан гадуурхсан ойлголт бусдаас зай барин зожигрох, бусдын өмнө доорд үзэгдэх байдлыг бий болгоно. Энэхүү ойлголтыг буруугаар ашиглавал дайсагналыг бий болгож, эе эвийг эвдэх болно. Энэ буруу ойлголт аливаа амжилтыг үгүйсгэж, зарим иргэдийн шашин шүтэх эрхийг нь үгүйсгэх, иргэний эрхийг нь хөндөх бөгөөд ийнхүү тэднийг бусдаас хөндийрүүлэх, ялгаварлан гадуурхах байдлыг бий болгоно [112].

132. Хэдийгээр улс орнууд ихээхэн чухал ач холбогдолтой иймэрхүү алхмуудыг хийж болох боловч тэд өөрсдөө

тулгамдсан асуудалд таарч тохирсон оновчтой шийдвэрийг бие даан хэрэгжүүлэх боломжгүй байдаг билээ. Учир нь "тухайн улс орны гаргасан шийдвэрийн үр дагавар олон улсын хамтын нийгэмлэгт бүхэлд нь зайлшгүй нөлөөлдөг" юм. Ингэсний үр дүнд "бидний авч буй хариу арга хэмжээ гагцхүү хамтын хүчин чармайлтын үр дагавар байх ёстой болдог" [113] бөгөөд энэ нь дүрвэгсдийн хөдөлгөөнүүдийг харгалзсан дэлхий дахины удирдлагын оновчтой хэлбэрийг олж хөгжүүлнэ гэсэн үг юм. Улмаар "дунд болон урт хугацааны төлөвлөлт шаардагдах бөгөөд эдгээр төлөвлөгөө онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээгээр хязгаарлагдах учиргүй юм. Энэхүү төлөвлөлт дүрвэгсдийг хүлээн авч буй улс орнууд тэднийг өөрийн хүмүүс болгож авахад зориулагдсан үр дүнтэй туслалцааны арга хэмжээнүүдийг багтаасан байх ёстой. Үүний зэрэгцээ эв санааны нэгдлийн зарчимд тулгуурлан дүрвэгсдийн уугуул улс орнууд хөгжихөд нь тус болох бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байдаг билээ. Гэхдээ тухайн дэмжлэг туслалцааг үзүүлэхдээ ингэхийгээ тусламж хүртэж буй ард түмнүүдийн хувьд тэдэнд болон тэдний соёлд харш, эсхүл бүр сөрөг шинж чанартай үзэл суртлын номлол, эсхүл үйл ажиллагаатай холбож болохгүй" [114].

### ХАРИЛЦАН БЭЛЭГ ӨГӨХ

133. Өөр хүмүүс нүүж ирэх, амьдралын өөр өөр хэвшилтэй, өөр өөр соёлыг төлөөлсөн хүмүүс нүүж ирэх нь хишиг хүртэж байгаатай адил юм болж байна хэмээн үзэж болно. Учир нь "дүрвэгсдийн түүх бол хувь хүмүүс болон соёлуудын хоорондын учралын түүх байдаг билээ. Дүрвэгсэд

хүрэлцэн ирж нэгдэн нийлж байгаа хамт олон, нийгэмдээ улам баялаг шинж чанартай болох, хүн бүрт цогц хөгжин дэвжих боломж бололцоог олгоно” [115]. Ийм учраас “би ялангуяа залуучуудад хандаж танай улс оронд хүрэлцэн ирж байгаа залуучуудыг эсэргүүцэхийг өдөөн хатгаж байгаа тэр хүмүүсийн тоглоом битгий болооч, өөр улс орноос хүрэлцэн ирж байгаа залуучууд аюул занал учруулна мэтээр сурталчилж байгаа хүмүүсийн өдөөн хатгалтад битгий автаач, хүн бүрт заяагдсан уугуул эрхэм чанар гадаадаас дүрвэн ирсэн хүмүүст байхгүй мэтээр ухуулж байгаа хүмүүст битгий хууртаач хэмээн хэлэх байна” [116].

134. Нээрээн та бид биднээс өөр хүмүүст зүрх сэтгэлээ нээснээр тэдэнд өөрсдийн өвөрмөц дүр төрхийг хадгалахын зэрэгцээ шинэ шинэ аргаар хөгжих боломж бололцоо нээн өгч байгаа юм. Зуун зууны турш хөгжсөн өөр өөр соёлуудыг хадгалан хамгаалснаар манай дэлхий ертөнц дотоод эрч хүчээ алдахгүй байх боломжтой болно. Ингэхийн зэрэгцээ өөр өөр соёлууд өөр бодит байдалтай тулгарснаар шинэ туршлага хуримтлуулан баяжих боломж бололцоонд нээлттэй байхыг урамшуулан зоригжуулах хэрэгтэй бөгөөд аливаа соёл гацаж хөшихийн эрсдэлд орох аюул заналтай байнга тулгарч байдаг учир ийнхүү нээлттэй болж баяжсанаар энэ эрсдэлээс зайлах боломжтой болох юм. Ийм учир “бид хоорондоо харилцаа холбоотой байх, хүн бүрийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, та биднийг хооронд нь ойртуулан холбож буй аливаа бүхнийг дэмжих, нэг нэгнээсээ өөр өөр ялгаатай байгаагаа нэг нэгнийгээ хүндэтгэн улам бүр өсөн дэвжихийн боломж бололцоо хэмээн олж харах шаардлагатай байна. Ийнхүү хоорондоо харилцахад нэг нэгэндээ итгэх, нэг нэгэндээ

хүлээцтэй хандах явдал зайлшгүй шаардагдана. Ингэснээр хувь хүмүүс, гэр бүлүүд, хамт олнууд өөрийн соёлын үнэт зүйлсийг бусдад түгээх, бусдын хуримтлуулсан туршлагаас сайн сайхныг нь өөрийн болгож хүлээн авах боломж бололцоотой байх болно" [117].

135. Энд би өмнө нь дурдаж байсан зарим жишээг та бүхэнд толилуулья. Латин Америкийн соёл бол "АНУ-ын соёлыг ихээхэн баяжуулах үнэт зүйлс болон боломж бололцоог нэмэгдүүлсэн хөрөнгө мөн", "эрчимтэй өрнөсөн нүүдэл суудал ямагт тухайн хүлээн авагч талын соёлд нөлөөлж, түүнийг өөрчлөн хувиргадаг билээ... Аргентин Улсад Италиас эхтэй эрчимтэй нүүдэл Аргентины нийгмийн соёлд өөрийн тодорхой тэмдгийг тавьсан юм. 200,000 орчим еврейчүүд Буэнос Айрес хотын соёлын "хэв маяг"-т хүчтэй нөлөө үзүүлсэн байдаг. Бусад улс орноос нүүж ирсэн дүрвэгсдэд нийгэмдээ дасан зохицоход нь дэмжин тусалвал тэдний нүүж ирсэн нь тухайн нийгмийн хувьд ихээхэн аз тохиосон хэрэг болно, түүний улам баяжихын эх сурвалж болно, тухайн нийгэм хөгжин дэвшихэд тус дэмжлэг үзүүлэхүйц шинэ бэлэг болно" [118].

136. Энэнээс илүү өргөн хүрээгээр яривал Их Имам Ахмад Аль-Тайеб бид хоёр "Дорно, Өрнө хоёр хоорондоо сайн харилцаатай байх нь аль алинд нь хэрэгтэй. Энэ хоёрын алийг нь ч үл тоож болохгүй, энэ хоёрын аль нь ч нөгөөдхөө үл тоомсорлож болохгүй. Харин үр дүнтэй харилцаа, яриа хэлэлцээний арга замаар нэг нэгнийхээ соёлыг баяжуулах нь зөв юм. Тухайлбал Өрнөдийн ертөнц материализм давамгайлсны уршгаар буй болсон оюун ухаан, шашны хямралаас гарах аргаа Дорнын ертөнцөөс олж болно. Харин Дорнын ертөнц сул дорой

байдал, хуваагдал хагарал, зөрчил мөргөлдөөн, шинжлэх ухаан, техникийн хоцрогдол, соёлын уруудал доройтлоос гарах олон аргыг Өрнийн ертөнцөөс олж болно. Түүнчлэн Дорнын ертөнцийн ааш араншин, соёл, соёл иргэншлийг төлөвшүүлэхэд ихээхэн чухал үүрэгтэй шашин, соёл болон түүхийн ялгаануудад анхаарал хандуулах хэрэгтэй юм. Дорнын болон Өрнийн эрэгтэй, эмэгтэй бүх хүмүүсийн нэр төртэй амьдралыг баталгаажуулахад туслах зорилгоор хүний суурь эрхүүдийн хэлхээ холбоог бэхжүүлэх нь мөн адил чухал ач холбогдолтой юм. Ингэснээр тухайн нөхцөл байдалд тохируулан нэг асуудалд хоёр өөр байр сууринаас ханддаг зохисгүй байдлаас зайлсхийж чадна" [119].

*Үр ашигтай солилцоо*

137. Улс орнууд хоорондоо харилцан туслаж байх нь аль алиныг нь баяжуулдаг бөгөөд энэ бол нэгэнт батлагдсан зүй тогтол мөн гэж хэлж болно. Өөрийн язгуур соёлын мөн чанарыг алдалгүй түүндээ тулгуурласан хэвээр байхын зэрэгцээ урагш дэвшин хөгжиж байгаа улс орон бол нийт хүн төрөлхтний хувьд үнэт баялаг мөн билээ. Өнөөдөр та бид нэг бол бүгдээрээ хамт аврагдана, эсхүл хэн нь ч ганцаараа аврагдаж чадахгүй гэсэн үнэнийг ойлгон хүлээн зөвшөөрөх ухаарлыг хөгжүүлэх хэрэгтэй байна. Ертөнцийн нэг өнцөгт ядуурал, уналт доройтол, зовлон зүдүүр оршсоор байгаа нь яваандаа нийт дэлхий дахиныг хамрах асуудлууд урган гарах чимээгүй шимт хөрс болж байдаг юм. Та бид зарим ан амьтан алга болж байна хэмээн санаа зовдог хэрнээ манай дэлхий ертөнцийн зарим хэсэгт хувь хүмүүс, ард түмнүүд ядуурал, эсхүл бүтцийн хязгаарлалтаас болж нөөц бололцоо, гоо сайхныгаа бүрэн

бүтнээр нь нээн хөгжүүлж чадахгүй байгааг анзаарахгүй царайлан сууж болохгүй, харин ч хамгийн ихээр санаа зовох ёстой билээ. Эс тэгвээс эцсийн эцэст ийм хүнд байдал та биднийг бүгдийг нь хамрах болно.

138. Нэг юм ямагт үнэн явсаар ирсэн, өнөөдөр дэлхий ертөнц даяаршлын нөлөөгөөр хоорондоо улам нарийн холбогдож байгаа энэ цаг үед түүний үнэн гэдэг нь илүү тодорхой болж ирж байна. Та бид дэлхий ертөнцөд хууль эрх зүйн, улс төрийн, эдийн засгийн шинэ журам тогтох шаардлагатайг ойлгох хэрэгтэй болсон байна. Энэхүү шинэ журам "бүх ард түмнүүд эв санааны нэгдлийн зарчимд тулгуурлан бүгдээрээ хөгжихийн тулд олон улсын хамтын ажиллагаа өрнүүлэх явдлыг нэмэгдүүлэх, ингэхийн зүг чигийг заах" [120] юм. Эцсийн эцэст "ядуу буурай орнуудад хөгжлийн туслалцаа дэмжлэг үзүүлснээр" гэсэн үг "бүгдэд зориулагдсан баялгийг бүтээнэ" [121] гэсэн утга санааг агуулж байдаг учир ийм шинэ журам тогтсоноор бүх дэлхий бүхэлдээ хожих юм. Цогц хөгжлийн өнцгөөс харвал шинэ журам тогтох нь "ядуу буурай улс орнууд хамтын шийдвэр гаргахад нөлөө үзүүлэхүйц дуу хоолойтой байх" [122], "ядуурал болон хөгжлийн хоцрогдлоос болоод зовж зүдэрч байгаа улс орнууд олон улсын зах зээлд гарах боломжтой байх" [123] чадавхыг буй болгох гэсэн утга санааг давхар илэрхийлж байгаа юм.

*Бусдад үнэ төлбөр нэхэлгүй туслахын тухай*

139. Энэ хүртэл миний хэлж ярьсан зүйл үр ашгийн тухай санааг давхар агуулж байсан нь үнэн ч энэхүү Түгмэл захидлын утга санааг зөвхөн ашиг хонжоо олох тухай өнцөг булангаас олж харах байдлаар явцуурууулж болохгүй. Энд "үнэ төлбөр нэхэлгүй туслах" тухай асуудал заавал багтах ёстой. Өөрөөр хэлбэл тэгж туслах нь өөрөө зөв бөгөөд сайхан учир ямар нэгэн үнэ төлбөр нэхэлгүйгээр, өөртөө ашиг хонжоо бодолгүйгээр, нөхөн олговор шаардалгүйгээр хийж бүтээх чадвартай байна гэсэн үг юм. Үнэ төлбөр нэхэлгүйгээр тусална гэдэг нь шууд гарт баригдахуйц ашиг хонжоо өгөхгүй ч танихгүй хүнийг хүндэтгэн хүлээн авах санааг илэрхийлж байгаа юм. Харин зарим улс орон гагцхүү эрдэмтэд, эсхүл хөрөнгө оруулагчдыг хүлээн авна гэсэн явцуу байр суурь баримталдаг билээ.

140. Бусдад үнэ төлбөр нэхэлгүйгээр туслах тухай ойлголтгүйгээр амьдрах нь арилжаа наймаа хийж байгаа мэт болох бөгөөд ингэснээр тухайн хүн өөрөө, хүмүүс өөрсдөө бусдад юу өгснийгөө болон хариуд нь бусдаас юу авсныгаа хооронд нь тулган яв цав нийцүүлэн тооцно гэсэн үг юм. Гэтэл нөгөө талаас Тэнгэрбурхан сүжиг бишрэлийн хувьд урваж шарвасан хүмүүст хүртэл өгөөмөр гараа сунган үнэ төлбөр нэхэлгүйгээр тусалдаг. Тэрээр "өөрийнх нь бүтээсэн гэгээн нар нүгэлтэн, буянтаны аль алиных нь дээрээс тусч байхаар зохицуулсан байдаг" (Матай 5:45). Есүс Христ учир шалтгаан байгаа болохоор та бидэнд хандан ийнхүү айлдсан байдаг: "Та өглөг өгөхдөө баруун гар чинь зүүн гар юу хийж байгааг заавал мэдэх албагүйг санаж байгаарай. Ингэснээр таны өглөг нууц байх нь

зөв” (Матай 6:3-4). Та бидэнд юунаас ч илүү үнэтэй амь нас үнэгүй өгөгдсөн. Та бид амь настай болохын төлөө ширхэг ч зоос төлөөгүй. Иймэ учир та бид заавал хариу шаардалгүйгээр бусдад өгч байх хэрэгтэй. Бусдын сайн сайхны төлөө зүтгэхдээ эргээд хариу нэхдэггүй байж чадах ёстой. Есүс Христ шавь нартаа хандан ингэж айлдсан байдаг: “Та үнэ төлбөргүйгээр авсан, та үнэ төлбөр нэхэлгүйгээр өг” (Матай 10:8).

141. Манай гариг дэлхийн улс орнуудын жинхэнэ үнэ цэнийг хэмжих хэмжүүр бол тэд өөрсдийгөө бусдаас хамааралгүйгээр тусдаа оршиж байгаа улс орон хэмээн үзэж байна уу, эсхүл нэг том хүн төрөлхтний гэр бүлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн хэмээн үзэж байна уу? гэдэгтэй шууд холбоотой. Энэ байдал ялангуяа хямралын үед илүү тод томруун харагдана. Хэт үндсэрхэх үзлийн явцуу хэлбэр бол бусдад үнэ төлбөргүйгээр туслахын утга учрыг ухаарах чадваргүй байгаагийн илэрхийлэл мөн. Тийм үзэлд автсан хүмүүс бусдаас шалтгаалалгүйгээр өөрсдөө хөгжиж чадна, бусдын зовлон зүдүүрийг үл анхаарах нь өөрсдөд нь сайн, бусдыг оруулалгүйгээр үүд хаалгаа хаах нь өөрсдийгөө сайн хамгаалж байгаа хэрэг хэмээн буруу боддог. Тэд дүрвэгсэд бол ямар ч хариу үр өгөөж байхгүй ашиглагчид мөн хэмээн үзнэ. Ингэснээр тэд ядуучууд бол аюултай бөгөөд ашиггүй хүмүүс, харин эрхтэн дархтангууд бол өгөөмөр өглөгчид мөн хэмээн хэт хялбаршуулан боддог билээ. Үнэн хэрэгтээ бусдыг уриалгахан бөгөөд хариуд нь үнэ төлбөр шаардалгүйгээр хүлээн авч чаддаг нийгмийн болон улс төрийн соёл бол ирээдүйтэй юм.

## ТУХАЙН НУТГИЙГ БА БҮХ НИЙТИЙГ ХАМАРСАН БАЙХЫН ТУХАЙ

142. “Даяаршил болон дангааршил гэсэн хоёр үзлийн хооронд угаасаа зөрчил байдаг. Та бид явцуурахгүй, улиг болсон юм давтахгүйн тулд яахын аргагүй даяаршилд анхаарлаа хандуулах ёстой. Үүний зэрэгцээ та бидний гар хөлийг газар хөрстэй холбож байдаг орон нутгийн онцлогийг байнга харж байх ёстой. Энэ хоёр нийлээд та биднийг аль нэг туйлшралд автахгүй байхын баталгаа болж байдаг юм. Даяаршлын хувьд хүмүүс хийсвэр, даяаршсан ертөнцөд татагдсан байдаг... Харин газар нутгаа гэсэн үзлийн хувьд хүмүүс юун түрүүн тухайн нутгийн ардын язгуур урлагийн мүзейд анхаарлаа хандуулдаг. Энэхүү мүзей нэг л юмыг дахин дахин үзүүлж харуулах бөгөөд аливаа шинэ юмыг хүлээн авах чадваргүй байдаг, Тэнгэрбурханы бүтээсэн гоо сайхан мүзейн тогтоосон хил хязгаарын цаана байдгийг олж харж, үнэлж чаддаггүй билээ” [124]. Та бид хөдөөний хоцрогдлоосоо салахын тулд дэлхий дахины өргөн зургийг харж, тэр хэмжээнд сэтгэдэг болох шаардлагатай. Та бидний оршин сууж байгаа байшин барилга бидний гэр орон гэхээсээ илүү саатуулах газар, шоронгийн камер лугаа адил санагддаг болвол энэ байдлаас даяаршлын ачаар гарна. Ингэхийг та биднийг зорилгодоо хүрэхэд чиглүүлж байдаг “сүүлчийн учир шалтгаан”-тай адилтган зүйрлэж болно. Үүний зэрэгцээ нутгийн хүчин зүйл бол анхны өдөөгчийн үүрэг гүйцэтгэдэг, аливааг өргөжүүлэн гүнзгийрүүлж баяжуулж байдаг, анхан шатанд үйлчилдэг амьд арга механизм болдог зэрэг даяаршилд байдаггүй мөн чанартай тул түүнээс салж болохгүй гэж хэлэх хэрэгтэй. Нийтийг хамарсан ахан дүүгийн ёс, нийгмийн

нөхөрлөл бол аливаа нийгэмд байх ёстой, нэг нэгнээс нь салгаж болохгүй, хоёулаа ижилхэн туйлын чухал хоёр туйл мөн билээ. Энэ хоёрыг нэг нэгнээс нь салгах нь аль алиных нь мөн чанарыг алдагдуулж, улмаар аюултай туйлшралыг бий болгоно.

*Тухайн нутгийн өнгө, амт*

143. Өөрийнхөө баялаг мөн чанарыг үгүйсгэдэг нээлттэй байдалтай байх нь зөв шийдвэр бишээ. Өөрийн өвөрмөц дүр төрхийг мэдэрч ухааралгүйгээр "бусад"-тай яриа хэлэлцээ хийх боломж байхгүйтэй адил нутаг усандаа, нутгийнхандаа, язгуур соёлдоо хайртай байх үндэс суурьгүйгээр ард түмнүүд, хүмүүс нэг нэгэндээ нээлттэй байх боломжгүй юм. Би өөрөө бат бэх суурьтай баймааж сая бусадтай нүүр тулан уулзан учирч болно. Чухамхүү бат бэх суурьтай баймааж сая би бусдын өгч байгааг хишиг хэмээн хүлээн авах боломжтой, хариуд нь өөрийн хишгийг өргөн барих боломжтой байна. Би өөрийн ард түмэн, өөрийн соёлд өөрөө үндэслэсэн баймааж сая өөрөөсөө өөр хүмүүсийг найрсгаар хүлээн авах, тэдний оруулж буй өвөрмөц хувь нэмрийн үнэ цэнийг мэдрэх болно. Хүн бүр өөрийн гэсэн гэр орондоо хайртай дуртай байдаг, түүнийгээ ямагт өөд нь татаж байх үүрэг хариуцлагаа ухамсарлаж байдаг лугаа адил төрсөн нутаг ус, сум, тосгоноо хайрладаг, түүний төлөө санаа тавьж байдаг билээ. Эс тэгвээс нэг улс оронд учирсан гамшиг, сүйрлийн үр дагавар дэлхий ертөнцөд бүхэлд нь нөлөөлөх юм. Энэ бүхэн өмчтэй байх эрхийг эерэг утгатай болгоно. Тодруулбал, би өмчийнхөө араас санаа тавина, би өмчөө арвижуулахын төлөө зүтгэнэ, гэхдээ ингэх нь

нийт хүмүүсийн сайн сайхны төлөө бүтээж байгаа үйл хэрэг мөн хэмээн ухамсарлана.

144. Ингэснээр эрүүл саруул, нэг нэгнийгээ улам баяжуулсан солилцоо хөгжих боломж бололцоо нээгдэнэ. Нэгэн онцгой газар өсөж бойжих, нэгэн онцгой соёлыг бусадтайгаа хамт хуваалцах нь та бидэнд бусад хүн тэр болгон амархан ухааран ойлгох боломжгүй бодит байдлын тийм гүн гүнзгий шинж чанарыг мэдэх боломжийг олгож байгаа юм. Бүхнийг хамарсан гэдэг нь зөвхөн нэг ноёлсон соёлд тулгуурласан, хэлбэр галбир муутай, бүгдийг нэг нэгээс нь ялгахын аргагүй болгож жигдэлж журамласан, нэг л стандартад тааруулж тохируулсан гэсэн үг биш юм. Хэрэв ингэх юм бол дэлхий ертөнц нүд баясгаж, сэтгэл сэргээж, ухаан бодол өдөөсөн олон өнгөгүй болно, улмаар бүх юм нэг нэгнээсээ ялгарахгүй хоорондоо адилхан болно. Бабель (Вавилон)-ийн цамхгийг босгох гэсэн эртний түүх нэг нэгнийгээ уруу татсан болчимгүй ажиллагаа байсан билээ. Тэнгэрт тулсан өндөр цамхаг босгох гэсэн оролдлого нь өөр өөрийн өвөрмөц өнцөг булангаас санаа бодлоо илэрхийлэх гэсэн янз янзын хүмүүсийн нэгдлийн илэрхийлэл байгаагүй юм. Энэ бол үнэн хэрэгтээ жинхэнэ санаа бодлоо нуун дарагдуулсан, хэт биеэ тоох, хэт ихийг санаархах байдлаас үүдсэн, Тэнгэрбурхан олон үндэстнүүдэд зориулан гаргасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх түүний хүсэл зоригоос огт өөр оролдлого байсан юм (харьцуул. *Эхлэл* 11:1-9).

145. Төрсөн газар нутгийнхаа суу билгийн гүн гүнзгийг олж ухаараагүйгээс үүдэлтэй хоосон сэтгэлээс үүссэн, эсхүл өөрийн нэг язгууртай ард түмэнтэй ямар нэгэн байдлаар шийдвэрлэгдээгүй зөрчилд орсноос үүсэл гаралтай

нийтлэг гэсэн нэртэй бүхэнд нээлттэй байх гэсэн буруу хандлага байдаг. Ямар ч байсан "та бид бүхнийг харах хараагаа өргөжүүлж, та бидэнд бүгдэд нь сайн сайхныг авчрах боломж бололцоо бүхий илүү том сайн сайхныг олж харах чадвартай байх ёстой. Нөгөө талаар ингэхдээ амьдралын жанжин шугамаас хазайлгүй, язгуур үндсээ таслахгүй байхыг хичээх хэрэгтэй. Та бид Тэнгэрбурханы бидэнд бэлэг болгон өгсөн төрсөн нутгийнхаа түүх, соёлын шимт хөрсөнд үндэс язгуураа гүн гүнзгий суулгах шаардлагатай. Та бид бага хүрээ хамарч, тухайлбал хөршүүдийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулж болно, чингэхдээ илүү өргөнийг харж, бодож ажиллах хэрэгтэй... Даяршсан бүхэн бүтэлгүйтэж нурна, тодорхой бүхэн бүдчиж унана гэж бодож болохгүй" [125]. Бидний яриад байгаа загвар бол олон талт бөмбөлөг (*polyhedron*) лүгээ адил бөгөөд ийм загварт хүн бүрийн үнэ цэнийг хүлээн зөвшөөрч хүндэтгэх юм. Ийм загварт "бүтэн нь аливаа хэсгээс том, тэр бүү хэл хэсгүүдийн нийлбэрээс ч том байх юм" [126].

*Нийтлэг алсын хараа*

146. Өөрийн үндэстэн, соёлыг хайрлах эрүүл сэтгэлтэй ямар ч холбоогүй гагцхүү өөрөө өөртөө дурлах сэтгэлийн илэрхийлэл болсон "нутгархах" үзэл байдаг. Энэ үзэл өөртөө үл итгэх байдал, бусдаас айх сэтгэлээс үүдэлтэй байдаг бөгөөд ингэснээр аливаа өөр болгоноос татгалзах, өөрийгөө хамгаалахын тулд өөрийгөө тойруулан хана хэрэм босгох хүсэл эрмэлзэл төрүүлнэ. Нээрээн нийтлэг бүхэнд нээлттэй байхгүйгээр, өөр газар нутагт болж байгаа үйл явдлууд өөрийг чинь бас сорьж байгаа шүү гэдгийг ойлгохгүйгээр, өөр өөр соёлуудын өөрийг чинь

баяжуулж байгаа нөлөөлөлд нээлттэй байхгүйгээр, өөр ард түмнүүдэд тохиолдож байгаа эмгэнэлт явдлын талаар санаа сэтгэл зовохгүйгээр, тэдэнтэй эв санааны нэгдэлтэйгээ илэрхийлэхгүйгээр эрүүл саруул “нутгархах үзэл” гэж байдаггүй билээ. “Өөртөө дурласан нутгархах үзэл” зөвхөн цөөн тооны санаа бодлын явцуу хүрээнд эргэлдэнэ, цөөн тооны зан заншил болон аюулгүй байдлын цөөн тооны хэлбэрт баригдана. Энэ үзэл өөрийнхөөс нь илүү том ертөнцийн нээн олгож байгаа агуу их нөөц бололцоо, гоо үзэсгэлэнг үнэлэн бишрэх чадваргүй байдаг, түүнд эв санааны нэгдлийн бодитой бөгөөд өгөөмөр мөн чанар ямагт дутагддаг. Ийнхүү нутгийн түвшний амьдрал улам улам хол хөндий болж, хүмүүс нэг нэгнийгээ нөхөн хамтдаа амьдрах арга ухаанаас ухарч санаа сэтгэл нь улам хаалттай болно. Ийм байдлаар хөгжих боломж бололцоо улам хумигдана, улам суларч, улам баталгаагүй болно. Нөгөө талаар эрүүл саруул их соёл нээлттэй хэвээр байх бөгөөд өөрийн мөн чанарын дагуу бусдыг элэгсэг дотноор угтан авах хүсэл эрмэлзлээ илэрхийлнэ, нээрээн “нийтлэг үнэт зүйлгүй соёл бол үнэн хэрэгтээ соёл биш юм” [127] гэж хэлж болно.

147. Та бидний оюун ухаан, зүрх сэтгэл явцуурах тусам эргэн тойрон байгаа дэлхий ертөнцийг ойлгох бидний ойлголт улам явцууран хумигдана. Ижил дасал болсноос өөр бүхэнтэй тулгарч, өөр бүхэнтэй ямар нэгэн харилцаанд оролгүйгээр өөрсдийгөө, өөрийн нутаг усаа тод томруун, бүрэн бүтнээр нь ойлгоход тун хэцүү байх билээ. Өөр соёлууд бол та бидний “дайснууд” биш, бид тэднээс өөрсдийгөө хамгаалах шаардлагагүй. Өөр соёлууд бол хүмүүний амьдралын шавхагдашгүй баялаг шинж чанарын янз янзын тусгал мөн билээ. Өөрсдийгөө

бусдын нүдээр харвал, өөр хүмүүсийн нүдээр харвал өөрсдийнхөө, өөрсдийн соёлын бусдаас ялгаатай шинж чанарыг илүү хурц олж харна. Өөрийн соёлын баялаг мөн чанар, түүний өргөн нөөц бололцоо, мөн түүний хэмжээ хязгаарын аль алиныг нь олж харна. Та бидний нутаг орондоо хуримтлуулсан туршлага өөр өөр соёлын хүрээнд амьдарч байгаа бусдын туршлагатай “сөргөлдүүлэн тавьбал”, түүнчлэн “эерэн найруулвал” хөгжих боломж бололцоотой болно.

148. Үнэн хэрэгтээ эрүүл саруул байдлаар бусадтай нээлттэй харилцвал өөрийн өвөрмөц дүр төрхөд аюул занал учрахгүй. Амьд соёл бусад газрын соёлын зарим хэсгийг аван баяжих бөгөөд чингэхдээ тэдгээр соёлыг хэвэнд цутгасан мэтээр хүлээн авдаггүй. Харин тэдгээр хэсгийг ихээхэн өвөрмөц аргаар өөртөө шингээн авдаг билээ. Ингэсний үр дүнд хоёр соёлын шинэ нэгдэл үүсэх бөгөөд энэ нь эцэстээ бүгдэд үр шимээ өгөх юм. Ингэсний үр дүнд өөр соёлыг хүлээн авч өөртөө шингээж байгаа соёл өөрөө арчилгаанд орж байгаа юм. Тийм учир би нутгийн уугуул иргэд үндэс угсаагаа, өвөг дээдсийн үлдээсэн соёлыг өвлөн авч явах нь чухал хэмээн анхааруулдаг билээ. Нөгөө талаар би ингэж хэлэхдээ “бүрэн хаагдан зожигрохыг, түүхийн үйл явцыг үгүйсгэхийг, царцсан “язгуур байдал”-д орохыг, бусадтай аливаа байдлаар холилдон хутгалдахыг (*mestizaje*) эсэргүүцэхийг санал болгож байгаа хэрэг огт бишээ. Учир нь “та бид өөрсөдтэйгээ ижил биш хүмүүс болон өөр соёлтой харилцаанд орсны үр дүнд бидний өөрийн соёлын өвөрмөц дүр төрх улам батжин бэхжиж, улам баялаг шинж чанартай болж байгаа юм” [129]. Дэлхий ертөнц хөгжиж байна, хөгжих тусмаа соёлоо бусдад хүчээр тулган хүлээн зөвшөөрүүлэхээс

ангид, бусдад нээлттэй байдаг, олон соёлын харилцан нэг нэгэндээ эргээр нөлөөлсний дагуу бий болсон шинэ нэгдлийн ачаар шинээр үзэсгэлэн төгөлдөр болж байна.

149. Нэгэн зэрэг өөрийн төрсөн нутгийг хайрлах болон өөрийгөө хүн төрөлхтний том гэр бүлийн нэг гишүүн мөн хэмээн гүн гүнзгий мэдрэх хоёрын хоорондын эрүүл саруул харилцааг тогтоохын тулд даяаршсан нийгэм бол янз янзын орнуудын нийлбэр биш харин тэдгээр улс орны хооронд бий болсон нарийн нандин харилцаа мөн гэдгийг санаж байх нь чухал ач холбогдолтой юм. Тус тусдаа бүлэг болохоос өмнө нэг нэгэндээ хамаатай гэдгээ мэдэрдэг билээ. Аливаа бүлэг нийтийн нарийн нандин харилцааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болдог бөгөөд ийм нарийн нандин харилцааны гоо үзэсгэлэнг өөртөө нээн олдог билээ. Хүн бүр гарал үүсэл өөр ч өөрийгөө агуу том хүмүүний гэр бүлийн нэгэн хэсэг мөн гэдгээ мэддэг бөгөөд чухамхүү ийм учир хүн өөрийгөө гүн гүнзгий ухааран ойлгодог аж.

150. Аливаа юм үзэгдлийг энэ өнцгөөс нь харвал ямар ч үндэстэн, ямар ч баялаг соёл, ямар ч мундаг хүн ганцаараа амжилтад хүрэх боломжгүйг ухаарна. Энэ ухаарал баяр баясгаланг авчирна. Та бид амьдралын зорилгодоо хүрэхийн тулд бусдын тус дэмийг авах шаардлагатай байдаг. Та бидэнд чадах, чадахгүйн хязгаар бий, та бид өөрсдөө төгс төгөлдөр биш хэмээх үнэнийг ухаарсан ухаарал нь яавч аюул занал биш бөгөөд харин хамтын төслийг төсөөлж, түүнийг хэрэгжүүлэх гол түлхүүр мөн юм. Учир нь “хүмүүн бол тухайн хүний хувьд хязгаартай ч бодгалийн хувьд хязгааргүй нэгэн мөн билээ” [130].

*Өөрийн бүс нутгаас эхлэх*

151. Бүс нутгийн хоорондын солилцооны ачаар ядуу улс орнууд өргөн дэлгэр дэлхий дахинд өөрийгөө нээн харуулдаг бөгөөд харин тэд ингэснээрээ өөр өөрийн бусдаас ялгарах онцлогийг алдаж байна гэж бодож болохгүй. Өөрийгөө дэлхий дахинд цагаа олж нээснээр ард түмнүүдийн том гэр бүлийн хүрээнд өөрийгөө хөршдөө нээж байна гэж ойлгох хэрэгтэй. Хөрш зэргэлдээ оршин сууж байгаа ард түмнүүдтэй соёл, эдийн засаг, улс төрийн хувьд ойртон нягтрах үйл явц тухайн үндэстний мэдлэг боловсролыг дээшлүүлэх үйл явцтай нэгэн зэрэг өрнөнө. Ийнхүү мэдлэг боловсрол гүнзгийрэн сайжирснаар хөршөө хайрлахын үнэ цэнийг ухаарна, хөршөө хайрлаж сурах нь эрүүл саруул байдлаар нийтээрээ хоорондоо ойртон нягтрах үйл явц амжилттай өрнөхийн эхний үе шат болох юм.

152. Манай хотуудын зарим хэсэгт хөршүүдийн хооронд амьд харилцаа холбоо тогтон оршсоор байгаа нь сайшаалтай. Ийм хэсэгт оршин сууж байгаа хүн бүр хэнээр ч хэлүүлэлтгүйгээр хөршөө харах, хөршдөө туслахыг өөрийн үүрэг хэмээн боддог. Ийм хамтын амьдралын үнэ цэнийг хадгалан хамгаалж байгаа газруудад хүмүүс нэг нэгэндээ талархалтай хандах, хоорондоо эв санааны нэгдэлтэй байх, харилцан туслах сэтгэлтэй байхад тулгуурласан ойр дотны харилцаа холбоотой болохын бодит туршлагыг хуримтлуулна. Хөрш зэргэлдээ байснаар хоёр этгээд тус тусын өвөрмөц дүр төрх хоорондоо зарим талаар адилхан юм байна гэсэн ойлголтыг төрүүлнэ [131]. Хөрш орнууд тухайн улс орны ард түмнүүд нэг нэгнийгээ хөршөө хэмээн ойр дотно хүлээн авах сэтгэлтэй болохыг дэмжиж чадсан бол уу гэдэг нь ихээхэн чухал билээ. Гэвч

хувиа бодох үзэл улс орнуудын хоорондын харилцаанд бас нөлөөлдөг. Бид өөрсдийгөө бусдаас хамгаалах ёстой хэмээн бодох, бусдыг өрсөлдөгчид, эсхүл аюулт дайснууд мөн хэмээн харахын аюул нэг бүс нутагт оршин сууж буй ард түмнүүдийн хоорондын харилцаанд мөн адил ихээхэн нөлөөлнө. Бид бүгд яг ийм айдас хүйдэст автах, үл итгэлцэхийн хүмүүжлээр хүмүүжсэн байж магадгүй.

153. Зарим хүчтэй улс орон, том том бизнесийн төлөөллүүд бусад үндэстэн, улс орон нэг нэгнээсээ зожигрон тусгаарласан байгааг далимдуулан ашиг хонжоо олдог бөгөөд тэд ийм улс орнуудтай нэг нэгээр нь харилцаж гэрээ хэлэлцээ хийхийг хүсдэг билээ. Гэтэл нөгөө талд нь байгаа жижиг, ядуу буурай улс орнууд нэг бүс нутгийн хөрш улс орнуудтай гэрээ хэлэлцээр байгуулан хамтран ажиллавал нэг том холбоо болж хүчирхэг улс орнуудтай хамтдаа хэлэлцээ хийж, улмаар тэднээс хэт их хамааралтай болох, бусадтай харилцах харилцаа нь тасрах, зожгирон ганцаардах аюулгүй болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

# ИЛҮҮ САЙН БОДЛОГО

154. Улс үндэстнүүдийн хоорондын нийгмийн нөхөрлөлийг тогтоон хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тулгуурласан ахан дүүгийн барилдлагатай даяаршсан нэгдлийг дэмжин хөгжүүлснээр үнэхээр нийтийн сайн сайхны төлөө зориулагдсан, одооныхоос илүү сайн улс төрийн ажиллагаа явуулахыг уриалж байгаа юм. Харамсалтай нь өнөөдөр улс төр одоогийнхоос өөр ертөнцийг байгуулах чиглэл рүү урагшлан дэвших үйл явцад саад тотгор учруулсан хэлбэртэй хэвээр байна.

## ПОПУЛИСТ ҮЗЭЛ БА ЛИБЕРАЛ ҮЗЛИЙН ЯНЗ БҮРИЙН ХЭЛБЭРҮҮД

155. Нийгмийн эмзэг хэсгийн төлөө санаа тавих сэтгэл нь дутсан хүмүүс популизмын ард нуугдаж, өөрсдийн явцуу эрх ашгийг гүйцэлдүүлэхийн тулд популист үгийг хамаа намаагүй хэрэглэдэг. Нөгөө талаар либерал үзлийг баримтлагчид гагцхүү эрх дархтай хүмүүсийн эдийн засгийн эрх ашгийг гүйцэлдүүлж тэдэнд улайм цайм үйлчилдэг. Энэ хоёр тохиолдлын аль нь ч хүн бүрийг, ялангуяа эмзэг бүлгийнхнийг багтаадаг, бусад соёлуудыг хүндэтгэдэг нээлттэй ертөнцийг төсөөлж, төлөөлж чаддаггүй юм.

*Түмний дунд нэр хүндтэй байх ба түмний сэтгэлээр тоглох*

156. Сүүлийн жилүүдэд "популизм" ба "популист" хэмээх үгнүүд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн олонтаа хэрэглэдэг, хүмүүсийн өдөр тутмын ярианд байнга сонсогддог үгс болжээ. Ингэснээр энэ хоёр үг ямар ч үнэ цэнэгүй болж, тэртээ тэргүй хуваагдмал нийгмийг улам гүнзгий хагалан туйлшруулах бас нэгэн учир шалтгаан болж байна. Бүхэл бүтэн ард түмэн, хэсэг бүлэг хүмүүс, нийгмийг тэр аяар нь болон Засгийн газруудыг "популист", эсхүл "популист биш" хэмээн ангилах нь элбэг тохиолддог болжээ. Өнөөдөр ("популист" эсхүл "популист биш" гэсэн хоёр туйлд) ангилагдалгүйгээр хэн нэгэн этгээд ямар нэгэн асуудлаар санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэн хуваалцах боломжгүй болсон байна. Харин тэгэх гэж оролдвол түүнд шууд элдвийн нэр хоч зүүх бөгөөд чингэхдээ заримыг нь туйлын шударга бусаар газар доор ортол нь хараана, заримыг нь тэнгэрт тултал магтана.

157. Нийгмийн бодит байдлыг тодорхойлох тайлбарын гол түлхүүр нь популист үзэл мөн хэмээн үзэх нь бас нэг өөр учир дутагдалтай бөгөөд ингэж байгаа нь уг нэр томъёо "ард түмэн" хэмээх үгийн хууль эрх зүйн утга санааг гуйвуулан завхруулж байгаад оршино. Энэ үгийг нийтийн дунд хэрэглэгддэг хэл ярианы хүрээнээс шахан гаргах гэж оролдвол ардчилал бол "ард түмний байгуулсан төр засаг мөн" хэмээх туйлын чухал ойлголтыг устгах чиглэл рүү явна гэсэн үг билээ. Хэрэв та бид нийгэм бол зүгээр л хувь хүмүүсийн нийлбэр мөн гэж хэлэх нь буруу гэсэн байр суурийг баримтлах юм бол "ард түмэн" хэмээх нэр томьёо заавал байх ёстой гэдэг нь ойлгомжтой. Олонхыг бүй болгодог нийгмийн үзэгдлүүд, түүнчлэн томоохон чиг

хандлага, бас нийгмийн бүлгүүдийн хүсэл эрмэлзлийн аль аль нь байдаг нь тодорхой. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр өөрийн онцлогийн хүлээсэнд баригдалгүйгээр нийтлэг зорилготой болж, түүндээ хүрэхийн тулд үйл ажиллагаагаа нэгтгэх нь тэдний давуу тал болно. Түүнчлэн урт удаан хугацаанд хэрэгжих төслийг бодит ажил хэрэг болгохын тулд түүнийг хамтын зорилго мөн хэмээн үзэж, хүчээ нэгтгэх шаардлагатай байдаг. Эдгээр хүчин зүйл та бидний өргөн хэрэглэдэг “ард түмэн”, “түмэн олны дунд нэр хүндтэй” хэмээх үгнүүдийн цаана оршиж байдаг билээ. Энэ бүхнийг тооцохгүй, түүнчлэн үүний зэрэгцээ олон түмний нэрийг барьсан дэмийрлийг шүүмжлэхгүй бол нийгмийн бодит байдлын суурь шинжийг олж харах боломжгүй юм.

158. Энд бас буруу ойлгох тохиолдол гарч болно. Хүмүүсийн хийж буй аливаа юм сайн, хүмүүс бол ерөнхийдөө “лха тэнгэр лүгээ адил” сайн шинж чанартай хэмээн үзвэл “ард түмэн” хэмээх нь логикийн ойлголт биш харин домог зүйн ойлголт болно. Үнэн хэрэгтээ “ард түмэн” хэмээх нь ихээхэн нуугдмал ойлголт билээ... Та ард түмэн гэдэг нь чухамхүү юу юм бэ? гэдгийг тайлбарлахын тулд логикийн ойлголтуудыг ашигладаг. Гэхдээ “ард түмэн” хэмээх үг нь өөрөө илүү гүн гүнзгий утга санаатай учир түүнийг гагцхүү логикийн аргаар тайлбарлах боломжгүй. Аливаа нэг ард түмэнд харьяалагдах, түүний нэгэн хэсэг байна гэдэг бол нийгмийн болон соёлын хэлхээ холбоогоос үүсгэсэн аль нэгэн хамтын өвөрмөц шинж чанарт хамааралтай байх гэсэн утгатай бөгөөд энэ нь аяндаа өөрөө үүсэхгүй бөгөөд харин хамтын төслийг хэрэгжүүлэх зүг чиг рүү чиглэгдсэн урт удаан хугацаанд үргэлжлэх амаргүй үйл явц мөн.” [132].

159. “Олны дунд нэр хүндтэй” удирдагчид байдаг бөгөөд тэд ард түмний сэтгэл санааг болон соёлын өөрчлөлтийн хөдөлгөөнийг, түүнчлэн нийгмийн гол гол чиг хандлагыг тайлбарлах чадвартай байдаг. Тэдний бусдыг нэгтгэж манлайлан зүтгэх зүтгэл нь нийтийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулах хичээл зүтгэл бүгдэд өөрийн гэсэн орон зай байх бололцоог нээсэн өөрчлөлт шинэчлэл, өсөлт хөгжлийн алсын харааг тууштай хэрэгжүүлэхийн үндэс суурь болдог билээ. Нөгөө талаар энэхүү зүтгэл өөрийн явцуу эрх ашгийг гүйцэлдүүлэх, эрх мэдлээсээ салахгүй зууралдахын тулд ямар нэгэн үзэл суртлын лоозонгийн ард нуугдаж, ард түмний соёлыг улс төрийн зорилгодоо урвуулан ашиглах хувь хүмүүсийн хор хөнөөлтэй “худлаа амлах” үйлдэл болж завхардаг тохиолдол бас бий. Зарим тохиолдолд иймэрхүү хүмүүс нийт хүн амын зарим хэсгийн хамгийн суурь, хамгийн ихээр хар амиа бодсон хүслийг өдөөх замаар олон түмний дунд нэр хүндтэй болох гэж улайран хөөцөлддөг. Ийм үйл ажиллагаа зарим байгууллага, тэр битгий хэл хуулийг зөвхөн өөрсдийн эрх ашигт нийцүүлэн ажиллах болтол нь эрхшээлдээ оруулахад хүргэдэг бөгөөд энэ нь харгис хатуу, эсхүл аядуу зөөлөн ямар ч хэлбэртэй байж болох боловч үнэн хэрэгтээ туйлын ихээр анхаарах ёстой аюултай үйлдэл мөн билээ.

160. Бусдад нээлттэй биш харин хаалттай байдаг, олон түмний дунд нэр төр олохын тулд яахаас ч буцдаггүй популист бүлэглэлүүд “ард түмэн” хэмээх үгийг гутаадаг билээ. Учир нь тэд үнэн хэрэгтээ жинхэнэ ард түмний тухай ярьдаг, санаа зовдог хүмүүс биш билээ. Идэвхтэй, санаачилгатай амьдарч байгаа ард түмэн, ирээдүйтэй ард түмэн бусдын ялгаатай шинж чанарыг хүлээж авах

чадвартай байдаг тул тэдгээрийг өөрийн мөн чанартай нэгтгэн шинэ цогцыг бий болгоход хэзээ ямагт нээлттэй байдаг. Ийм нөхцөлд энэхүү ард түмэн өөрийн бодит дүр төрхийг үгүйсгэдэггүй, харин бусад улс түмэн өөрсдийг нь сорихоод, бусдын нөлөөгөөр соёл нь өргөжин баяжихад, ямар нэгэн шаардлагаар дайчлагдахад хэзээ ямагт бэлэн байдаг билээ. Ингэснээр ийм ард түмэн өсөн өндийж, хөгжин дэвшиж чаддаг юм.

161. Түмэн олны дунд нэр төртэй байхыг хэтэрхий их хичээдэг удирдагчид нэр хүндээ алдаж байгаагийн бас нэгэн тэмдэг бол тэд ойрын ашиг сонирхлын хойноос хөөцөлддөгт оршино. Ийм удирдагч санал цуглуулах, эсхүл дэмжлэг авахад хэрэгцээтэй олон түмний шаардлагыг хангаж чадаж байгаа ч хүмүүс өөрсдөө хүчин чармайлт гаргаж, бүтээлч үйл ажиллагаа явуулснаар хөгжих, амьдралд хэрэгцээтэй орлоготой болоход шаардлагатай эх үүсвэрийг буй болгох, хуримтлуулахад чиглэгдсэн ихээхэн хүч хөдөлмөр, байнгын хүчин чармайлт гарган урагшлах тал дээр ямар ч ахиц дэвшил гаргаж чаддаггүй билээ. Ийм учир би "би хариуцлагагүй популизм буюу олон түмнийг өөрийн талд татахын тулд тэдэнд таалагдсаныг нь ярьдаг, гэхдээ ярьснаа хэрэгжүүлдэггүй хариуцлагагүй үйлдлийг санал болгож байгаа юм огт биш шүү" [133] гэж тов тодорхой хэлсэн. Тэгш бус байдлыг устгахын тулд бүс нутаг болгоны нөөц бололцоог бүрэн дайчлах, ингэснээр тогтвортой тэгш байдлыг баталгаатай хангах боломжийг олгосон эдийн засгийн өсөлт хэрэгтэй [134]. Үүнтэй хамт "тулгамдсан хэрэгцээг хангахад зориулагдсан нийгмийн чиг баримжаатай төслүүд бол богино хугацааны шийдлүүд мөн" [135] хэмээн үзэх хэрэгтэй юм.

162. Ер нь хамгийн том асуудал бол ажил хөдөлмөр эрхлэх тухай асуудал юм. Үнэхээр "олон түмний дунд нэр хүндтэй" зүйл бол (тэгээд ч энэ нь хүмүүсийн сайн сайхны төлөө асуудал мөн юм) Тэнгэрбурхан хүн бүрт суулгасан үр буюу авьяас чадвар, идэвх санаачилга, дотоод нөөц бололцоо зэргийг арчлан ургуулан бойжуулах боломж бололцоог хүн бүрт олгох явдал юм. Энэ бол та бид ядуучуудад үзүүлж болох хамгийн сайн тус дэмжлэг, тэд эрхэм чанараа хүндэтгэн нэр төртэй амьдрах гарц мөн билээ. Тийм учир би дараахыг дахин дахин тууштай давтан хэлдэг: "Ядуучуудад санхүүгийн тус дэмжлэг үзүүлэх нь тулгамдсан хэрэгцээг хангахын тулд гаргаж байгаа түр зуурын шийдвэр байх ёстой. Харин ядуучуудыг ажилтай болгосноор тэдэнд нэр төртэй амьдрах боломж бололцоог олгох нь илүү том, өргөн цар хүрээтэй зорилго байх ёстой" [136]. Үйлдвэрлэлийн систем өөрчлөгдөж болно, харин улс төрийн систем хүн бүр өөрийн авьяас чадвар, хүчин чармайлтыг бүрэн дайчлах боломжийг түүнд өгдөг байхаар нийгмийн бүтцийг байнга сайжруулах чиглэлээр тууштай ажиллах ёстой билээ. Нээрээн "хүнээс ажлын байрыг нь, ажлын тэр эрхэм чанарыг нь салгаад авчихдаг ядуурлаас илүү аймшигтай ядуурал гэж байхгүй" [137]. Жинхэнэ хөгжсөн нийгэмд ажил бол нийгмийн амьдралын хамгийн гол хэмжүүр мөн билээ. Учир нь ажил бол өдөр тутмын хоол хүнсээ залгуулах төдий зүйл биш, харин хувь хүний хөгжилд ихээхэн тустай, эрүүл саруул харилцаа тогтооход чухал, өөрийгөө илэрхийлэхэд ихээхэн үүрэгтэй, нэг нэгэндээ бэлэг сэлт өгч, нэг нэгнийгээ баярлуулахад чухал ач холбогдолтой арга мөн билээ. Ажил та бидэнд дэлхий ертөнцийг хөгжүүлэхэд, эцсийн эцэст нийт хүмүүс та бидний хувьд бидний амьдралыг сайн сайхан болгоход

чухал ач холбогдол бүхий хамтын хариуцлагыг мэдрэх мэдрэмжийг төрүүлдэг юм.

*Либерал хандлагын сайн ба муу талууд*

163. Нийгэм бол харилцан зэрэгцэн оршиж байгаа ашиг сонирхлуудын энгийн нийлбэр мөн гэж үздэг, хувь хүний эрх ашгийг хэт дөвийлгөдөг либерал хандлага нэгэн хамт олон болон нэг хэсэг хүмүүсийн хоорондын соёлын нарийн нандин хэлхээ холбооны тухай эерэг ойлголтыг дагуулж байдаг "Ард түмэн" хэмээх ухагдахууныг үгүйсгэдэг билээ. Энэхүү үзлийг баримтлагчид эрх чөлөөний тухай ярих дуртай байдаг, гэхдээ хүмүүс хамтын домог түүхэнд үндэс язгууртай байдгийн тухай дурддаггүй. Зарим нөхцөлд нийгмийн хамгийн эмзэг гишүүдийн эрхийг хамгаалдаг хүмүүсийг популистууд буюу хүмүүст таалагдсаныг нь хэлж нэр хүндээ өсгөхийг зорьдог этгээдүүд хэмээн шүүмжилдэг. Ард түмэн хэмээх ухагдахуун бол хийсвэр, байхгүй юмны тухай ойлголт мөн хэмээн үздэг. Ингэж үзвэл хоёрдмол байдлыг бий болгож байгаа бөгөөд уг нь ингэх шаардлага байхгүй. "Ард түмэн", "хөрш" хэмээх ойлголтуудыг хийсвэр, эсхүл зөвхөн сэтгэлийн хөдлөлийг илэрхийлсэн үгс мөн хэмээн ойлгох нь өрөөсгөл бөгөөд ингэсэн тохиолдолд нийгмийн байгуулал, шинжлэх ухаан, иргэний байгууллагуудыг нэг бол үгүйсгэх, эсхүл тэдэнд үл тоомсорлох байдлаар хандах хандлага бий болж магадгүй, харин ингэхийг зөвшөөрч үл болно [138].

164. Байгууллагууд, хууль, технологи, туршлага, мэргэжлийн дүгнэлт, шинжлэх ухааны судалгаа, захиргааны журмууд гэх мэтийг бүгдийг нь цогцоор нь хамарсан түүхэн өөрчлөлтийн үр ашигтай үйл явцыг өдөөсөн буяны үйл хэрэг хийсвэр болон бодит хэмээх хоёр хэмжүүрийг

хоёуланг нь нэгтгэдэг юм. Үүнийг тодруулбал "хувь хүний амьдрал нийтийг хамарсан эмх замбараат тогтоолгүйгээр баттай хамгаалагдахгүй. Хуулиар хамгаалагдаагүй байвал, хуулинд тулгуурласан амар амгалан байдал тогтоогүй байхад, хөдөлмөр, худалдааны солилцоо, нийгмийн шударга ёс, улс төрийн иргэншлийг тус тусад нь болон цогцоор нь зохицуулсны улмаас хүмүүст наад захын хэрэгцээг нь хангасан байдал байхгүй байвал айлын гал голомт илчээ өгөхгүй" [139] билээ.

165. Жинхэнэ буяны үйл хэрэг бусдын сайн сайхны төлөө чиглэгдсэн байдаг учир энэ бүх хэсгүүдийг дотроо агуулж байдаг юм. Энэхүү буяны үйл ажиллагаа зохион байгуулалтад орсон, чөлөөт, бүтээлч нийгмийн байгууллагуудын хуримтлуулсан бүхий л нөөц бололцоог дайчилснаар хувь хүмүүсийг, тухайлбал алсад суугаа, эсхүл мартагдсан ах, эгч, дүү нарыг хооронд нь учруулан уулзуулж чадна. Сайн Самари хүнд хүртэл өөрөө хүссэн ч бие даан үзүүлж чадахгүй тусыг үзүүлэх боломжтой, ойрхон байрлах дэн буудал хэрэгтэй байсан билээ. Хөршийн хайр тодорхой байдаг бөгөөд ядуу зүдүү, сул дорой хүмүүст сайн сайхныг авчрах түүхэн өөрчлөлтийг хийхэд шаардлагатай нөөц бололцооны өчүүхнийг нь ч гээж үрэгдүүлдэггүй юм. Харин зарим үед зүүний үзэл суртал, эсхүл хувь хүний үйл ажиллагааг хэт дөвийлгөсөн нийгмийн номлолууд, түүнчлэн үр ашиг муутай үйл ажиллагаа зөвхөн цөөн тооны хүмүүст тус болж, олонх нь бусдын сайн сайхан сэтгэлд найдсан, тэднээс хэт шалтгаалсан хэвээр хоцордог юм. Ийм байдал ахан дүүгийн харилцаа холбоо тогтоох илүү их хүсэл, сэтгэл байхыг шаардаж байна. Нөгөө талаар ядуу улс оронд зовж зүдэрч, үхэж үрэгдэж байгаа, хаягдаж

орхигдсон хүмүүсийг олноор нь хиаруулж буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд даян дэлхийн хэмжээнд илүү оновчтой, үр ашигтай зохион байгуулалтад орох шаардлагатай нь улам бүр тод томруун нотлогдож байна. Түүнчлэн ийм байдал ганцхан арга замаар бүх асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэдгийг, бүгд хүлээн зөвшөөрөх нэг аргачлал, бүгдэд таарч тохирсон нэг эдийн засгийн жор байхгүйг харуулж байна. Тэгэж ярих юм бол шинжлэх ухааны хамгийн нарийн судалгаа хүртэл аливаа үйлдэл хэд хэдэн зам мөрөөр өрнөж болох саналыг дэвшүүлдэг билээ.

166. Тийм учир аливаа юм зүрх сэтгэл, хандах хандлага, амьдралын хэв маягийг өөрчлөх шаардлагыг олж харах та бидний чадвараас шалтгаалдаг юм. Эс тэгвээс улс төрийн ухуулга суртачилгаа, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, олон түмний санаа бодлыг залан чиглүүлэгчид хүний хувиа бодох хүслийг хэт дөвийлгөсөн, ямар ч зохицуулалтгүй эдийн засгийн ашиг сонирхол болон ихээхэн эрх мэдлийг гартаа төвлөрүүлсэн этгээдүүдэд үйлчилдэг нийгмийн байгууллагуудад үг дуугүй зарагддаг, шүүмжлэхийг мэддэггүй соёлыг дэмжин дэлгэрүүлэх үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр байх болно. Би техник, технологийн загварыг хэт шүтэхийг шүүмжилж байгаа нь техник, технологийн хөгжлийн сөрөг үр дагаврыг хяналтандаа авчихвал бүх юм сайн сайхан болно хэмээн гэнэн ойлгож байгаа хэрэг огт биш юм. Хамгийн их эрсдэл ямар нэгэн тодорхой объект, материаллаг бодит байдал, эсхүл байгууллагуудаас гэхээс илүү тэдгээрийг хэрхэн яаж ашиглаж байна вэ? хэмээхээс ирж байна. Энэ нь хүний сул тал, Христийн шашны уламжлалд “шунал, тачаал” хэмээн тодорхойлдог тэр ухагдахууны нэгэн хэсэг болсон,

салахад хэцүү хувиа хичээх үзэлтэй холбоотой юм. Хүн зөвхөн өөртөө санаа тавих, ойр дотны бүлэглэлийнхээ төлөө санаа зовох, өөрийн аар саархан ашиг сонирхлын хойноос хөөцөлддөг нь түүний гэм биш зан билээ. Шунал тачаал бол зөвхөн өнөөдөр байгаа дутагдал биш, энэ муу муухай дутагдал хүн төрөлхтөн үүссэн тэр цагаас хойш оршсоор байгаа бөгөөд цаг хугацаа улиран өнгөрөх тусам түүхийн тухайн богино цаг хугацаанд түүнд таарч тохирсон аргыг ашиглан өөрчлөгдөн хувирч, янз бүрийн хэлбэр галбиртай болж ирсэн байдаг. Гэхдээ Тэнгэрбурханы тус дэмжлэгтэйгээр шунал тачаалын хүлээснээс мултран гарч болно.

167. Сайн боловсрол, зөв хүмүүжил, бусдын төлөө санаа зовох сэтгэл, амьдралын тухай болон оюун ухааны хөгжлийн талаар төлөвшсөн цогц үзэл зэрэг нь хүмүүсийн хооронд чанартай харилцаа холбоо тогтооход, нийгэм өөрөө шударга бус явдал, аливаа гажуудал, эдийн засаг, технологи, улс төр, хэвлэл мэдээллийн эрх мэдлээ урвуулан ашиглахтай тэмцэх чадвартай болоход туйлын чухал ач холбогдолтой юм. Зарим либерал чиг хандлага хүний сул талын хүчин зүйлийг огт тооцдоггүй бөгөөд тэд дэлхий ертөнц нэгэнт тогтсон журмын дагуу оршин тогтнож байгаа, энэхүү журам бүгдийн ирээдүйг гэрэл гэгээтэй болгоно, асуудал болгоныг шийдвэрлэж чадна хэмээн төсөөлдөг юм.

168. Шинэ либерал үзлийг баримтлагчдын амны уншлага болсон хөшүүн номлолд та бид хүсээд ч итгэх боломжгүй, нээрээн зах зээл өөрөө бүх асуудлыг шийдвэрлэж чадахгүй. Энэхүү гүехэн бөгөөд нэг л юмыг улиг болтол нь давтсаар байгаа номлол болсон санаа аливаа сорилт

тулгарахад нэг л жорыг санал болгодог билээ. Шинэ либерал онол ид шидтэй хэмээх “хэтэрч хальсан”, эсхүл “нэвчин урсаж байгаа” гэх мэтийн нэр томъёог шууд хэрэглэхгүй ч утга санааг нь ашиглан нийгмийн аливаа асуудлыг шийдвэрлэх цорын ганц түлхүүр мөн хэмээн улиг болтол нь номлодог. “Олон төрлийн бүтээгдэхүүн боловсруулан үйлдвэрлэх, бизнесийн бүтээлч ажиллагааг дэмжих”-эд [140] чиглэгдсэн, ажлын байрыг устгадаг биш харин ажлын байр шинээр бий болгодог эдийн засгийн идэвхтэй бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага та бидэнд тулгарсан байна. Анхнаасаа богино хугацаанд ашиг олох зорилготой санхүүгийн аз сорьсон панзлал эмх замбараагүй байдлыг бий болгож байна. Нээрээн “эв санааны нэгдлийн дотоод хэлбэр, харилцан итгэлцэл байхгүйгээр зах зээл эдийн засгийн зохистой үйл ажиллагаа явуулж чадахгүй билээ. Харин өнөөдөр энэхүү харилцан итгэлцэл алга болсон байна” [141]. Энэ түүхийн төгсгөл анх бодож байсанчлан болсонгүй, эдийн засгийн онол ноёлсон ч түүний хөшүүн томьёо огт алдаагүй байж чадсангүй. Цар тахалтай нүүр тулсан дэлхий ертөнц эмзэг гэдэг нь тогтоогдож, зах зээлийн чөлөөт байдал бүх юмыг шийдвэрлэж чадахгүй гэдэг нь ойлгомжтой болсон юм. Энэ байдал санхүүгийнхний зарлигдсан болгоныг дагадаггүй эрүүл саруул улс төрийн амьдралыг сэргээх шаардлагатайг, түүнчлэн “та бид хүний эрхэм чанарыг аливаа юмны төвд буцааж тавих ёстойг, түүнд тулгуурлан та бидэнд хэрэгтэй нийгмийн өөр бүтцийг шинээр байгуулах шаардлагатайг харуулж байна” [142].

169. Зарим хаалттай, нэг л хэв маягийн эдийн засгийн хандлагад ажилгүйчүүд, түр зуурын ажилтай, албан бусаар ажиллаж байгаа хүмүүс, одоо байгаа бүтцэд

өөрийн гэсэн орон зайгаа олж чадаагүй байгаа олон олон хүнийг нэгтгэдэг олон түмний хөдөлгөөнүүдийг оруулж тооцдоггүй билээ. Гэтэл олон түмний эдгээр хөдөлгөөн нь олон түмнийг оролцуулсан эдийн засаг, хамт олноороо бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажиллагаа зэрэг янз бүрийн хэлбэрийн үйл ажиллагааг зохицуулдаг байна. "Олон түмний хөдөлгөөнийг татан оролцуулдаг, хамтын хувь заяагаа бүтээх нийтийн үйл хэрэгт өмнө нь түүний гадна орхигдсон байсан хүмүүсийг татан оролцуулснаар бүй болох ёс суртахууны эрч хүчийн урсгал нутгийн, үндэсний, олон улсын засаглалын бүтцийг амилуулан идэвхжүүлдэг" тийм нийгэм, улс төр, эдийн засгийн оролцооны загварыг бий болгох нь яахын аргагүй шаардагдаж байна. Энэ загвар "доороос, бүр газар дэлхийн хөрснөөс урган гарч ирж байгаа эв санааны нэгдлийн олон туршлага хүчээ нэгтгэх, хоорондоо илүү уялдаатай болох, нэг нэгэнтэйгээ учирдаг байх" [143] байдлыг ханган баталгаажуулах шаардлагатайг сануулж байна. Гэхдээ энэ бүхэн ажил хэрэг болохдоо "өөрчлөлтийн үрийг тарьж суулгагч, найраглалын бүтээлч сүлжээ үүсгэдэг үгс лүгээ адил том, бага сая сая үйлдлийг багтаасан үйл явцыг хөхиүлэн дэмжигч" [144] лүгээ адил өвөрмөц байдлаар өрнөхөөс буцаж огт болохгүй. Энэ утгаар нь аваад үзвэл олон түмний хөдөлгөөнүүд бол "нийгмийн найрагчид мөн" бөгөөд тэд өөр өөрийн аргаар ажиллана, санал дэвшүүлнэ, дэмжихийгээ дэмжинэ, элдвийн хүлээснээс чөлөөлнө. Эдгээр хөдөлгөөн "хэзээ ч ядуучуудтай хамт байдаггүй, ядуучуудын өөрсдийнх нь бодлого болдоггүй, тэр тусмаа хүмүүсийг хооронд нь нэгтгэн нийлүүлдэг төслийн нэгэн хэсэг байдаггүй, харин ядуучуудад зориулсан хэмээх бодлого байдаг нийгмийн бодлогын үзэл санаа"-ны [145] тогтоосон хязгаарыг

давсан хүний цогц хөгжил боломжтой болж хэрэгжихэд тус дөхөм үзүүлнэ. Эдгээр хөдөлгөөн байнга асуудал үүсгэж яршигтай юм шиг санагдана, тэр битгий хэл зарим "онолчид" эдгээр хөдөлгөөнийг ангилж чадахгүй будилдаг билээ. Хэдий тийм ч эдгээр хөдөлгөөнгүйгээр "ардчилал хатна, хоосон үг болно, хэлбэр төдий зүйл болно; ард түмнийг эрхэм чанараа хамгаалах, ирээдүйгээ өөрсдийн гараар бүтээхийн төлөө явуулж байгаа тэмцэл дунд нь орхин хаяж байгаа учир төлөөллийн шинж чанараа алдана, хий хоосон үзэгдэл болно" [146].

## ОЛОН УЛСЫН ЭРХ МЭДЭЛ

170. "2007-2008 онуудын санхүүгийн хямрал ёс зүйн зарчмуудад илүү анхаарал хандуулсан шинэ эдийн засгийг хөгжүүлэх, санхүүгийн аз сорьсон панзлал болон виртуал буюу бодит бус баялгийг зохицуулах шинэ арга замыг хөгжүүлэх боломж бололцоог олгосон юм. Гэвч энэхүү хямралыг давах гэсэн оролдлого манай дэлхийг өнөө хүртэл удирдсаар байгаа хоцрогдсон шалгуурыг эргэж харах гарцыг өөртөө багтаагаагүй юм" [147]. Нээрээн хямралын өмнөхөн дэлхий дахинд боловсруулсан бодит стратеги хэт хувийн ашиг сонирхлын хойноос хөөцөлдөхийг улам хүчтэй өрнүүлж, хэзээ ямагт хүнд хэцүү байдлаас ямар нэгэн шарх сорвигүйгээр мултрах замаа олдог эрх мэдэлтнүүдэд илүү эрх чөлөөг олгож, тэд нийгэмтэйгээ ойр дотно харилцаа холбоо тогтоохыг улам бага хүсэх байдлыг өөгшүүлсэн нь тодорхой болсон билээ.

171. "Хүн бүрт өөрийнхийг нь өгнө хэмээх шударга ёсны сонгодог тодорхойлолтыг дагана гэх нь аливаа хувь хүн,

эсхүл бүлэг хүн өөрийгөө, эсхүл өөрсдийгөө үнэмлэхүй шинж чанартай хэмээн үзэж болохгүй, бусад хүн, нийгмийн бүлгүүдийн эрх, эрхэм чанарыг үл тоомсорлон дарангуйлж болохгүй гэсэн үг билээ. Эрх мэдлийг олон этгээдийн дунд оновчтой хуваарилах (ингэх нь ялангуяа улс төр, эдийн засаг, батлан хамгаалахтай холбоотой болон технологийн эрх мэдэлд хамаатай), янз бүрийн этгээдүүдийн нэг нэгэндээ тавих шаардлага, тэдний илэрхийлэх эрх ашгийг зохицуулдаг эрх зүйн тогтолцоог байгуулах нь эрх мэдлийг хязгаарлах аргын нэг хэлбэр мөн. Гэтэл өнөөдөр дэлхий дахинд олон худал эрхүүд бий болсон байна, үүний зэрэгцээ эмзэг хэсгүүд, эрх мэдлийн золиос болсон хүмүүсийн эрхийг огт ханган хэрэгжүүлэхгүй байна.

172. 21 дүгээр зуун “нэг үндэстэн – нэг улс гэсэн ойлголтын эрч хүч суларч байгаагийн гэрч нь болж байна гэж хэлж болно. Яагаад ингэж байгаагийн учир шалтгаан гол нь эдийн засгийн болон санхүүгийн салбарууд үндэстэн дамнасан шинжтэй болохоор улс төрийн үйл явцын дээр нь гарч байгаад оршино. Нөхцөл байдал ийм байгаа учир үндэсний Засгийн газруудын тохиролцсоны дагуу шударгаар томилогддог түшмэдтэй, одооныхоос илүү хүчтэй, илүү үр ашигтай үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудыг анхнаас нь зөв зүйтэй төлөвлөн байгуулж ажиллуулах нь ихээхэн чухал байна. Эдгээр байгууллагууд шаардлагатай бол хориг тавих эрхтэй байх ёстой” [149]. Та бид үйл ажиллагааг нь хуулиар зохицуулсан нэг хэлбэрийн Дэлхийн эрх мэдлийг хэрэгжүүлэх этгээдийг байгуулан ажиллуулах тухай ярихдаа [150] нэг хүний эрх мэдлийн тухай ярьж байна гэж ойлгох хэрэггүй. Ийм эрх мэдэлтэй этгээд бий болох юм бол хамгийн наад зах нь

нийтийн сайн сайхны төлөө, өлсгөлөн, ядуурлыг устгахын төлөө, хүний суурь эрхүүдийг баталгаатай хангахын төлөө ажиллах эрх мэдэлтэй, үр дүнтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг дэмжих шаардлагатай юм.

173. Энэ тухай илүү тодруулбал би "янз бүрийн үндэстнүүдийн нэгэн том гэр бүл хэмээх ойлголтыг үнэхээр бодитой хэрэгжүүлэхийн тулд НҮБ болон түүнтэй ижил төстэй олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудыг" [151] шинэчлэх шаардлагатай гэж үздэгээ онцлон тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Ингэхдээ эрх мэдлийг цөөн тооны улс орон өөрийн эрх ашигт нийцүүлэн урвуулан ашиглахаас зайлсхийх, өөрийн соёлыг бусдад тулгах явдлаас болон үзэл суртлын ялгааг үндэслэн сул дорой улс үндэстний суурь эрх чөлөөг хязгаарлах гэсэн аливаа оролдлогоос сэргийлэхэд зориулан маш тодорхой хууль эрх зүйн хязгаарлуултыг тогтоох шаардлагатай гэдэг нь ойлгомжтой. Учир нь "олон улсын хамтын нөхөрлөл бол хууль эрх зүйн зохицуулалт бүхий нэгдэл мөн бөгөөд энэхүү нэгдэл түүний гишүүн орон бүрийн онцгой бүрэн эрхэд суурилдаг. Эдгээр улс орны аль нь ч тухайн улсын тусгаар тогтнолыг үгүйсгэсэн, эсхүл хязгаарласан үр дагаврыг дагуулсан нэг нэгэндээ захирагдах холбоосоор холбогдоогүй байдаг билээ" [152]. Үүний зэрэгцээ "НҮБ-ыг үүсгэн байгуулахдаа баталсан Дүрмийн өмнөтгөл болон эхний зүйл заалтуудад суулгасан зарчмуудын дагуу тогтоосон ажил үүрэг нь бүх нийтийг хамарсан ахан дүүгийн ёсны эрхэм зорилгод хүрэхийн тулд шаардагдаж байгаа хамгийн чухал нөхцөл бол шударга ёс мөн бөгөөд шударга ёсыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үндэслэсэн хуулинд захирагдах ёсыг хөгжүүлэх, дэмжихэд оршино гэж хэлж болно" [153]. Одоо энэ чухал байгууллагыг

хууль ёсны биш байгууллага болгох гэж оролдох ямар ч шаардлага байхгүй гэж үзэж байна. Учир нь энэхүү байгууллагын асуудлууд болон түүний алдаа дутагдлыг хамтын хүчээр авч хэлэлцэн шийдвэрлэж болно гэдэгт итгэлтэй байна.

174. Хамт хүрэх зорилгоо тодорхойлох, зарим туйлын чухал зарчмуудыг дэлхий нийтээрээ даган баримтлахыг баталгаатай хангахын тулд эр зориг болон өгөөмөр сэтгэлийн аль аль нь шаардагдана. Эдгээр нь үнэхээр үр дүнгээ өгөхийн тулд "байгуулсан гэрээгээ чанд баримтлах шаардлагатай (*pacta sunt servanda*)" [154] бөгөөд "хуулиар захирахын оронд хүчээр захирах гэсэн хүсэлд автах"-аас [155] аль болохоор зайлсхийх хэрэгтэй. Энэ бол "будлиантай байдлыг энх тайвны аргаар шийдвэрлэж байхын тулд хууль эрх зүйн арга хэрэгслийг" ашиглахын зөв зүйтэйг тогтооно, "ингэснээр эдгээр хууль эрх зүйн арга хэрэгслийн цар хүрээ болон тэдгээрийг заавал дагаж мөрдөх зарчмыг чангаруулна" [156] гэсэн үг юм. Энэхүү журмаар тогтоосон арга хэрэгслийн дотор хоёр талын гэрээг бодвол жинхэнэ бүгдэд зориулагдсан нийтийн сайн сайхныг дэмжихийг болон сул дорой улс орныг хамгаалахыг баталгаатай хангах илүү боломжтой олон талын гэрээ байгуулан хэрэгжүүлэхийг дэмжих нь зүйтэй гэж үзэж байна.

175. Аз болоход иргэний нийгэмд багтдаг олон хэсгүүд болон байгууллагууд олон улсын хамтын нийгэмлэгийн алдаа дутагдал, тэдний амаргүй нөхцөлд хоорондоо уялдаа холбоогүй байдаг байдлыг нь, хүний суурь эрхүүдэд тэр болгон анхаарал хандуулдаггүйг нь, зарим хэсэг бүлэг хүмүүсийн ихээхэн чухал хэрэгцээг үл тоомсорлодгийг нь

засан залруулж, нөхөн гүйцээж байдаг билээ. Энд та бид эрх шилжүүлэх зарчим тодорхой хэрэгжиж байгааг харж болно. Энэ зарчим хэрэгжсэнээр тухайн орон нутгийн нэгдлүүд (*communities*) болон байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулснаар төр засгийн чиг үүргийг доод шатанд хэрэгжүүлж, нөхөж байдаг нь зөв болохыг ухаарч болно. Эдгээр нэгдлүүд болон байгууллагууд нийтийн сайн сайхны төлөө идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг нь сайшаалтай бөгөөд тэдгээрийн гишүүд зарим үед манай хүн төрөлхтөн үнэхээр агуу шүү гэдгийг нээн харуулахуйц жинхэнэ бахархмаар гавьяа байгуулдаг юм.

## НИЙГМИЙН БОЛОН УЛС ТӨРИЙН БУЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

176. Өнөөдөр олон хүний хувьд улс төр хэмээх нь ихээхэн бохир үг болсон бөгөөд үүний учир шалтгаан зарим улс төрчийн алдаа дутагдал, тэдний хээл хахуульд холбогдсон байдал, үр ашиггүй үйл ажиллагаа явуулж байгаатай шууд холбоотой. Нөгөө талаар улс төрийн нэр хүндийг бүр унагаах, түүнийг эдийн засгаар орлуулах, эсхүл ямар нэгэн үзэл суртлыг сурталчлагч болгон завхруулах гэсэн оролдлого байдаг. Гэхдээ та бидний энэ дэлхий улс төргүйгээр оршин тогтнох уу? Бүхнийг хамарсан ах дүүгийн харилцаа холбоо болон нийгмийн энх тайвныг тогтоох зорилготой үр ашигтай үйл явц эрүүл саруул улс төрийн амьдралгүйгээр өрнөх үү? [157]

177. Энд би нэгэн ажиглалтынхаа тухай дахин давтан хэлье: “Улс төр эдийн засагт захирагдах ёсгүй, эдийн засаг технократуудын зөвхөн үр ашгийн хойноос улайран хөөцөлдсөн загварт захирагдах ёсгүй билээ” [158]. Хэдийгээр эрх мэдлийг урвуулан ашиглах, хээл хахуульд автах, хуулийг үл тоомсорлох, үр ашиггүй үйл ажиллагаа явуулах зэргийг устган арилгах нь зөв ч “улс төргүй эдийн засгийн ноёрхлыг зөвшөөрч болохгүй, учир нь ингэвэл өнөөгийн хямралын янз бүрийн талуудыг зохицуулах өөр олон аргыг эрж хайн олох боломжгүй нөхцөлийг бий болгох юм” [159]. Харин ингэж будилахын оронд “алсын хараатай, шинэ, цогц, олон салбарын хоорондын уялдааг хангасан чиг хандлагатай улс төр хэрэгтэй бөгөөд ийм улс төр өнөөгийн хямралын янз бүрийн тулгамдсан асуудлыг зохицуулж чадах юм” [160]. Өөрөөр хэлвэл “байгууллагуудыг шинэчлэх, хоорондын уялдаа холбоог нь сайжруулах, хамгийн шилдэг үйл ажиллагааг дэмжих, янз бүрийн дарамт шахалт болон хүнд суртлын хөшүүн хойрго байдлыг давах чадвартай эрүүл саруул улс төр” хэрэгтэй [161] гэсэн үг юм. Та бид эдийн засаг энэ бүхнийг хийж чадна хэмээн бодож болохгүй, эдийн засаг засаг төрийн бодит эрх мэдлийг булаан авахыг зөвшөөрч болохгүй.

178. Богино хугацаанд орж ирэх ашиг хонжооны хойноос хөөцөлддөг улс төрийн явцуу арга хэлбэр оршсоор байгаа энэ үед би: “жинхэнэ засаг төрийн үйл ажиллагаа гэж юу юм бэ? гэвэл хүнд хэцүү цагт өндөр зарчмыг баримтлах, урт удаан хугацаанд нийтийн сайн сайхны төлөө гэсэн санаа бодолдоо үнэнч байхыг хэлнэ. Улс төрийн эрх

мэдэл бүхий этгээдүүд улс үндэстнээ өөд нь татан босгож хөгжүүлэх үйл ажиллагаа явуулахдаа энэхүү чухал үүргийг биелүүлэх нь амаргүй гэдгийг мэддэг билээ" [162]. Тэд өнөө цагт болон ирээдүйд бүхэл бүтэн том хүн төрөлхтний гэр бүлийн сайн сайханд чиглэгдсэн томоохон төслийг хэрэгжүүлэхэд дээрх зарчмын дагуу ажиллах нь бүр хэцүү гэдгийг ч ойлгодог. Ирээдүй хойч үеийн тухай хичнээн бодлоо гээд өнөөгийн сонгуульд шууд үр дүн авчрахгүй нь үнэн ч жинхэнэ шударга ёс чухам ингэхийг шаарддаг юм. Португалын Тэргүүн хамба нарын номлон сургаснаар "өнөө үеийнхэн газар дэлхийг түр хугацаагаар зээлээр эзэмшиж байгаа бөгөөд дараагийн үеийнхэндээ бүрэн бүтнээр нь шилжүүлэн өгөх ёстой" [163] билээ.

179. Глобал нийгэм буруу бүтцийн алдаа дутагдлаас болж хямарч байгаа бөгөөд энэ байдлыг бага багаар өөрчилснөөр, эсхүл түр зуурын шуурхай арга хэмжээ авснаар засан залруулах боломжгүй юм. Үндэс сууриар нь өөрчлөн шинэчлэх, томоохон өөрчлөлтийг зоригтой хийх замаар өөрчлөх шаардлага тулгарч ирээд байна. Янз бүрийн салбарууд болон ур чадварын аль алийг нь багтаасан эрүүл саруул улс төр энэхүү үйл явцыг өрнүүлэн амжилтад хүргэж чадна. Эдийн засаг бол нийтийн сайн сайхны төлөө зориулагдсан улс төр, нийгэм, соёлын хөтөлбөрийн нэгэн салшгүй хэсгийн хувьд "хүний бүтээлч үйл ажиллагааг унтраах, хөгжлийн эрхэм зорилгыг гутаах биш харин энэхүү их эрч хүчийг шинэ сувгаар залан чиглүүлэх аргаар янз бүрийн боломжуудад" [164] дардан зам засаж өгөх шаардлагатай билээ.

*Улс төрийн хайр*

180. Бүх хүмүүс та бидний ах, эгч мөн гэдгийг хүлээн зөвшөөрөх, бүгдийг өөртөө багтаасан нийгмийн нөхөрлөлийн арга хэлбэрийг олохын төлөө эрэл хайгуул хийх нь бүтэшгүй мөрөөдөл бишээ. Энэхүү зорилгод хүрэхийн тулд үр ашигтай арга хэлбэрийг олж сонгохын төлөө тууштай зүтгэх ёстой юм. Энэ чиглэлээр явуулж байгаа аливаа үйл ажиллагаа бусдын сайн сайхны төлөө буян хийж байгаатай адил билээ. Учир нь хувь хүмүүс туслалцаа дэмжлэг шаардагдаж байгаа хүмүүст туслах, ахан дүүгийн харилцаа холбоо хөгжүүлэх болон шударга ёсыг тогтоохын тулд нийгмийн үйл явцыг өрнүүлэх санаачилга гаргах нь тэд "хамгийн өндөр их энэрэл хайрын орон зай өөрөөр хэлбэл, улс төрийн энэрэл хайрын орон зайд" [165] нэвтрэн орж байна гэсэн үг юм. Ингэхийн тулд нийгэм, улс төрийн шинэ журам тогтоохын төлөө ажиллана гэсэн үг мөн бөгөөд энэхүү шинэ журмын амин зүрх нь нийгмийн энэрэл хайрын үйл хэрэг мөн [166] билээ. Энэ удаа мөн адил миний бие "бусдын сайн сайхны төлөө зүтгэж байгаа учир сэтгэлийн эрхэм дуудлага бөгөөд энэрэл хайрын нэгэн дээд хэлбэр" [167] болсон улс төрийг шинээр ухааран ойлгохыг дахин уриалж байна.

181. Манай Шашны нийгмийн номлолын гаралтай аливаа хичээл зүтгэл нь "Есүсийн сургаалын дагуу тэнгэрлэг Хуулийн биелэлт болсон энэрэл хайраас" (харьцуул. Матай 22:36-40)" үүдэлтэй юм. Энэ нь "алхам бүртээ нэг нэгнийгээ халамжлахыг агуулсан хайрын сэтгэл бол иргэний бөгөөд улс төрийн шинж чанартай бөгөөд илүү сайн сайхан дэлхий ертөнцийг байгуулахын төлөө явуулж буй үйл ажиллагаа, авч байгаа арга хэмжээ бүртээ

өөрийгөө мэдрүүлж байдаг юм” [169]. Ийм учир энэрэл хайрын үйл хэрэг тэр болгон харагддаггүй, нүднээс далд өрнөдөг нарийн нандин харилцаанд илэрхийллээ олоод зогсохгүй “нийгэм, эдийн засаг, улс төрийн макро харилцаанд” [170] тодордог билээ.

182. Улс төрийн энэрэл хайрын үйл хэрэг хувиа хичээсэн санаа бодол бүрийн явцуу хязгаарыг давдаг нийгмийн ухамсраас үүдэлтэй байдаг. “‘Нийгмийн энэрэл хайр нийтийн сайн сайхны төлөө хийж буй сайн ажилд дуртай болгодог’, бүх хүмүүсийн сайн сайхны төлөө үйл хэрэг бүтээх зорилго бүхий үр дүнтэй хүсэл эрмэлзлийг төрүүлдэг, ингэснээр та бид нийт хүмүүсийг тэд тус тусдаа хувь хүн мөн хэмээн бодохоос илүү тэднийг хооронд нь холбож байдаг нийгмийн хэмжүүрээр нь хүлээн авдаг билээ” [171]. Та бидний хэн нь ч аль нэгэн ард түмний нэг хэсэг баймааж сая бүрэн бүтэн хувь хүн болж чадна. Үүний зэрэгцээ хүн бүрийн өөрийн гэсэн өвөрмөц шинжийг хүндэтгэлгүйгээр ард түмэн болно гэж байдаггүй. “Ард түмэн” болон “хувь хүн” хэмээх үгс хоорондоо салшгүй хүйн холбоотой билээ. Гэвч өнөөдөр эрх дархтай этгээдүүд нийт хүмүүсийг өөрсдийн явцуу эрх ашгийг гүйцэлдүүлэх хэрэгсэл болгох, хүмүүсийг нэг нэгнээсээ зожигорсон, бусдаасаа үл шалтгаалсан тус тусдаа хувь хүн болгосноор тэднийг санаснаараа удирдан чиглүүлж байдаг болгох гэсэн оролдлогууд хийгдсээр байна. Улс төрийн сайн бодлого бол даяаршлыг зөв зохицуулж, зөв чиглүүлж, түүний сөрөг үр дагавраас зайлсхийхийн төлөө нийгмийн амьдралын шат болгонд нэгэн хамт олон болсон бүлгүүдийг байгуулахад чиглэгдэж байх ёстой.

*Үр дүнтэй хайрын сэтгэл*

183. “Нийгмийн хайрын сэтгэл” [172] бол хайрын сэтгэлийн соёл иргэншлийг бүтээн байгуулахын тулд урагшлан дэвших боломж бололцоог олгодог. Энэхүү хайрын соёл иргэншил та биднийг бүгдийг даллан дуудаж байдаг билээ. Энэрэл хайр бүгдийг хамран багтаах гэсэн хүсэл эрмэлзэлтэй байдаг тул шинэ ертөнцийг бүтээн байгуулах чадвартай [173] юм. Учир нь энэрэл хайр бол жирийн сэтгэлийн хөдлөл биш, харин хүн бүрт зориулагдсан хөгжлийн хамгийн үр дүнтэй зам мөрийг нээн олоход тус дөхөм болсон арга хэрэгсэл мөн. “Нийгмийн хайрын сэтгэл” бол “өнөөгийн дэлхий ертөнцийн бүхий л асуудалд хандах, одоо байгаа бүтцүүд, нийгмийн байгууллагууд, хууль эрх зүйн тогтолцоог бүр дотроос нь гүн гүнзгий өөрчлөх шинэ хандлагыг өдөөсөн их эрч хүч мөн” [174] билээ.

184. Буяны сэтгэл аливаа эрүүл саруул, нээлттэй нийгмийн амин зүрхэд оршиж байдаг ч өнөөдөр “ёс суртахууны хариуцлага хүлээхийн тухай тайлбарлах болон түүнийг чиглүүлэхэд огт хэрэггүй мэтээр үгүйсгэгддэг” [175] болсон байна. Үнэнийг хатуу чанд баримталсан буяны сэтгэл бол хувь хүний сэтгэл биш хамаагүй агуу том бөгөөд тийм учир “байнга өөрчлөгддөг мөн чанартай тухайн хүний сэтгэл хөдлөл, саналын эрхшээлд орох” [176] ёсгүй. Үнэхээр буяны сэтгэл үнэнтэй салшгүй холбоотой байдаг онцлогтой тул энэхүү сэтгэл бүгдийг хамарсан шинжтэй болдог, “хэнтэй ч ямар ч харилцаа холбоогүй байхын явцуу хүрээнд хязгаарлагдахын аюул” [177]-аас аврагдсан байдаг байна. Эс тэгвээс буяны сэтгэл “онолын мэдлэг болон амьдралын туршлага хоёрын харилцаан дундаас

буй болох бүхнийг хамарсан шинжтэй хүмүүний хөгжлийг дэмжих төлөвлөгөө болон үйл явцын өрнөлөөс хасагдах" аюул заналтай шууд [178] тулгарна. Үнэн байхгүй бол сэтгэл санаа бодит, нийгмийн ач холбогдол бүхий утга агуулгаа гээнэ. Тийм учир буяны сэтгэлийн үнэнд ямагт нээлттэй байдаг шинж чанар түүнийг хүмүүний болон бүхнийг хамарсан өргөн цар хүрээнээс нь салгадаг мухар сүсэгт баригдах аюул"-аас [179] аврана.

185. Энэрэл хайрын сэтгэл та бидний байнга эрж хайж байдаг үнэний гэрлийг үгүйлж байдаг юм. "Тэр гэрэл гэгээ бол нэгэн зэрэг ухааны гэрэл, итгэлийн гэрэл байдаг" [180] билээ. Энэ гэрэл харьцангуй байх хэмээхийн ямар нэгэн хэлбэрт баригдан явцуурдаггүй билээ. Энэхүү үнэний гэрэл гэгээ шинжлэх ухааны хөгжлийг хүндэтгэн хүлээн зөвшөөрнө, шинжлэх ухаан хүссэн зорилгодоо хүрэхийн тулд хамгийн баталгаатай, хамгийн бодитой арга хэрэгслийг олж тогтооход ихээхэн чухал үүрэгтэйг бас хүлээн зөвшөөрнө. Учир нь бусдын төлөө сайн сайхныг бүтээх эрхэм зорилгыг дэвшүүлсэн байхад зүгээр сайхан сэтгэлтэй байх нь хангалттай биш байдаг билээ. Тухайн хүмүүс, тухайн үндэстэн хөгжин дэвшихэд чухам юу юу хэрэгтэй байгааг олж хэрэгжүүлэхийн тулд ихээхэн тодорхой алхмуудыг хийх ёстой байдаг юм.

### УЛС ТӨРИЙН ХАЙРЫН СЭТГЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

186. "Дэвлэн оргилдог" нэгэн төрлийн хайрын сэтгэл байдаг бөгөөд үйлс нь энэрэл хайрын мөн чанараас шууд үүсдэг бөгөөд хувь хүнд, ард түмэнд чиглэгддэг. Түүнчлэн анхнаасаа "захирагдсан" шинж чанартай хайрын сэтгэл гэж байна. Энэхүү хайрын сэтгэл эрүүл саруул үйл

ажиллагаатай улам олон байгууллагыг байгуулах, шударга журмуудыг батлан хэрэгжүүлэх, нийт хүмүүст тус дэм болохуйц бүтцийг бүтээх хүсэл эрмэлзлийг хүмүүсийн оюун ухаанд бий болгохыг өдөөсөн нигүүлсэнгүй сэтгэлийн үйл хэргээр илэрнэ [181]. Энэ нь "нийгмийн бүтцийг тогтоох, нийгмийг зохион байгуулахдаа "тухайн хүний хөрш ядуу зүдүү амьдралын эргүүлэгт унаж живэхгүй" [182] байхыг зорих нь хайрын сэтгэлийн мөн адил салшгүй үйл хэрэг юм" [181] гэсэн зарчмыг дагаж байгаа юм. Энэ бол зовж байгаа хэн нэгэнд туслахын тулд буян үйлдэхийн тухай юм. Түүнчлэн тухайн хүнийг сайн мэдэхгүй ч тэр хүн зовж байгаагийн нийгмийн учир шалтгааныг өөрчлөхийн тулд үйлдэж буй буяны үйл хэрэг юм. Өндөр настай хүнд гол гэтлэхэд нь тусална гэдэг бол буяны үйл хэрэг мөн. Нөгөө талаар гүүр барьж байгаа улс төрч мөн адил буяны үйл хэргийг бүтээж байна. Нэг хүн нөгөө хүнд идэх хоол өгч тусалж байгаа бол улс төрч тэрхүү ядарсан хүнд ажил олгож тусалж байна. Ингэснээр илүү их буяны үйл хэргийг бүтээж, түүний нэр хүнд өсөж байгаа юм.

*Хайрын сэтгэлийн улмаас өөрийгөө золиослох нь*

187. Улс төрийн үйл ажиллагааны амин зүрх болсон энэхүү энэрэл хайр бусдын тусламж юуны түрүүн хамгийн их шаардагдаж байгаа тэр хүмүүсийг хайрлахад чиглэгдэнэ. Энэхүү хайрын сэтгэл та бидний тэдгээр хүмүүсийн тусын тулд хэрэгжүүлж байгаа аливаа үйл хэргийн үндэс суурь болж байдаг [183] юм. Нигүүлсэнгүй сэтгэлийн ачаар өөрчлөгдсөн билгийн хараа бусад хүмүүсийн эрхэм чанарыг хүндэтгэн хүлээн зөвшөөрөх боломж олгоно, ингэсний ачаар ядуусын эрхэм чанарыг мөн адил хүлээн

зөвшөөрч хүндэтгэн үнэлэх, тэдний эрхэм чанарын илэрхийлэл болсон соёлыг хүндэтгэх, улмаар тэднийг нийгмийн харилцаанд жинхэнэ ёсоор татан оролцуулах юм. Энэхүү билгийн хараа улс төрийн жинхэнэ мөн чанарын амин зүрхэнд оршдог хэмээн хэлж болно. Энэхүү билгийн хараа зүрх сэтгэлгүй прагматик хандлагын замнах зам мөрөөс огт өөр зам мөрийг олж харан нээж чаддаг юм. Энэхүү билгийн хараaны ачаар та бид “ядуурлыг дагасан хэл амыг ядуучуудыг тайвшруулж тэднийг номхон хүлцэнгүй, эр зориггүй болгодог, байгаа байдлыг хэвээр нь хадгалах зорилго бүхий аргаар дарж болохгүй. Наанаа өнгөц харахад бусдад туслаад байгаа юм шиг буяны ажил үнэн хэрэгтээ хүмүүсийг идэвхгүй болгож буйг харахад юутай гунигтай байдаг билээ” [184] гэдгийг ухаарах боломж бололцоо олгодог билээ. Өнөөдөр өөрийгөө илэрхийлэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох шинэ арга замыг нээх шаардлага тулгарч байна. Ингэхэд чухамхүү боловсрол бодитой тус дэмжлэг үзүүлэх бөгөөд боловсролын ачаар хүн бүр өөрийн ирээдүйг хүсэл сонирхлынхоо дагуу бүтээх боломжтой болдог юм. Энд эв санааны нэгдлийн зарчимтай хүйн холбоотой өөрөө удирдах ёсын зарчмыг баримтлахын ач холбогдол улам бүр тодорхой болж байна.

188. Та бид эдгээр эрэгцүүллийн ачаар хүний суурь эрхүүдэд аюул занал учруулж байгаа, эсхүл тэдгээр эрхийг зөрчиж буй аливаа бүхэнтэй тууштай тэмцэх зайлшгүй шаардлагатай гэдгийг ухаарах боломжтой болж байна. Улс төрчдөд хандаж “ядуу зүдүү, сул дорой хувь хүн болон нийт хүмүүст анхаарлаа хандуулахыг уриалж байна. Эцэстээ ‘сул доройгоо ад үзэн хаяж орхидог соёл’ руу өөрийн эрхгүй хөтөлсөөр аваачдаг гагцхүү хоосон үйл

ажиллагаанд дулдуйдсан, бүхний эхэнд хувийн эрх ашгаа тавьсан сэтгэлгээ ноёлсон үед ядуу зүдүү, сул доройдоо тусална гэдэг нь ихээхэн эрч хүч, нинжин сэтгэл, хүчин чармайлт, өгөөмөр сэтгэл шаарддаг билээ... Ингэх нь дээд зэргийн ялгаварлал бий болгож, уур бухимдал хуримтлуулсан өнөөгийн нөхцөл байдалд дээд зэргийн хариуцлагатай хандаж, ийм нөхцөл байдалд орсон хүний эрхэм чанарыг сэргээхэд тустай юм" [185]. Ингэж чадсанаар "хүмүүний нийгэмд эзлэх байр суурь, эрхэм чанарыг хамгаалахын тулд бүхнийг хийх ёстой" [186] гэсэн ойлголтыг баталгаажуулах хүчин чармайлтыг идэвхжүүлэх юм. Улс төрчид бол өмнөө том зорилго тавьсан, аливаа хязгаарыг давж чаддаг өргөн, бодит, прагматик хараатай ажил хэрэгч хүмүүс, бүтээн байгуулагчид мөн билээ. Тэд санал асуулгаар нэр нь доошилсонд гэхээсээ илүү "хүн худалдаалах, хүний эрхтнийг зарах, охид хөвгүүдийг бэлгийн харьцаанд хүчээр татан оруулах, энгийн хүмүүсийг боолчлох, янхан болгох, хар тамхи, зэвсгийн наймаа хийх, алан хядах ажиллагаа явуулах, олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэг хийх зэрэг хор хохиролтой үр дагавар дагуулдаг нийгмийн болон эдийн засгийн аргаар хүмүүсийг хүн шиг амьдрах амьдралын тойргоос шахан гаргадаг үзэгдэл"-ийг [187] оновчтой шийдвэрлэх арга замыг олоход анхаарлаа хандуулах ёстой. "Эдгээр хүнд хэцүү нөхцөл байдлын хамарч байгаа цар хүрээ дэндүү өргөн, тэдгээрээс болж гэм зэмгүй хүмүүсийн амьдрал сүйдэж байгаа тоо дэндүү олон учир эдгээр эмгэнэлт нөхцөл байдлыг янз янзын үгээр илбэдэн томьёолж оюун ухаанаа тайвшруулан төөрөгдүүлэх гэсэн хүсэлд уруу татагдаж хэрхэвч болохгүй. Та бид бидний байгуулсан байгууллууд эдгээр муу муухай явдалтай үр

дүнтэй тэмцэж чадна гэдгийг үзүүлэх хэрэгтэй" [187]. Ингэх нь технологийн хөгжлийн бий болгож байгаа асар их нөөц бололцоог ухаалгаар ашиглах санааг дотроо мөн адил багтааж байгаа юм.

189. Та бид хамгийн суурь хүний эрхүүдийг одоо хүртэл дэлхий дахинаараа хүлээн зөвшөөрөөгүй байгааг мэдэж байна. Тийм учир даян дэлхийн улс төрийн хамгийн чухал, зайлшгүй хэрэгжүүлэх ёстой зорилго бол юуны түрүүн өлсгөлөнгийн асуудлыг нэг мөр дуусгах явдал мөн билээ. Нээрээн "санхүүгийн аз сорьсон панзлал хоол хүнсийг жирийн нэгэн бараа бүтээгдэхүүн мэтээр үзэж, түүний үнээр тоглож байхад өлсгөлөнгөөс болж сая сая хүн зовж, үхэж байна. Гэтэл хэдэн арван тонн хоол хүнсийг хаяж, устгаж байна. Ингэх нь үнэхээр олон түмний эгдүүцэл дургүйцлийг төрүүлж байна. Хүнийг өлсгөх нь өөрөө гэмт хэрэг мөн. Хоол хүнс бол хүний салшгүй, заяагдмал эрх юм" [188]. Та бид хоорондоо үгээр, үзэл суртлаар маргалдан цэц булаацалдаж байх хооронд та бидний ах, эгч, дүү нар олон олноороо орох оронгүй, эмнэлгийн үйлчилгээ авах боломжгүй өлсөж, цангаж үхэж байна. Ийнхүү тэдний хамгийн наад захын хэрэгцээг нь хангахгүй байхын зэрэгцээ амьд хүмүүсийг худалдаалах явдал газар авч байгаа нь өнөөгийн хүн төрөлхтний бас нэгэн шившиг болж байна. Олон улсын улс төрийн бодлого зөвхөн сайхан үг хэлэх, сайхан санаа дэвшүүлэх гэсэн хязгаарлагдмал хүрээнээсээ даван гарч ийм гутамшигт байдлыг үл тэвчин нэн даруй арга хэмжээ авах цаг болжээ. Эдгээр нь амин чухал асуудал мөн бөгөөд цаг хугацаа алдалгүй шийдвэрлэх ёстой зорилго мөн билээ.

*Хооронд нь ойртуулан холбодог хайрын сэтгэл*

190. Улс төрийн нигүүлсэнгүй сэтгэл бүгдэд нээлттэй байх сэтгэлээр илэрхийлэгдэнэ. Засаг төрийн удирдагчид үгүйдээ гэхэд зарим нэн чухал асуудлаар нэг нэгэнтэйгээ нүүр тулан уулзах, байр сууриа ойртуулан нягтруулахын тулд эхлэн санаачлага гаргаж өөрсдийн ашиг сонирхлыг золиослож чаддаг байх хэрэгтэй. Тэд өөр санаа бодлыг сонсох, хүн бүрт орон зай гаргаж өгөхөд бэлэн байгаагаа харуулах ёстой. Тэд өөрсдийн зүгээс хувийн ашиг сонирхлыг золиослох, тэвчээр үзүүлэх чадвартайгаа харуулснаар хүн бүр өөр өөрийн орон зайтай болох боломжийг олгосон олон талтай, сайхан бодит байдлыг бүтээж чадна гэдэгт итгэлтэй байна. Ийм нөхцөлд зөвхөн эдийн засгийн яриа хэлэлцээ хүсэн хүлээсэн үр дүн авчирч чадахгүй. Арай өөр юм шаардагдана, тухайлбал нийтийн баялгийг бий болгохын тулд нэг нэгэндээ өгөөмөр сэтгэлээр хандан бэлэг сэлт өгөх хэрэгтэй. Энэ санал гэнэн бөгөөд бүтэшгүй юм шиг санагдаж болох боловч та бид энэхүү эрхэм зорилгоос татгалзах эрхгүй юм.

191. Бусдыг үл зөвшөөрөх фундаменталист буюу хэт туйлширсан үзлийн янз янзын хэлбэр хувь хүмүүс, хэсэг бүлэг хүмүүс, ард түмнүүдийн хоорондын харилцаа холбоог нурааж байгаа энэ цаг үед бусдыг хүндэтгэхийн үнэ цэн, нэг нэгнээсээ ялгаатай байхыг дэмждэг хайрын сэтгэл, хүн бүрийн эрхэм чанар тухайн хүний баримталдаг үзэл санаа, сэтгэгдэл, түүний амьдралдаа баримтлан хэрэгжүүлдэг хэв маяг, тэр байтугай түүний үйлдсэн нүглээс хүртэл илүү чухлыг зааж номлох, ингэхийн төлөө амьдрах хэрэгтэй хэмээн бодож амьдралын зорилгоо болгох нь зүйтэй хэмээн үзэж байна. Хэдийгээр өнөөдрийн

нийгэмд хэт туйлшрах үзэл, хэт явцуу ухаан санаа, түүнчлэн нийгмийн болон соёлын ялгарал, хуваагдал газар авч байгаа нь үнэн ч сайн улс төрч хүн эхлээд санаачилга гаргаж өөр дуу хоолойг сонсох ёстой гэсэн байр суурь баримталдаг билээ. Үл ойлголцол зөрчлийг өдөөж магадгүй ч бүхнийг нэг хэв загварт оруулвал амьсгалах агааргүй болсон мэт бачуурах бөгөөд соёлын уналт доройтолд орно. Бодит амьдралын нэг л хэсэг дотор хоригдон түгжигдсэндээ санаа сэтгэл ханамжтай байхгүй байх болтугай хэмээн ерөөе.

192. Ийм ч учир Их Имам Ахмад Аль-Тайеб бид хоёр “олон улсын улс төр, дэлхийн эдийн засгийн дүр зургийг зурж тодорхойгчдод хандан нэг нэгнийгээ тэвчих, энх тайванчаар хамтран орших соёлыг дэлгэрүүлэхийн тулд, гэм зэмгүй хүмүүсийн цус урсгахыг зогсоохын тулд аль болохоор цаг алдалгүй боломж боломцоо болгоныг ашиглахын төлөө цуцалтгүй ажиллахыг уриалсан юм” [189]. Улс орныхоо сайн сайхны төлөө гэсэн нэрийдлээр нэгэн гаж бодлого явуулсны уршгаар бусад улс үндэстний эсрэг үзэн ядах сэтгэл төрүүлж, айдас хүйдсийг бий болгож эхэлмэгц түүнд анхаарлаа хандуулах, санаа зовох, цаг алдалгүй шуурхай арга хэмжээ авч буруу чиг хандлагыг засан залруулах шаардлагатай болдог билээ.

### ҮР ШИМЭЭ ӨГӨХ НЬ ҮР ДҮНГЭЭС ИЛҮҮ ЧУХАЛ БАЙХЫН ТУХАЙ

193. Улс төрчид ядрах цуцахыг мэдэхгүй ажиллах ёстой нь үнэн ч тэд өөрсдөө жирийн эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэдгийг мартаж болохгүй. Тэд ч гэсэн мөн адил өөрсдийн өдөр тутмын харилцаандаа хайрын сэтгэлийг эрхэмлэж байх

ёстой гэсэн шаардлагатай байнга тулгарч байдаг. Тэд хувь хүмүүсийн хувьд “орчин үеийн дэлхий техникийн хөгжил дэвшлийн үр дүнд янз бүрийн үйлчилгээнд ангилагдаж хуваагдсан хүмүүсийн хүслийг гүйцэлдүүлэхэд чиглэгдэж байна. Яваандаа хүмүүсийг нэрээр нь дуудах нь улам улмаар багасах, хүн хэмээх энэхүү ер бусын бодгальд өөрийн мэдрэхүйтэй, зовлонтой, асуудалтай, баяр баясгалантай, гэр бүлтэй хувь хүн мөн хэмээн хандах хандлага улам улмаар багасах төлөвтэй байна. Тэдний өвчин зовлонг эмчлэхийн төлөө л мэддэг, санхүүгийн хэрэгцээг нь тэдэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхийн тулд л судалдаг, тэд өөрийн гэсэн гэр оронгүй байгааг нь тэднийг толгой хорогдох байртай болгохын тулд анхаардаг, амрах, цэнгэх хүслийг нь тэднийг зугацуулахын тулд анхаардаг болох төлөвтэй байна”. Гэхдээ хэдий тийм ч “хамгийн ач холбогдолгүй хэмээн тооцогддог хүмүүнийг хүртэл дэлхийд түүнээс өөр хүн байхгүй юм шигээр бодож ах, дүү шигээ хайрлах нь цаг заваа дэмий юманд үрсэн мэтээр тооцож болохгүй ариун үйл хэрэг мөн билээ” [190] гэдгийг харгалзах шаардлагатай байгаа юм.

194. Улс төр ч бусдыг нинжин сэтгэлээр хайрлах тэр боломжид орон зай гаргаж өгөх ёстой. “Нинжин сэтгэл гэж юу вэ? Энэ бол улам ойр дотно санагддаг, улам бодитой болдог тийм хайрын сэтгэл мөн. Та бидний зүрх сэтгэлээс эхлээд бидний нүдийг нээдэг, чихийг онгойлгодог, гарыг онцгой мэдрэмжтэй болгодог урсгал хөдөлгөөн мөн... Нинжин сэтгэл бол хамгийн хүчтэй, эр зоригтой эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өөрсдөө сонгодог зам мөр мөн” [191]. Улс төрийн амьдралын өдөр тутмын тулгамдсан асуудлуудын дунд цаг зав муутай байж байхад “хамгийн бага, хамгийн сул дорой, хамгийн ядуу нь та бидний зүрх сэтгэлийг

хөндөн хөдөлгөдөг. Үнэхээр тэд та бидний зүрх сэтгэлд хандан уриалах “эрхтэй” гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай. Тэд нар та бидний ах, эгч, дүү нар мөн бөгөөд тийм ч учир бид тэднийг хайрлах, тэднийг асран халамжлах үүрэгтэй” [192].

195. Энэ бүхэн та бид чухал зүйл болгон сайн үр дүнд хүргэнэ хэмээн бодож болохгүй гэсэн үнэнийг ухаарах боломжийг олгож байна. Ингэх нь угаасаа бүтэхгүй гэдэг нь ойлгомжтой. Та бид санаж байх ёстой юм бол улс төрийн үйл ажиллагаанд “гадна талаасаа яаж харагдаж байгаа нь гол биш. Хүн бүр ариун бөгөөд та бидний хайрыг хүртэх эрхтэй билээ. Ийм учир би нэг ч гэсэн хүнд амьдрал нь сайн сайхан болоход тусалсан бол энэ нь би хүн болж төрсний утга учрыг зөвтгөн тайлбарлаж байгаа юм. Тэнгэрбурханы үнэнч ард түмэн байх нь гайхамшигтай. Та бид хана хэрмийг нураагаад, ингэсний ачаар өөрсдийн зүрх сэтгэлийг хүмүүсийн нүүр царай, нэрсээр дүүргэвэл нэгэн зорилгодоо хүрч байгаа нь тэр билээ! [193]. Та бидний хүсэл мөрөөдөл, төлөвлөгөөний агуу зорилгуудын нэг хэсэг нь л биелэгдэнэ. Гэхдээ хайрлаж чаддаг хүмүүс, улс төр бол гагцхүү эрх мэдлийн хойноос хөөцөлддөг хэрэгсэл мөн гэж боддоггүй хүмүүс “та бидний хайрын сэтгэлийн илэрхийлэл болсон үйл хэрэг болгон гээгдэхгүй, та бидний бусдын сайн сайхны төлөө илэрхийлсэн сайхан сэтгэл бүр мартагдахгүй гэдэгт итгэлтэй байж болно. Тэнгэрбурханыг хайрласан хайрын сэтгэлийн үйл хэрэг бүр гээгдэхгүй, өгөөмөр сэтгэлийн илэрхийлэл болсон хүчин чармайлт бүр мартагдахгүй, хүнд хэцүү ч тэсвэр тэвчээрийн дээдийг үзүүлсэн үйлдэл бүр орхигдохгүй. Энэ бүхэн манай дэлхийг амьдралын агуу хүч мэт тойрон хүрээлж байдаг юм” [194].

196. Ийм учир та бид сайн сайхны үрийг суулгаж байгаа болохоор тэдгээр үрийн нуугдмал хүчинд итгэх нь туйлын зөв болно. Ингэснээр бусдын хураах жимсийг боловсруулах тэрхүү үйл явцыг эхлүүлэх юм. Сайн улс төр хайрын сэтгэлийг итгэл найдвартай холбодог, хүмүүсийн зүрх сэтгэлд байдаг сайн сайханд бүрэн итгэх итгэлийн галыг асаадаг билээ. Нээрээн "улс төрийн жинхэнэ амьдрал хуулийг хүндэтгэх хүндэтгэл, хувь хүмүүсийн хоорондын чин сэтгэлийн яриан дээр тогтдог бөгөөд эмэгтэй, эрэгтэй хүн бүр, шинэ үе болгон цоо шинэ харилцааны, оюун ухааны, соёлын, зүрх сэтгэлийн эрч хүч ирнэ гэдгийг амлаж буйг ухаарах бүртээ байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг юм" [195].

197. Энэ өнцгөөс нь харвал улс төр бол бусдын гайхширлыг алдагдуулахын тулд дүр эсгэх, улс төрийн зах зээлд үнэ хүрэх гэж тэмүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчтэй сурталчилгаа явуулахаас илүү эрхэм үйл хэрэг мөн билээ. Харин эдгээр үйл ажиллагаа бол хагарал бутрал, зөрчил, нэгдсэн зорилгод хүрэхийн тулд хүмүүсийг дайчлах чадваргүй юунд ч үл итгэхбайдлын үрийг тарихаас өөр ямар ч үр дүн авчрахгүй юм. Заримдаа та бид ирээдүйн тухай эргэцүүлэн бодохдоо өөрсдөөсөө ингэж асуух нь зөв билээ: "Яагаад би энийг хийж байгаа билээ? Миний жинхэнэ бодит зорилго юу вэ?" Учир нь цаг хугацаа өнгөрөхөд өнгөрснийхөө тухай эргэцүүлэн бодохдоо дараах асуултуудыг өөрөөсөө асуух нь утгагүй байдаг: "Намайг хэдэн хүн дэмжсэн бэ?", "Миний төлөө хэдэн хүн саналаа өгсөн бэ?", "Хэдэн хүн миний тухай эерэг сэтгэгдэлтэй байсан бэ?" Харин жинхэнэ бодит, амаргүй асуултууд гэвэл дараах асуултууд байх ёстой: "Би хэдий хэмжээний хайрын сэтгэлийг ажилдаа шингээсэн бэ?",

“Би ард түмнийхээ хөгжил дэвшилд ямар хувь нэмэр оруулж чадсан бэ?”, “Би нийгмийн амьдралд өөрийн гэсэн ямар ул мөр үлдээж чадсан бэ?”, “Би ямар ямар бодит харилцаа холбоо бий болгож чадсан бэ?”, “Би ямар ямар эерэг эрч хүчийг дайчилж чадсан бэ?”, “Би ямар хэмжээний нийгмийн энх тайвныг тогтоосон бэ?”, “Олон түмний итгэлээр очсон ажил дээрээ байхдаа ямар ямар сайн сайхан үйл хэрэг бүтээж чадсан бэ?”

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

# НИЙГЭМ ДЭХ ХҮМҮҮС ХООРОНДЫН ЯРИЛЦАА, НӨХӨРЛӨЛ

198. Нэгэндээ хандах, нэг нэгэнтэйгээ ярих, нэг нэгнийгээ сонсох, нэг нэгэн рүүгээ харах, нэг нэгнийгээ мэдэх, ойлгох, нэгтгэж байгаа зүйлээ олох зэрэг энэхүү олон үйлдэл "нэг нэгэнтэйгээ ярих" гэсэн нэг үгэнд багтана. Хэрэв та бид нэг нэгэнтэйгээ уулзаж учрая, нэг нэгэндээ туслая гэж бодож байгаа бол нэг нэгэнтэйгээ ярих хэрэгтэй. Би нэг нэгэнтэйгээ ярихын сайн талыг онцлон тэмдэглэх шаардлагагүй гэж бодож байна. Харин би гэр бүлүүдээ, хамт олноо хамгаалан дэмжиж байдаг өгөөмөр сэтгэлтэй хүмүүс хоорондоо нэг нэгэнтэйгээ хүлээцтэйгээр ярихаа больчихвол манай дэлхий ямар болох бол? хэмээн бодож байна. Нэг нэгэнтэйгээ байнга, эр зориг гарган ярих нь санал бодол үл нийлэх, хоорондоо зөрчилдөх лүгээ адил хэвлэл мэдээллийн анхаарал татахгүй ч чухамхүү ингэсний ачаар дэлхий та бидний төсөөлснөөс илүү сайхан амьдрахад элдвийн шуугиангүйгээр тусална.

199. Зарим хүн бодит байдлаас зайлан зугтах, өөрийн жижиг ертөнцөд нуугдан хорогдох хүсэлтэй байдаг. Зарим хүн бодит байдлыг хүчээр эвдэн нураахыг оролддог. Гэвч “амиа бодсон хайхрамжгүй хандлага болон хүч хэрэглэсэн эсэргүүцлийн дунд өөр боломжийн сонголт заавал байдаг. Тэр нь: нэг нэгэнтэйгээ ярих юм. Үеүдийн хооронд яриа хийх, та бид өөрсдөө ард түмнүүдийнхээ салшгүй хэсэг мөн учир манай ард түмнүүдийн хооронд яриа хийх, үнэнд нээлттэй байхын зэрэгцээ авах, өгөхөд бэлэн байх нь чухал юм. Нийтийн соёл, их, дээд сургуулийн соёл, залуучуудын соёл, урлагийн соёл, технологийн соёл, эдийн засгийн соёл, гэр бүлийн соёл, хэвлэл мэдээллийн соёл зэрэг баялаг соёлын олон бүрэлдэхүүн хэсгүүдийн хооронд бүтээлч яриа өрнөдөг улс орон хөгжин цэцэглэдэг билээ” [196].

200. Яриа хийнэ гэдгийг тэр болгон найдвартай биш хэвлэлийн мэдээлэлд тулгуурласан асуудлаар сошиал сүлжээнд хурцаар санал солилцох гэсэн огт өөр юмтай хольж хутгадаг явдал олонтаа тохиолддог билээ. Ингэж санал солилцож байгаа нь үнэн хэрэгтээ хүн хүн өөр өөрөө дангаараа нэгэн зэрэг ярьж байгаа үйл явц гэж ойлгох хэрэгтэй. Ийм байдлаар санал солилцохдоо хурц үг хэлж, түрэмгий өнгө аяс гаргадаг учир зарим анхаарлыг татдаг. Гэвч өөрөө дангаараа ярих нь хэн нэгнийг яриандаа татан оруулдаггүй учир дутагдалтай байдаг. Ийм ярианы утга агуулга зөвхөн тухайн хүнд өөрт нь хэрэгтэй бөгөөд ихээхэн зөрчилтэй байдаг билээ.

201. Нээрээн хүн бүр өөр өөрийн санаа бодолтой гөжүүдлэн зууралдах, ашиг сонирхол, сонголтдоо дуртай байдаг тул, өөрөөс нь бусад бүх хүн буруу хэмээн өөрийгөө зөвтгөх хүсэлтэй байдаг учир хэвлэл мэдээллийн хэрэгслээр баримт, саналуудыг хольж хутган дахин дахин давтан ярих, дамжуулах нь бодит яриа өрнүүлэхэд саад бэрхшээл учруулна. Илүү гүн гүнзгий түвшинд санал нийлэх зорилготой нэг нэгнийгээ харилцан хүндэтгэсэн яриа эхлүүлэхийн оронд бүр эхнээсээ бусдын нэр хүндэд халдах, доромжлох нь илүү амархан санагддаг. Голдуу улс төрийн кампанит ажлыг хэвлэл мэдээллээр дамжуулахад хэрэглэдэг бүдүүлэг хэл яриа өргөн дэлгэрч, хүмүүсийн хоорондын өдөр тутмын хэрэглэдэг үг хэллэг болж байгаа нь бүр харамсалтай. Олон түмний санаа бодолд нөлөөлөн шударга бус аргаар өөрийн талд татах зорилготой хүчирхэг тусгай ашиг сонирхлууд аливаа хэлэлцүүлгийг завхруулдаг билээ. Ийнхүү завхруулах аргыг Засгийн газрууд ашиглаад зогсохгүй энэ муу арга улс төр, эдийн засаг, харилцаа холбоо, шашин болон бусад салбарт өргөн хэрэглэгддэг юм. Энэ муу аргыг хэн нэгний эдийн засгийн, эсхүл үзэл суртлын ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахдаа элдвийн зөвтгөл, үндэслэл олох гэсэн оролдлого хийгддэг ч эрт орой хэзээ нэгэн цагт энэ муу арга чухамхүү тэр ашиг сонирхлын өөрийнх нь эсрэг үйлчилдэг.

202. Нэг нэгэнтэйгээ яриа өрнүүлэхгүй байх нь хүмүүс нийтийн сайн сайхны төлөө санаа сэтгэл зовохгүй байх, эрх мэдлийн хойноос улайран хөөцөлдөх, эсхүл хамгийн сайнаар бодоход өөрийн санаа бодлыг бусдад тулгах үйлдэл болж хувирна. Ийм нөхцөлд дугуй ширээний ярианууд хоорондоо хэлэлцээ хийх хуралдаанууд

болно, нийтийн сайн сайхны төлөө хамтран ажиллахыг эрмэлзэхийн оронд мөч болгоныг өөртөө ашигтай байдал бий болгохын тулд ашиглах гэсэн оролдлого болж хувирна. Харин ирээдүйн баатрууд бол иймэрхүү эрүүл саруул биш санаа бодлын хайрцгийг эвдэж, хувийн ашиг сонирхолыг хажуу тийш тавьж, бүрэн бүтэн үнэнийг дэмжихийн тулд бусдад хүндэтгэлтэйгээр хандах байр суурийг тууштай баримталдаг хүмүүс байх болно. Тэнгэрбурханы хүсэл, ерөөлөөр ийм баатрууд манай нийгмийн харилцаан дунд яг одоо илүү дутуу шуугиангүйгээр төрж байгаа гэдэгт итгэж байна.

*Хамтдаа барьж бүтээх*

203. Нийгмийн жинхэнэ хоёр талын яриа нөгөө талынхаа үзэл бодлыг хүндэтгэх, тэрхүү үзэл бодол өөртөө хууль ёсны итгэл үнэмшлийг хүндэтгэх хүндэтгэл болон эргэлзээ тээнэгэлзээ аль алийг нь агуулж болно гэдгийг хүлээн зөвшөөрөх чадварыг багтаадаг. Бусад хүмүүс өөрсдийн өвөрмөц дүр төрх, туршлагад тулгуурлан хоёр талынярианд өөрсдийн хувь нэмрийг оруулж чадах нь ойлгомжтой. Тэд нийгмийн мэтгэлцээнийг үр дүнтэй болгохын тулд өөрсдийн байр суурийг нээлттэй тайлбарлаж байх нь чухал билээ. Хувь хүмүүс, эсхүл хэсэг хүмүүс бодол санаагаа тууштай баримтлах, өөрсдийн үнэт зүйлс, итгэл үнэмшлийг хамгаалдаг байх, өөрсдийн үндэслэлийг улам нарийн боловсруулан хөгжүүлдэг байх нь нийгэмд ашиг тустай. Гэхдээ гагцхүү чин сэтгэлийн яриа хөөрөө өрнөх, бусдад нээлттэй байх нөхцөлд ийм боломж бололцоо хангагдана. Нээрээн “хоёр талын яриа хөөрөө жинхэнэ ёсоор өрнөнө гэж бодвол ярианы дунд хэдийгээр бид өөрийн итгэл үнэмшил болгож чадахгүй

ч та бидний бусдын хэлсэн, хийсний ач холбогдлыг ухааран ойлгох чадвар өсөж хөгжинө. Ингэснээр бусадтай ярьж хөөрөхдөө чин сэтгэлээсээ бөгөөд нээлттэй байх, бусадтай харилцаа холбоо тогтоож авцалдах тэр цэгээ олох, хамгийн гол нь хамт зүтгэх, хамт тэмцэх боломжтой болно" [197]. Нээрээн хүн бүрт өөр өөрийн орон зай гарган өгч байгаа бол, бусдын тархи толгойг эргүүлээгүй, мэдээллийг нуун дарагдуулаагүй бол нийтээрээ хэлэлцэх нь үнэнийг илүү сайн ухан ойлгох, үгүйдээ гэхэд үнэнийг илүү тод томруун илэрхийлэхийг байнга өдөөж байдаг билээ. Нийтийн хэлэлцүүлэг янз бүрийн салбар бусаддаа хайхрамжгүй хандах, аливааг харахдаа анхаарлаа өөр дээрээ төвлөрүүлэн явцуурах, жижиг хүрээний асуудалд санаа зовохоос сэргийлж чадна. Бүгдээрээ "аливаа ялгаа бүтээлч шинж чанартай байдаг, аливаа ялгаа хурцадмал байдлыг бий болгоно, харин хурцадмал байдлыг намжаах нь хүн төрөлхтний хөгжил дэвшлийг түргэсгэнэ" [198] гэдгийг байнга санаж байхыг уриалж байна.

204. Та бид шинжлэх ухааны нарийвчилсан судалгаанд үндэслэсэн хөгжил дэвшлийн хамт цаашид салбар хоорондын харилцаа холбоог гүнзгийрүүлэх шаардлагатай болжээ гэсэн итгэл үнэмшил улам бүр өсөн нэмэгдэж байгаа билээ. Хэдийгээр бодит байдал ганцхан байдаг нь үнэн ч энэхүү байдалд хандахдаа олон өнцөг булангаас харан судалж, олон аргачлалыг ашиглаж болно. Гагцхүү шинжлэх ухааны хөгжил дэвшилд дулдуйдан тэр л өнцгөөс харвал амьдрал, нийгэм, дэлхийн зөвхөн нэг хэсгийг харж чадах томруулдаг шилтэй болох аюул бий. Өөрийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн судлаачид бусад шинжлэх ухааны салбар, шинжлэх ухааны сэдвийн ололт, нээлттэй танилцсан байвал өөрсдийн судлагдахууны өөр

өөр талыг гүн гүнзгий танин мэдэх боломжтой болно. Ингэснээр тэд бодит байдлын талаар илүү цогц, илүү олныг багтаасан мэдлэг эзэмшихэд нээлттэй байж чадна.

205. Өнөөдрийн даяаршсан ертөнцөд "хэвлэл мэдээлийн байгууллагууд та бид нэг нэгэндээ ойр дотно болсон мэт санагдахад тусална. Ингэснээр хүмүүний том гэр бүлийн эв нэгдлийн талаар сайхан мэдрэмж төрүүлнэ. Улмаар хүмүүсийн хооронд эв санааны нэгдэлтэй байх хүслийг өдөөж хүн бүр одоогийнхоос илүү нэр хүндтэйгээр амьдрахын тулд ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатайг сануулна... Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ийм нөхцөл байдлыг бий болгоход ихээхэн тус дэмжлэг үзүүлж чадах нь ойлгомжтой. Ялангуяа хүмүүсийн хоорондын харилцаа холбооны сүлжээ урьд өмнө үзэгдээгүй хурдтайгаар хөгжиж буй өнөөдөр ийм тус дэмжлэгийг үзүүлж чадна. Тухайлбал интернэтийн холбоо хүмүүс хоорондоо уулзан учрах, эв санааны нэгдлийг илэрхийлэх өргөн боломж бололцоог олгож байна. Энэ бол үнэхээр сайн сайхан юм мөн бөгөөд түүнийг Тэнгэрбурханы хайрласан бэлэг хэмээн хүлээн авбал зохино" [199]. Та бид үнэн хэрэгтээ өнөөдрийн харилцаа холбооны хэлбэрүүд биднийг бусадтай уулзан учрах, цогц үнэнийг олохын төлөө чин сэтгэлээсээ тэмүүлэх, бусдад үйлчлэх, хавчигдан шахагдсан хүмүүст ойр дотно байх, нийтийн сайн сайхныг дэмжих зам мөрийг заан чиглүүлэх ёстой хэмээн ойлгож хүчин чармайлт гаргаж байх шаардлагатай. Австралийн Тэргүүн хамба нарын айлдаж онцлон тэмдэглэснээр та бид "бидний сул талыг ашиглах, хүмүүсийн дотор хамгийн муу муухай чанарыг нь өдөөхөд зориулагдсан цахим ертөнц" [200] байхыг огт хүлээн зөвшөөрч болохгүй.

206. Аливааг харьцангуй гэж үзэх нь зөв шийдвэр гаргахад тус болохгүй. Хүлээцтэй, тэвчээртэй байхын багийн цаана аливааг харьцангуй хэмээн үзэх үзэл эрх дархтнуудад ёс суртахууны үнэ цэнтэй зүйл гэж юу вэ гэдгийг өөрсөддөө тохируулан, өөрсдийн харж байгаагаар тайлбарлах боломжийг олгоно. “Бодит үнэн гээч байхгүй, эрүүл саруул зарчим гээч байхгүй гэж үзвэл зөвхөн өөрийн хүсэл шуналыг гүйцэлдүүлэх, өөрсдийн нэн шаардлагатай хэрэгцээг хангахын төлөө улайран хөөцөлдөх явдал л үлдэнэ... Ийм нөхцөлд улс төрийн хүчин чармайлт гаргах, хуулийн хүчийг үзүүлэх нь хангалттай гэж бодож болохгүй... Ер нь соёл нь өөрөө хээл хахуульд идэгдчихсэн, бодит үнэн болон нийтээрээ баримтлах ёстой чухал зарчмуудыг баримтлахаа больчихсон үед хуулийг түр зуурын хугацаагаар тогтоосон зохицуулалт, эсхүл тойрч гарч болох саад бэрхшээл хэмээн үздэг билээ” [201].

207. Үнэний төлөө санаа зовох хэрэгтэй юу? Амьдралын хамгийн гүн гүнзгий утга учирт нийцэж дүйцсэн үнэнийг эрж хайх хэрэгтэй юу? Хүмүүн хэмээх бодгал бол ариун мөн чанартай, халдашгүй дархан гэсэн олон зууны эргэцүүлэл, агуу их оюун ухаанаас үүдэлтэй итгэл үнэмшил байхгүй бол хууль гэж юу билээ? Хэрэв аливаа нийгэмд ирээдүй байх ёстой гэж үзэх юм бол тэр нийгэм хүмүүн бидний эрхэм чанарын үнэнийг хүндэтгэх, энэ үнэнийг хүлээн зөвшөөрөх ёстой. Хүний амь насанд халдах нь нийгмийн харилцаанд хүлээн зөвшөөрөх аргагүй гэмт хэрэг мөн бөгөөд тэгсэн хүнийг хуулиар шийтгэдэг хэмээн тайлбарлах нь хангалттай биш. Түүнийг буруушаах илүү гүн гүнзгий итгэл үнэмшил байдаг билээ.

Энэ бол оюун ухааны учир шалтгааны аргаар хүрсэн, гүн гүнзгий ухамсраар хүлээн зөвшөөрсөн, үл наймаалцах үнэн мөн билээ. Аливаа нийгэм үнэнийг эрэлхийлдэг, хамгийн суурь үнэнийг баримталдаг гэдгээрээ эрүүл саруул бөгөөд эрхэм мөн чанартай хэмээн тооцогдоно.

208. Та бид олон нийтэд зориулсан, эсхүл хүмүүс хоорондынярианд тухайн нөхцөлд тохируулан үнэнээр хэрхэн тоглодог, үнэнийг хэрхэн мушгин гуйвуулдаг, үнэнийг хэрхэн нуун дарагдуулдаг янз янзын аргууд байдгийг илчилж сурах хэрэгтэй. "Үнэн" гэж чухам яг юуг хэлээд байна вэ? гэвэл зөвхөн өдөр тутмын сонинд хэвлэгдсэн баримт, үйл явдлын тухай мэдээлэл биш юм. Үнэн хэрэгтээ "үнэн" бол та бидний шийдвэрүүд, та бидний хуулийг тогтвортой тэтгэн хамгаалж байдаг бат бэх суурийг олохын төлөөх эрэл хайгуул мөн билээ. Энэ нь хүний оюун ухаан бол яг одоо санаа сэтгэл зовоож байгаа асуудлуудыг давж өнгөрсөнд ч үнэн байсан, одоо ч үнэн хэвээр байгаа тэр үл өөрчлөгддөг үнэнийг ухан ойлгож чадна гэдгийг хүлээн зөвшөөрөх шаардлагатайг сануулна. Оюун ухаан хүний дотоод мөн чанар руу улам гүнзгий өнгийн харвал тэр мөн чанараас үүдэн гарсан, бүх нийтэд хамаатай үнэт зүйлсийг олж нээж чаддаг юм.

209. Эс тэгвээс идэвхгүй, айдас хүйдэст автсан хүн амын "дэмжлэг"-ийг авсан гэх эрх мэдэлтнүүд та бидний хэнбугай ч зөрчих эрхгүй хэмээн үздэг хүний эрхийг үгүйсгэнэ гэдэг нь ойлгогдохгүй байна гэж үү? Цаашилбал элдвийн ухуулгад автамтгай бөгөөд өртөмтгий учир янз янзын үндэстнүүд хоорондоо нэгэн зөвшилцөлд хүрсэн байлаа ч ингэсэн нь хүний суурь эрхийг хамгаалахад хангалтгүй билээ. Та бид асар их сайн үйл бүтээж чадна

гэдгийг баталсан хангалттай олон нотолгоо байдаг ч нөгөө талаар та бидний дотор мөн адил асар их нураах хүч нуугдаж байдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Та бид аливаад хайнга, хайхрамжгүй хандаж байгаа нь, хар амиа бодсон хувиа хичээх үзэлд автсан нь илүү эрхэм үнэт зүйлс буюу та бидний өдөр тутмын ахуйн хэрэгцээг давсан илүү эрхэм үнэт зүйлсийн хойноос тэмүүлэхээсээ хойргошоон хойш суусны баталгаа биш гэж үү? Бүх юм харьцангүй хэмээн хүлээж аваад байх юм бол эрх мэдэлтнүүд, эсхүл та биднээс илүү зальтай, илүү ухаантай этгээдүүд мушгин гуйвуулсан үнэнийг бидэнд тулган хүлээлгэх эрсдэл байнга байх болно шүү гэдгийг ухаарах хэрэгтэй. Харин "аливаа хүний дотор байдаг муу муухайг хориглодог ёс суртахууны хэм хэмжээнүүд хэн нэгэнд илүү их эрх дарх байх ёстой, эсхүл хэн нэгнийг бусдаас илүүд үзэх ёстой гэдэггүй. Эдгээр хэм хэмжээ энэхүү газар дэлхийн хамгийн мундаг хүн, эсхүл "үгээгүй хоосон этгээд" хэн ч байлаа нэгнийг нь илүүд, нөгөөдөхийг нь доорд үзэж ялгаварладаггүй билээ. Ёс суртахууны шалгууруудын өмнө та бид бүгд ижил тэгш юм" [202].

210. Өнөөдөр ёс суртахуун болон улс төрийн аль аль нь махан биеийн хүсэл шуналд захирагддаг болсон учир та бид энэ байдалд өөрийн эрхгүй уруу татагдаж бидний оюун ухаанд шалиг завхай, үр дүнгүй санаа бодол төрдөг болсон байна. Буян, нүгэл хоёр тус тусдаа байдаг гэсэн ойлголт алга болж, ашиг хонжоо олох, эсхүл ачаа дарамт учрах гэдгийг тооцолдог болсон байна. Ёс суртахууны үүднээс эргэцүүлэн бодохоо больсон учир хууль бол шударга ёсны суурь тусгал мөн хэмээн тооцохоо больж, оронд нь хуулийг өнөөдөр олон түмэнд гоё санагдан таалагдаж байгаа ойлголтуудын шууд тусгал байх ёстой

гэж үздэг болсон байна. Ингэснээр их задрал явагдаж, аливаа юм ашиг сонирхлоороо наймаалцсаны үндсэн дээр бий болсон өнгөцхөн зөвшилцлөөр “тэгшигтгэгдэж” байна. Улмаар эцэстээ хамгийн хүчтэйгийн зөв гэсэн хууль үйлчилж эхэлж байна.

*Зөвшилцөл ба үнэн*

211. Олон ургальч үзэлтэй нийгэмд зөвшилцөл хэмээх хэврэгхэн ойлголцлыг бодвол хоёр талын яриа бол ямагт батлагдан нотлогдож, хүндлэгдэж байх ёстой учир тохиролцох хамгийн сайн арга мөн билээ. Ийм яриаг эрүүл саруул бодол, рационал үндэслэл, олон гаргалгааны тухай төсөөлөл, мэдлэгийн олон салбарын оруулж буй хувь нэмэр, олон өнцөг булангаас харах боломж зэргээр улам баяжуулан гэрэл гэгээтэй болгох шаардлагатай. Түүнчлэн ийм ярианы ачаар эцсийн дүндээ байнга дэмжиж байх ёстой суурь үнэнүүд дээр тохирч болно гэсэн итгэл заавал байх ёстой юм. Хэдийгээр тэдгээрийг олж харах, ухан ойлгох нь амаргүй байдаг ч зарим байнгын шинж чанартай үнэт зүйлс буйг хүлээн зөвшөөрснөөр ямагт амьд, бат бэх нийгмийн ёс суртахууныг бий болгоно. Ярьсны ачаар тохиролцоонд хүрч, улмаар суурь үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрч, өөрийн болгон авснаар тэдгээр үнэт зүйлс зөвшилцлөөс илүү чухал шинж чанартай болдог билээ. Тэдгээр үнэт зүйлс тодорхой нөхцөл байдлаас шалтгаалахаа больж, тэдгээрийн талаар наймаалцах нь утгагүй болно. Ингэснээр та бидний тэдгээрийн утга учир, цар хүрээний талаарх ойлголт улам гүнзгийрэн нэмэгдэж, энэ утгаар нь авч үзвэл зөвшилцөл нь хувиран өөрчлөгдөж байдаг бодит байдал болох бөгөөд тэдгээр үнэт зүйлс өөрсдөө дотроо агуулж байгаа гүн гүнзгий утга учраараа

байнга орших шинж чанартай болно.

212. Ямар нэгэн юм нийгмийн харилцааны зохицуулалт сайн байхад нь байнга эерэг нөлөө үзүүлээд байгаа гэдэг нь үүний цаана хүний оюун ухаанаар хүрч болохуйц хувиршгүй үнэн байгааг нотолж байгаа хэрэг биш үү? Та бид хөгжин дэвших, эсхүл аливаа хүнд саад бэрхшээлийг даван туулах чадварыг дэмждэг тодорхой суурь бүтэц хүмүүн хэмээх бодгаль болон нийгмийн мөн чанарт ямагт оршиж байдаг билээ. Эндээс зарим шаардлага урган гарах бөгөөд тэдгээрийг гагцхүү хоёр талын ярианы ачаар нээн ухаарч болно. Гэхдээ эдгээр шаардлагыг зөвшилцлөөр нээн олох боломжгүй. Зарим дүрэм журам нийгмийн амьдралд зайлшгүй шаардлагатай бөгөөд тэдгээр нь нийгмийн амьдралаас салшгүй хэмээх баримт байгаа нь тэдгээрт сайн чанар байна, тэдгээрийн мөн чанар нь сайн гэсэн үг юм. Тийм учир нийгмийн ашиг сонирхол, зөвшилцөл болон бодит үнэн гурвыг нэг нэгэнтэй нь сөргөлдүүлэн тавих шаардлагагүй юм. Хүмүүс нэг нэгэнтэйгээ ярих замаар аливаа тулгамдсан асуудлын гол учрыг ухан ойлгохоосоо айж эмээхгүй байгаа цагт эдгээр гурван бодит байдлыг хооронд нь уялдуулан зохицуулах замаар эв найрыг тогтоож болно.

213. Ямар ч нөхцөлд бусдын эрхэм чанарыг хүндэтгэж байх ёстой. Эрхэм чанар бол та бидний өөрсдөө зохиож бүтээсэн, эсхүл төсөөлсөн зүйл биш билээ. Эрхэм чанар бол материаллаг зүйл болон санаандгүй бий болсон нөхцөл байдлаас хамаагүй илүү үнэ цэн бүхий шинж чанар мөн бөгөөд хүмүүн бүрт энэхүү шинж чанар төрөлхийн заяагдмал байдаг юм. Ийнхүү үзэх нь хүн бүрт өөр өөрт нь тохируулж хүндэтгэлтэй хандах ёстой гэсэн үг юм.

Хүн бүрт эрхэм чанар заяагдмал байдаг хэмээх нь аливаа соёлын өөрчлөлтөөс үл шалтгаалан хүлээн зөвшөөрөгдөж байх ёстой хүний мөн чанарыг тодорхойлсон үнэн юм. Ийм учир хүмүүс аль ч түүхэн цаг хугацаанд яг ижилхэн халдашгүй эрхэм чанартай байдаг бөгөөд хэнбугай ч ямар ч нөхцөлд өөрийгөө энэхүү үнэнийг үгүйсгэх, эсхүл түүний эсрэг үйлдэл хийх эрхтэй хэмээн үзэж үл болно. Оюун ухаан аливаа эд зүйлсийн мөн чанарыг эргэцүүлэх, турших, эсхүл ярилцах замаар танин мэддэг бөгөөд ингэхдээ өөрийнх нь танин мэдэх хүчин чадлаас давсан бодит байдалд зарим бүгдийг хамарсан ёс суртахууны шаардлагын суурь оршиж буйг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болдог билээ.

214. Агностикууд буюу ертөнцийг танин мэдэх боломжгүй хэмээн үзэгчид энэхүү чухал ойлголт дараа дараагийн сүйрлийг урьдчилан сэргийлэхэд тус дөхөм болох суурь, үл марган хүлээн зөвшөөрөх ёстой ёс суртахууны зарчмууд бат бэх бөгөөд тогтвортой, бүгдийг хамарсан ач холбогдолтой юм хэмээн үзэхэд хангалттай гэж тооцдог. Харин сүсэгтэн олны хувьд бид ёс суртахууны зарчмуудын эх сурвалж болсон хүмүүний мөн чанарыг Тэнгэрбурхан бүтээсэн бөгөөд эцсийн эцэст чухамхүү Тэрээр эдгээр зарчим бат бэх, тогтвортой үндэс суурьтай байхыг тогтоодог гэдэгт эргэлзэлгүй итгэдэг билээ [203]. Гэхдээ ингэж янз янзаар үзэж байгаа нь хөшүүн ёс суртахууны зарчмыг тогтоож байна, эсхүл ганцхан ёс суртахууны тогтолцоог баримтлахаас өөр аргагүй болгож байна гэсэн үг биш юм. Учир нь үндэс суурь болсон, бүгдийг хамарсан ёс суртахууны чухал зарчмуудыг амьдралд хэрэгжих боломжтой янз янзын дүрэм журмын хэлбэрт оруулан баримталж болно. Тийм болохоор хоёр этгээдийн

хоорондын яриа хөөрөө өрнөх боломж бололцоо ямагт байна гэсэн үг юм.

ШИНЭ СОЁЛ

215. Хэдийгээр олон олон зөрчил байдаг ч амьдрал бол уулзан учрахын урлаг мөн [204]. Би цаг ямагт та бидний ялгаа, хуваагдмал байдлыг даван арилгах чадвартай уулзан учрахын соёлыг хөгжүүлэхийг уриалж ирсэн билээ. Энэ нь "бүрэн бүтэн нь нэг хэсгээс илүү" [205] гэсэн зарчимд тулгуурласан, өөр өөр олон хэсгээс бүрдсэн нэгдлийг төлөөлсөн полихедрон буюу олон талт бүтцийг бүтээхийн төлөө ажиллах гэсэн үг юм. Полихедрон буюу олон талт бүтцийн дүр зураг хэдийгээр санал бодол нийлэхгүй байх, өөрийн бодолд үнэнч хэвээр үлдэх зэрэг явдал байж болох боловч өөр өөр ялгаатай байдал зэрэгцэн орших, нэг нэгнийгээ нөхөх, нэг нэгнийгээ баяжуулах, нэг нэгнийгээ гэрэл гэгээгээр дүүргэх нийгмийг төлөөлнө. Хүн бүр бусдаасаа ямар нэгэн юм сурч болно. Хэнийг ч хэрэггүй, ач холбогдолгүй хэмээн тооцож үл болно. Энэ нь амьдралын зах хязгаарт оршиж байгаа тэр хүмүүсийг үйл хэрэгтээ татан оролцуулна гэсэн үг юм. Учир нь тэд аливааг өөр өнцгөөс харах өөрийн гэсэн өнцөгтэй, тэд чухал чухал шийдвэр гаргадаг эрх мэдлийн төвөөс харагддаггүй амьдралын бодит байдлын хэсгийг олж харж чаддаг юм.

*Соёл болж хувирдаг учрал*

216. "Соёл" хэмээх үг ард түмний дотор гүн гүнзгий орших нэгэн зүйлийг заана, энэ үг хүмүүсийн хамгийн нарийн нандин итгэл үнэмшил, тэдгээрийн амьдралын хэв маягийг

илэрхийлнэ. Ард түмний "соёл" хэмээх нь зүгээр нэгэн хийсвэр санаа биш билээ. Энэ ойлголт хүмүүсийн хүсэл, сонирхол, эцэстээ тэдний амьдралын хэв маяг ямар вэ? гэдгийг тодорхойлно. "Уулзаж учрахын соёл" хэмээхийн тухай ярина гэдэг нь та бид хүмүүсийн хувьд бусадтай уулзан учрах, тэдэнтэй холбоо тогтоох далим эрж хайх, хүмүүсийн хооронд гүүр барих, бүгдийг багтаасан төслийг төлөвлөхийн төлөө сэтгэл санаагаа бүхэлд нь асаах ёстой гэсэн үг юм. Ингэх нь та бидний хүсэл тэмүүлэл, амьдралын хэв маяг болно. Энэхүү соёлын эзэн нь ард түмэн мөн билээ, мэргэжлийн хүмүүс болон хэвлэл мэдээллийн нөөц бололцоог дайчлан тэдний тусыг авах замаар бусдыгаа тайвшруулдаг тэр нэг хэсэг энэ соёлын эзэн байж таарахгүй.

*217.* Нийгмийн энх амгалан байдлыг тогтоохын тулд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулах хэрэгтэй, ингэх нь уран ажиллагаа шаардана гэсэн үг билээ. Ямар ямар эрх чөлөө эдлэх вэ? Хэр зэрэг өөр өөр байж болох вэ? зэргийг ихээхэн арга заль гаргаж, хөрөнгө мөнгө зарцуулж байгаад нэг хэсэг тогтоон барьж болно. Гэвч ийм байдлаар тогтоосон энх амгалан байдал өнгөцхөн бөгөөд хэврэг байх болно, тогтвортой байдлыг бат бэх тогтоодог соёлын үр жимс болж чадахгүй. Ялгаануудыг хооронд нь нарийн холбоотой болгох нь илүү хүнд хэцүү бөгөөд урт удаан цаг хугацаа шаардсан үйл ажиллагаа болно, гэхдээ ингэсний ачаар жинхэнэ, бат бэх энх тайван тогтохын баталгаа бий болно. Энэхүү энх тайвныг тогтоож өгөхийг нэр төр нь цэвэр ариун, ямар нэгэн толбогүй хүмүүст хандаж хүссэнээр тогтчихгүй, учир нь "алдаа дутагдал ихтэй болохоороо эргэлзээ тээнэгэлзээ төрүүлсэн хүмүүсээс ч ямар нэгэн юм сурч болно гэдгийг мартаж болохгүй" [206] гэдэг нь ихээхэн

учиртай билээ. Нийгмийн шаардлагыг үл тоосноор, эсхүл тогтворгүй байдлыг хүчээр дарснаар энх амгалан байдал бат бэх тогтохгүй. Учир нь энх амгалан байдал бол “цаасан дээр бичсэн зөвшилцөл, эсхүл санаа сэтгэл нь амарсан цөөнхөд зориулсан түр хугацааны намжмал байдал” [207] биш билээ. Чухам юу их чухал вэ? гэвэл уулзаж учрахын үйл явцыг өрнүүлэх, өөр өөр ялгааг хүлээн зөвшөөрч чадах тийм хүмүүсийг бүтээх үйл явцыг өрнүүлэх гэж хэлж болно. Хүүхдүүддээ бусадтай ярихын хүчирхэг зэвсгийг атгуулъя! Ярихын соёлын сайн тэмцлийг яаж амжилттай өрнүүлэхийг тэдэнд зааж сургая!

*Бусдыг хүлээн зөвшөөрөхийн баяр баясгалан*

218. Энэ бүхэн бусад хүмүүс өөрийнхөөрөө байх, бусдаас өөр байх эрхтэйг хүлээн зөвшөөрөх чадвартай болохыг уриалж байна. Ингэж бусдыгаа хүлээн зөвшөөрөх чадвар нь соёл болж тогтсоноор нийгмийн гэрээ байгуулах боломжийг бүрдүүлнэ. Ингээгүй цагт бусдыг нийгэмд ач холбогдолгүй, хамаарал байхгүй, үнэ цэн байхгүй этгээд мэтээр ойлгуулдаг, нүдэнд ил тод харагдахгүй ч олон муу арга байна. Тухайлбал, нүдэнд ил хүчирхийллийн зарим хэлбэрийг эсэргүүцэн үгүйсгэж болох ч ил харагддагүй ихээхэн хор хөнөөлтэй хүчирхийллийн хэлбэр тогтох аюултай байдаг. Энэ бол өөр хүмүүсийг жигших, ялангуяа тэдгээр хүмүүсийн хүсэл ямар нэгэн байдлаар өөрсдийнх нь хувийн ашиг сонирхолтой зөрчилдвөл тэднийг бүр хүчтэй жигшихийн хүчирхийлэл билээ.

219. Нийгмийн нэг хэсэг нь ядуучууд гэж огт байхгүй байгаа юм шиг аяглаж дэлхий ертөнцийн хайрлаж байгаа бүхнийг зөвхөн өөрсдөө эдэлж хэрэглээд байх юм бол ингэснээс

ямар нэгэн үр дагавар заавал гарна. Бусад хүмүүс оршиж байгаа, тэд бас эрхтэй гэдгийг үл тоомсорловол эрт, орой хэзээ нэгэн цагт, ихэнх тохиолдолд огт санаандгүй байж байтал хүчирхийллийн хэлбэртэй тэсрэлт болно. Хүн бүрт хамаатай хэмээн үзэж хэрэгжүүлэхгүй бол эрх чөлөө, тэгш эрх, ахан дүүгийн харилцаа холбоо хэмээх нь хий хоосон санаанууд болж хувирна. Зөвхөн эдийн засаг, улс төр, шинжлэх ухааны эрх мэдэлтнүүдийн хооронд уулзаж учрах нь хангалтгүй билээ. Жинхэнэ нийгмийн хүрээнд уулзаж учрах гэдэг нь хүн амын ихэнхийн дээдэлдэг соёлыг оролцуулсан яриа хөөрөө өрнүүлэхийг уриалан дуудна гэсэн үг юм. Сайн санаа бодол байж болох боловч нийгмийн ядуу хэсэг нь тэдгээрийг харийн шинжтэй, өөрийн гэж санагдахгүй соёлын дүр төрхтэй гэж үзвэл яасан ч хүлээн авахгүй билээ. Бодитой бөгөөд бусдыг бүгдийг нь хамарсан нийгмийн гэрээ бас "соёлын гэрээ" байх ёстой юм. Ийм гэрээ ертөнцийг үзэх өөр өөр үзэл, өөр өөр соёл, өөр өөр амьдралын хэв маяг нийгэмд зэрэгцэн оршиж болно гэдгийг хүндэтгэн хүлээн зөвшөөрдөг билээ.

220. Уугуул иргэд хөгжил дэвшлийг үгүйсгэдэггүй, гэхдээ тэд хөгжил дэвшил гэж чухам юу вэ? гэдгийн талаар өөр төсөөлөлтэй байдаг. Тэдний төсөөлөл хөгжингүй ард түмнүүдийн орчин үеийн соёлыг бодвол илүү хүмүүнлэг шинж чанартай. Тэдний соёл бол эрх мэдэлтнүүдэд ашигтай, зөвхөн өөрсөддөө зориулж газар дээр диваажин барьж бүтээхийг зорьсон соёл биш юм. Уугуул үндэстнүүдийн соёлыг үл тэвчих, үл хүндэтгэх нь тэднийг хүйтэн цэвдэг сэтгэлийн нүдээр, тэднийг өөлсөн, шүүмжилсэн нүдээр харахад үндэслэн суурилсан хүчирхийллийн нэгэн хэлбэр мөн билээ. Хэрэв уугуул

үндэстнүүд, ялангуяа ядуучуудын янз бүрийн соёлоос эхлэхгүй бол жинхэнэ, гүн гүнзгий, урт удаан хугацаанд үр нөлөөтэй байх өөрчлөлт хийгдэхгүй. Соёлын гэрээ тухайн газар нутгийн өвөрмөц дүр төрхийн талаар ядуухан ойлголттой байхаас аль болохоор зайлсхийдэг. Соёлын гэрээ араасаа бүгдэд хөгжин дэвших, нийгмийн нягтралд орох боломж бололцоог олгох замаар олон шинж чанарыг хүндэтгэн зөвшөөрөх үйл явцыг дагуулна.

221. Энэ гэрээ нийтийн сайн сайхны төлөө зарим зүйлээс зоригтой татгалзах хэрэгтэйг ухаарахыг шаарддаг. Хэнбугай ч бүтэн үнэнийг өмчлөх, эсхүл өөрийн хүсэл шунал болгоныг гүйцэлдүүлэх боломжгүй билээ. Ийм тэмүүлэлтэй байх юм бол бусдын эрхийг үгүйсгэж тэднийг огт байхгүй юм шиг тооцох шаардлагатай болох бөгөөд энэ нь хэзээ ч бүтэшгүй гэдэг нь ойлгомжтой. Дүр эсгэсэн хүлээцтэй байдал өөр өөрийн зарчмуудад үнэнч байхын зэрэгцээ бусдууд өөрсөдтэй нь адил тийм байх эрхтэйг хүлээн зөвшөөрдөг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын бодитой яриа өрнөхөд саад бэрхшээл учруулалгүй зам тавьж өгөх хэрэгтэй. Ийнхүү бусдыгаа чин сэтгэлээсээ хүлээн зөвшөөрөх нь гагцхүү хайрын сэтгэл байгаа цагт бүтнэ. Та бид өөрсдийгөө бусдын байранд тавьж, ингэснээр тэдний жинхэнэ, үгүйдээ гэхэд ойлгож болох зорилго, санаа бодол юунд байгааг ухан мэдэж болно.

## САЙХАН СЭТГЭЛИЙГ СЭРГЭЭХ НЬ

222. Хэрэглэхийн дон туссан хувиа хичээхийн үзэл ихээхэн шударга бус байдлыг бий болгосон. Бусад хүмүүс бол бидний амар амгалан оршиход саад бэрхшээл учруулж

байгаа этгээдүүд юм гэсэн үзэл тогтсон. Бид бусад хүмүүсийг амьдралын замд таарсан саад бэрхшээлүүд мөн хэмээн тооцож, тэдэнд улам бүр түрэмгий ааш араншин гаргадаг болсон. Ийм байдал хямрал, сүйрэл, хүнд хэцүү саад бэрхшээл учирсан цагт улам бүр өсөн нэмэгдэнэ. Ийм үед бид "хүн бүр амиа бодох" гэсэн хоцрогдсон үгийг санаж, тэр зарчмыг баримтлах нь зөв юм шиг санагддаг. Гэхдээ ийм хүнд хэцүү цаг үед ч бид сайхан сэтгэлийг өдөөн бий болгож болдог билээ. Ингэж чадсан тэр хүмүүс хав харанхуйд гэрэлтэх одод болно.

223. Гэгээн Паул сайхан сэтгэлийг Ариун Сүнсийн үр жимс мөн хэмээн тодорхойлдог билээ (*Галат* 5:22). Тэрээр ийнхүү тодорхойлохдоо chrestytes (*крестотес*) хэмээх грек үгийг хэрэглэдэг. Энэ үг аядуу зөөлөн, тааламжтай, дэмжлэг үзүүлэх зэрэг утга санааг илэрхийлнэ. Энэ үг бүдүүлэг, эсхүл хараах гэсэн утга санааг илэрхийлэхгүй. Энэхүү шинж чанарыг эзэмшсэн хувь хүн бусад хүмүүст амьдралын ачааг дааж болохоор санагдуулна, тэр тусмаа ийм шинж чанарыг эзэмшсэн хүн бусдын тулгамдсан асуудлууд, хэрэгцээ шаардлага, айдас хүйдсийг бүгдийг нь тэдэнтэй хуваалцдаг учир цаадуулынх нь амьдралын ачаа хөнгөрнө. Бусадтай ингэж харьцах нь янз бүрийн хэлбэрээр илэрч болно: тухайлбал сайхан сэтгэлийн илэрхийлэл болсон үйл бүтээх, бусдыг үгээр, эсхүл үйлдлээр гомдоочихгүй байх гэсэн сэтгэлтэй байх, хүмүүсийн ачааг хөнгөлж өгөхөд хэзээ ямагт бэлэн байх зэрэг хэлбэр байдаг. Түүнчлэн "тайвшруулах, эрч хүчтэй болгох, тайтгаруулах, зоригжуулах үг хэлэх", "хүнийг илэрхий доош нь хийхгүй байх, уйтгар гунигт автуулахгүй байх, уур уцаарыг нь хүргэхгүй байх, бусдыг жигшин сэжиглэхгүй байх" [208] хэлбэрээр илэрнэ.

224. Сайхан сэтгэл та биднийг зарим үед хүмүүсийн хоорондын харилцааг хордуулдаг зэрлэг догшин байдал, бусдын төлөө бодох сэхээгүй болгодог сэтгэл санааны түгшүүрт байдал, бусад хүмүүс мөн адил аз жаргалтай байх эрхтэй гэдгийг марттал биднийг цаг завгүй болгодог ийш тийш үсчсэн байдал зэргээс ангижруулан чөлөөлдөг билээ. Өнөөдөр та бид байрандаа тогтож эргэн тойрноо харах, бусад хүмүүст сайхан сэтгэлээр хандах, "уучлаарай", "өршөөгөөрэй", "баярлалаа" гэж хэлэх цаг завгүй, эрч хүчгүй болсон байх нь олонтаа тохиолдоно. Гэхдээ үе үе нэгэн ид шидийн ачаар гэнэт сайхан сэтгэлтэй хүн бий болж, нийтийг хамарсан юунд ч үл сонирхох байдал тогтсон нөхцөлд хамаг ажлаа хажуу тийш нь тавьж, бусдын төлөө анхаарал хандуулах, бусдад инээмсэглэл бэлэглэх, бусдад хандан зоригжуулсан үг хэлэх, бусдыг анхааралтай сонсох хүсэлтэйгээ үзүүлж харуулдаг билээ. Хэрэв та бид өдөр бүр чухамхүү ингэж байх аваас үл ойлголцлыг зохицуулах, зөрчлийг арилгах эрүүл саруул нийгмийн уур амьсгалыг бүрдүүлж чадна. Сайхан сэтгэлийг бойжуулан ургуулах хэрэгтэй. Энэ бол өнгөцхөн, хөрөнгөтний бахархал огт биш билээ. Сайхан сэтгэл бусдыг хүндэтгэх сэтгэлийг араасаа дагуулдаг учир нэгэнт сайхан сэтгэл тухайн нийгмийн дотор соёл болон төлөвшиж тогтвол амьдралын хэв маяг, хүмүүсийн хоорондын харилцаа, үзэл санааг хэлэлцэх, хооронд нь харьцуулах аргыг бүгдийг нь үндсээр нь өөрчилнө. Сайхан сэтгэл зөвшилцлийг хүсэх эрмэлзлийг төрүүлэн зохицуулна; дайсагнал, зөрчил аливаа гүүрийг шатаан нураадаг бол сайхан сэтгэл шинэ шинэ замыг нээнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

# ШИНЭЭР СЭРГЭЭСЭН УЧРАЛЫН ЗАМ МӨР

225. Дэлхийн олон хэсэгт шарх сорвийг илааршуулах энх тайвны зам мөрийг тавих шаардлага байна. Энх тайвныг тогтоогчид буюу аливаа шарх сорвийг эмчлэх, шинэ шинэ учралыг санаачлахын тулд зоригтой, бүтээлчээр ажиллах чадвартай эрэгтэй, эмэгтэй хүмүүс хэрэгтэй байна.

## ҮНЭНИЙГ БАРИМТЛАН ШИНЭЭР ЭХЛЭХ

226. Шинээр учрах гэдэг нь зөрчил бий болохоос өмнө байсан тэр байдалдаа буцаж очихын нэр биш билээ. Та бид бүгд цаг хугацаа улиран өнгөрөхөд өөрчлөгддөг. Өвчин зовлон, зөрчил маргаан та биднийг өөрчилдөг. Одоо та бид бодит байдлыг нуудаг хоосон дипломат арга, санаа бодлоо бусдаас нуух, давхар утга санаатай үг хэлэх, нуугдмал зорилго агуулах, бусдыг хуурахын тулд соёлч боловсон загнах зэргийг үргэлжлүүлсэн хэвээр байх нь утгагүй. Саяхан хүртэл эвлэршгүй дайснууд байсан хүмүүс бүх үнэн, цэвэр үнэнийг хэлж эхлэх хэрэгтэй байна. Хүмүүс яаж өмнөх алдаанаасаа сургамж авах чадвартай гэмших ой санамжийг хөгжүүлэх талаар суралцах шаардлагатай байна. Ийм ой санамж өөрийн харамсал, шийдэгдээгүй асуудлууд, бүтээгүй төлөвлөгөөнүүдээр ирээдүйг эс сүүдэртүүлэн бүрхэгдүүлэхийн тулд өнгөрснийг бүрэн

бүтнээр нь хүлээн зөвшөөрөх чадвартай байх хэрэгтэй. Гагцхүү өөрсдөө үйл явдлуудын түүхэн үнэнд тулгуурлаж чадвал хүмүүс нэг нэгнийгээ ойлгохын тулд өргөн цар хүрээтэй, тууштай оролдлого хийж чадах бөгөөд улмаар бүх нийтийн сайн сайхны төлөө харилцан шүтэлцсэн шинэ цогц тогтолцоо *(синтез)*-г бий болгоно. Аливаа "энх тайвны үйл явц хүлээсэн үүрэгтээ тууштай хандахыг шаарддаг. Энэ нь үнэн болон шударга ёсыг эрж хайх, хохирч хэлмэгдсэн хүмүүсийн дурсгалыг хүндэтгэх, өшөө хонзон авах хүслээс илүү хүчтэй хамтын итгэл найдварт хүрэх зам мөрийг эрж хайхын төлөө тууштай зүтгэнэ" [209] гэсэн үг юм. Конгогийн Тэргүүн хамба нар дахин дахин давтагдан гараад байгаа зөрчил мөргөлдөөний тухай: "Цаасан дээр энх тайвны гэрээ байгуулах нь хангалтгүй. Бид илүү хол алхах хэрэгтэй. Ингэхдээ энэхүү дахин давтагдаад байгаа зөрчлийн үүссэн учир шалтгааны талаар үнэнийг тогтоохыг хүсэж байгаа тэр шаардлагыг хүндэтгэх ёстой. Хүмүүс чухам юу болсныг мэдэх эрхтэй" [210] гэж айлдсан байна.

227. "Үнэн хэрэгтээ үнэн бол шударга ёс болон өршөөнгүй сэтгэлийн салшгүй дагуул мөн билээ. Энэ гурав энх тайвныг бүтээхэд гурвуулаа чухал ач холбогдолтой. Мөн түүнчлэн аль нэг нь байснаараа бусад хоёрыг гажуудуулах үйл явцаас урьдчилан сэргийлдэг... Үнэн өшөө хонзон өвөрлөдөггүй, харин эвлэрэл, уучлалыг дагуулдаг. Үнэн уй гашууд автсан гэр бүлийнхэнд нь ойр дотны хүмүүстэй нь юу учирсныг хэлнэ. Харгис хэрцгий, зэрлэг балмад хүмүүсийн олзлон барьцаалсан хүүхдүүдтэй юу тохиолдсоныг үнэн нэгд нэгэнгүй дэлгэнэ. Үнэн бол хүчирхийлэл, дээрэнгүй үйлдлийн золиос болсон эмэгтэйчүүдийн өвчин зовлонг илчлэнэ... Хүмүүний

эсрэг үйлдсэн аливаа хүчирхийлэлийн үйлдэл бүр хүн төрөлхтний бие махбодод учруулсан шарх сорви мөн билээ. Хүчирхийллийн улмаас алдагдсан амь нас болгон хүмүүс биднийг сулруулж байдаг юм... Хүчирхийлэл араасаа хүчирхийллийг дагуулна, үзэн ядах сэтгэл араасаа үзэн ядалтыг дагуулна, үхэл хагацал араасаа үхэл хагацлыг дагуулна. Та бид энэхүү зугтан гарах боломжгүй тойргийг таслах шаардлагатай" [211].

## ЭНХ ТАЙВНЫ УРЛАГ БОЛОН УРАН БАРИЛГА

228. Энх тайвны зам мөрөөр замнана гэдэг нь нийгмийг нэг хэв шинжийн уйтгартай болгоно гэсэн үг бишээ. Харин хүн бүрт ач тустай зорилгод хүрэхийн тулд хүмүүс хамтран ажиллах, нэг нэгэнтэйгээ мөр зэрэгцэн зүтгэх гэсэн үг юм. Өргөн хүрээтэй бодитой саналууд, янз бүрийн туршлагууд хамтын зорилгод хүрэх, нийтийн сайн сайхны үйл хэргийг бүтээхэд тус дэмжлэг болох учиртай. Тухайн нийгмийн тулгамдсан асуудлуудыг тодорхой тогтоох хэрэгтэй, ингэснээр тэдгээрийг ойлгох, шийдвэрлэх олон олон арга замыг олж болно. Нийгмийн эв нэгдэлд хүрэх зам мөр бусад хүмүүс алдсан ч, зохисгүй зүйл хийсэн ч эрх зүйн хувьд өөрсдийн өнцгөөс харах эрхтэй, нийтийн үйл хэрэгт өчүүхэн ч гэсэн хувь нэмэр оруулах боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрөх сайн үр дагаврыг ямагт дагуулдаг билээ. "Та бид бусдыг хэлснээр нь, эсхүл хийснээр нь явцуу ойлгож болохгүй, харин тэдний төлөөлж байгаа сайн үйл хэргийн амлалтыг үнэлэх ёстой юм" [212]. Энэхүү амлалт ямагт шинэ найдварын оч болно гэдэгт итгэх хэрэгтэй.

229. Өмнөд Африкийн тэргүүн хамба нар жинхэнэ эвлэрэлд санаачилгатай байснаар хүрнэ гэдгийг онцлон тэмдэглэсэн

байдаг. Тэд: “бусдыг захиран дарангуйлахын тулд биш харин тэдэнд үйлчлэх зарчимд суурилсан нийгэм, шинэ нийгмийг цогцлоон бүтээснээр, хувиа хичээж өөр рүүгээ татан хамж баяжихын төлөө биш харин хүн бүр өөрт байгаагаа бусадтайгаа хуваалцах зарчимд тулгуурласан нийгмийг бүтээснээр, нэг гэр бүл, нэг үндэстэн, нэг өнгийн арьстай хүмүүс, нэг соёлтой хүмүүс хэмээн явцууралгүйгээр хүмүүн болж төрсний хувьд бүгдээрээ хамттай байх нь ихээхэн чухал гэдгийг үнэлдэг нийгмийг бүтээснээр” [213] жинхэнэ эвлэрлийг тогтооно гэжээ. Өмнөд Солонгосын тэргүүн хамба нарын тэмдэглэснээр: “гагцхүү яриа хөөрөө өрнүүлэх, эвлэрлийг байгуулах, харилцан хөгжих замаар шударга ёсыг бат бэх тогтоохын төлөө зүтгэн тэмүүлснээр” [214] жинхэнэ энх тайванд хүрэх билээ.

230. Өөрсдийн өвөрмөц дүр төрхийг гээлгүйгээр ялгарал хуваагдлаа даван туулахын төлөө хичээх нь хүн бүр бусадтайгаа хамааралтай гэсэн суурь үзэл байдгийг илэрхийлнэ. Нээрээн “хүн бүр, хэсэг хүмүүсийн аль аль нь тухайн нийгмийг гэр орондоо байгаа мэт сайхан сэтгэгдэлтэйгээр хүлээн авч байгаа бол тэр нийгэм хожно. Тухайлбал нэгэн гэр бүлд өвөө эмээ, эцэг эх, хүүхдүүд бүгд хамт, хэн ч тэдний хэнийг нь ч ад үздэггүй шүү дээ. Хэрэв хэн нэг нь асуудалтай, зүгээр биш бүр хүнд асуудалтай тулгарлавал, тэр битгий хэл тухайн хүн өөрийн алдаанаас болж тийм хэцүү асуудалтай тулгарлавал гэр бүлийн гишүүд бүгд түүнд тусалдаг. Учир нь тэд тухайн хүний тулгамдсан асуудал бол мөн адил тэдний асуудал мөн хэмээн хүлээн авдаг билээ... Гэр бүлд гэр бүлийн гишүүн бүр тухайн гэр бүлийн хамтын зорилгод хүрэхийн тулд өөр өөрийн хувь нэмрийг оруулдаг. Гэр бүлийн гишүүн

бүр бусдынхаа нийтийн сайн сайхны төлөө хичээл зүтгэл гаргадаг, ингэхдээ нэг нэгнийхээ өвөрмөц дүр төрхийг үгүйсгэдэггүй, харин ч дэмждэг, зоригжуулдаг юм. Гэр бүлийн гишүүд зарим тохиолдолд хоорондоо ам мурийна, гэхдээ тэд нэг гэр бүлийн нарийн нандин холбоосоор холбогдсон байдаг тул тэдний хоорондын харилцаа эвдрэн өөрчлөгддөггүй. Гэр бүлийн доторх маргаан ямагт ямар нэгэн байдлаар шийдвэрлэгддэг. Тухайн гэр бүлийн гишүүний баяр баясгалан, уйтгар гашууг гэр бүлийн гишүүд бүгд хуваалцдаг. Чухам ийм байхыг гэр бүл байхын утга учир мөн гэж хэлдэг! Харин та бид улс төрийн өрсөлдөгчдөө, хөршүүдээ өөрийн хүүхдүүд, эсхүл хань ижилтэйгээ адилхан ойр дотно хүлээж авч чадвал юутай сайн байх вэ! Та бид дотор нь амьдарч байгаа нийгэмдээ хайртай юу? Эсхүл энэ нийгэм та бидний хувьд нэгэн хоосон юм, бидний оролцоогүй эзгүй юм, бидэнд огт хамаагүй хол хөндий юм гэж хүлээж авдаг уу" [215] ?

231. Энх тайванд хүргэх тодорхой зам мөрийг олж хэлбэржүүлэхийн тулд хэлэлцээ хийх шаардагатай. Урт удаан хугацаанд энх тайвныг бат бэх тогтоох өөрчлөлтийг авчрах үйл явцыг чухамхүү бүгдийн оролцоотойгоор өрнүүлнэ. Ингэхийн тулд хүн бүр өдөр бүр яаж амьдарч, амьдралын ямар хэв маягтай байгаагаараа зүйрлэвэл талхны хөрөнгөлүгээ адил сайн сайхныг өдөөж энх тайвныг цогцлоон бүтээнэ. Ширээний ард, ажлын тасалгаандаа суугаад агуу өөрчлөлтүүдийг хийх боломжгүй. Энэ нь "түүхийн шинэ хуудсыг бичих, итгэл найдвар, энх тайван, эвлэрлийг илэрхийлсэн шинэ хуудсыг бичихэд чиглэгдсэн нэгэн томоохон бүтээлч төслийг хэрэгжүүлэхийн тулд хүн бүр өөрийн зүгээс хамгийн чухал үүрэг гүйцэтгэх ёстой" [216] гэсэн үг юм. Өөрийн эрдэм мэдлэг, хариуцаж буй

ажилдаа тулгуурлан нийгмийн янз бүрийн байгууллагууд хувь нэмрээ оруулснаар “энх тайвны уран барилга”-ыг бүтээж болно. Харин хүн бүрийн оролцоотойгоор бүтээвэл тэр нь “энх тайвны урлаг” болно. Ертөнцийн янз янзын хэсэгт өрнөсөн энх тайвныг тогтоох үйл явцуудаас “бид нэгийг ухаарав. Энэ бол энх тайвныг тогтоох зорилготой энэхүү үйл явц, өшөө хонзонг биш харин эрүүл саруул ухааныг эрхэмлэсэн үйл явц, улс төр болон хууль хоёрыг хооронд нь эв найрын холбоогоор холбосон үйл явц жирийн хүмүүсийг татан оролцуулж баймааж сая үр дүнтэй болно хэмээх ухаарал юм. Сайн сайхан зорилго дэвшүүлсэн улс төр, эдийн засгийн бүлэглэлүүд хоорондоо тохиролцсоноор, эрх зүйн бичиг баримт үйлдсэнээр, байгууллагууд хоорондын харилцааг журамласнаар бат бэх энх тайван тогтож чадахгүй... Урьд өмнө нь анхаарлын гадна хоцордог байсан салбаруудын туршлагыг та бидний явуулж байгаа энх тайвны үйл явцад татан оролцуулах нь ихээхэн тустай. Ингэснээр хамт олнууд нийтийн ой санамжийг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж чадна” [217].

232. Аливаа улс орны нийгмийн энх тайвныг тогтоох үйл явцад төгсгөл байдаггүй. Энэ бол “хүн бүрийн үүрэг оролцоог шаардсан, үндэстнийхээ эв нэгдлийг тогтоохын төлөө эцэж цуцахыг мэдэлгүй ажиллахыг уриалсан эцэс төгсгөлгүй оролдлого, хэзээ ч биеллээ хэмээн санаа сэтгэл амран тайвширч болохгүй ихээхэн чухал даалгавар мөн билээ. Энх тайвны аргаар зэрэгцэн орших нөхцөлийг бүрдүүлэхийн тулд туулах замд элдвийн саад бэрхшээл учрах, ялгаа зөрүү харагдах, янз янзын шийдвэрүүд гарах ч энэхүү эрхэм зорилго “соёлын уулзалт учрал”-ыг дэмжихийн тулд тууштай тэмцэхийг уриалж байдаг

билээ. Энэ нь аливаа улс төр, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааны төвд хамгийн дээд зэргийн эрхэм чанарыг цогцлоосон, нийтийн сайн сайхны төлөө зүтгэх учрыг ойлгон хүндэтгэсэн хүнийг тавих ёстой гэсэн үг билээ. Ийнхүү хатуу шийдсэнээр та бид сэтгэлээ өшөө хонзон өвөрлөх хүсэлд эзэмдүүлэхгүй, нэг талын ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх гэсэн ойрхон зорилгод хүрч санаа сэтгэл амрах гэж бодохгүй юм" [218]. Аль нэгэн талаас зохион байгуулсан туйлширсан жагсаал цуглаан шийдвэр олоход тус болж чадахгүй. Учир нь Колумбын Тэргүүн хамба нарын айлдсанаар "нийтийг хамарсан жагсаал цуглааны учир шалтгаан, зорилго тэр болгон тодорхой байдаггүй. Жагсаал цуглааны цаана улс төрийн тоглоомын янз бүрийн хэлбэр нуугдаж байдаг, зарим тохиолдолд жагсаал цуглаан нэг талын ашиг сонирхлыг илэрхийлж байдаг юм" [219].

*Хамгийн багаас эхлэх*

233. Нийгмийн үерхлийг тогтоохын тулд түүхийн нэгэн амаргүй үед өөр өөр байр суурь баримталсан бүлэглэлүүдийн хооронд эе эвийг тогтоохыг уриалаад зогсохгүй хамгийн гол нь нийгмийн хамгийн эмзэг, хамгийн ядарсан хэсэгтэй дахин уулзан учрахыг уриалдаг билээ. Учир нь энх тайван бол "зүгээр дайн дажингүй байх гэсэн үг биш харин илүү эрх мэдэлтэй учир илүү үүрэг хүлээж байгаа хүмүүс та бидний ах, эгч, дүү болсон хүмүүсийн эрхэм чанарыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах, сэргээн тогтоохын төлөө эцэж цуцахыг үл мэдэн тууштай зүтгэх үүрэг мөн. Ах, эгч, дүү нарынхаа эрхэм чанарыг ихэнх тохиолдолд анзаардаггүй, тоодоггүй нь та бидний хувьд гэм биш зан болсон байдаг бөгөөд харин бусдаасаа илүү

үүрэг хүлээсэн хүмүүс тэднийхээ эрхэм чанарыг сэргээн тогтоосноор өөрсдийгөө тухайн үндэстний хувь тавиланг гол хамгаалагчид мөн гэдгээ батлан нотлох юм" [220].

234. Олон тохиолдолд нийгмийн хамгийн эмзэг хэсгийнхэн шударга бус ерөнхий дүгнэлтүүдийн золиос болдог билээ. Зарим тохиолдолд ядуу зүдүү, өмч хөрөнгөгүй хүмүүс нийгмийн хэв журмыг зөрчдөг нь үнэн ч ихэнх тохиолдолд ингэсэн нь тэд нийгмийн амьдралаас шахагдан гарсны болон бусад хүмүүсийн доромжлолын урт удаан түүхийн улмаас төрсөн бүдүүлэгдүү хариу гэж үзвэл зохино. Латин Америкийн Тэргүүн хамба нар ийнхүү ажиглан тэмдэглэжээ: "та бид ахан дүүгийн харилцаатай болохын тулд хоорондоо ойртох ёстой, ингэснээр ядуучуудын баримталдаг үнэ цэнтэй зүйлсийг гүн гүнзгий ухааран ойлгоно, тэдний хууль ёсны хүсэл эрмэлзэл, итгэл үнэмшил, сүжиг бишрэлээ өөрийнхөөрөө илэрхийлэн баримталж амьдардгийг нь үнэлж чадна. Та бид ядуучуудыг сонгосноороо ядуучуудтай найз нөхдийн харилцаа тогтооно" [221].

235. Нийгмийн амар амгалан зэрэгцэн орших зарчмыг хэрэгжүүлэхийн төлөө зүтгэж байгаа хүмүүс ижил тэгш бус байдал, хүний хөгжлийг цогцоор нь тусгаагүй харалган бодлого бат бэх энх тайвныг тогтоох ямар ч боломж олгодоггүйг хэзээ ч мартаж болохгүй. Нээрээн "ижил тэгш боломж бололцоо олгоогүй нөхцөл янз бүрийн хэлбэрийн түрэмгийлэл, зөрчил мөргөлдөөн буй болох тааламжтай хөрсийг тавьдаг бөгөөд улмаар тэдгээр нь тэсэрдэг билээ. Тухайн нутгийн, эсхүл үндэсний хэмжээний, эсхүл бүр даяаршсан нийгэм өөрийн нэг хэсгийг зах хязгаарт орхин мартвал хууль хэрэгжүүлэх, эсхүл хяналтын системийг

нэвтрүүлэх ямар ч хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэхийн тулд их хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулсан ч тодорхой бус хугацаагаар тайван амгалан байдлыг бат бэх тогтоож чадахгүй” [222] юм. Хэрэв та бид болж бүтэхгүйгээ засахын тулд аливааг цоо шинээр эхлэх гэж байгаа бол юуны түрүүн хамгийн сул дорой ах, эгч, дүү нараа харж үзэхээс эхлэх ёстой.

### УУЧЛАХЫН ҮНЭ ЦЭН БӨГӨӨД УТГА УЧИР

236. Зарим хүн зөрчилдөх, мөргөлдөх, түрэмгийлэн хүчирхийлэх, нурж унах зэрэг нь нийгмийн хэвийн амьдралын нэгэн хэсэг мөн хэмээн боддог учир эвлэрлийн тухай ярих дургүй байдаг. Ямар ч хүний бүлэглэл дунд янз бүрийн хэсгүүдийн хооронд дандаа эрх мэдлийн төлөө тэмцэл байх бөгөөд тэр тэмцэл зарим үед илүү хурц ширүүн, зарим үед аядуу зөөлөн байдаг нь үнэн. Зарим хүн уучлахыг дэмжих нь бусдад илүү их орон зай тавьж өгч байна, тэднийг илүү нөлөөтэй болгож байна хэмээн боддог. Тийм учир тэд нөхцөл байдлыг бахь байдгаар нь хадгалан байлгах нь зөв гэж үздэг бөгөөд ингэхийн тулд янз янзын хэсгүүдийн хооронд хүчний тэнцвэрийг хэвээр хадгалах хүсэлтэй байдаг. Зарим хүн эвлэрлийг сул доройгоо үзүүлж байгаагийн тэмдэг мөн хэмээн үздэг бөгөөд тийм хүмүүс жинхэнэ нухацтай яриа хөөрөө өрнүүлэх чадваргүй байдаг билээ. Тэд шударга бус байдлыг анзаараагүй юм шиг царайлж, хурц асуудлыг тойрч байдаг юм. Тэд хурц асуудлыг шийдвэрлэх чадваргүй байдаг тул өнгөц хэврэг энх тайвныг сонгодог.

237. Христийн шашны хувьд уучлах болон эвлэрэх нь гол сэдэв мөн билээ. Бусад шашны хувьд ямар нэгэн байдлаар энэ асуудлууд мөн адил гол сэдэв болдог. Харин эдгээр гүн гүнзгий итгэл үнэмшлийн асуудлуудыг буруу ойлгох, эсхүл буруу тайлбарлан таниулбал хүлцэнгүй болох, идэвхгүй болох, шударга бус байдалтай эвлэрэх, тэр битгий хэл бүр бусдыг үл тэвчих, хүчирхийлэл үйлдэхэд хүргэх аюул бий.

238. Есүс хэзээ ч хүчирхийлэл, бусдыг үл тэвчихийг өчүүхэн төдий дэмжиж байгаагүй. Тэрээр бусдыг эрх мэдэлдээ оруулахын тулд хүч хэрэглэхийг ил тод буруушаадаг байсан. "Харийнхны захирагчид тэднийг ноёрхдог бөгөөд ихэс дээдэс нь тэднийг эрхшээдгийг тэд нар мэднэ. Та нарын дунд бүү ийм байг" (Матай 20:25-26). Шинэ гэрээ та бидэнд бусдыг "далан долоон удаа" (Матай 18:22) уучлахыг сургадаг, өөрийг нь уучилсан байхад өөрөө хариуд нь бусдыг уучилж чаддаггүй буян санадаггүй нэгэн зарцын тухай сургамжит түүхийг өгүүлдэг юм (харьцуул. Матай 18:23-35).

239. Та бид Шинэ гэрээний бусад эхүүдийг уншиж байхад хамгийн анхны Христийн итгэгчид тэр үеийн бөөгийн шүтлэгтэй, хээл хахуульд идэгдсэн, ер бусын гажиг юм болгонд татагдсан ертөнцөд тэсвэр тэвчээрийг үзүүлж, аливаад хүлээцтэй хандаж, бусдыг ойлгон зөвтгөхийг хичээж байсан нь харагддаг. Энэ өнцгөөс нь харж уншвал уг номын зарим хэсэг тов тодорхой байдаг. Тэдгээр хэсэгт эсэргүүцэгчдээ "соёлч боловсон зангаараа" *(2 Тимот* 2:25) өөрийн талд татаж бай гэсэн байна. Түүнчлэн "бусдын тухай муугаар битгий ярь, хэрүүл маргаанаас хол бай, бусадтай соёлч боловсон харилц, хүн бүрт

хүндэтгэлтэйгээр ханд. Учир нь та бид өөрсдөө урьд өмнө бас л ингэж төөрөгдөж байсан" (*Тит* 3:2-3) хэмээн айлдсан байдаг билээ. Апостолуудын буюу Есүс Христийн хамгийн ойр арван хоёр шавь нарын Үйлс хэсэгт хэдийгээр эрх мэдэлтнүүд Христийн шавь нарыг мөрдөн мөшгиж хавчин хэлмэгдүүлж байсан ч "жирийн ард иргэд тэднийг дэмждэг байсан" (2:47; харьцуул. *Үйлс* 4:21.33; 5:13) *хэмээн өгүүлсэн байдаг юм.*

240. Гэхдээ та бид уучлал, энх тайван, эе найрлын тухай эргэцүүлж байхдаа хүссэн хүсээгүй Христийн өөрийнх нь айлдсан аймшигт үгтэй учирдаг билээ: "Намайг газар дээр энх тайвныг авчрахаар ирсэн гэж бүү бод. Би энх тайвныг бус харин илд авчрахаар ирсэн юм. Хүүг эцгийнх нь эсрэг, охиныг эхийнх нь эсрэг, бэрийг хадам эхийнх нь эсрэг болгохын тулд Би ирсэн. Хүний дайсан нь гэр бүлийнхэн нь болно." *(Матай 10:34-36*). Эдгээр үгийг ариун номын тухайн бүлгийн утга санааны хүрээнд ухан ойлгох нь зөв юм. Энд Есүс та бид Түүнд итгэн дагахад бидний итгэл үнэмшил чин сэтгэлийнх байх ёстойг анхааруулсан байна. Тийнхүү шийдэж итгэхдээ бид шийдвэрээсээ ичихгүй байх ёстой, ямар ч саад бэрхшээл учирсан, тэр байтугай та бидний хамгийн ойр дотны, хайртай хүмүүс хүлээн зөвшөөрөхгүй байсан ч шийдвэрээсээ ухран буцахгүй байх ёстойг ойлгуулсан байна. Христийн айлдсан үг та бид зөрчил мөргөлдөөнийг өдөөхийг уриалаагүй. Харин зөрчил мөргөлдөөн гарахад тэрийг тэсэн гарахыг, бидний гэр бүлд, эсхүл нийгэмд энх тайвныг тогтоохын тулд бусдад хүндэтгэлээ илэрхийлэх, тэдэнд тал засахдаа өөрсдийн итгэл үнэмшил, чин сэтгэлээсээ урвахгүй байхыг анхааруулан сануулж байгаа юм. Гэгээн II Иохан Паул нэгэнтээ эргэцүүлэн айлдахдаа манай Шашин бол

"нийгмийн зөрчлийн хэлбэр бүрийг шууд буруушаах зорилгыг агуулдаггүй. Манай Шашин түүхийн цаг хугацаа улиран өнгөрөхөд нийгмийн янз янзын хэсгүүдийн хооронд зөрчил мөргөлдөөн гарах нь зайлшгүйг сайн ухамсарлаж байдаг бөгөөд чухамхүү ийм зөрчил мөргөлдөөн гарсан тохиолдолд Христийн шашинтай хүмүүс ямар нэгэн байр суурийг баримтлахдаа чин сэтгэлээсээ хандаж, тууштай байх ёстой хэмээн үздэг юм" [223] гэжээ.

*Хууль ёсны зөрчил мөргөлдөөн болон уучлахын тухай*

241. Өөрсдөө эрхээсээ татгалзахаас өөр аргагүй байдалд орох, хээл хахуульд баригдсан албан тушаалтнуудтай тулах, гэмт хэрэгтнүүд, эсхүл та бидний эрхэм чанарыг үгүйсгэж байгаа этгээдүүдтэй учрахдаа тэднийг бүгдийг нь уучлахыг уриалж байна гэж бодох хэрэггүй. Та бид хэнийг ч үл орхин бүгдийг хайрлах ёстой. Үүний зэрэгцээ дарангуйлагчийг хайрлана гэдэг нь түүний та биднийг дарангуйлж байгааг хүлээн зөвшөөрнө гэсэн үг биш, түүнчлэн түүний юу дуртайгаа хийж байгааг бид хүлээн зөвшөөрч байна хэмээн түүнд ойлгуулна гэсэн үг биш юм. Дарангуйлагчийг хайрлана гэдэг бол харин ч эсрэгээрээ буюу түүний бусдыг дарангуйлахыг нь болиулах арга замыг эрж хайна гэсэн үг юм. Энэ бол түүнийг урвуулан ашиглаж байгаа, түүнийг өөрийнх нь болон бусдын хүмүүнлэг шинж чанарыг устгаж буй, өөрөө яаж зөв зүйтэй дайчлан ашиглахаа мэдэхгүй байгаа тэр эрх мэдлээс нь салгана гэсэн үг юм. Уучлана гэдэг бол дарангуйлагчдад өөрсдийнхөө болон бусдын эрхэм чанарыг дэвслэхэд нь боломж олгоно, гэмт хэрэгтнүүд буруу үйлдлээ үргэлжлүүлэн хийхийг зөвшөөрнө гэсэн үг биш юм. Шударга бус явдлаас болж хохирч байгаа хүмүүс өөрийн болон гэр бүлийнхнийхээ

эрхийг хамгаалахын төлөө тууштай тэмцэх бүрэн эрхтэй билээ. Тэд Тэнгэрбурханаас өөрсдөд нь хайрын бэлэг болгон өгсөн тэр эрхэм чанараа хамгаалах үүрэгтэй гэж хэлж болно. Хэрэв гэмт хэрэгтэн надад, эсхүл миний хайртай хүнд хор хохирол учруулбал би шударга ёсны дагуу шаардлага тавьж, тэр этгээд, эсхүл өөр хэнбугай ч надад хор хохирол дахин учруулахгүй байх нөхцлийг баттай тогтоохын төлөө тууштай хөөцөлдөхийг хэн ч хориглож чадахгүй билээ. Ингэх нь шударга ёсонд бүрэн нийцэх бөгөөд уучлана гэдэг нь ийнхүү өөрийн болон бусдын эрхэм чанарыг хамгаалахыг хориглохгүйгээр барахгүй үнэн хэрэгтээ чухам тэгэхийг шаардаж байгаа юм.

242. Хамгийн гол нь уур уцаарыг улам өрдөн асаах хэрэггүй байдаг бөгөөд ингэх нь та бидний өөрсдийн болон бусад хүмүүсийн сэтгэл санааг бохирдуулах аюулыг дагуулна, эсхүл ингэснээр та бид бусдаас өшөө хонзон авах, бусдыг устгах шунал тачаалд донтоно. Хэн ч тийм замаар өөрийн сэтгэлд энх амгалан байдлыг бий болгож, эсхүл энгийн тайван амьдралаа сэргээж үл чадна. Үнэн юунд орших вэ? гэвэл "тэднийг нэг нэгэнтэй нь уулзуулан учруулж, ялгааг нь арилган нэгтгэж байдаг цорын ганц хүч нь гагцхүү өшөө хонзон, үзэн ядах сэтгэл байх юм бол тийм гэр бүл, тийм хөршүүдийн холбоо, тийм үндэстэн, тийм ард түмэнд ямар ч ирээдүй байхгүй билээ. Та бид ганцхан өшөө хонзон авахын тулд, эсхүл бусад хүмүүс бидэнтэй зэрлэг балмадаар харьцсантай нь яг адилхан тэдэнтэй харьцахын тулд, эсхүл хуулийн дагуу нэртэйгээр үнэн хэрэгтээ хариу авах зорилготойгоор өөрсдөдөө боломж гаргах гэж үгсэн хуйвалдахын тулд хоорондоо ойлголцон

нэгдэж хэрхэвч болохгүй" [224]. Ийм замаар замнаад юу ч олж долоохгүй, харин бүхнийг алдах болно.

243. Нээрээн "шударга бус явдалтай учирсны дараа түүний үлдээсэн ул мөрийг арилгах, зөрчил мөргөлдөөний дараа үлдсэн дайсагнал, үл итгэлцлийг мартах амаргүй. Гэхдээ муу үйлийг гагцхүү сайн үйлээр давна (харьцуул. *Ром* 12:21), эвлэрэл, эв нэгдэл, энх тайвныг дэмжсэн сайн чанарыг өөртөө бий болгон хөгжүүлснээр давна" [225]. Ингэснээр "зүрхэндээ сайхан сэтгэлийг бойжуулан бий болгож байгаа хүмүүс сайхан сэтгэлийг дагаад хүнд хэцүү байдал тохиолдсон ч, үл ойлголцол бий болсон ч оюун ухаан энх амгалан байна, баяр баясгалан гүн гүнзгий болно гэдгийг өөрсөддөө нээн ухаарна. Доромжлолтой учирсан ч сайхан сэтгэл сулрахгүй, харин ч өшөө хонзон авахаас татгалзсанаараа улам хүчтэй болно" [226]. Та бид бүгдээрээ "би зүрх сэтгэлдээ ах, эгч, дүүдээ хатуу шаардлага тавина, доторх шарх минь анихгүй байна, дайрч доромжилсныг нь хэзээ ч үл мартана, хорсолдоо эзэмдүүлж улам шанална гэдэг бол энэ бүхэн нь үнэн хэрэгтээ миний сэтгэлд буцалж байгаа тэмцлийн зөрчил, миний зүрхэнд ассан өчүүхэн гал мөн гэж үзэх хэрэгтэй бөгөөд түүнийг түймэр болж дэврэхээс нь өмнө унтраавал зохино" [227].

*Урагшлан зүтгэх хамгийн зөв зам мөр*

244. Зөрчил мөргөлдөөний учрыг бүрэн намжаан шийдвэрлэхийн оронд түүнийг өнгөрсөн цагт хамаатуулан нуун дарагдуулах, эсхүл ор тас мартан орхих гэж оролдвол, түүний тухай таг дуугүй байх юм бол ингэх нь үнэн хэрэгтээ буруу үйлдэл, гэмт хэргийг өөгшүүлсэн, тэр

байтугай хамт үйлдсэн хэрэг болно. Жинхэнэ эвлэрэл бол зөрчил мөргөлдөөнөөс зугтах биш, харин чухамхүү тэр зөрчил мөргөлдөөн дунд ойлголцон эвлэрэхийг хэлнэ. Яриа хөөрөө өрнүүлж, чин сэтгэлийн, нээлттэй, тэвчээртэй хэлэлцээ хийсний үр дүнд зөрчлийг найдвартай арилгаж чадна. Янз бүрийн бүлэглэлүүдийн хооронд бий болсон зөрчил нь "нэг нэгэнтэйгээ дайсагнах, нэг нэгнийгээ үзэн ядах сэтгэлд бүрмөсөн автахгүй байх аваас яваандаа шударга ёсыг тогтоох гэсэн хүсэл эрмэлзэлд тулгуурласан чин сэтгэлийн яриа хэлэлцээ болж өөрчлөгдөх билээ" [228].

245. Олон тохиолдолд би нэгэн санааг хэлсээр ирсэн билээ. Энэ бол: "аливаа нийгэмд нөхөрлөлийг бий болгоход шаардагддаг зарчим буюу эв нэгдэл нь зөрчил мөргөлдөөнөөс илүү чухал билээ... Энэ бол нэг нэгэндээ уусан холилдож нэгэн цул болох биш, эсхүл нэг нь нөгөөгөө залгин өөртөө уусгана гэсэн үг биш, харин хоёр тал илүү дээд түвшинд ойлголцон хамтрахдаа тус тусын үнэт зүйлсийг хадгалан авч үлдэх тухай билээ" [229]. Та бид бүгд нэгэн зүйлийг сайн мэднэ. Энэ бол "бид хувь хүмүүс болон хамт олны хувьд өөрсдийн явцуу эрх ашгийг давуулан харж сурвал, цаашид хамтран тууштай зүтгэснээр үр дүн гарна гэдгийг ухаарвал урьд өмнө зөрчил мөргөлдөөн, хурцадмал байдал, хэсэг бүлэг болж хуваагдах зэргээс зайлахын аргагүй гэж бодогдож байсан нөхцөл байдал засагдан өөрчлөгдөж цоо шинэ амьдралыг цогцлоон бүтээх олон талт эв нэгдэл болно" [230] хэмээх ойлголт мөн билээ.

246. Шударга бус явдал, өөрсөдтэй нь харгис хэрцгий харьцсанаас болж зовж хохирсон хүмүүсээс “нийгмийн уучлал”-ыг шаардах хэрэггүй. Эвлэрэл бол хүн бүрийн хувьд хувийн үйлдэл мөн бөгөөд хэдийгээр эвлэрэл ихээхэн чухал байсан ч хэн ч түүнийг бусдад тулган шаардах ёсгүй. Хэдийгээр хуулийн дагуу нийгэм, түүний эрх зүйн систем шийтгэхийг шаардаж байгаа ч чухамхүү хувь хүн өөрөө эрх чөлөөтэйгээр, өгөөмөр сэтгэлийн үүднээс шийтгэлийг шаардахгүй байх сонголтыг хийж болно (харьцуул. Матай 5:44-46). Нөгөө талаар шарх сорвийг хүчээр аниулахын тулд ямар нэгэн тушаал шийдвэр гаргах, эсхүл бүхнийг таг мартуулахын тулд шударга бус явдлыг нуун дарагдуулах зорилготойгоор “ерөнхийдөө эвлэрэх”-ийг зарлан тунхаглах боломжгүй юм. Хэн бусдын өмнөөс уучлах онцгой эрхтэй байх билээ? Зовж зүдэрснээ ардаа орхиж уучилж чадаж байгаа хүмүүсийг харахад сэтгэл хөдлөнө, гэхдээ тэгэж уучилж чадахгүй байгаа хүмүүсийг ойлгох нь бас хүмүүнлэг ёс мөн. Ямар ч байсан мартах нь хэзээ ч зөв хариу болохгүй.

247. Холокостыг яагаад ч мартах боломжгүй. Энэ бол “хүний үйлдсэн хамгийн муухай аймшигт нүгэл гэж юу вэ? гэдгийг харуулсан гэмт үйлдэл мөн бөгөөд хуурамч үзэл суртлууд ийм муухай нүгэл үйлдэхэд хүргэдэг билээ. Ийм аймшигт нүгэл хүн бүрийн суурь эрхэм чанарыг хүлээн зөвшөөрөөгүйгээс үүдэлтэй байдаг бөгөөд хүний суурь эрхэм чанар бол тухайн хүний яс үндэс, шашин шүтлэгийг үл харгалзан түүнийг ямар ч нөхцөлгүйгээр хүндэтгэх ёстой гэсэн зарчмыг илэрхийлж байдаг юм” [231]. Би энэхүү аймшигт нүглийн тухай бодох болгондоо

нэгэн мөргөлийг давтан хэлдэг юм: "Эзэн Тэнгэрбурхан минь, өөрийнхөө өршөөлийг бидэнд хайрла. Хүмүүн бид юу үйлдсэнээсээ, сайн муу, зөв бурууг үл ялган юу л бол юуг тахин шүтдэгээсээ, бид Таны шавраар урлаж бүтээсэн, Таны өөрийн бүлээн амьсгалаар амьдруулсан бие махбодыг өөрсдөө дорд үзэж, үй олноор нь устган хөнөөснөөсөө ичин гэмших сэтгэл төрөх хишгийг хайрла. Эзэн Тэнгэрбурхан минь, дахин хэзээ ч ийм нүгэл хийхгүй, хэзээ ч үгүй!" [232]

248. Түүнчлэн та бид Хирошима, Нагасаки хотуудад атомын бөмбөг хаясныг мартаж болохгүй. "Би зовж зүдэрч хохирсон бүх хүмүүст мөргөе. Эхний үхлийн хоромыг тэсч үлдсэн ч дараа нь олон жилийн турш махан биеийнхээ эдгэшгүй шарх сорвиноосоо болж тэсэхүйеэ бэрх өвчин зовлон дунд амьдарсан, өөрсдийнх нь амьдралын эрч хүчийг шавхан хатаасан үхлийн үрийг сэтгэлдээ тээж явсан тэр хүмүүсийн эрч хүч, эрхэм чанарыг хүндэтгэн мөргөе... Та бид өнөөгийн болон ирээдүйн үеийнхэн чухам юу болсны тухай ой санамжаа гээж мартахыг хүлээн зөвшөөрч болохгүй. Ийм ой санамж байснаар илүү шударга, илүү ахан дүүгийн харилцаа холбоо бүхий ирээдүйг бүтээн байгуулах боломжийг баталгаатай болгоно, хүмүүсийг зоригжуулна" [233] гэж дахин хэлж байна. Түүнчлэн та бид хэлмэгдлийг мартаж болохгүй, олон улс орнуудад боолын худалдаа хийж байсныг, яс үндсээр нь ялгаварлан гадуурхаж үй олноор нь хөнөөж байсныг, мөн хүн төрөлхтний шившиг болсон түүхэн өөр олон үйл явдлыг хэзээ ч мартаж болохгүй. Тэдгээрийг ямагт санаж байх хэрэгтэй, саяхан болсон мэтээр санаж, ой санамждаа хуучруулалгүйгээр хадгалж байх ёстой.

Та бид тэдгээр эмгэнэлт үйл явдлуудад дасан дадаж болохгүй.

249. Өнөөдөр түүхийн нэгэн хуудсыг эргүүлмээр санагдаж болох юм, энэ бүх үйл явдал эрт дээр үед болсон гэж ярьж болох юм, ирээдүй рүүгээ харъя гэж хэлж болох юм. Тэнгэрбурхан минь өршөө, үгүй, ингэж болохгүй! Та бид өнгөрснийгөө мартсанаар хэзээ ч ирээдүй рүүгээ урагшилж чадахгүй: та бид толь шиг тод үнэн, элдвийн сүүдэрт хучигдаагүй ой санамжгүйгээр хөгжин дэвшиж чадахгүй. Та бид "хамтын ухамсрын галын дөлийг бөхийлгөлгүй авч явах хэрэгтэй бөгөөд ингэснээр ирээдүйн үеийнхэнд болж өнгөрсний аймшгийн гэрч болох" хэрэгтэй. Иймхүү гэрч болсноор "хохирсон хүмүүсийн ой санамжийг сэргээж хамгаална. Ингэснээр бусдыг дарангуйлах, устган хөнөөх хүсэл эрмэлзэл бий болох тохиолдол бүрт хүн төрөлхтний хамтын ухамсар сэргэн босч байх учиртай" [234] юм. Хувь хүмүүс, нийгмийн бүлэглэлүүд, үндэстнүүд гэх зэрэг зовж хохирсон хэн боловч аймшигт зовлонг давж туулсан учир гэсэн зөвтгөлтэйгээр хариугаа авах, эсхүл ямар нэгэн хүчирхийлэл хийхийг дэмждэг ойлголттой болж, түүндээ живэхийг хүсээгүй л юм бол өөрсдөө мөн адил өнгөрсний тухай ой санамжаа хадгалах ёстой. Иймучир би зэрлэг балмад үйлдлийн тухай санаж байхын талаар бодохоос гадна ийм хүнлэг бус хүчирхийлэл, хээл хахуулийн аюул заналтай учрахдаа эрхэм чанараа хадгалан авч үлдсэн, их, бага ямар нэгэн үйлдлээрээ эв нэгдлийг эрхэмлэн сонгосон, уучлах, ахан дүүгийн харилцаа холбоо тогтоохын талд баттай зогсож чадсан тэр хүмүүсийн тухай боддог билээ. Сайн юм, сайн үйлдлийг санаж байх нь яахын аргагүй эрүүл зүйл мөн.

*Уучилна, харин мартахгүй*

250. Уучлах нь мартахын нэр биш. Үгүйсгэх, харьцангуй хэмээн үзэх, эсхүл нуун дарагдуулах боломжгүй тийм бодит байдалтай тулгарсан ч уучлал байж болно. Тэвчиж үл болох, үндэслэж, эсхүл зөвтгөж болохгүй нөхцөлтэй тулгарсан ч уучилж болно. Яагаад ч мартаж болохгүй юмыг хүртэл уучилж болно. Ямар нэгэн дарамт шахалтад оролгүйгээр, чин зүрхнээсээ уучлах нь эрхэм чанарын үйлдэл мөн. Ингэх нь Тэнгэрбурханы уучлах зах хязгааргүй өгөөмөр сэтгэл, чадварын тусгал мөн билээ. Хариу нэхээгүй уучлал байдаг тул түүнийг нүглээ наманчлахыг эсэргүүцэж байгаа, уучлахыг гуйх чадваргүй тийм этгээдэд хүртэл үзүүлж болно.

251. Үнэнээсээ уучилж байгаа хүмүүс хэзээ ч мартдаггүй. Тэд өөрсдөд нь их зовлон учруулсан тэр сүйрлийн хүчинд бууж өгөхгүй гэсэн эр зоригийн сонголтыг хийж байгаа юм. Тийм хүмүүс нүглийн тойргийг тас цохиж байгаа юм. Тэд сүйрлийн хүчин урагш ахихыг зогсоож байгаа юм. Тэд хэзээ нэгэн цагт эргэн ирж ихээхэн зовлон зүдүүр учруулах өшөө хонзон авахын шунал тачаалыг нийгэмд тараахгүй байх нь зөв гэсэн сонголтыг хийж байна. Өшөө хонзон хохирогсдыг хэзээ ч тайвшруулж чадахгүй. Зарим гэмт хэрэг үнэхээр аймшигтай, үнэхээр зэрлэг балмад байдаг учир тэдгээрийг үйлдсэн этгээдүүдийг яаж ч шийтгэлээ гэсэн учирсан хор хохирлыг нөхөх боломжгүй байдаг. Гэмт хэрэгтний амийг егүүтгэсэн ч цайрахгүй нүгэл байдаг, хэлмэгдсэн хүний амссан зовлонгийн хэмжээнд яг таарч тохирсон ямар ч хэлбэрийн шийтгэл байхгүй тийм нүгэл байдаг. Тийм учир өшөө хонзон авах нь юуг ч шийдвэрлэж, тайвшруулж чадахгүй билээ.

252. Гэхдээ энэ бүхэн нь аливаа шийтгэлээс зайлан зугтаж болно гэсэн үг биш юм. Шударга ёсыг эрхэмлэсэн учир шударга ёсыг тогтоохын төлөө хөөцөлдөх шаардлагатай. Шударга бус явдлын улмаас хохирсон хүмүүсийг хүндэтгэж байгаа учир, шинэ гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд, нийтийн сайн сайхныг хамгаалахын төлөө шударга ёсыг тогтоох гэж хүчин чармайлт гаргадаг билээ. Хувийн уур уцаарын утааг гаргахын тулд шударга ёсыг тогтоохын төлөө хөөцөлддөггүй юм. Өшөө хонзонгийн эргүүлэгт унахгүй байя гэвэл, эсхүл мартахын шударга бус явдалд живэхгүй байя гэвэл уучлах нь хамгийн зөв үйлдэл мөн.

253. Хоёр талын хоёулангаас нөгөө талтайгаа шударга бусаар харьцсан байвал аль аль талынх нь нөгөө талдаа учруулсан хор хохирол адилхан байсан уу, эсхүл харьцуулах боломжтой юу? гэдгийг тогтоох нь ихээхэн чухал билээ. Аль нэгэн улс орны төр засаг бүхий л бүтцийн байгууллагууд, өөрт байгаа бүхий л хүчийг дайчлан үйлдсэн хүчирхийллийг тодорхой хэсэг бүлэг хүмүүсийн үйлдсэн хүчирхийлэлтэй харьцуулахын аргагүй билээ. Гэхдээ ямар ч байсан хор хохирол амссан хоёр талын ганцхан нэг талынх нь амссан хор хохирлыг онцлон дөвийлгөх хэрэггүй. Хорватийн Тэргүүн хамба нарын айлдсанаар: "та бид гэмгүй хэлмэгдсэн хүн бүрт ижил тэгш хүндэтгэл үзүүлэх хэрэгтэй. Ийм нөхцөлд арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн намын харьяалал зэрэгт тулгуурласан ялгаварлан гадуурхах үзэл огт байж болохгүй" [235].

254. Би Тэнгэрбурханаас ингэж гуйсан: "ах, эгч, дүү нартайгаа учран уулзахад бэлдэж бидний зүрх сэтгэлийг хөглөж өгөөч. Ингэснээр бид улс төрийн үзэл бодол, хэл, соёл,

шашинд суурилсан ялгаануудыг даван гарч чадна. Бидний алдаа дутагдал, үл ойлголцол, хэрүүл маргаанаас үүдэлтэй шударга бус үйлдлийн шарх сорвийг эдгэрүүлж чадах их нигүүлсэнгүй сэтгэлийн шидэт тосоороо бидний бүхий л бие сэтгэлийг ариусгаж өгөхийг Тэнгэрбурханаас хамтдаа залбиран гуйцгаая. Бидний энх тайвны эрэл хайгуулын ихээхэн бэрхшээлтэй, бас сургамжтай зам мөрөөр эгэл даруухан байдлаар замнахыг дэмжин хишиг юугаан хайрлахыг Тэнгэрбурханаас хамтдаа гуйцгаая" [236].

## ДАЙН БАЙЛДААН БА ЦААЗЫН ЯЛ

255. Онцгой хүнд хэцүү байдалд зөв шийдвэр мэт санагдаж болох туйлширсан хоёр нөхцөл бий болдог. Гэхдээ үнэн хэрэгтээ энэ хоёр нөхцөл шийдвэрлэх ёстой асуудлуудаа шийдвэрлэж чаддаггүй бөгөөд эцэстээ үндэсний болон даяаршсан нийгмийн нарийн нандин харилцаа холбооны эд эсийг эвдэн нураах шинэ биетийг амилуулж түүнийг бодитой болгодог юм. Энэ бол дайн дажин болон цаазын ял мөн билээ.

### *Дайны шударга бус шинж чанар*

256. "Муу юм санасан хүн санаагаа нуудаг, харин энх тайвныг дэмжигч нь баяр баясгаланг илэрхийлдэг билээ" (Сургаалт Үгс 12:20). Гэхдээ дайн дажин дэгдээх замаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ гэж боддог хүмүүс байдаг. Харилцаа холбоо эвдэрсэн, бусдыг эрхэндээ оруулах гэж хүссэн, эрх мэдлээ урвуулж, хэтрүүлэн ашигласан, бусдаас айж эмээсэн, олон янзын байхыг саад бэрхшээл мөн гэж харсан зэргээс болж дайн дажин өдөөгддөг [237]. Дайн дажин бол өнгөрснөөс үлдсэн хий үзэгдэл биш, харин

байнга учирч байдаг аюул занал мөн. Манай ертөнц, газар дэлхий энх тайвны зам мөрөөр удаан ч гэсэн урагшилж байна, ингэсэн нь сайн үр дүн авчирч эхэлж байна. Гэхдээ энэ замаар замнахад тулгарч байгаа хүндрэл бэрхшээл улам бүр тодрон томорч байна.

257. Дайн дажин эхлэх нөхцөл дахин бүрэлдэж эхэлсэн учир би дараахийг дахин давтан хэлэхээс өөр аргагүй байдалд орж байна: “дайн бол аливаа эрхийг бүгдийг нь үгүйсгэж байгаа хэрэг мөн. Түүнчлэн байгал орчинд аймшигтай хор хөнөөл учруулдаг үйлдэл мөн билээ. Хэрэв та бид бүгдэд зориулж хүн төрөлхтний жинхэнэ цогц хөгжил дэвшил гарахыг хүсч байгаа бол ард түмнүүд болон хүмүүсийн хооронд дайн дажин дэгдэхгүй байхын төлөө борви бохиролгүй зүтгэх ёстой. Ийм учир хуулиар захирах ёсыг хэлбэрэлтгүй мөрддөг болох, хэлэлцээ явуулах, хоёр талын хооронд зуучлах, буруу зөвийг нь шударгаар тогтоохын төлөө цуцалтгүй зүтгэх шаардлагатай юм. Энэ тухай НҮБ-ын Дүрэмд тодорхой тусгасан байдаг бөгөөд энэхүү Дүрэм бол хүн төрөлхтний бүгдэд хамаатай эрх зүйн суурь хэм хэмжээ мөн билээ” [238]. Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдсанаас хойш 75 жилийн урт хугацаа өнгөрчээ. Шинэ мянган эхэлснээс хойш өнгөрсөн эхний 20 жил олон улсын хуулийн хэм хэмжээг бүрэн бүтнээр нь баримтлан хэрэгжүүлбэл үнэхээр сайн үр дүн гарна, харин тэдгээрийг баримтлахгүй бол ихээхэн хэмжээний хор хохирол учирна гэдгийг нотлон харуулсан билээ. НҮБ-ын Дүрмийг баримталж, ил тод, чин сэтгэлээр хэрэгжүүлбэл энэ нь шударга ёсыг хамгийн сайн нотлох баримт бичиг мөн бөгөөд түүнчлэн энх тайвны суваг мөн билээ. Муу муухай санаархлыг нуух, нэг улс орон, эсхүл хэсэг улс орны явцуу ашиг сонирхлыг нийтийн

сайн сайхны дээр тавихыг оролдож хэрхэвч болохгүй. Хэрэв аливаа дүрэм журам гагцхүү өөрт ашигтай нөхцөл байдалд ашиглагдах зориулалттай, харин ашиггүй нөхцөлд тэдгээрийг үл хэрэгсэж болно гэж бодвол нийгмүүд, ядуу зүдүү, эмзэг бүлгийн хүмүүс, ахан дүүгийн ёс, байгал орчин, соёлын үнэт зүйлс зэрэгт бүгдэд нь аймшигтай хор хохирол учруулж болзошгүй, удирдлагагүй их хүчийг сул тавьсантай адил болно гэж үзэх хэрэгтэй. Ингэсэн нөхцөлд нийт хүн төрөлхтний хамтын нийгэмд нөхөж баршгүй их хэмжээний хор хохирол учрах болно.

258. Дайныг бүх төрлийн хүмүүнлэгийн, батлан хамгаалахын, эсхүл урьдчилан сэргийлэхийн шалтаг шалтгаан болгож, тэр битгий хэл бүр мэдээллийг санаатайгаар мушгин гуйвуулж, түүнийгээ мөн адил шалтаг шалтгаан болгон ашиглаж амархан өдөөдөг. Өнгөрсөн жилүүдэд дайн болгоныг дэгдээхдээ дандаа өнгөн дээрээ "үндэслэлтэй" хэмээн зөвтгөж байсан. Католик Шашны Сурах Бичиг буюу Асуулт хариултын лавлагаа нь зэвсэгт хүчнийг дайчлах замаар хууль ёсны дагуу өөрийгөө хамгаалах боломж буюу "аргагүй хамгаалалт"-ын тухай айлддаг билээ. Энэ нь "ёс суртахууны эрх зүйн тодорхой бөгөөд нарийн зохицуулалт бүхий нөхцөл"-ийг [239] бас багтаадаг юм. Гэхдээ энэхүү ихээхэн гүн гүнзгий утга учир бүхий эрхийг хэт өргөн тайлбарлах эрсдэл бий. Тодруулбал ингэснээр зарим хүн "урьдчилан сэргийлэх" гэсэн тайлбартайгаар бусад руу түрэмгийлэн дайрах, эсхүл бүр дайн дажин дэгдээхийг үндэслэлгүйгээр зөвтгөх гэж оролддог билээ. Гэтэл энэхүү "урьдчилан сэргийлэх" гэсэн нэртэй түрэмгийлэл нь "урьдчилан сэргийлэх гээд байгаа тэр хор хохиролоос хавьгүй илүү хор хохирол учруулж, эвдрэл сүйрэл авчирдаг" [240] юм. Цөмийн,

химийн, биологийн зэвсгийн хөгжил, шинэ технологийн асар их хэмжээний, тэгсэн хэрнээ цаашид ч улам бүр нэмэгдэх боломжууд дайн хэмээх аймшигт үзэгдлийг гэм зэмгүй олон хүний амь насыг сүйрүүлэх хэмжээний, хэнбугай ч удирдан зохицуулах боломжгүй хүчтэй болгож байгаа нь өөрөө үлэмж том асуудал болж байна. “Урьд өмнө хүн төрөлхтөн хэзээ ч өөрөө өөрийнхөө хувь заяаг хаашаа ч эргүүлэн шийдвэрлэж болох тийм их хүчийг хуримтлуулж байгаагүй бөгөөд одоо чухамхүү энэ их хүчийг ухаалгаар ашиглаж чадах уу үгүй юу? гэдэгт ямар нэгэн баталгаа байхгүй байна” [241]. Та бид одоо дайн бол олон шийдвэрийн нэг нь юм хэмээн үздэг байсан тэр цаг өнгөрснийг ухаарах хэрэгтэй, учир нь түүний учруулж байгаа эрсдэл нь түүний авчирч магадгүй эерэг үр дүнгээс дандаа хэд дахин давсан байхаар болсон байна. Энэ бүхний үүднээс харвал “шударга дайн” хийх боломжтой эсэх тухай өнөөдөр ярилаа гэж бодоход өмнөх зуунуудад баримталдаг байсан бодитой хэмээх шалгууруудыг зөвтгөхөд нэн амаргүй юм. Дайн дажин дахин хэзээ ч гарахгүй байх болтугай! [242]

259. Үүн дээр нэмж хэлэхэд даяаршил улам бүр тэлэн нэмэгдэж байгаа нөхцөлд дэлхий ертөнцийн нэг хэсгийн хувьд тулгамдсан асуудлыг богино хугацаанд бодитойгоор шийдвэрлэж байгаа мэт санагдаж болох боловч үнэн хэрэгтээ ингэснээр харгис хэрцгий, үхэл сүйрэл дагуулсан үйл явдлуулын гинжин урвалыг өдөөж, эцэст нь бүхэл бүтэн гараг дэлхийд хор хохирол учруулах, ирээдүйн шинэ, урьд өмнөхөөс илүү муу үр дагавартай дайн дажин дэгдэх үүд хаалгыг нээх болно. Өнөөгийн ертөнцөд нэг, хоёр оронд хязгаарлагдмал дайн өрнөнө гэж бодох боломжгүй болсон байна. Харин улс орнуудын хувь заяа дэлхийн

тавцан дээр хоорондоо дэндүү нарийн нягт сүлжилдсэн байгаа тул "хэсэг хэсгээр энд тэнд өрнөж байгаа дэлхийн дайн" болж байгаа нь ойлгогдож байна.

260. Гэгээн Пап лам XXIII Иоханы айлдсанаар: "дайн дажиныг шударга ёс зөрчигдсөнийг засаж залруулахын тулд ашигладаг арга хэрэгсэл гэж үзэх нь өөрөө утгагүй болжээ" [243]. Тэрээр олон улсын байдал ихээхэн хурцадмал байсан үед энэхүү мэргэн санааг илэрхийлэхдээ Хүйтэн дайны үед буй болж, улам бүр өсөн нэмэгдэж байсан энх тайвныг тогтоохыг хүссэн хүсэл эрмэлзлийг илэрхийлж дуу хоолойгоо өргөсөн байна. Тэрээр энх тайвны төлөө дэвшүүлж байгаа аливаа үндэслэл нь онцгой эрх ашгийг нарийн тооцоолсон тооцоо, түүнчлэн зэр зэвсгийг ашиглах нь зөв хэмээн үзсэн итгэлээс хавьгүй илүү хүчтэй гэсэн итгэл үнэмшлийг дэмжиж байсан байдаг. Харамсалтай нь Хүйтэн дайн дууссаны улмаас буй болсон боломж боломцоог бүрэн дүүрэн ашиглаж чадаагүй бөгөөд энэ нь ирээдүйгээ харах хараа дутагдаж, нийтийн хувь заяаны төлөө хамтын оюун ухаанаа дайчлаагүй зэргээс үүдэлтэй гэж хэлж болно. Ингэхийн оронд талууд тус бүрийн явцуу эрх ашгийн хойноос хөөцөлдөх, нийтийн сайн сайхны төлөө хэмээхийг үл тоомсорлох байдал үзүүлэх нь хамгийн хялбар зам мөн хэмээн эндүүрдэг билээ. Ингэснээр аймшигт дайны сүнс дахин амилж шинэ орон зай эзлэх нөхцөл бүрддэг.

261. Аливаа дайн та бидний ертөнцийг дайн эхлэхээс өмнө байсан байдлаас дордуулдаг. Дайн бол улс төрийн бодлогын дампуурал, хүн төрөлхтний хувьд том уналт мөн. Дайн бол муу муухайг төлөөлсөн хүчний өмнө шившигтэйгээр бууж өгсөн үйлдэл, түүний өмнө хүлээсэн

ялагдал мөн. Бүгдээрээ эцэс төгсгөлгүй онолын маргаан мэтгэлцээнд живэх хэрэггүй, харин ингэхийн оронд дайны золиос болсон хүмүүсийн шарх сорвийг илаарьшуулахын төлөө хичээцгээе. Бүгдээрээ дайнд амь насаа алдсан, “дагалдах гарз хохирол” хэмээн тодорхойлогдсон тэр хүмүүсийг дахин нэг харцгаая. Дайны золиос болсон хүмүүсээс өөрсдөөс нь асууцгаая. Дүрвэгсэд, гэр орноо орхин нүүсэн хүмүүс, цөмийн зэвсгийн цацраг идэвхт туяанд түлэгдэж, химийн зэвсэгт өртөн хордож зовсон хүмүүс, дайнд үр хүүхдээ алдсан ээжүүд, бүх насаараа тахир дутуу болсон, хүүхэд насаа үзэж чадаагүй хөвгүүд, охидын тухай бодоцгооё. Харгислалын золиос болсон хүмүүсийн үнэн бодит түүхийг сонсоцгооё, тэдний нүдээр бодит байдлыг харцгаая, тэдний ярьж байгаа түүхийг зүрх сэтгэлээ нээн сонсоцгооё. Ингэснээр та бид дайн дажины голд аймшигт нүглийн эргүүлэг байдгийг ухааран ойлгож чадна. Та биднийг энх тайвныг сонгосны төлөө гэнэн хэмээн цоллохыг тоож ач холбогдол өгөх хэрэггүй.

262. Хэрэв та бид бусдыг айлган сүрдүүлэх, эсхүл цөмийн, химийн, биологийн зэвсгээр заналхийлэх замаар өнөөгийн тулгамдсан асуудлуудыг шийдэж болно хэмээн бодсон хэвээр байх юм бол ямар ч дүрэм, журам байгаад нэмэргүй. Нээрээн “хэрэв та бид хорин нэгдүгээр зууны олон туйл бүхий дэлхийд олон хэмжүүр бүхий энх тайван болон аюулгүй байдалд учирч байгаа гол гол аюул занал буюу алан хядах үйл ажиллагаа, тэнцвэргүй зөрчил мөргөлдөөн, кибер аюулгүй байдал, байгал орчны асуудлууд, ядуурал зэргийг анхааралтай авч үзвэл тэдгээрийг оновчтой шийдвэрлэхийн тулд цөмийн зэвсгээр далайлгаж айлган сүрдүүлэх нь ямар ч утгагүй гэдгийн талаар эргэлзэх хүн тэр бүр гарахгүй

бизээ. Цөмийн зэвсгийг ямар нэгэн байдлаар хэрэглэвэл тэгсний үр дүнд цаг хугацаа улиран өнгөрч, орон зай тэлэх тусам асар их хөнөөлтэй, урьдчилан таамаглах аргагүй, хязгаарлаж хянах боломжгүй хор уршиг учрах бөгөөд ингэснээр хүмүүнлэгийн болон байгал орчны хувьд гамшгийн хэмжээний сүйрэл гарна гэдгийг тооцон бодвол та бидний санаа сэтгэл улам ихээр зовох нь ойлгомжтой. Түүнчлэн та бид өөрсдөөсөө дараах асуултыг асуух хэрэгтэй болно: айдас хүйдсийг улам ихээр нэмэгдүүлсэн, хүмүүсийн хоорондох итгэлцэлд тулгуурласан харилцааг орвонгоор нь эргүүлж эвдсэн айдаст суурилсан тогтвортой байдал хэр удаан настай байж чадах вэ? Олон улсын энх тайван, тогтвортой байдал аюулгүй байдлын талаархи хуурамч, алдаатай төсөөлөлд, харилцан устгалцах, эсхүл бүр бүхнийг бүрмөсөн устгах заналхийлэлд, эсхүл энгийнээр хэлвэл хүчний тэнцвэрийг хадгалах зорилгод тулгуурласнаар тогтохгүй бөгөөд бэхжихгүй... Энэ үүднээс авч үзвэл цөмийн зэвсгийг нэгбүрчлэн бүрмөсөн устгах зорилго нь нэг талаас томоохон сорилт, нөгөө талаас заавал даган биелүүлэх ёстой ёс суртахууны болон хүмүүнлэгийн шинж чанартай үүрэг тушаал болж байна... Улам бүр өсөн нэмэгдэж байгаа харилцан хамаарал, даяаршил цөмийн зэвсгийн аюул заналд аливаа хариулт өгөхдөө тэр нь заавал хамтын, хоорондоо уялдаатай, харилцан итгэлцэлд суурилсан зарчимд нийцсэн байх ёстой гэдгийг нотолж байна. Энэхүү итгэлцэл хэн нэгний явцуу эрх ашиг, тусгай ашиг сонирхлыг хамгаалахад биш харин гагцхүү нийтийн сайн сайхны төлөө гэсэн бодит зорилгыг агуулсан тал талын яриа хөөрөөнд тулгуурлан босох ёстой" [244]. Зэр зэвсэг үйлдвэрлэх, бусад цэргийн зардлыг санхүүжүүлэх зорилготойгоор

зарцуулсан их хэмжээний хөрөнгө мөнгийг глобал сан байгуулахад чиглүүлцгээе [245]. Энэ сан эцсийн эцэст өлсгөлөнг бүрмөсөн арилгана, ядуу буурай улс орнуудын хөгжил дэвшлийг дэмжинэ, ингэснээр тэдгээр улс орны иргэд хүчирхийлэлд дулдуйдсан, хий хоосон дүгнэлтэд тулгуурласан болчимгүй шийдвэр гаргах гэж улайран хөөцөлдөх, эсхүл өөр газар нэр төртэй амьдрахын тулд эх орноосоо дайжин зутгахаа болих юм.

*Цаазын ял*

263. Бусдыг устгах өөр нэгэн арга бий. Энэ арга улс орнууд руу биш харин хувь хүмүүс рүү чиглэсэн байдаг. Энэ бол цаазын ял мөн билээ. Гэгээн II Иохан Паул цаазын ялыг ёс суртахууны хувьд зөвтгөхийн аргагүй бөгөөд энэ нь шударга шүүхийн хувьд мөн адил шаардлагагүй болсон хэмээн туйлын тодорхой, хатуу мэдэгдсэн байдаг [246]. Энэ байр сууринаас нэг сөөм ч ухарч болохгүй. Өнөөдөр та бид: “цаазын ялыг хэрхэвч хүлээн зөвшөөрч болохгүй” [247] хэмээн шууд хэлэх ёстой бөгөөд манай Шашин түүнийг даян дэлхийд бүрмөсөн хориглохыг уриалан дуудаж, энэ байр суурин дээрээ хатуу зогсох болно [248].

264. Шинэ гэрээнд хувь хүмүүс шударга ёс тогтоох шүүхийн үүргийг өөртөө авч болохгүй гэж айлдсан байдаг (харьцуул. *Ром* 12:17.19). Харин эрх баригчид буруу юм хийсэн хүмүүсийг шийтгэх эрхтэй байх нь зөв гэсэн байдаг (харьцуул. *Ром* 13:4; *1 Петр* 2:14). Нээрээн “зохион байгуулалтад орсон хамт олныг тойроод өрнөж байгаа нийгмийн амьдралыг хамтдаа зэрэгцэн орших дүрэм журмаар зохицуулах ёстой. Эдгээр дүрэм журмыг санаатайгаар зөрчсөн бол түүнд нь таарч тохирсон

шийтгэл оногдуулах шаардлагатай" [249]. Энэ бол хууль ёсны төр засгийн эрх баригчид "үйлдсэн гэмт хэргийн их, бага хэмжээг харгалзан тодорхой шийтгэлийг оногдуулна" [250] гэсэн зарчмыг баримталж болно, тэгэх ч ёстой гэсэн үг билээ. Энэхүү зарчмыг баримтлан хэрэгжүүлэх шүүх эрх мэдэл "хууль хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай хараат бус байдал"-аар баталгаатай хангагдсан байх ёстой байдаг [251].

265. Манай Шашин үүсэн байгуулагдсан хамгийн эхний зуунаасаа эхлээд цаазын ялыг эсэргүүцсэн байр суурийг баримталсан нь тодорхой байдаг. Тухайлбал, Лактанц (Лактанций) дараах байр суурийг баримталж байсан байна: "энэхүү зарчмаас ямар ч нөхцөлд ухарч болохгүй: ер нь хүний амь насанд халдах нь хууль бус билээ" [252]. I Николас/ (Николай) Пап: "гэм буруугүй хүмүүсээр зогсохгүй гэм буруутай хүмүүст мөн адил цаазын ял оноох явдлаас чөлөөлөх хэрэгтэй" [253] хэмээн айлдаж, энэ чиглэлээр хүчин чармайлт гаргахыг шахаж шаардаж байсан байна. Хоёр санваартны амь насанд халдсан алуурчдыг шүүх хуралдаан болж байх үед Гэгээн Августин шүүгчид хандан алуурчдын амь насанд нь халдах хэрэггүй хэмээн хүсэхдээ дараах тайлбарыг хэлсэн байна: "Бид та энэхүү нүгэлт хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэн тэдний эрх чөлөөг хязгаарлах гэж байгааг эсэргүүцэхгүй байна. Бидний цорын ганц хүсэл бол та шударга ёсыг тогтоохдоо тэдний амь насанд битгий халдаач, мөн тэдний бие махбодын аль нэгэн хэсгийг тахир дутуу битгий болгооч гэдэгт оршино. Үүний зэрэгцээ хуулийн хүрээнд шийтгэлийн арга хэмжээ авч тэдний ухаан санааг нь элий балай болгосон уур уцаарыг нь эрүүл саруул ухаантай хүний амгалан тайван байдалд

оруулах, муу муухай хэрэг хийсэн алдааг нь нийгэмд хэрэгтэй хөдөлмөр эрхлүүлэн засуулах нь зөв болно. Ийм арга хэмжээ авах нь ял шийтгэл оногдуулж байгаа явдал мөн. Гэхдээ зэрлэг балмад үйлдлийг номхотгох, үйлдсэн гэмт хэрэгтээ гэмших боломж бололцоо олгох нь гэмт хэрэгтнийг зүгээр шийтгээд орхиж байгаа хэрэг биш бөгөөд харин түүнд өөрт нь ашигтай буян хийж байна гэж үзэхээс өөр аргагүй... Гэмт хэрэгтнүүдийн үйлдсэн нүглийн учруулсан хор хохирлыг тэднээс өшөө хонзон авах хүсэл болгон хувиргаж болохгүй. Харин тэдний үйлдсэн гэмт хэрэг өөрсдийнх нь сэтгэл санаанд учруулсан шарх сорвийг эдгэрүүлэн илаарьшуулах хүсэл болгох нь зөв болно" [254].

266. Айдас хүйдэс, жигшил дургүйцэл шийтгэлийг өшөө хонзон авах, авах авахдаа харгис хатуу хэлбэрээр авах арга мөн гэж үзэх гээд байдаг. Гэтэл шийтгэл нь тухайн гэмт хэрэгтнийг эмчлэх, эргээд нийгмийн харилцаанд оруулах үйл явц мөн гэж тооцох хэрэгтэй юм. Өнөөдөр "улс төрийн зарим хүрээнийхэн, хэвлэл мэдээллийн зарим байгууллага хувь хүмүүс болон төр засгийн байгууллага харгис хатуу аргаар өшөө хонзон авах ёстой мэтээр сурталчлан өдөөн хатгадаг. Ингэхдээ тэд зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдээр зогсохгүй хууль зөрчсөн нь тогтоогдоогүй ч тэгсэн байж магадгүй хэмээн сэжиглэгдэж байгаа хүмүүсийг хүртэл хатуу шийтгэхийг шаарддаг билээ... Заримдаа санаатайгаар зохиомол дайснуудыг бий болгодог: тухайн нийгэмд аюул занал учруулж байгаа хэмээн ойлгодог, эсхүл төсөөлдөг шинж чанарыг илэрхийлсэн дүр төрхийг хүмүүст наадаг билээ. Ийм дүр төрхийг бий болгох арга нь тухайн үед арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг түгээн дэлгэрүүлэхдээ

ашиглаж байсан аргатай адил байдаг билээ” [255]. Энэ бүхнээс үзэхүл зарим улс оронд урьдчилан хорих байранд гэм зэм нь тогтоогдоогүй хүмүүсийг хорих, эсхүл шүүхийн шийдвэргүйгээр хорих, ялангуяа цаазын ял оногдуулах зэрэг үйл ажиллагаа улам бүр өргөн дэлгэр болж байгаа нь ихээхэн аюул занал учруулж байна хэмээн дүгнэхэд хүргэж байна.

267. Энд би нэгэн зүйлийг онцлон тэмдэглэж байна: “өнөөдөр төр засагт шударга бус түрэмгийллэгчийн дайралтаас бусад хүмүүсийн амь насыг хамгаалахын тулд цаазын ял оноохоос өөр хэрэглэх арга хэрэгсэл байхгүй хэмээн төсөөлөх ямар ч боломжгүй билээ”. Энэ өнцгөөс харвал хуулийн гадуур, шүүхийн гадуур хэмээх аргаар цаазын ял оноож шийтгэх нь онцгой асуудал мөн билээ. Энэ бол үнэн хэрэгтээ “зарим улс орны төр засаг, тэдгээрийн төлөөний байгууллага, хүмүүсийн санаатайгаар үйлдэж байгаа аллага мөн бөгөөд тэд энэ үйлдлээ голдуу гэмт хэрэгтнүүдтэй тэмцэж байгаа хэрэг, эсхүл хууль хэрэгжүүлэхийн тулд хүчийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд, үндэслэлтэйгээр, таарч тохируулан хэрэглэсний үр дүнд өмнө нь тооцоолохын аргагүй гарсан үр дагавар мөн хэмээн зөвтгөн тайлбарладаг” [256].

268. “Цаазын ялыг буруушаан шүүмжилсэн үндэслэл олон байдаг бөгөөд тэдгээрийг хүмүүс сайн мэддэг билээ. Манай Шашин тэдгээрийн заримд нь онцгой анхаарлаа хандуулдаг нь зөв юм. Энэ бол шүүхийн алдааны улмаас, эсхүл тоталитар, дарангуйлалын дэглэмээс улс төрийн өөр үзэл бодлыг нухчин дарах, шашны болон соёлын хувьд цөөнхийг залхаан цээрлүүлэхийн тулд, түүнчлэн тэдгээр дэглэмийн тогтоосон шударга бус хуулийн дагуу

"гэмт хэрэгтнүүд" хэмээн яллагдаж золиослогдсон бүх хүмүүст цаазын ял оногдуулахыг эсэргүүцдэг гэсэн үг билээ. Өнөөдөр Христийн шашинтнууд, сайн санааны бүх хүмүүст хандан хуулийн дагуу, эсхүл хууль бусаар гэх зэрэг аливаа хэлбэрээр цаазын ял оноохыг хориглохын төлөө тэмцэхийн зэрэгцээ эрх чөлөөг нь хязгаарласан хүмүүсийн эрхэм чанарыг хүндэтгэхийн үүднээс шоронгийн нөхцөлийг сайжруулахын төлөө хүчин чармайлт гаргахыг уриалж байна. Үүнтэй холбоотойгоор хэлэхэд бүх насаар нь шоронд хорих тухай ялыг авч үзэж түүнийг хориглох хэрэгтэй гэж бодож байна. Бүх насаар нь шоронд хорих ял бол далд хэлбэрийн цаазын ял мөн билээ" [257].

269. Та бид нэг юмыг хатуу санаж байх ёстой. Энэ бол "алуурчин хүртэл эрхэм чанартай, түүнийг нь Тэнгэрбурхан өөрөө баталж байдаг юм" [258] гэсэн ойлголт мөн билээ. Цаазын ялыг шийдвэртэйгээр эсэргүүцнэ гэдэг бол хүн бүр заяагдмал эрхэм чанартайг болон эрэгтэй, эмэгтэй аливаа хүн энэхүү ертөнцөд өөрийн гэсэн орон зайтай гэдгийг ямар хэмжээнд хүлээн зөвшөөрөх вэ? гэдгийг харуулна гэсэн үг юм. Хэрэв би хамгийн адгийн гэмт хэрэгтнүүд хүртэл тийм эрхэм чанартай гэдгийг үгүйсгэхгүй байгаа бол өөр хэнийг ч тийм эрхэм чанартай гэж үгүйсгэхгүй нь ойлгомжтой. Хэдийгээр хүмүүс хоорондоо өөр өөр гэдэг нь үнэн ч би хүн бүр энэхүү газар дэлхий дээр надтай хамт зэрэгцэн орших эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

270. Би энэхүү байр суурийг баримтлах эсэх талаар эргэлзэж байгаа Христийн шашинтнууд болон аливаа хэлбэрийн хүчирхийллийн арга хэрэглэхийг хорхойсоод байгаа хүмүүст хандан Исаиагийн номд айлдсан: "Тэд сэлмээ анжис болгоно" (2:4) гэсэн үгийг байнга санаж байхыг

анхааруулж байна. Бидний хувьд энэхүү мэргэн үг хожим Есүс Христийн үед бодитой сургаал болсон байдаг. Есүс Христ шавь нь хүч хэрэглэхийг завдаж байгааг хараад түүнд хандан ингэж хатуухан хэлсэн байна: “Наад илдээ буцаагаад хуйнд нь хий. Илд гаргаж далайсан хүн эргээд илдэндээ цавчуулна” (Матай 26:52). Энэ мэргэн үг “Би хүмүүний амьдралын үнэ цэнийг бодохыг шаардаж байна. Хүний цусыг урсгасан хүний цусыг эргээд өөр хүн урсгах болно” (*Эхлэл* 9:5-6) гэсэн эртний сэрэмжлүүлэгийг санагдуулна. Есүсийн зүрх сэтгэлийн гүнээс булгилан гарсан сургаал үг зуун зууныг холбосон гүүр болж, өнөөдөр хүртэл том томруун сонсогдсоор байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

# МАНАЙ ДЭЛХИЙД АХАН ДҮҮГИЙН ЁСЫГ ТОГТООХЫН ТӨЛӨӨХ ИХ ҮЙЛ ХЭРЭГТ ШАШНУУДЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

271. Хүн бүр Тэнгэрбурханы үр мөн хэмээн үздэг хүндэтгэлд суурилсан шашнууд ахан дүүгийн харилцаа холбоо тогтоох, нийгэмд шударга ёсыг бататган хамгаалах үйл хэрэгт чухал хувь нэмэр оруулж байгаа билээ. Янз бүрийн шашны дагагчдын дунд яриа хөөрөө өрнөх нь зүгээр дипломат харилцаа тогтоон хөгжүүлэх, нэг нэгнийгээ хүндэтгэж байгааг харуулах, нэг нэгэндээ хүлээцтэй хандаж байгааг илэрхийлэхийн тулд биш билээ. Энэтхэгийн Хамба нарын айлдсанаар: “яриа хөөрөө өрнүүлэхийн зорилго найрамдал, энх тайван, эе найрыг тогтоох, жинхэнэ үнэн, хайрын сэтгэлийн дагуу оюун ухааны болон ёс суртахууны үнэт зүйлс, туршлагаа солилцон хуваалцахад оршино” [259].

## ХАМГИЙН ГОЛ ҮНДЭС СУУРЬ

272. Бид сүсэгтнүүдийн хувьд бүгдийн Эцэг Тэнгэрбурханд бүрэн нээлттэй биш байх юм бол ахан дүүсийн ёсыг тогтоохыг уриалан дууддаг тэр дуудлага бат бэх, тогтвортой үндэслэл бүхий учир шалтгаантай байх боломжгүй билээ. Та бид “бид бүгд өнчирсөн хүмүүс биш, харин хүүхдүүд мөн билээ гэдгээ ухамсарласны ачаар нэг нэгэнтэйгээ энх тайвнаар хамт амьдарч чадна”

[260] гэдэгтээ эргэлздэггүй юм. Тэгээд ч “оюун ухаан бол хүмүүс нэг нэгэнтэйгээ ижил тэгш гэдгийг ухаарах, хүмүүс иргэдийн хувьд нэг нэгэнтэйгээ зэрэгцэн орших тогтвортой байдлыг хангах чадвар мөн билээ. Харин оюун ухаан өөрөө дангаараа ахан дүүгийн харилцааг тогтоож чадахгүй” [261].

273. Үүнтэй холбоотойгоор би нэгэн дурсамжтай мэдэгдлийг иш татахыг хүсэж байна: “Хэрэв хүн дуулгавартайяа дагаснаараа өөрийн мөн чанар бүхий дүр төрхийг бүрэн бүтнээр нь нээдэг үнэмлэхүй үнэн гэж байдаггүй гэвэл хүмүүсийн хооронд шударга харилцааг бат бэх тогтоосон зарчим баталгаатай байдаг гэж хэлэхэд хэцүү болно. Хүмүүс анги, хэсэг бүлэг, үндэстнээрээ хуваагдаж өөр өөрийн явцуу эрх ашигт хөтлөгдөж, ингэснээр тэд өөрийн эрхгүй нэг нэгнийгээ үгүйсгэн эсэргүүцэж эхэлнэ. Хэрэв хүн үнэмлэхүй үнэн байдгийг хүлээн зөвшөөрөхгүй бол аль хүчтэй нь бусдыгаа эрхшээлдээ оруулна, хүн бүр өөрт байгаа арга хэрэгслийг тултал нь ашиглаж өөрийн ашиг сонирхол, санаа бодлоо гүйцэлдүүлэн бусдад тулгах гэж зүтгэх бөгөөд бусдын эрхийг огт тооцохгүй, хүндэтгэхгүй байх билээ. Орчин үеийн дарангуйллын дэглэмийн үндэс хүн бүр үнэмлэхүй эрхэм чанартай гэдгийг үгүйсгэсэн үгүйсгэлээс урган гарна. Хүмүүн бол нүдэнд харагдахгүй Тэнгэрбурханы дүр төрхийн илэрхийлэл мөн бөгөөд тийм учир өөрийнхөө мөн чанарын хувьд салшгүй, заяагдмал эрх бүхий этгээд мөн. Түүний эдгээр эрхийг хувь хүн, хэсэг бүлэг хүмүүс, анги давхарга, үндэстэн, төр засаг гээд хэнбугай ч зөрчих ёсгүй билээ. Нийгмийн харилцаанд олонхийг бүрдүүлж байгаа этгээдүүд цөөнхийнхөө эсрэг дайрч эдгээр эрхийг нь мөн адил зөрчих ёсгүй юм” [262].

274. Янз бүрийн шашныг төлөөлсөн олон олон сүсэгтэн та бид зуун зууны турш шашин шүтсэнээрээ хуримтлуулсан туршлага, олж нээсэн мэргэн ухаан, түүнчлэн олон олон сул талаа дүгнэж, гаргасан алдаа дутагдлаа цэгнэж авсан сургамжуудаас нэгэн үнэнийг гүн гүнзгий ойлгосон билээ. Энэ бол та бид Тэнгэрбурхан байгааг гэрчлэх нь манай нийгмүүдэд ихээхэн ач холбогдолтой гэсэн үнэн билээ. Та бид Тэнгэрбурханыг чин сэтгэлээсээ эрж хайх, ингэхдээ сэтгэл зүрхээ аливаа үзэл суртал, эсхүл явцуу эрх ашгаа гүйцэлдүүлэх санаа бодлоор бохирдуулахгүй байх нь нэг нэгнийгээ алс холын замд хамт явж байгаа аянчид, жинхэнэ ах, эгч, дүү нар мөн хэмээн хүлээн зөвшөөрөхөд ихээхэн ач тустай юм. Та бид "хэрэв аливаа үзэл суртлын нэрээр Тэнгэрбурханыг нийгмийн харилцаанаас авч хаяхыг оролдвол тэр нийгэм элдвийн шүтээнийг сохроор шүтэн тэдгээрт мөргөсөөр дуусдаг бөгөөд тун удалгүй нэг мэдэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүс амьдралын зөв зам мөрөө алдаж, төөрөн будлиж, тэдний эрхэм чанар доромжлогдож, эрх, эрх чөлөө нь зөрчигдөнө. Та бүхэн оюун ухааны эрх чөлөө, шашны эрх чөлөөг үгүйсгэснээр ямар их зовлон зүдүүр учирдгийг сайн мэднэ, ингэснээр үүссэн шарх сорвитой болсон хүн төрөлхтөн, итгэл найдвараа алдсан, зам мөрийг нь заан чиглүүлэх үлгэрлэлгүй болсон хүмүүс ядууран хоосордгийг мөн адил сайн мэднэ" [263] гэдэгт эргэлзэхгүй байна.

275. Нэгэн зүйлийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энэ бол "орчин үеийн дэлхий дахины хямралын хамгийн гол учир шалтгааны нэг нь хүний оюун ухаан ямар ч мэдрэмжгүй болсон явдал мөн билээ. Ингэснээр хүний оюун ухаан шашны үнэт зүйлсээс холдон хөндийрч, хүнийг бурханчлан шүтсэн болон бүхнээс дээр орших, үнэмлэхүй

зарчмуудын оронд ахуй амьдралын материаллаг шинж чанартай баялгийг өргөмжлөн залсан материалист философиор өөрийгөө хүрээлүүлэн хамгаалуулсан хувиа хичээх үзэл ноёлох болсон" [264] билээ. Олон нийтийг хамрах ёстой мэтгэлцээнд гагцхүү эрх мэдэлтэй, эд баялагтай хүмүүс болон "экспертүүд" гэсэн чимэг тодотголтой хүмүүсийн дуу хоолой сонсогддог нь буруу юм. Зуун зууны туршлага, мэргэн ухааныг агуулсан шашны уламжлалаас төрөн гардаг эргэцүүллийг сэргээн багтаах орон зай шаардагдаж байна. Учир нь "шашны сонгодог ном судар аль ч үед таарч тохирох гүн гүнзгий утга санааг агуулж байдаг нь нэгэнтээ батлагдсан үнэн мөн билээ. Тэдгээр ном судар [шинэ гарцыг нээж, алсын харааны хаяаг тэлж, бодол санааг өдөөж, оюун ухааны цар хүрээг өргөтгөж, зүрх сэтгэлийг улам уужуу тэнүүн болгож байдаг] шавхагдашгүй их хүчийн ундарга болдог" юм. Гэтэл "рационал буюу бодитой хэмээх тодотголтой үзлийн хараалган хараа"-наас [265] болж ийм ном судрыг үл хэрэгсдэг билээ.

276. Энэ бүхний учир манай Шашин улс төрийн амьдралын автономит байдлыг хүндэтгэхийн зэрэгцээ өөрийн үүрэг зорилгоо гагцхүү хувь хүний амьдралын хүрээгээр хязгаарладаггүй билээ. Харин ч эсрэгээрээ буюу сайн сайхан ертөнцийг бүтээх их үйл хэргийн "гадна талд үлддэггүй, үлдэх ч ёсгүй" гэсэн зарчмыг баримталдаг. Түүнчлэн нийгмийг сайн сайхан болгоход хувь нэмэр оруулахын тулд "сэтгэл санаа, оюуны эрч хүчийг сэрээх" их үйл хэргийг бүтээхээс хойш суудаггүй юм [266]. Шашны хуврагууд улс төрийн намуудын үйл хэрэгт оролцож болохгүй нь зөв ч, намын ажлыг энгийн хар

хүмүүс хийдэг нь үнэн ч нийтийн сайн сайханд байнга анхаарлаа хандуулах, хүмүүний цогц хөгжилд байнга санаа зовж байхыг өөртөө агуулж байдаг амьдралын улс төрийн хэмжүүрийг [267] огт хамаагүй хэмээн орхидоггүй юм. Манай Шашин "нийтийн сайн сайхныг бүтээх үйл хэрэгт зүтгэхдээ үйл ажиллагаагаа зөвхөн буяны болон боловсролын ажлаар хязгаарладаггүй" билээ. Манай Шашин "хүн төрөлхтний хөгжил дэвшил, бүх нийтийн ахан дүүгийн харилцаа холбоог тогтоон хөгжүүлэхийн төлөө" [268] ажилладаг юм. Манай Шашин шашны бус байгууллагууд, албан тушаалтнуудтай ажлыг нь булаацалддаггүй бөгөөд харин өөрийгөө бусдын сайн сайхны төлөө зориулдгаа дараах үгээр илэрхийлдэг: "гэр бүлүүдийн дундах нэгэн гэр бүл, энэ бол манай Шашин мөн бөгөөд энэхүү Шашин өнөөгийн дэлхий ертөнцөд гэрч байхдаа нээлттэй, Тэнгэрбурханд, Тэнгэрбурханы онцгойлон хайрладаг тэр хүмүүст итгэх итгэл, найдах найдвар, хайрлах хайрын сэтгэлд ямагт нээлттэй байдаг билээ. Манай Шашин бол хаалга нь нээлттэй байшин мөн, манай Шашин сүсэгтэн олны хувьд эх нь мөн учир хаалга нь нээлттэй байшин мөн билээ" [269]. Есүсийн эх гэгээн Мариаг дагаж "бид бусдад тусалдаг, тэдэнд үйлчилдэг Шашин байхыг хүснэ. Ар гэрээ, мөргөлийн газраа, сүм хийдээ ардаа орхиод явдаг, хаана амьдрал буцалж байна тэнд дагаад очдог, итгэл найдварыг бат бэх байлгах, эв нэгдлийн бэлэг тэмдэг байх... хоёр эргийг хооронд нь холбосон гүүр байх, хана хэрмийг нураах болон эвлэрлийн үрийг цацахын төлөө цуцалтгүй урагшлан зүтгэж байдаг Шашин байхыг хүснэ" [270].

*Христийн шашинтны дүр төрх*

277. Манай Шашин Тэнгэрбурханы үйл хэрэг бусад шашнуудад ямар арга замаар явагддагийг харж, хүндэтгэж байдаг билээ. Бид "тэдгээр шашинд буй аливаа үнэн бөгөөд ариун бүхнийг үгүйсгэдэггүй юм. Манай Шашин тэдгээр шашны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг гэгээрүүлж байдаг үнэний гэрэл туяаг цацрааж байдаг ном сургаал, тэдгээрийн ухагдахуун болон амьдралын хэв маяг, дэг жаягт туйлын хүндэтгэлтэйгээр ханддаг билээ" [271]. Үүний зэрэгцээ Христийн шашинтан бид нар "хэрэв Есүс Христийн Сайн мэдээний айлтгалын ая хөгжим бидний бие, сэтгэлийг хөглөхөө болих юм бол бид нигүүлсэнгүй сэтгэл, итгэл бишрэлээс төрсөн ариун нандин хайрын сэтгэл, биднийг бүгдийг уучлан өршөөсөн, амьдралын зам мөрийг тодорхой болгосон тухай бидний мэдлэгээс эх сурвалжтай хоорондоо эвлэрэх авьяас чадварын баяр баясгалангүй болох юм. Хэрэв Есүс Христийн Сайн мэдээний айлтгалын ая хөгжим бидний гэр орон, олон нийтийн гудамж талбай, бидний ажлын байр, бидний улс төрийн болон эдийн засгийн амьдралд эгшиглэхээ больвол бид эрэгтэй, эмэгтэй хүн бүрийн эрхэм чанарыг хамгаалахыг уриалан дуудаж байсан тэр эр зоригийн дуудлагыг сонсохоо болино" [272]. Бусад хүмүүс өөр өөр эх ундаргаас хүртэж цангаагаа тайлдаг юм. Тэгвэл бидний хувьд хүний эрхэм чанар, ахан дүүгийн харилцаа холбооны тухай ойлголтын эх ундрага бол Есүс Христийн Сайн мэдээний айлтгал мөн билээ. Энэхүү Сайн мэдээний айлтгалаас дараах мэргэн үг ундран гарч байдаг билээ: "Христийн шашны сургаал, манай Шашны үйл хэргийн хувьд хоорондоо харилцаа холбоо тогтоох, өөр хүний ариун нууц ертөнцтэй уулзан учрах, хүн төрөлхтний том

гэр бүлтэй бүгдтэй нь хамтдаа харилцах зэрэг нь тэргүүн зэргийн ач холбогдолтой хэмээн үздэг бөгөөд ингэх нь бид бүгдийн амьдралын дуудлага мөн гэж тооцогдоно" [273].

278. Газар бүр үндэслэж байх ёстой манай Шашин олон зууны турш дэлхийн өнцөг булан бүрт оршсоор байгаа бөгөөд ингэснээр "*catholic*" буюу "бүхнийг, бүгдийг багтаагч" гэсэн үгийн утга санааг бүрэн бүтнээр нь илэрхийлж байгаа юм. Манай Шашин тэнгэрлэг хишиг, хүний нүгэл гэж чухам юу болох тухай үзсэн туршлагадаа тулгуурлан бүгдийг багтаасан хайрын сэтгэлтэй болох уриалгын гоо сайхныг ухааран ойлгосон байдаг юм. Нээрээн "хүмүүний хэмээх тодотголтой бүх юм бидэнд хамаатай... улс үндэстний зөвлөлүүд хүний эрх, эрх чөлөө болон үүрэг хариуцлагыг тодорхойлон тогтоохын тулд хаана хуран цугларна манай Шашин тэдний дунд өөрийн байраа эзлэхээр уригддаг нь бидний хувьд нэр хүндийн хэрэг мөн билээ" [274]. Олон олон Христийн шашинтны хувьд ахан дүүгийн харилцаа холбоо тогтоох их аяллын замд Мариа хэмээх нэр алдартай Эхийн хамт явж байгаа юм. Энэхүү бүгдийн Эх болох үүргээ Загалмайн доор хүлээн авсан (харьцуул. Иохан 19:26) Мариа эх ганцхан Христийн төлөө бус харин "бусад бүх хүүхдийнхээ төлөө" (харьцуул. *Илчлэл* 12:17) зүрх сэтгэлээ зориулж байдаг юм. Дахин амилсан Эзэн тэнгэрийн эрч хүчийн ачаар Мариа эх шинэ ертөнцийг төрүүлэхийг хүсэж байгаа билээ. Шинэ ертөнцөд бид нар бүгдээрээ нэг нэгэндээ ах, эгч, дүү байх болно, манай нийгмүүдэд шоовдорлогдож ад үзэгдсэн бүх хүмүүс тэр шинэ ертөнцөд өөрийн гэсэн байр суурийг эзлэнэ, шинэ ертөнцөд шударга ёс ялж, энх тайван бат бэх тогтоно.

279. Христийн шашинтан бид цөөнх байгаа улс орнуудад бидний эрх чөлөөг баталгаатай хангаж өгөхийг хүсдэг, бид Христийн шашинтай бус хүмүүс цөөнх байгаа улс орнуудад тэдний эрх чөлөөг баталгаатай хангахыг хоёргүй сэтгэлээр дэмжиж байдаг билээ. Ахан дүүгийн харилцаа холбоо, энх тайвныг бат бэх тогтоох их аяны замд явж байхдаа хүний эрхүүдийн нэгэн суурь эрхийн тухай мартаж огт болохгүй. Энэ бол бүх шашны дагагчдын шашин шүтэх эрх. эрх чөлөөг баталгаатай хангах явдал юм. Энэхүү эрх чөлөө бид бүгд "эе найр болон янз бүрийн соёл, шашны хооронд ойлголцлыг бүтээж чадна. Энэхүү эрх чөлөө бид бүгд олон олон сэжмээр хоорондоо холбогдсон байдаг тул өөр өөрийн бусдаас ялгарах ялгааг хүлээн зөвшөөрч, нэг Тэнгэрбурханы үр сад болсон ах, эгч, дүү нар мөн тул эрүүл саруул, эмх замбараатай, энх тайванч байдлаар зэрэгцэн орших арга чаргыг олж болно гэдгийг гэрчилсэн баримт болж байдаг" [275] билээ.

